ИНВЕСКОР АКТИВ



# "Инвескор Актив" ХБҮЦ

Автомашины зээлийн багцын хөрөнгөөр баталгаажсан
24 сарын хугацаатай 4,000,000,000 төгрөгийн үнэт цаас

**"Инвескор ББСБ" ХК – 3,000,000,000 төгрөг**
**"Микро Кредит ББСБ" ХХК – 1,000,000,000 төгрөг**

**Андеррайтер:**
"Инвескор Капитал ҮЦК" ХХК

InvesCore
КАПИТАЛ ХХК

**Зээлийн шинжилгээ гаргагч:**
"БДО Аудит" ХХК

BDO

**Хуулийн фирм:**
"Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН

MDSKhanLex

Танилцуулгыг 2020 оны 08 сарын 17-ны өдөр бэлтгэв

СЗХ
он сар өдөр 2021 01 06
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020-11-12
БҮРТГЭВ

# АГУУЛГА

**НЭР ТОМЬЁО** 5

**1. ҮНЭТ ЦААСНЫ ХУРААНГУЙ ТАНИЛЦУУЛГА**
1.1 ОРОЛЦОГЧ ТАЛУУД 7
1.2 ҮНЭТ ЦААСНЫ ҮНДСЭН НӨХЦӨЛҮҮД 8
1.3 БАГЦ, ТӨЛБӨР ЦУГЛУУЛАХ, МӨНГӨН УРСГАЛЫН ЗОХИЦУУЛАЛТ 9
1.4 ТӨЛБӨРИЙН ДАРААЛАЛ 9
1.5 БУСАД БИЧИГ БАРИМТ 10
ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД 12

**2. ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦСОН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ** 13

**3. ҮНЭТ ЦААС ГАРГАХ БОЛСОН ҮНДЭСЛЭЛ/ЗОРИЛГО**
3.1 МАКРО ХҮЧИН ЗҮЙЛС 14
3.2 ҮНДЭСЛЭЛ/ЗОРИЛГО 14
3.3 ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС /НЭЭЛТТЭЙ/ 15

**4. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ**
4.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН МЭДЭЭЛЭЛ 17
4.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧИЙН ТУХАЙ 18
4.3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН УДИРДЛАГА 20
4.4 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН/ЭХЛЭЛТИЙН ТАЙЛАН 23
4.5 САНХҮҮГИЙН ТӨСӨӨЛӨЛ 23
4.6 ЗӨВШӨӨРӨГДСӨН ДАНСУУД 28
4.7 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНАЛААР ХУГАЦААНААС ӨМНӨ ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАЖ АВАХ БОЛОМЖ 28

**5. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ**
5.1 САНАЛ БОЛГОЖ БУЙ ХҮҮГИЙН ТҮВШИН БОЛОН ҮНДЭСЛЭЛ 29
5.2 ҮНЭТ ЦААСЖУУЛАХ ХЭЛЦЛИЙН ЗУРАГЛАЛ 30
5.3 ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧДЭД ТӨЛӨХ ТӨЛБӨРИЙН ЭХ ҮҮСВЭР, ТӨЛБӨРИЙН ХУВААРЬ 31
5.4 ХӨРӨНГИЙН БАГЦ, БАГЦАД ТАВИГДАХ ШААРДЛАГА 33
5.5 БАГЦЫН ТОЙМ 33
5.6 ҮНЭТ ЦААСАНД НӨЛӨӨЛӨХ ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ 36
5.7 ХӨРӨНГИЙГ БАГЦАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, БАГЦААС ХАСАХ ЖУРАМ 41

**6. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ**
6.1 ИНВЕСКОР ББСБ 43
6.2 МИКРОКРЕДИТ ББСБ 46

**7. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ** 49

**8. ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧ**
8.1 ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА
8.2 ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧИЙН САНХҮҮГИЙН БАЙДАЛ 50
8.3 КОМПАНИЙН УДИРДЛАГА 51
8.4 ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАХ ЖУРАМ 51
8.5 ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧИЙГ СОЛИХ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ 52
53

**9. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН**
9.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ 55

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК
6581463

МОНГОЛ ... ХОРОО
2020-11-12
БҮРТГЭВ-02

2021.01.06
БҮРТГЭВ
№01


9.2 АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧ БОЛОН ХӨРӨНГИЙН БАГЦТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТУУД 56

**10. ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА**

10.1 ҮНЭТ ЦААСЫГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ 59
10.2 ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНД ОРОЛЦОХ, ЗАХИАЛГА АВАХ ЗААВАР 60
10.3 ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА, ХҮҮГИЙН ТӨЛБӨР, ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН ГРАФИК 61
10.4 ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ 61
10.5 Б ТРАНЧ ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧИЙН АРИЛЖААНЫ ХЯЗГААРЛАЛТ 61
10.6 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ 62
10.7 ТАТВАР 62

**11. ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУДЫН МЭДЭЭЛЭЛ**

11.1 АНДЕРРАЙТЕР 63
11.2 ЗЭЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ ГАРГАГЧ 65
11.3 ХУУЛИЙН ФИРМ 66

**12. ХЭЛЦЭЛТЭЙ ХОЛБООТОЙ ГЭРЭЭ, ЖУРМУУД** 68


## ХАВСРАЛТУУД:


1 Аудиторын дүгнэлт
2 Хуулийн дүгнэлт
3 Андеррайтерийн дүгнэлт
4 Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
5 Үнэт цаас гаргагчийн дүрмийн хуулбар
6 Үнэт цаас гаргагчийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар
7 Үнэт цаас гаргагчийн эхлэлтийн баланс
8 Үнэт цаас гаргагчийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тухай шийдвэр
9 Үнэт цаас гаргагчийн Хөрөнгө худалдан авах тухай шийдвэр
10 Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн багцад тавигдах шалгуур узүүлэлт баталсан шийдвэр, шалгуур үзүүлэлтүүд
11 Үүсгэн байгуулагч бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч "Инвескор ББСБ" ХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
12 Үүсгэн байгуулагч Анхны үүрэг гүйцэтгүүлэгч "Инвескор ББСБ" ХК-ийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар
13 Үүсгэн байгуулагч Анхны үүрэг гүйцэтгүүлэгч "Микро Кредит ББСБ" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
14 Үүсгэн байгуулагч Анхны үүрэг гүйцэтгүүлэгч "Микро Кредит ББСБ" ХХК -ийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар
15 Анхны үүрэг гүйцэтгүүлэгчдийн Хөрөнгө худалдах тухай шийдвэр
16 Хөрөнгө итгэмжлэн удирдагч "Рэдбэрал Инвестмент энд Менежмент" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
17 Хөрөнгө итгэмжлэн удирдагч "Рэдбэрал Инвестмент энд Менежмент" ХХК-ийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар
18 Үүсгэн байгуулагч, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн санхүүгийн ашиг сонирхлын талаарх мэдээлэл
19 Хөрөнгийн мэдээллийн дэлгэрүүлсэн жагсаалт


"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ҮЦК ХХК
2020 0754 581463

## ХҮСНЭГТҮҮД:

| | | |
|---|---|---|
| 4-1 | ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БҮРТГЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ | 17 |
| 4-2 | ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД | 18 |
| 4-3 | ИНВЕСКОР ББСБ ХК ТАНИЛЦУУЛГА | 18 |
| 4-4 | МИКРОКРЕДИТ ББСБ ХХК ТАНИЛЦУУЛГА | 19 |
| 4-5 | ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД | 22 |
| 4-6 | ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЭХЛЭЛТИЙН ТАЙЛАН | 23 |
| 4-7 | ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ОРЛОГЫН ТӨСӨӨЛӨЛ | 24 |
| 4-8 | ТЗК-ИЙН ХӨРӨНГӨ БАГЦЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ГОЛ ЗАРДЛУУД (НЭГ УДААГИЙН) | 25 |
| 4-9 | ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАХ ГЭРЭЭНИЙ ЗАРДАЛ (УЛИРАЛ БҮР) | 25 |
| 4-10 | ТЗК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЗАРДАЛ | 25 |
| 4-11 | АУДИТЫН ЗАРДАЛ | 26 |
| 4-12 | ТЗК-ИЙН МӨНГӨН УРСГАЛЫН ТӨСӨӨЛӨЛ | 26 |
| 5-1 | А ТРАНЧ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ӨГӨӨЖ | 30 |
| 5-2 | Б ТРАНЧ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ӨГӨӨЖ | 30 |
| 5-3 | ХҮҮ ТООЦОХ АРГАЧЛАЛ | 32 |
| 5-4 | ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨРИЙН ГРАФИК | 32 |
| 5-5 | ҮНЭТ ЦААСЖУУЛАХ БАГЦЫН ТОЙМ | 33 |
| 5-6 | БАГЦЫН АНХ ОЛГОСОН ХУГАЦААНЫ МЭДЭЭЛЭЛ | 34 |
| 5-7 | БАГЦЫН АНХ ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ХУГАЦАА | 34 |
| 5-8 | БАГЦЫН АНХ ОЛГОСОН ДҮН | 35 |
| 5-9 | БАГЦЫН БАРЬЦАА ХАНГАЛТ | 35 |
| 5-10 | ЗЭЭЛИЙН ХҮҮНИЙ ТАРХАЛТ | 36 |
| 5-11 | БАРЬЦАА АВТОМАШИНЫ ТӨРӨЛ | 36 |
| 5-12 | ИНВЕСКОР АВТОМАШИНЫ ЗЭЭЛИЙН БАГЦ (ЗЭЭЛИЙН БАГЦААС) | 37 |
| 5-13 | МИКРОКРЕДИТ АВТОМАШИНЫ ЗЭЭЛИЙН ТҮҮХ (АНХ ОЛГОСОН ДҮНГЭЭС) | 37 |
| 5-14 | А3 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙН ТӨСӨӨЛӨЛ MCKINSEY&COMPANY | 40 |
| 5-15 | А1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙН ТӨСӨӨЛӨЛ MCKINSEY&COMPANY | 40 |
| 6-1 | ИНВЕСКОР ББСБ САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН | 44 |
| 6-2 | ИНВЕСКОР ББСБ ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН | 44 |
| 6-3 | МИКРОКРЕДИТ ББСБ САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН | 47 |
| 6-4 | МИКРОКРЕДИТ ББСБ ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН | 47 |
| 8-1 | ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УРИРДАГЧИЙН САНХҮҮГИЙН БАЙДАЛ | 51 |
| 8-2 | ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧИЙН ТУЗ-ИЙН ГИШҮҮД | 52 |
| 10-1 | ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨРИЙН ГРАФИК | 61 |

## Графикууд:

| | | |
|---|---|---|
| 3-1 | НЭЭЛТТЭЙ БОНДЫН АРИЛЖААНЫ СТАТИСТИК | 14 |
| 5-1 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭРЭГСЛҮҮДИЙН ӨГӨӨЖИЙН ХАРЬЦУУЛАЛТ | 29 |
| 5-2 | ББСБ ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ | 29 |
| 5-3 | БАГЦЫН ЗЭЭЛИЙН ҮНДСЭН БОЛОН ХҮҮГИЙН ТӨЛБӨРИЙН ТӨСӨӨЛӨЛ | 31 |
| 6-1 | ИНВЕСКОР ББСБ САНХҮҮГИЙН БАЙДАЛ | 43 |
| 6-2 | ИНВЕСКОР ББСБ ЗЭЭЛИЙН БАГЦ, АШИГТ АЖИЛЛАГАА | 43 |
| 6-3 | МИКРОКРЕДИТ ББСБ САНХҮҮГИЙН БАЙДАЛ | 46 |
| 6-4 | МИКРОКРЕДИТ ББСБ ЗЭЭЛИЙН БАГЦ, АШИГТ АЖИЛЛАГАА | 46 |

## Зураг:

| | | |
|---|---|---|
| 5-1 | ҮНЭТ ЦААСЖУУЛАХ ХЭЛЦЛИЙН ЗУРАГЛАЛ | 31 |
| 10-1 | ҮНЭТ ЦААСЫГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ ЯВЦ | 59 |
| 10-2 | ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНД ОРОЛЦОХ ЗААВАР | 60 |

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2020-11-12
БҮРТГЭВ-02

СЗХ
2021.01.06
БҮРТГЭВ

# НЭР ТОМЬЁО БА ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

| | |
|---|---|
| **Авлага** | Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Зээлдэгчид олгосон зээлийн дагуу хүлээн авах эрх бүхий сар тутмын хүү, үндсэн төлбөр, нэмэгдүүлсэн хүү болон бусад төлбөр |
| **Анхдагч зах зээлийн арилжаа** | Монголын Хөрөнгийн Биржийн анхдагч зах зээлийн арилжаа |
| **Анхны үүрэг гүйцэтгүүлэгч** | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт тодорхойлсон, Үнэт цаас гаргагчтай "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ" "Фидуцийн барьцааны гэрээ" байгуулсан энэ Танилцуулгад тусгагдсан хуулийн этгээд |
| **Автомашины зээл эсхүл Зээл** | Зээлдүүлэгч буюу Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Зээлдэгчид автомашин худалдан авахад нь зориулан Зээлийн гэрээний дагуу олгож, тухайн автомашиныг уг зээлийн үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар Фидуцийн гэрээ байгуулсан зээл |
| **Бирж** | "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК |
| **Зээлдэгч** | Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн холбогдох журамд заасан шалгуурыг хангаж автомашины зээл авсан, уг зээлийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид төлөх үүрэгтэй этгээд |
| **Зээлийн данс бүртгэл** | Зээлдэгч тус бүрийн Зээлийн эргэн төлөлт, үлдэгдэл, хүү, нэмэгдүүлсэн хүүг тооцоолж, эргэн төлөлтийг хугацаатай нь бүртгэсэн мэдээлэл |
| **Зээлийн эргэн төлөлт** | Зээлдэгчийн Үйлчилгээ үзүүлэгчид сар тутам Зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөх Зээлийн үндсэн төлбөр, хүү болон Зээлийн гэрээний дагуу тооцогдох нэмэгдүүлсэн хүү |
| **Орлуулах хөрөнгө** | Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид болон Үнэт цаас гаргагчийн хоорондын Хөрөнгө худалдах худалдан авах гэрээний 5.3.1 дэх хэсэгт тодорхойлсон Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн Шаардлага хангахгүй хөрөнгийн оронд сольж, Үнэт цаас гаргагчид шилжүүлэх хөрөнгө |
| **Төвбанк** | Монгол Улсын Төв Банк /Монголбанк/ |
| **Төлбөр гүйцэтгэх данс** | Үнэт цаас гаргагчийн "Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлөх журам"-д тодорхойлсон, Хөрөнгийн багцын эргэн төлөлт, бусад холбогдох төлбөрийг хүлээн авах зорилгоор Үнэт цаас гаргагчийн нэр дээр Худалдаа Хөгжлийн Банканд нээлгэсэн 3 сарын хугацаатай хадгаламжийн данс |
| **Төлбөр цуглуулах данс** | Үнэт цаас гаргагчийн "Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлөх журам"-д тодорхойлсон, Зээлдэгчийн Зээлийн эргэн төлөлтийг цуглуулах, Хөрөнгийн багцын эргэн төлөлтийг Үнэт цаас гаргагчийн Төлбөр гүйцэтгэх дансанд шилжүүлэх зорилгоор Үйлчилгээ үзүүлэгчийн нэр дээр Худалдаа Хөгжлийн Банканд нээлгэсэн харилцах данс; |
| **ТУЗ** | Төлөөлөн удирдах зөвлөл |
| **Үйлчилгээ** | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу Үйлчилгээ үзүүлэгч нь Үнэт цаас гаргагчтай байгуулсан Үйлчилгээ үзүүлэх гэрээний хүрээнд хөрөнгөтэй холбоотой төлбөр цуглуулан шилжүүлэхтэй холбоотойгоор үзүүлж буй үйлчилгээ |
| **Үйлчилгээ үзүүлэгч** | Үнэт цаас гаргагчтай байгуулсан Үйлчилгээ үзүүлэх гэрээний хүрээнд Хөрөнгөтэй холбоотой төлбөр цуглуулан шилжүүлэх үйлчилгээг үзүүлж буй Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19 дүгээр зүйлд тодорхойлсон хуулийн этгээд |
| **Үнэт цаас гаргагч эсхүл ТЗК** | "Инвескор Актив ТЗК" ХХК |
| **Үнэт цаас эзэмшигч** | ХБҮЦ-ыг үнэт цаасны зах зээлийн анхдагч болон хоёрдогч арилжаанаас худалдан авсан, тийнхүү худалдан авсан огнооноос хойш Үнэт цаасны төлбөрийг хүлээн авах эрх бүхий хувь хүн, хуулийн этгээд |

InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР

СЗХ
2021 сар 06 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020 -11- 12
БҮРТГЭВ-02

| | |
|---|---|
| **Үнэт цаасны төлбөр** | Энэхүү Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан Үнэт цаасны үндсэн төлбөр болон хүүгийн төлбөр |
| **ҮЦТ эсхүл Танилцуулга** | Энэхүү Үнэт цаасны танилцуулга |
| **ҮЦТХТ** | Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв |
| **Харилцах данс** | ТЗК-ийн нэр дээр Худалдаа Хөгжлийн Банканд нээлгэсэн байгууллагын энгийн харилцах данс |
| **Хороо** | Санхүүгийн Зохицуулах Хороо |
| **Хөрөнгө** | Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид болон Үнэт цаас гаргагчийн хоорондын Хөрөнгө худалдах худалдан авах гэрээний 2.1.1 дэх хэсэгт тодорхойлогдсон, ХБҮЦ-ыг баталгаажуулж буй Зээлийн хөрөнгө болон түүнд холбогдох эрх |
| **Хөрөнгө итгэмжлэн удирдагч** | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасан, Үнэт цаас гаргагчтай Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ байгуулсан энэ Танилцуулгад тусгагдсан хуулийн этгээд |
| **Хөрөнгийн багц эсхүл Багц** | Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид болон Үнэт цаас гаргагчийн хоорондын Хөрөнгө худалдах худалдан авах гэрээний 2.1.1 дэх хэсэгт тодорхойлогдсон, Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Үнэт цаас гаргагчид худалдсан хөрөнгүүдийн багц |
| **Хөрөнгийн багцын эсхүл Багцын эргэн төлөлт** | Сар тутам Үйлчилгээ үзүүлэгч нь Төлбөр цуглуулах данснаас Үнэт цаас гаргагчийн Төлбөр гүйцэтгэх дансанд шилжүүлж буй Зээлийн эргэн төлөлтийн нийлбэр дүн |
| **Хөрөнгийн жагсаалт** | Энэхүү Танилцуулга болон Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид болон Үнэт цаас гаргагчийн хоорондын "Хөрөнгө худалдах худалдан авах гэрээ"-нд хавсаргасан Хөрөнгийн жагсаалт |
| **Шаардлага хангахгүй хөрөнгө** | Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид болон Үнэт цаас гаргагчийн хоорондын "Хөрөнгө худалдах худалдан авах гэрээ", Үнэт цаас гаргагчийн "Багцын хөрөнгөд өөрчлөлт оруулах, хөрөнгийг багцаас хасах журам"-д тодорхойлж, энэхүү Танилцуулгын 5.7.1 дэх хэсэгт тусгасан хөрөнгө |
| **Шалгуур үзүүлэлт** | Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 06-р сарын 09-ний өдрийн 20/03 тоот тогтоолоор баталсан Хөрөнгийн багцад тавигдах санхүүгийн болон хуулийн шалгуур үзүүлэлтүүд |

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ҮЦК ХХК

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020 -11- 12
БҮРТГЭВ-02

СЗХ
он 2021 сар 01 . 06 өдөр
БҮРТГЭВ
№ 01

# 1. ҮНЭТ ЦААСНЫ ХУРААНГУЙ ТАНИЛЦУУЛГА

Нийтэд танилцуулж буй Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны болон багцлах хөрөнгийн товч танилцуулгыг доор хураангуйлав. Дэлгэрэнгүй мэдээлэл болон үнэт цаас гаргахад шаардлагатай дүгнэлтүүдийг Танилцуулгын бусад хэсгээс харах боломжтой.

ТОМ үсгээр тэмдэглэсэн үгсийн тайллыг Танилцуулгын "Нэр Томьёо ба товчилсон үгийн тайлбар" хэсгээс харж болно.

## 1.1 Оролцогч талууд

| | |
|---|---|
| **Үнэт цаас гаргагч** | "Инвескор Актив ТЗК" ХХК |
| **Үүсгэн байгуулагч** | "Инвескор ББСБ" ХК - 75%<br>"Микрокредит ББСБ" ХХК - 25% |
| **Анхны үүрэг гүйцэтгүүлэгч** | "Инвескор ББСБ" ХК<br>"Микрокредит ББСБ" ХХК |
| **Үйлчилгээ үзүүлэгч** | "Инвескор ББСБ" ХК<br>"Микрокредит ББСБ" ХХК |
| **Хөрөнгө итгэмжлэн удирдагч** | "Рэдбэрал Инвестмент энд Менежмент" ХХК |
| **Үнэт цаасны төлбөр гүйцэтгэх данс байрших банк** | Худалдаа Хөгжлийн Банк |
| **Үйлчилгээ үзүүлэгчийн зээлийн эргэн төлөлтийн төлбөр цуглуулах данс байрших банк** | "Инвескор ББСБ" ХК - Худалдаа Хөгжлийн Банк<br>"Микро Кредит ББСБ" ХХК - Худалдаа Хөгжлийн Банк |
| **Андеррайтер** | "Инвескор Капитал ҮЦК" ХХК |
| **Аудитор** | "БДО Аудит" ХХК |
| **Хуулийн зөвлөх** | Өмгөөллийн "Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН |
| **Төлбөр тооцоо** | "Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв" ХХК |
| **Үнэт цаасны хадгаламж** | "Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв" ХХК |
| **Арилжаалах зах зээл** | "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК |

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
119277128
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК
6581463

САХ
он сар өдөр
2021 01 06
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020 -12- 28
БҮРТГЭВ-02

## 1.2 Үнэт цаасны үндсэн нөхцөлүүд

| | |
|---|---|
| **Үнэт цаасны төрөл** | Автомашины зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас |
| **Үнэт цаасны тоо ширхэг** | 10,000 (арван мянган) ширхэг<br>▪ Олон нийтэд нээлттэй арилжаалах 8,500 ширхэг (А Транч)<br>▪ Хязгаарлагдмал хүрээнд арилжаалах 1,500 ширхэг (Б Транч) |
| **Үнэт цаасны нэгжийн нэрлэсэн үнэ** | 400,000 (дөрвөн зуун мянга) төгрөг |
| **Үнэт цаасны нийт дүн** | 4,000,000,000 (дөрвөн тэрбум) төгрөг |
| **Үнэт цаасны хугацаа** | Үнэт цаас нь Транч харгалзахгүйгээр Үнэт цаас гаргасан өдрөөс хойш 24 сарын хугацаатай |
| **Үнэт цаасны хүү, төлөгдөх хэлбэр** | Үнэт цаасыг олон нийтэд арилжаалсан өдрөөс хойш хуанлийн 3 сар тутамд үндсэн төлбөрийн үлдэгдлээс Транч харгалзахгүй жилийн 14.4% хүү тооцож төлнө. |
| **Үнэт цаасны үндсэн төлбөр, төлөгдөх хэлбэр** | Үнэт цаасыг олон нийтэд арилжаалсан өдрөөс хойш үндсэн төлбөрийг 8 тэнцүү дүнгээр хуанлийн 3 сар тутамд төлнө. |
| **Үнэт цаасны төлбөр төлөгдөх эх үүсвэр** | Үнэт цаасны төлбөрийг Хөрөнгийн багцын зээлийн үндсэн төлбөр, хүүгийн төлбөрөөр гүйцэтгэнэ.<br><br>Үнэт цаасны төлбөр тасалдахаас сэргийлэх нөөц хөрөнгийг Үнэт цаас гаргагчийн баталсан Эрсдэлийн удирдлага, дотоод хяналт хэрэгжүүлэх, эрсдэлийн сан байгуулах, сангийн хөрөнгийг зарцуулах тухай журмын дагуу байршуулна. |
| **Үнэт цаасны хүүд ногдох татвар** | Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны хүүгийн орлогод Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу 5 хувийн татвар ногдуулж, ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИЙН ҮНЭТ ЦААСНЫ ДАНС РУУ ШИЛЖҮҮЛЭХДЭЭ СУУТГАН АВНА. |
| **Үнэт цаас гаргагчийн саналаар хугацаанаас өмнө эргүүлэн худалдаж авах эрх** | Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны хугацааны турш аль ч үед гаргасан үнэт цаасыг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн зах зээлийн үнээр нь худалдаж авах санал гаргаж болно. |
| **Үнэт цаасыг анхдагч зах зээлд борлуулсан орлогын зарцуулалт** | Үнэт цаас гаргагч нь анхдагч зах зээлд борлуулсан үнэт цаасны орлогоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Хөрөнгийн багцыг шилжүүлэн авах, Үнэт цаас гаргахтай холбоотой зардлыг төлөхөд зарцуулна. |

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК
9020080714 6581463

## 1.3 Багц, төлбөр цуглуулах, мөнгөн урсгалын зохицуулалт

**Багц**

Үнэт цаасны хөрөнгийн баталгаа болох зээлийн багц нь "Инвескор ББСБ" ХК-ийн 3,000,000,000 төгрөг, "Микро Кредит ББСБ" ХХК-ийн 1,000,000,000 төгрөгийн дүн бүхий автомашины зээлийн багцын нийлбэр байна.

**Багцын төлбөр цуглуулалт**

Багцын зээлийн эргэн төлөлт, хүүгийн төлөлтийг "Төлбөр цуглуулах гэрээ"-ний дагуу Инвескор ББСБ, Микрокредит ББСБ гүйцэтгэнэ.

**Багцын зээлийн шалгуур**

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн шаардлагыг хангасан, хэвийн ангилалтай, анхны үүрэг гүйцэтгүүлэгчдийн зээлийн хэвийн үйл ажиллагааны дагуу олгогдсон, автомашины зээлүүд байна. Зээлийн нөхцөлд дараах шаардлагыг тавьсан.

- Зээлийн хүү: Багцын зээлийн жигнэсэн дундаж хүү 2.9% байна
- Зээлийн хугацаа: 24 сараас доошгүй хугацаатай олгогдсон, анх олгосноос хойш зээлийн нийт хугацааны 1/3-ээс ихгүй хугацаа өнгөрсөн байх.

Хөрөнгийн багц нь үүргийн гүйцэтгэлийн хэрэгсэл, барьцаагаар хангагдсан байна.

## 1.4 Төлбөрийн дараалал

**Үнэт цаасны хэвийн эргэн төлөлтийн үеийн төлбөрийн дараалал**

ТЗК-ийн аливаа төлбөр хийхэд мөнгөн урсгалын дараах дарааллыг баримтална:

1. А Транчийн үнэт цаасны хүүгийн төлбөр
2. А Транчийн үнэт цаасны үндсэн төлбөр
3. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний төлбөр
4. Аудитын үйлчилгээний төлбөр
5. ТЗК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин
6. Б Транчийн үнэт цаасны хүүгийн төлбөр
7. Б Транчийн үнэт цаасны үндсэн төлбөр
8. Төлбөр цуглуулах үйлчилгээний төлбөр
9. Бусад төлбөр

**Үнэт цаасны төлбөр төлөгдөж дуусах үеийн төлбөрийн дараалал**

Үнэт цаасны төлбөр төлөгдөж дуусах үед Үнэт цаас гаргагч нь дараах дарааллыг баримталж төлбөр гүйцэтгэнэ:

1. А Транчийн үнэт цаасны хүүгийн төлбөрийн үлдэгдэл
2. А Транчийн үнэт цаасны үндсэн төлбөрийн үлдэгдэл
3. Төлбөр цуглуулах үйлчилгээний төлбөрийн үлдэгдэл
4. Бусад төлбөрийн үлдэгдэл
5. Хувьцаа эзэмшигчдэд төлөх төлбөр

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

2020-12-28
БҮРТГЭВ

2021.01.06
БҮРТГЭВ

СЗХ
он сар өдөр
2021 ... 
БҮРТГЭВ
№ 01

2020-11-12
БҮРТГЭВ-02

6. Б Траншийн үнэт цаасны хүүгийн төлбөрийн үлдэгдэл

7. Б Траншийн үнэт цаасны үндсэн төлбөрийн үлдэгдэл

8. Төлбөр цуглуулах үйлчилгээний төлбөрийн үлдэгдэл

9. Бусад төлбөрийн үлдэгдэл

10. Хувьцаа эзэмшигчдэд төлөх төлбөр

**Эрсдэлийн сан**

Үүсгэн байгуулагчид нь Үнэт цаасны нийт хугацааны турш Үнэт цаасны төлбөр тасалдахаас сэргийлж, 150,000,000 төгрөгийг Үнэт цаас гаргагчийн холбогдох журмын дагуу Эрсдэлийн санд байршуулна.

## 1.5 Бусад бичиг баримт

**Үнэт цаас гаргагчаас баталж мөрдөх журмууд**

Үнэт цаасжуулах үйл ажиллагаатай холбоотойгоор Үнэт цаас гаргагчаас доорх журмуудыг баталж мөрдүүлэх бөгөөд Үнэт цаасжуулах ажиллагаанд оролцогчид болон тэдгээрийн ажилтан, албан тушаалтан болон гэрээлэгчид заавал дагаж мөрдөх үүрэгтэй:

1. ТУЗ-ийн үйл ажиллагааны журам
2. Хөндлөнгийн аудиторыг сонгох, солих журам
3. Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих журам
4. Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааны журам
5. Багцын хөрөнгөд өөрчлөлт оруулах, хөрөнгийг багцаас хасах журам
6. Эрсдэлийн удирдлага, дотоод хяналт хэрэгжүүлэх, эрсдэлийн сан байгуулах, сангийн хөрөнгийг зарцуулах журам
7. Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлөх журам
8. Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах журам

**Үнэт цаасжуулах хэлцлийн оролцогчидтой байгуулах гэрээнүүд**

Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасжуулах үйл ажиллагааны оролцогч нартай дор дурьдсан гэрээ, хэлцлүүдийг байгуулна:

1. Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ /Анхны үүрэг гүйцэтгүүлэгчидтэй/

2. Фидуцийн барьцааны гэрээ /Анхны үүрэг гүйцэтгүүлэгчидтэй/

3. Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ /Анхны үүрэг гүйцэтгүүлэгчидтэй/

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 ... 1119277128
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ЗВК ХХК
9020080754 ... 658...

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2020 -11- 12
БҮРТГЭВ-02

2021.01.06
БҮРТГЭВ

4. Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлэх гэрээ
/Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай/

5. Төлбөр цуглуулах дансны барьцааны гэрээ
/Үйлчилгээ үзүүлэгчидтэй/

**Үнэт цаасжуулах үйл ажиллагаанд оролцогчидтой байгуулсан гэрээнүүд**

1. Зээлийн шинжилгээ хийлгэх гэрээ
/"БДО Аудит" ХХК/

2. Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ
/"Өмгөөллийн Эм Ди Эс Хаанлекс" ХХН/

3. Андеррайтерийн болон зөвлөх үйлчилгээний гэрээ
/Үүсгэн байгуулагчид болон "Инвескор Капитал ҮЦК" ХХК-тай гурван талт гэрээ/

**Бусад гэрээ**

1. Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ
/"Лидер Экаунт Аудит" ХХК/

2. "Тусгай нөхцөлтэй байгууллагын мөнгөн хадгаламжийн гэрээ"
/Худалдаа Хөгжлийн Банк/

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2020 -11- 12
БҮРТГЭВ-02

# ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ НЬ МОНГОЛ УЛСЫН "КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛЬ", "ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ", "ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ ХУУЛЬ" БОЛОН МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО БОЛОН МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ХОЛБОГДОХ ЖУРМУУДЫН ДАГУУ ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС ГАРГАЖ БАЙГАА БОЛНО.

Энэхүү Үнэт цаасны танилцуулгыг Үнэт цаас гаргагчаас нэг бүр нь 400,000 (дөрвөн зуун мянган) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 4,000,000,000 /дөрвөн тэрбум/ төгрөгийн үнийн дүн бүхий 10,000 (арван мянган) ширхэг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй гаргахтай холбоотойгоор хөрөнгө оруулагчдад зориулж бэлтгэсэн болно. Үнэт цаас гаргагч "Инвескор Актив" ХХК нь энэхүү 4.0 тэрбум төгрөгийн үнэт цаасыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч "Инвескор ББСБ" ХК болон "Микро Кредит ББСБ" ХХК-иас зээлийн багц шилжүүлэн авахад ашиглах бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь өөрийн зах зээлийг тэлж зээл олгоход ашиглана.

Энэхүү Үнэт цаасны танилцуулга нь Хөрөнгө оруулагч таны хараат бус үнэлгээ гаргах, шинжилгээ хийх ажиллагааг орлохгүй, уг ажиллагаанд тооцогдохгүй. Мөн Санхүүгийн Зохицуулах Хороо үнэт цаасыг бүртгэсэн нь уг үнэт цаас болон түүнийг баталгаажуулж буй зээлийн багц дахь мэдээлэл, хөдлөх хөрөнгийн үнэлгээ болон холбогдох бусад мэдээлэл нь үнэн зөв, эрсдэлгүй гэсэн баталгаа биш бөгөөд хэрэв үнэт цаасанд эрсдэл үүсвэл Санхүүгийн Зохицуулах Хороо хариуцахгүй болно. Иймд хөрөнгө оруулагч та Үнэт цаас гаргагч болоод түүний гаргаж буй үнэт цаас, холбогдох мэдээллийн талаар бие даасан хөндлөнгийн судалгаа шинжилгээг хийн санхүү, хуулийн болон бусад зохих мэргэжлийн зөвлөхүүдтэй зөвлөлдсөний үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.

Энэхүү Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан зарим ирээдүйн болон зөвхөн одоогоор цаг хугацааны шинж чанартай гаргасан мэдээлэл, мэдэгдэл, тооцоолол, төсөөлөл нь Андеррайтерийн холбогдох эх сурвалжаас цуглуулсан мэдээлэл, итгэл үнэмшил дээр тулгуурласан бөгөөд санаатайгаар ямар нэгэн мэдээллийг орхигдуулаагүй болно. Андеррайтер нь эдгээр мэдээлэл, мэдэгдэл, тооцоолол, төсөөллийг гаргахдаа аль болох үнэн зөв, шийдвэр гаргахад шаардагдах магадлалтай гэж үзсэн мэдээллийг ашиглан бодит байдалд нийцүүлэхийг зорьсон бөгөөд тооцоолол, ирээдүйн төсөөллийн биелэлтэд баталгаа өгөөгүй болно.

ҮНЭТ ЦААСЫГ МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ БҮРТГЭСЭН НЬ УГ ҮНЭТ ЦААСНЫ ЭРСДЭЛИЙН ТАЛААР АЛИВАА БАТАЛГАА ГАРГААГҮЙ БОЛОХЫГ АНХААРАХ НЬ ЗҮЙТЭЙ. ҮНЭТ ЦААС ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНЫ ХУВЬД ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ ҮЙЛДЭЛ БАЙДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА, ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛСНЫ ҮНДСЭН ДЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.

Энэхүү үнэт цаасны танилцуулгад хөрөнгө оруулагч танд тус үнэт цаасыг худалдан авах шийдвэр гаргахад туслах шаардлагатай бүхий л мэдээллийг агуулахыг зорьсон болно. Хөрөнгө оруулагч таны шийдвэр гаргалтад танилцуулгад тусгагдсан мэдээллээс илүү дэлгэрэнгүй, нэмэлт мэдээлэл шаардлагатай болох буюу лавлаж тодруулах зүйл байвал Үнэт цаас гаргагч болон Андеррайтерт хандаж тодруулна уу.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN S...
2020-11-12
БҮРТГЭВ-02



2021.01.06 өдөр
БҮРТГЭВ
№ 01

## 2. ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦСОН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ

**Андеррайтер**

**"Инвескор Капитал ҮЦК"** ХХК

- Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, Сөүлийн гудамж 10/1, Твин тауэр-1, 13 давхар
- Утас: (976) 77090077(2)
- Э-шуудан: info@icapital.mn
- Веб хуудас: www.icapital.mn

**Зээлийн шинжилгээ гаргагч**

**"БДО Аудит"** ХХК

- Хаяг: Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Нарны зам-62, Юнескогийн гудамж, Юнион Бюлдинг, В Блок, 15-р давхар, 1502 тоот, Улаанбаатар хот, Монгол Улс
- Утас: (976) 77404040, (976) 77404041
- Э-шуудан: bdo@bdo.mn
- Вэб хуудас: www.bdo.mn

**Хуулийн фирм**

**"Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс"** ХХН

- Хаяг: Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай гудамж, Сентрал Тауэр, 13 давхар, 1301 тоот
- Утас: (976) 330048
- Э-шуудан: info@mdsa.mn
- Вэб хуудас: www.mdskhanlex.com

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЭК ХХК

# 3. ҮНЭТ ЦААС ГАРГАХ БОЛСОН ҮНДЭСЛЭЛ / ЗОРИЛГО

## 3.1 Макро хүчин зүйлс

Өрийн бичиг, санхүүгийн бусад үүсмэл хэрэгслүүдийн нэгэн адил хөрөнгийн зах зээлийг хөдөлгөгч томоохон хэрэгсэл нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас юм. Олон улсад банкнуудын хөрвөх чадварыг дэмжиж, зах зээлээ тэлэх боломжоор хангадаг бөгөөд хөрөнгө оруулагчдад тооцоолж болохуйц эрсдэлээр тогтвортой өгөөж амладаг учир маш хурдацтай хөгжиж ирсэн байна.

Монгол Улсын хувьд банк санхүүгийн байгууллагууд, хөрөнгө оруулагч, даатгалын компаниуд чөлөөт эх үүсвэрээ байршуулах бүтээгдэхүүний сонголт бага байдаг, Төвбанкны үнэт цаас, Засгийн газрын үнэт цаас эсвэл валютад хөрөнгө оруулах нь түгээмэл байдаг байна. Энэ нь зах зээлээс эргээд эх үүсвэр татаж, хөрөнгө оруулалтын боломжуудыг хязгаарладаг сул талтай юм.

Түүнчлэн 2020 оны 1-р улиралд үүссэн онцгой нөхцөл байдлаас шалтгаалан Төвбанкнаас бодлогын хүүгээ буулгах бодлого баримталж, дараалан бууруулсан нь хөрөнгө оруулагчдын өгөөжийг бууруулж гадаад валютад хөрөнгө оруулах хөдөлгөөнийг улам нэмэгдүүлж байна.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь тодорхой шалгуурыг хангаж нэгэнт байршсан авлага буюу хөрөнгөд хөрөнгө оруулж байгаа учир хөрөнгө оруулагч нь эрсдэлээ тооцоолох боломжтой байдаг давуу талтай. Нөгөө талаар, анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь суларсан эх үүсвэрээрээ дахин хөрөнгө оруулж зах зээлээ тэлэх боломжтой байдаг тул эдийн засгийн өсөлтөд өндөр ач холбогдолтой хурдасгуур болдог.
Иймд өнөөдрийн эдийн засгийн нөхцөл байдалд хөрөнгө оруулагчдын хэрэгцээг хангаж, компаниудын хөрвөх чадварыг сайжруулах ач холбогдолтой бүтээгдэхүүн гэж үзэж байна.

## 3.2 Үндэслэл/Зорилго

2017 оноос хойш Засгийн газрын төгрөгийн бондод хөрөнгө оруулах хөрөнгө оруулагчдын сонирхол нэмэгдсэн бөгөөд 2017 оны 10-р сард бондын нийлүүлэлт зогссоноос хойш дотоодын аж ахуйн нэгжүүдийн бондод хөрөнгө оруулах эрэлт нэмэгдсэн билээ. Гэсэн хэдий ч бонд гаргахад аливаа барьцаа, баталгаа эсвэл төлбөрийн тасалдлын даатгал гэх мэт баталгаа заавал шаарддаг нь зах зээлд эрэлт их байгаа ч тэр хэмжээний итгэл төрөхгүй байгааг харуулж байгаа юм. Нөгөө талаар дийлэнх бондын хөрөнгө оруулагчид нь жижиглэнгийн буюу мэргэжлийн бус хөрөнгө оруулагчид байгаа нь мөн нөлөөлөх хүчин зүйл болж байгаа билээ.

**График 3-1.** *Нээлттэй бондын арилжааны статистик /тэрбум төгрөг/*




*МХБ, СЗХ, Сангийн яам*

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020-11-12
БҮРТГЭВ-02

СЗХ
он ... сар ... өдөр
2021-01-06
БҮРТГЭВ
№ 11

Түүнчлэн нээлттэй бонд анхдагч зах зээлд гаргахад хувьцаа гаргахтай ижил цаг хугацаа зарцуулдаг тул компаниуд хаалттай бонд гаргах явдал ихэссээр байгаа юм.
Өөрөөр хэлбэл 2017 оноос хойш харьцангуй өндөр өгөөжтэй төгрөгийн үнэт цаасанд хөрөнгө оруулдаг хөрөнгө оруулагчдад зориулан гаргадаг Засгийн газрын бондын орон зайг хаалттай бондоор нөхөж ирсэн нь арилжааны банкны зээл, хадгаламжаас бусад санхүүгийн хэрэгслийн зах зээлийг тэлж байгаа боловч нээлттэй зах зээлийг хөгжүүлэхгүй, олон нийтэд хаалттай хэвээр байгаа нь олон нийтийн хөрөнгө оруулах хэрэгцээг хангахуйц хангалттай өндөр өгөөж бүхий, эргэн төлөлтийн баталгаатай санхүүгийн хэрэгслийг зах зээлд нийлүүлэх шаардлагыг бий болгож байгаа юм.Энэ ч утгаараа сүүлийн үед Компаниуд нээлттэй бонд гаргах нь ихсэж байна.

## 3.3 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас /нээлттэй/

### 3.3.1 Давуу тал

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зөвхөн тодорхой шалгуур хангасан авлагуудыг багцлан үнэт цаасжуулснаар хөрөнгө оруулагч нар ирээдүйн эрсдэлээ зөв тооцоолох боломж олгож, харьцангуй тогтвортой өгөөж амладаг.

- Хөрвөх чадвар сайн
- Эргэн төлөлтийн мөнгөн урсгал нь тодорхой
- Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа болон эрсдэл анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс үл хамаарна
- Хөрөнгө оруулагчдын эрсдэлийг хамгаалах мөнгөн урсгалын шатлал, төлбөрийн дараалалтай

### 3.3.2 Сул тал

Авлагын төлөлт хугацаанаас өмнө хийгдвэл ХБҮЦ-наас хүлээгдэж байсан өгөөжөөс бага өгөөж бодогдох боломжтой. Гэвч энэ нөхцөлийг түүхэн статистик, олон шатлалт үнэт цаасжуулалтын замаар бууруулдаг. Инвескор Актив ХБҮЦ-ны хувьд Багц дахь зээлийн эргэн төлөлт хугацаанаас өмнө төлөлт хийгдэж ТЗК-ийн мөнгөн урсгалд нөлөөлөхөөр байх нөхцөлд зээлийн чанарыг алдагдуулахгүйгээр холбогдох журмын дагуу солих үүргийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид хүлээлгэсэн байна. /ҮЦТ-ын 5.7.1/

### 3.3.3 Олон улсын чиг хандлага

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны баталгаа болж буй хөрөнгөөр нь 4 ангилж болно. Үүнд:

- Consumer - сургалтын, кредит картын болон авто машины зээл зэрэг хувь хүний хэрэглээний зээлийн эргэн төлөлтөөр баталгаажсан
- Corporate – олон тооны ипотекийн эсхүл бизнесийн зээлийн багцын эргэн төлөлтөөр баталгаажсан
- Commercial – үйл ажиллагааны авлага болон усан онгоц, нисдэг тэрэг зэрэг ашиг олох зорилготой техникийн лизингийн эргэн төлөлтөөр баталгаажсан
- Whole Business – франчайз, брэнд нэр зэргийн роялти эсхүл зарын самбарын түрээс гэх мэт тухайн бизнесийн үйл ажиллагааны мөнгөн урсгалаар баталгаажсан

### 3.3.4 Монгол улсын туршлага

Монгол Улсад Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль 2010 онд батлагдаж, Хорооны 2011 оны 266 дугаар тогтоолоор "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК
9020080754 6581463

СЗХ 2021 .01 сар 06 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ 2020 -11- 12 БҮРТГЭВ-02

журам" баталснаар хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах эрх зүйн орчин бүрдсэн.

2020 оны байдлаар "МИК ОССК" ХХК-ийн үүсгэн байгуулсан тусгай зориулалтын компаниудын 23 удаагийн үнэт цаасжуулалтаар нийт 4 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас болон "Жимобайл вексель" ХХК-ийн 7 тэрбумын үнэт цаасыг Хороонд бүртгүүлсэн байна.

Банк, санхүүгийн байгууллагаас бусад төрлийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуй нэгжүүдэд, тухайлбал үүрэн холбоо, интернэт, телевизийн суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргаж санхүүжилт татах боломжийг Хорооны дээрх журмын 3.21.2.-т олгосон байна.

Хорооны 2018 оны 310 дугаар тогтоолоор "Санхүүгийн зохицуулах хорооны стратеги, төлөвлөгөө (2018-2021 он)"-г баталсан бөгөөд уг төлөвлөгөөний 4.1.-т "Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлж санхүүгийн зах зээлийг тэлэх зорилт" дэвшүүлсэн байна. Уг зорилтын хүрээнд "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийг сонгодог хэлбэрээр хөгжүүлэх чиглэлээр талуудтай хамтран ажиллана" хэмээн тусгажээ. Өнөөгийн байдлаар Засгийн газрын дотоодын үнэт цаасны нийлүүлэлт зогссон учир арилжааны банкнууд Төв банкны үнэт цаас худалдаж авах нь ихэссэн бөгөөд 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн Монгол банкнаас гаргадаг мэдээгээр нийт 4,5 их наяд төгрөгт хүрсэн. Энэ нь хөрөнгийн зах зээлд бодлогын хүүгээс илүү өгөөжтэй тогтмол орлоготой бүтээгдэхүүнд хөрөнгө оруулалт хийх бүрэн боломж байгааг харуулна.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК
9020080754 6581463

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020 -11- 12
БҮРТГЭВ-02

2021.01.06 өдөр
БҮРТГЭВ
№ 1

# 4. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ

## 4.1 Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Үнэт цаас гаргагч "Инвескор Актив ТЗК" ХХК нь 2020 оны 05-р сарын 29-ний өдөр үүсгэн байгуулагдсан хуулийн этгээд бөгөөд Хорооны 2020 оны 08 сарын 12 өдрийн 754 тоот тогтоолоор Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг авсан болно.

***Хүснэгт 4.1*** *Үнэт цаас гаргагчийн бүртгэлийн мэдээлэл*

| | |
|---|---|
| **Үнэт цаас гаргагч:** | "Инвескор Актив ТЗК" ХХК |
| **Байгуулагдсан огноо:** | 2020 оны 05 дугаар сарын 29-ний өдөр |
| **Улсын бүртгэлд бүртгүүлсэн огноо:** | 2020 оны 06 дугаар сарын 07-ны өдөр |
| **Регистрийн дугаар:** | 6581463 |
| **Үйл ажиллагааны үндсэн чиглэл:** | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах |
| **Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ:** | 62,500,000 (Жаран хоёр сая таван зуун мянган төгрөг) |
| **Хаяг:** | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2 дугаар хороо, Сөүлийн гудамж, Твин Тауэр-1, 13 давхар |
| **Утас:** | 90060254 |
| **Э-шуудан:** | |

## 4.2 Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагчийн тухай

### 4.2.1 Үүсгэн байгуулагч, тэдгээрийн хувь эзэмшил

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсэгт заасны дагуу баталгаат үнэт цаас гаргах тусгай зориулалтын компанийг банк, банк бус санхүүгийн байгууллага, орон сууцны санхүүжилтийн компани болон Хорооноос зөвшөөрсөн санхүүгийн бусад байгууллага байгуулж болохоор заасан бөгөөд Үнэт цаас гаргагчийг Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан банк бус санхүүгийн байгууллагууд болох "Инвескор ББСБ" ХК, "Микро Кредит ББСБ" ХХК нар 2020 оны 05-р сарын 29-ний өдөр үүсгэн байгуулсан болно.

Уг үүсгэн байгуулагчид нь Үнэт цаас гаргагчийн нийт гаргасан 62,500 ширхэг хувьцааг дараах байдлаар эзэмшиж байна. Үүнд:

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК
9020080754 6581463

СРХ
он сар едөр
2021.01.06
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
Үнэт цаас гаргагчийн тухай
2020-11-12
БҮРТГЭВ-02

***Хүснэгт 4.2*** *Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчид*

| | Хувьцаа эзэмшигч | Эзэмшиж буй хувьцааны тоо | Эзэмшлийн хувь |
|---|---|---|---|
| 1 | "Инвескор ББСБ" ХК | 46,875 | 75% |
| 2 | "Микро Кредит ББСБ" ХХК | 15,625 | 25% |
| | Нийт | 62,500 | 100% |

### 4.2.2 Үүсгэн байгуулагчдын мэдээлэл

**"ИНВЕСКОР ББСБ" ХК**
Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагч болох "Инвескор ББСБ" ХК нь 2016 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг Монгол Улсын хуулийн этгээд юм. "Инвескор ББСБ" ХК нь 2019 оны 6-р сард Биржээр дамжуулан хувьцаагаа анх удаа нийтэд нээлттэй арилжаалж, хувьцаат компани болсон.

***Хүснэгт 4-3*** *Инвескор ББСБ ХК танилцуулга*

| | |
|---|---|
| **Үүсгэн байгуулагч** | "Инвескор ББСБ" ХК |
| **Үүсгэн байгуулагдсан огноо** | 2016.03.29 |
| **Регистрийн дугаар** | 6060854 |
| **Санхүүгийн Зохицуулах Хорооноос тусгай зөвшөөрөл олгосон огноо, дугаар** | 2016.05.17<br>ТЗ 101/554 Банк бус санхүүгийн үйл ажиллагаа |
| **Тусгай зөвшөөрөл хүчинтэй эсэх** | Хүчинтэй |
| **Үйл ажиллагааны чиглэл** | • Зээлийн үйл ажиллагаа<br>• Факторингийн үйлчилгээ<br>• Итгэлцлийн үйлчилгээ<br>• Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх |

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК

| | |
|---|---|
| | - Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх<br>- Төлбөрийн баталгаа гаргах |
| **Гүйцэтгэх удирдлагын мэдээлэл** | Гүйцэтгэх захирал Д.Баясгалан |
| **Хаяг** | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2 дугаар хороо, Сөүлийн гудамж, Твин Тауэр-1, 13 давхар |
| **5 болон түүнээс дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч, эзэмшлийн хувь хэмжээ** | Монгол улсын хуулийн этгээд "Эс Ай Би Жэй Капитал" ХХК - 85% |

**"МИКРО КРЕДИТ ББСБ" ХХК**
Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагч болох "Микро Кредит ББСБ" ХХК нь 2014 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг Монгол Улсын хуулийн этгээд болно.

***Хүснэгт 4-4*** *Микро Кредит ББСБ ХК танилцуулга*

| | |
|---|---|
| **Үүсгэн байгуулагч** | "Микро Кредит ББСБ" ХХК |
| **Үүсгэн байгуулагдсан огноо** | 2014.09.01 |
| **Регистрийн дугаар** | 5877997 |
| **Санхүүгийн Зохицуулах Хорооноос тусгай зөвшөөрөл олгосон огноо, дугаар** | 2014.10.21<br>ТЗ 101/414 Банк бус санхүүгийн үйл ажиллагаа |
| **Тусгай зөвшөөрөл хүчинтэй эсэх** | Хүчинтэй |
| **Үйл ажиллагааны чиглэл** | - Зээлийн үйл ажиллагаа<br>- Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх<br>- Итгэлцлийн үйлчилгээ |
| **Гүйцэтгэх удирдлагын мэдээлэл** | Гүйцэтгэх захирал Г.Булганчимэг |

*Хүснэгт 4-4 Микро Кредит ББСБ ХК танилцуулга үргэлжлэл*

| | |
|---|---|
| **Хаяг** | Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө, 7/2 байр, 101 тоот |
| **5 болон түүнээс дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч, эзэмшлийн хувь хэмжээ** | Монгол улсын иргэн Т.Батзул – 50%<br>Монгол улсын иргэн Т.Тэлмэн – 50% |

## 4.3 Үнэт цаас гаргагчийн удирдлага

Үнэт цаас гаргагч нь Компанийн тухай хуулийн дагуу Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр үүсгэн байгуулагдаж байгаа тул удирдлагын тогтолцоо нь Компанийн тухай хуулиар Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлага гэсэн үндсэн тогтолцоотой байх боловч ХБҮЦ гаргах зорилгоор байгуулагдаж буй Тусгай зориулалтын компани болохын хувьд эдгээрийн эдлэх эрх, үүрэг болон хэрэгжүүлэх субъект нь ХБҮЦ-ны тухай хуулиар нарийвчлан зохицуулагдаж байна.

Компанийн тухай хууль, Хорооны "ХБҮЦ гаргах бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-ын 3.11 дэх хэсэгт заасны дагуу болон Үнэт цаас гаргагчийн Дүрмийн 6.1 дэх хэсэгт заасны дагуу Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байх бөгөөд дараах асуудлыг бүрэн эрхийн хүрээнд хэлэлцэн шийдвэрлэнэ.

- Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;
- Компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;
- ТУЗ-ийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;
- Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
- ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;
- ТУЗ-аас хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал.

Хувьцаа эзэмшигчдийн хурал нь дээрх бүрэн эрхийг хэрэгжүүлэхдээ ХБҮЦ-ны тухай хууль, Хорооны "ХБҮЦ гаргах бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам", Үнэт цаас гаргагчийн Дүрмийг дагаж мөрдөх бөгөөд ХБҮЦ-ны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.12.6-д заасны дагуу Хорооны зөвшөөрөлгүйгээр компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно.

Түүнчлэн Хувьцаа эзэмшигчид нь ХБҮЦ-ны тухай хуулиар зохицуулагдах тусгай зориулалтын компанийн хувьцаа эзэмшигчийн хувьд Компанийн тухай хуульд заасан хувьцаа эзэмшигчийн зарим эрхийг хязгаарлагдмал хүрээнд эдлэх болохоо гэрээгээр хүлээн зөвшөөрсөн /Хувьцаа эзэмшигчдийн гэрээний 4.2.4/ бөгөөд ХБҮЦ-ны тухай хууль, Хорооны "ХБҮЦ гаргах бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам", Үнэт цаас гаргагчийн Дүрэмд заасан доор дурдсан болон бусад хязгаарлалтын хүрээнд эрхээ хэрэгжүүлнэ. Үүнд:

СЗХ 2021 .01 сар 0.3 өдөр БҮРТГЭВ № 01
2020-11-12 БҮРТГЭВ-02
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL 6317839 1119277128 УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК

2020 -11- 12
БҮРТГЭВ-02
СЗХ
2021 .01. 06
БҮРТГЭВ

- Хорооноос урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр өөрийн хувьцаагаа худалдах, арилжих, барьцаалах эсхүл шилжүүлэх эрхгүй байна. / ХБҮЦ-ны тухай хуулийн 12.7, Үнэт цаас гаргагчийн Дүрмийн 3.3/
- ХБҮЦ-ны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Компанийн эсрэг өөрийн гаргасан шаардлага эсхүл түүний өмнө Компанийн хүлээх аливаа үүрэг, хариуцлагатай холбоотойгоор ямар нэгэн хууль зүйн маргаан үүсгэх, хянан шийдвэрлэх ажиллагаа эхлүүлэх, Компанид хариуцлага хүлээлгэхээр санал гаргах буюу санал өгөх, эсхүл Дүрэмд зааснаас бусад тохиолдолд Компанийг татан буулгахаар хүсэлт гаргахыг хориглоно. /Үнэт цаас гаргагчийн дүрмийн 3.4/

### 4.3.1 Төлөөлөн удирдах зөвлөл

**Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх**

ХБҮЦ-ны тухай хууль болон Хорооны "ХБҮЦ гаргах бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-д Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн талаар зохицуулсан бөгөөд уг журмын 3.12 дахь хэсэгт "ТЗК-ийн үйл ажиллагааг ТУЗ удирдаж, хяналт тавих бөгөөд энэхүү үүргийг тодорхой гэрээний дагуу бусад этгээдээр гүйцэтгүүлж болно. ТУЗ-ийн гишүүн нь 3 болон түүнээс дээш байх ба нийт гишүүдийн олонх нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.8-д заасан шаардлага хангасан хараат бус этгээд байна. " гэж заасан байдаг. Үнэт цаас гаргагчийн Дүрмийн 4.2 дахь хэсэгт заасны дагуу Компани нь 3 (гурав) гишүүн бүхий Төлөөлөн удирдах зөвлөлтэй байх бөгөөд бүрэн эрх нь Компани татан буугдах буюу "ТУЗ-ийн үйл ажиллагааны журам"-д заасан үндэслэлээр бүрэн эрхийг дуусгавар болгох хүртэл хугацаанд үргэлжлэхээр зохицуулсан байна.
Үнэт цаас гаргагчийн Дүрмийн 4.2.1 дэх хэсэгт заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээний асуудлаас гадна дүрэмд заасан дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

- Компанийн дүрмийн хэрэгжилтийг хангуулах;
- Хэлцэл эрхлэн гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсны үндсэн дээр Компанийн өдөр тутмын удирдлагыг гүйцэтгүүлэх;
- Компанийн хөрөнгийг Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн эзэмшил, удирдлагад шилжүүлэх, хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээг байгуулснаас хойш хууль тогтоомжид заасны дагуу хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглоно;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасан эрх үүргийн хэрэгжилтэд хяналт тавих;
- Дүрэмд заасан Компанийн зөвшөөрөгдсөн ажил хэрэг болон үйл ажиллагаатай холбоотой гэрээ болон бусад баримт бичиг байгуулах;
- Компанийн нэр дээр банкны данс нээлгэх, аудит болон нягтлан бодох бүртгэлийг удирдан хянахтай холбоотой болон Компанийн зардлын төлбөрийн төсвийг батлах;
- Компанийн худалдан авсан зээлийн хөрөнгөд үйлчилгээ үзүүлж буй этгээдийн гүйцэтгэлийг хянах, шаардлагатай бол тэдгээрийг солих санал гаргах;
- Компани нь өөрийн байгуулсан гэрээ болон бусад баримт бичгүүдээр хүлээсэн үүргээ чанд мөрдөж, гүйцэтгэж байгаад хяналт тавьж, хангуулах;
- Компанийн байгуулсан гэрээ болон бусад баримт бичгүүдээр Компанид олгогдсон бүх эрх болон эрх хамгаалах хэрэгслийг хэрэгжүүлэх;
- Хууль, СЗХ-ны журам болон Дүрэм, "ТУЗ-ийн үйл ажиллагааны журам"-д заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэх.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК
9020080754 6581463

## Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам

Үнэт цаас гаргагчийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2020 оны 06-р сарын 09-ний 20/01 тоот шийдвэрээр "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ыг баталсан бөгөөд ТУЗ-ийн үндсэн чиг үүрэг, бүрэн эрх, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх этгээдэд тавигдах шаардлага, гишүүдийг сонгох журам, хараат бус гишүүний шалгуур үзүүлэлт, ТУЗ-ийн гишүүдийн эрх, үүрэг, ТУЗ-ийн хурлын зарыг хүргэх, хуралд оролцох, санал өгөх, үүргээ зохих түвшинд хэрэгжүүлээгүй гишүүнд хүлээлгэх хариуцлага болон ТУЗ-ийн бусад үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулсан байна.
Тус журмын 6.1 дэх хэсэгт заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөл нь сард нэг удаа ээлжит хурал хуралдуулах бөгөөд ээлжит бус хурлыг ТУЗ-ийн дарга, түүний гишүүд, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч, Хэлцэл эрхлэн гүйцэтгэгчийн санаачилга, шаардлагаар хэдийд ч зарлан хуралдуулж болохоор байна.

## Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд

"Инвескор Актив ТЗК" ХХК-ийн үүсгэн байгуулагчдын 2020 оны 05-р сарын 29-ний өдрийн 01 тоот шийдвэрээр тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг томилсон байна.

***Хүснэгт 4-5*** *Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд*

| | ТУЗ-ийн гишүүдийн нэр | Албан тушаал |
|---|---|---|
| 1 | Батдэлгэр овогтой Хишигтөр | ТУЗ-ийн дарга, Хараат бус гишүүн |
| 2 | Шанив овогтой Цэрэндаваа | ТУЗ-ийн гишүүн |
| 3 | Батхуяг овогтой Энхмарал | ТУЗ-ийн хараат бус гишүүн |

## Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн товч танилцуулга



### ТУЗ-ийн дарга, хараат бус гишүүн Б.Хишигтөр

Б.Хишигтөр нь Монгол Улсын Их Сургуульд Хүний генетикийн чиглэлээр бакалавр, БНСУ-ын Сонмун Их Сургуульд Олон Улсын эдийн засаг чиглэлээр бизнесийн удирдлагын магистрын зэрэг хамгаалсан. Тэрээр АНУ-ын American Insurance Corp, Тэнгэр Даатгал, Монгол Даатгал зэрэг байгууллагад ажиллаж байсан туршлагатай бөгөөд одоогоор Амар Даатгалд Даатгалын газрын захирлаар ажилладаг.

2020-11-12
БҮРТГЭВ-02
2021.01.06



ТУЗ-ийн гишүүн Ш.Цэрэндаваа

Ш.Цэрэндаваа нь Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийг нягтлан бодох бүртгэлийн бакалавр, МУИС-Эдийн Засгийн Сургуулийг Банк санхүүгийн чиглэлээр Бизнесийн удирдлагын магистрын зэрэг тус тус хамгаалсан. Банк санхүүгийн салбарт 24 жил ажилласан туршлагатай тэрээр Ардын банк, СББ Банк, Анод Банк, Кредит Монгол ББСБ, Голомт Банканд тус тус ажилласан байсан туршлагатай, одоогоор "Инвескор ББСБ" ХК-д Санхүүгийн газрын захирлаар ажилладаг.



ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Энхмарал

Б.Энхмарал нь МУИС-Хууль Зүйн Сургуульд Олон улсын эрх зүйн чиглэлээр бакалавр, Английн Лондон Хотын Их Сургуульд Олон улсын худалдааны эрх зүйн чиглэлээр хууль зүйн магистрын зэрэг тус тус хамгаалсан. "Өмгөөлийн И Эл Би Партнерс" ХХН-д хуульч, өмгөөлөгч, нөхөрлөлийн гишүүнээр ажиллаж байсан туршлагатай бөгөөд, одоогоор "Инвескор Капитал ҮЦК" ХХК-д Хөрөнгө оруулалтын зөвлөхөөр ажилладаг.

**ТУЗ-ийн нарийн бичгийн дарга**

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.12.5 дахь хэсэг, Хорооны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-ын 3.17 дахь хэсэгт тус тус заасны дагуу Үнэт цаас гаргагч нь хөдөлмөрийн гэрээгээр ажилтан авч ажиллуулах хориотой бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийг Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Үнэт цаас гаргагчтай байгуулсан Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлэх гэрээ болон Үнэт цаас гаргагчийн баталсан "Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааны журам", "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-д заасны дагуу хэрэгжүүлнэ.

## 4.4 Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан/эхлэлтийн тайлан Үнэт цаас гаргагчийн удирдлага

***Хүснэгт 4-6*** *Үнэт цаас гаргагчийн эхлэлтийн тайлан*

| № | Үзүүлэлтийн нэр | Актив | Пассив |
|---|---|---|---|
| 1 | Мөнгөн хөрөнгө | 62,500,000 | |
| 2 | Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө | | 62,500,000 |
| | **Тэнцэл** | **62,500,000** | **62,500,000** |

## 4.5 Санхүүгийн төсөөлөл

ТЗК-ийн Үйлчилгээ үзүүлэгчдээс сар тутам хүлээн авах Хөрөнгийн багцын эргэн төлөлтийн орлого, төлөвлөгдсөн зардалд үндэслэн мөнгөн урсгалын төсөөллийг боловсруулсан болно. Мөнгөн урсгалын төсөөллийн дагуу ТЗК нь ирээдүйд үүсэх хуваарьт төлбөрүүдийг тасалдалгүй төлөх боломжтой бөгөөд, тасалдал үүсэхээс сэргийлэх арга хэрэгслүүдийг авсан болно. Гэвч төсөөлөлд нөлөөлж болохуйц эрсдэлүүд үүсэж болох бөгөөд мөнгөн урсгалын төсөөлөл нь заавал биелэх албагүй, зөвхөн төсөөлөл өгөх зорилготой юм.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2021.01.06
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020-12-28
БҮРТГЭВ

### 4.5.1 Орлогын төсөөлөл

***Хүснэгт 4 7** Үнэт цаас гаргагчийн Орлогын төсөөлөл /сая төгрөг/*

| | Улирал 0 | Улирал I | Улирал II | Улирал III | Улирал IV | Улирал V | Улирал VI | Улирал VII | Улирал VIII |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Зээлийн хүү төлөлтийн орлого | 82.7 | 332.2 | 302.8 | 270.8 | 235.9 | 197.9 | 163.7 | 137.6 | 97.6 |
| А Транч ХБҮЦ-ны хүүгийн төлбөр | - | **(142.8)** | **(107.1)** | **(91.8)** | **(76.5)** | **(61.2)** | **(45.9)** | **(30.6)** | **(15.3)** |
| Б Транч ХБҮЦ-ийн хүүгийн төлбөр | - | **(25.2)** | **(18.9)** | **(16.2)** | **(13.5)** | **(10.8)** | **(8.1)** | **(5.4)** | **(2.7)** |
| Удирдлагын зардал | **(62.4)** | **(22.4)** | **(19.9)** | **(17.4)** | **(20.7)** | **(12.4)** | **(9.9)** | **(7.4)** | **(10.7)** |
| Төлбөр цуглуулах үйлчилгээний зардал | - | **(16.0)** | **(13.2)** | **(13.2)** | **(13.2)** | **(13.2)** | **(13.1)** | **(12.7)** | **(10.8)** |
| Зээлийн эрсдэл | Зээлдэгчийн зээл авахыг хүссэн өргөдлийн эрсдэлийн түвшинд шинжилгээ хийж, зөвшөөрөгдөхүйц эрсдэл бүхий зээлийг сонгох болно. Зээлийн эрсдэлийг урьдчилан тооцоолох, болзошгүй эрсдэлээс сэргийлэх үүднээс зээлийн үнэлгээг тогтмол хийдэг. Зээлийн үйл ажиллагааны болзошгүй эрсдэлийг нарийн тодорхойлох, түүнийг хэрхэн зайлуулах талаар арга хэмжээ авч хэрэгжүүлдэг.Зээлийг хянахдаа дараах хүчин зүйлүүдийг анхаарна. Үүнд:<br>• Эрсдэлийн талаарх үнэлгээ<br>• Зээл төлөлт графикийн дагуу явж байгаа эсэх<br>• Олгогдсон зээлийн зориулалт<br>• Зээлдэгчийн бизнесийн үйл ажиллагааны явц<br>• Зээлийн гэрээний үүргийг дагаж мөрдөж байгаа эсэх |
| Үйл ажиллагааны эрсдэл | Компани нь зээлийн үйл ажиллагаанд нөлөөлж болох гадаад хүчин зүйлсийн нөлөөллийг үнэлж, учирч болох эрсдэлийн түвшнийг тооцон, хязгаар үзүүлэлтийг тогтоож, зээлийн үнэ цэний бууралт, чанарын удирдлагын арга аргачлалыг сайжруулан, эрсдэлтэй зээлд баримтлах зарчим, арга ажиллагааг тодорхойлж, хэрэгжүүлэн ажилладаг. Мөн зээлийн хяналт, мониторингийн системийг автоматжуулан зээлийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг бууруулан ажилладаг. |

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ББСБ ХХК
9020080 6581463

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020-11-12
БҮРТГЭВ-02

# 7. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ

Үйлчилгээ үзүүлэгч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д заасны дагуу Зээлдэгчтэй харилцаж, хөрөнгийн багцтай холбоотой төлбөрийг цуглуулан ТЗК-д шилжүүлэх, бүртгэх, тайлагнах болон Үйлчилгээ үзүүлэх гэрээнд заасан хөрөнгийн багцтай холбоотой бусад үйлчилгээ, үйл ажиллагаа эрхлэхээр ТЗК-тай Үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулсан хуулийн этгээд байх ба Инвескор Актив ТЗК нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нартай харилцан тохирсны үндсэн дээр тэдгээр компаниуд болох Инвескор ББСБ, Микро Кредит ББСБ нартай Үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулсан байна. Багцын зээлийн хүүгийн болон үндсэн төлбөрийг Зээлдэгчдээс цуглуулж Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу ТЗК-ийн тогтсон дансанд шилжүүлэх үйлчилгээг Үйлчилгээ үзүүлэгчийн хувиар Инвескор ББСБ, Микро Кредит ББСБ нар үзүүлнэ. Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу Үйлчилгээ үзүүлэгчид нь зээлийн эргэн төлөлтийг өөрсдийн Төлбөр цуглуулах дансанд цуглуулж, сар тутам ТЗК-ийн Төлбөр гүйцэтгэх дансанд шилжүүлэх ба ТЗК нь Сарын төлбөр төлөх хуваарийн дагуу бүрэн төлөгдсөн Багцын эргэн төлөлт (зээлийн хүүгийн болон үндсэн төлбөр)-ийн дүнгийн 2%-тай тэнцэх хэмжээгээр Төлбөр цуглуулах үйлчилгээний хөлсийг улирлаар буюу сараар хуримтлуулан Үйлчилгээ үзүүлэгчид төлнө.

Хэрэв Үйлчилгээ үзүүлэгч нь "Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих журам"-д заасан шаардлагыг хангахгүй болсон эсвэл журамд заасан бусад үндэслэл бий болсон тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Үйлчилгээ үзүүлэх гэрээг цуцлан 1 сараас ихгүй хугацаанд багтаан уг журамд заасан шаардлага хангахуйц дараагийн Үйлчилгээ үзүүлэгчийг сонгон Үйлчилгээ үзүлэх гэрээ байгуулан ажиллуулна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
Хөрөнгө итгэмжлэн удирдагч
2020-11-12
БҮРТГЭВ-02

# 8. ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧ

## 8.1 Ерөнхий танилцуулга, тусгай зөвшөөрөл авсан тухай мэдээлэл

Хөрөнгө итгэмжлэн удирдагч болох "Рэдбэрал инвестмент энд менежмент" ХХК нь 2011 онд хөрөнгө оруулалт менежментийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх зорилготойгоор үүсгэн байгуулагдсан. 2013 оны 3-р сарын 13-нд Хорооны 74 дугаар тогтоолоор үнэт цаасны зах зээл дээр "Харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил үйлчилгээ" эрхлэх тусгай зөвшөөрлийг авч, үйл ажиллагаа явуулж байгаад 2016 оноос эхлэн зөвлөх үйлчилгээг түлхүү үзүүлж ирсэн байна. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, харилцагчийн үнэт цаас болон бусад хөрөнгийг итгэмжлэн удирдах үйл ажиллагааны чиглэлээр ажиллаж байгаа болно.

| | |
|---|---|
| **Хөрөнгө итгэмжлэн удирдагч** | Рэдбэрал Инвестмент энд Менежмент" ХХК |
| **Үүсгэн байгуулагдсан огноо** | 2011.10.03 |
| **Регистрийн дугаар** | 5520266 |
| **Санхүүгийн Зохицуулах Хорооноос тусгай зөвшөөрөл олгосон огноо, дугаар** | 2020 оны 08-р сарын 12<br>752 |
| **Тусгай зөвшөөрөл хүчинтэй эсэх** | Хүчинтэй |
| **Үйл ажиллагааны чиглэл** | Хөрөнгө итгэмжлэн удирдах |
| **Гүйцэтгэх удирдлагын мэдээлэл** | Гүйцэтгэх захирал Б.Намуугэрэл |
| **Хаяг** | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дугаар хороо, Олимп гудамж-5, Аюуд Тауэр 1503 тоот |
| **5 болон түүнээс дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч, эзэмшлийн хувь хэмжээ** | Монгол улсын иргэн С.Оргилмаа – 100% |

**"Рэдбэрал Инвестмент энд Менежмент" ХХК нь дараах бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлдэг болно.**

### Баталгаат үнэт цаас гаргах ТЗК-ийн хөрөнгийг итгэмжлэн удирдах

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн дагуу Тусгай оруулагчийн зориулалтын компанийн гаргасан Баталгаат үнэт цаасыг хөрөнгө эрх ашигт нийцүүлэн эзэмших, удирдах, хөрөнгө оруулагчид шаардлагатай тайлан, мэдээг гаргаж өгөх, хөрөнгийг удирдах буюу хөрөнгөоруулагчийн эрх ашгийг хамгаалах, түүний хүсэл сонирхолд нийцүүлэн худалдан авах ажиллагааг хянах, хэрэгжүүлэх үйлчилгээ.

### Харилцагчийн үнэт цаас болон бусад хөрөнгийг итгэмжлэн удирдах

Гадаад, дотоодын иргэн болон хуулийн этгээдийн олгосон итгэмжлэл, даалгаврын дагуу эзэмшиж буй хөрөнгөнд нь хяналт тавих, холбогдох тайлан, мэдээллийг тогтмол илгээх, хууль журмаар хориглоогүй аливаа хэлцэл харилцагчийг төлөөлөн оролцох, холбогдох судалгаа шинжилгээг хийх, хөрөнгийн өгөөжийг өсгөн нэмэгдүүлэх, шинээр хөрөнгө оруулалт хийхэд зуучлах, хууль эрхзүй болон татварын асуудлуудыг шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх зэрэг үйлчилгээ багтана.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020-11-12
БҮРТГЭВ-02



2021.01.06

## 8.2 Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн санхүүгийн байдал

***Хүснэгт 8-1*** *Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн санхүүгийн байдал*

| Санхүүгийн үзүүлэлт | 2017.12.31 | 2018.12.31 | 2019.12.31 |
|---|---|---|---|
| Хөрөнгө | | | |
| Эргэлтийн хөрөнгийн дүн | 351,982,067.22 | 1,042,450,179.75 | 795,346,505.13 |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 26,077,456.90 | 183,159,082.99 | 168,047,703.98 |
| **Нийт хөрөнгийн дүн** | **378,059,524.12** | **1,225,609,262.74** | **963,394,209.11** |
| Богино хугацаат өр төлбөрийн дүн | 185,199,550.40 | 158,690,779.62 | 170,479,016.22 |
| Урт хугацаат өр төлбөрийн дүн | 0.00 | 123,416,404.23 | 114,395,460.71 |
| Өр төлбөрийн нийт дүн | 185,199,550.40 | 282,107,183.85 | 284,874,476.93 |
| Өмч | 400,000,000.00 | 1,150,000,000.00 | 1,150,000,000.00 |
| Эздийн өмчийн дүн | 192,859,973.72 | 943,502,078.89 | 678,519,732.18 |
| **Өр төлбөр ба эздийн өмчийн дүн** | **378,059,524.12** | **1,225,609,262.74** | **963,394,209.11** |

## 8.3 Компанийн Удирдлага

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Компанийн тухай хуулийн дагуу хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр үүсгэн байгуулагдсан бөгөөд удирдлагын тогтолцоо нь тус компанийн дүрэмд заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага гэсэн бүтэцтэй байна.

### 8.3.1 Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх

Компанийн тухай хууль, Хорооны "ХБҮЦ гаргах бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-ын 3.11 дэх хэсэгт заасны дагуу болон Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байх бөгөөд тухай хууль, Хорооны "ХБҮЦ гаргах бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-ын 3.11 дэх хэсэгт заасны дагуу болон Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна.

### 8.3.2 Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх

Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн дүрэмд заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн эрх барих дээд байгууллага байхаар заасан байх бөгөөд 3 болон түүнээс дээш тооны гишүүнтэй байхаар заажээ. Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурлыг улиралд 1-ээс доошгүй удаа хийхээр заасан байх ба ээлжит бус хурлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга зарлан хуралдуулахаар заасан байна.

Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн дүрэмд заасны дагуу Компанийн хэтийн чиглэл стратегийг тодорхойлох, хянаж үзэх, эрсдэлийн удирдлагын бодлого болон бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийг батлах, гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөх, гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөл, цалин урамшууллыг тогтоох, аудитын байгууллага сонгон аудит хийлгэх, ногдол ашиг хуваарилах болон бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр байна.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277126
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
Хөрөнгө итгэмжлэн удирдагч
2020-11-12
БҮРТГЭВ-02

СЗХ
2021.01.06

### 8.3.3 ТУЗ-ийн гишүүд

"Рэдбэрал Инвестмент энд Менежмент" ХХК- Төлөөлөн удирдах зөвлөл нь дараах гишүүдтэй байна.

***Хүснэгт 8-2*** *Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн ТУЗ-ийн гишүүд*

| № | ТУЗ-ийн гишүүдийн нэр | Албан тушаал |
|---|---|---|
| 1 | Галсан овогтой Сурахбаяр | ТУЗ-ийн дарга |
| 2 | Пүрэв овогтой Ариунаа | ТУЗ-ийн хараат бус гишүүн |
| 3 | Төмөрбаатар овогтой Энхболд | ТУЗ-ийн гишүүн |

## 8.4 Хөрөнгө итгэмжлэн удирдах журам

Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь "Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааны журам"-ыг 2020 оны 08-р сарын 05-ны өдөр баталсан байна.

Уг журмын дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Үнэт цаас эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, хөрөнгийг холбогдох гэрээ болон журамд заасны дагуу шударгаар, зохих ёсоор итгэмжлэн удирдах, аливаа байдлаар зүй бусаар захиран зарцуулах, ашиглахгүй байх, өөрийн үйл ажиллагааг ТЗК-ийн ТУЗ-д тогтмол тайлагнаж байх, зөвхөн зөвшөөрөгдсөн үйл ажиллагааг явуулж, өөрт олгогдсон эрх хэмжээг хэтрүүлэн ашиглахгүй байх, хэлцэл эрхлэн гүйцэтгэгчийн хувиар болон хөрөнгө итгэмжлэн удирдагчийн хувиар ТЗК-ийг төлөөлж, ТЗК-д үйлчилгээ үзүүлэхдээ Компани болон түүнтэй холбоотой этгээдүүдийн эрх ашгийг өөрийн эрх ашгийн урд тавих зарчмыг үйл ажиллагаандаа удирдлага болгохоор заасан байна.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь дараах үйл ажиллагааг явуулж, Үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлнэ. Үүнд:

- Хөрөнгийн багцыг удирдах, хяналт тавих;
- Хөрөнгө багц дахь хөрөнгөд өөрчлөлт оруулах хасах;
- Хөрөнгийн багц дах хөрөнгийг зохих журмын дагуу солих, багцаас хасах,
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах зэргээр захиран зарцуулах;
- Үнэт цаас эзэмшигчид болон эрх бүхий этгээдэд тайлан мэдээлэл өгөх;
- Үнэт цаас гаргагчид тайлан мэдээлэл өгөх;
- Төлбөр гүйцэтгэх дансанд цугларсан хөрөнгөд хяналт тавих;
- Үнэт цаас эзэмшигчдэд Үнэт цаасны төлбөр төлөх;
- Компанийн үйл ажиллагаанд зориулж зардал гаргах;
- Үйлчилгээ үзүүлэгчийн Төлбөр цуглуулах дансыг барьцаалах;

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ТЗК-ийн өмнөөс Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс хөрөнгө хүлээн авах ба хөрөнгийн багц дахь данс бүртгэлийг өөрийн бусад зээлийн данс бүртгэлээс тусад нь хөтөлж, Үйлчилгээ үзүүлэгчээс зээлийн хөрөнгийн эргэн төлөлт, данс бүртгэлтэй холбоотой тайланг авч, тулган баталгаажуулах бөгөөд багцын хөрөнгөд өөрчлөлт оруулах, хасах, нэмэх ажиллагааг Үнэт цаас гаргагчийг төлөөлөн хийж гүйцэтгэнэ.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ТЗК-ийн ТУЗ-өөс 2020 оны 08-р сарын 05-ны өдөр баталсан "Үнэт цаасны төлбөр төлөх, цуглуулах журам"-д заасны дагуу ТЗК-ийн дансанд цугларсан мөнгөн хөрөнгийг энэхүү танилцуулгын 4.5.2 дахь хэсэгт бичсэний дагуу захиран зарцуулах, үнэт цаас эзэмшигчдэд үнэт цаасны төлбөр төлөх ажиллагааг хийж гүйцэтгэнэ.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК
9020080754 6581463

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCH...
2020 -11- 12
БҮРТГЭВ-02



2021.01.06 өдөр ...ЭВ

ТЗК нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу гүйцэтгэх удирдлага болон ажилтангүй тул Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг дараах байдлаар удирдлагаар хангана. Үүнд:

- Компанийн нягтлан бодох бүртгэл хөтөлж, тайлан гаргах зэргээр нягтлан бодогчийн үүрэг гүйцэтгэх, Компанийн ТУЗ, холбогдох эрх бүхий байгууллага болон үнэт цаас эзэмшигчдэд тайлан мэдээ хүргэх ажиллагааг хийж гүйцэтгэнэ.

- Компанийн нарийн бичгийн үйлчилгээг үзүүлэх, Төлөөлөн удирдах зөвлөлийн болон хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах, хурлаас гарах шийдвэр тогтоолын төслийг боловсруулах, тэмдэглэл хөтлөх, хурлаар батлагдсан тогтоол шийдвэрийг хадгалах, хувийг эрх бүхий байгууллагад хүргүүлэх зэрэг ажиллагааг хийж гүйцэтгэнэ.

- "Эрсдэлийн удирдлага, дотоод хяналт хэрэгжүүлэх, эрсдэлийн сан байгуулах, сангийн хөрөнгийг зарцуулах тухай журам"-д заасны дагуу эрсдэлийн удирдлага хэрэгжүүлж, уг журамд заасны дагуу эрсдэлийг үнэлэн тодорхойлж, Үнэт цаас гаргагчийн ТУЗ-д мэдэгдэх бөгөөд уг ажиллагааг хийж гүйцэтгэх орон тооны Эрсдэл хариуцсан ажилтан ажиллуулна.

- Компанийн шаардсан болон Компанитай гэрээгээр тохиролцсон бусад үйлчилгээг үзүүлнэ.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь өөрийн ажлыг ТЗК-ийн ТУЗ-д сар тутам тайлагнаж байх бөгөөд ТУЗ нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйл ажиллагаа, ажлын гүйцэтгэлд тогтмол хяналт тавьж, үүрэг өгч, биелэлтийг нь шалгана.

## 8.5 Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг солих, үйл ажиллагааг зохицуулах журам

Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь "Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн сонгох, солих журам"-ыг 2020 оны 08-р сарын 05-ны өдөр баталсан байна.

ТЗК болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн байгуулсан Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлэх гэрээнд заасны дагуу дараах үндэслэлээр ТЗК-ийн санаачилгаар Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай байгуулах гэрээг цуцлахаар заажээ. Үүнд:

- Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тусгай зөвшөөрөл цуцлагдах, татан буугдах нөхцөл байдал үүссэн;

- Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлэх гэрээнд заасан ноцтой зөрчил гаргасан, эсхүл үүргээ биелүүлээгүй бөгөөд үүргийн зөрчил арилгах тухай ТЗК-ийн мэдэгдлийг хүлээн авсан болов зөрчлийг арилгаагүй;

- Гэрээнд заасан үйлчилгээг цаашид үзүүлэх боломжгүй болсон;
- "Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн сонгох, солих журам"-д заасан хөрөнгө итгэмжлэн удирдагчид тавигдах шаардлагыг хангахгүй болсон.

ТЗК нь "Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн сонгох, солих журам"-д заасны дагуу дээр заасан үндэслэл болон хууль тогтоомж, төрийн эрх бүхий байгууллагаас шаардсанаас бусад тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай байгуулсан

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК
9020080... 6581463

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020 -11- 12
БҮРТГЭВ-02

гэрээг цуцлахгүй бөгөөд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ТЗК-ийн урьдчилан бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр гэрээг цуцлах эрхгүй тийнхүү цуцалсан тохиолдолд ТЗК болон үнэт цаас эзэмшигчдэд учирсан хохирлыг төлж барагдуулах үүрэг хүлээсэн байна.

Уг журам болон гэрээнд заасны дагуу ТЗК нь гэрээ цуцлах тухай мэдэгдэл хүргүүлснээс хойш 1 сараас ихгүй хугацаанд багтаан шинэ хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгон томилох бөгөөд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь тийнхүү шинээр томилогдох хүртэл хугацаанд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хууль тогтоомж болон энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ хэвийн, урьдын адил гүйцэтгэх бөгөөд шинэ хөрөнгө итгэмжлэн удирдагчтай хөрөнгийн багцын данс бүртгэл болон банк дахь дансны үлдэгдлийг тулган баталгаажуулж, үнэт цаас болон Хөрөнгийн багцтай холбоотой баримт бичгийг шилжүүлэх үүрэгтэй байна.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК
9020080754 6581463

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020-11-12
БҮРТГЭВ-02



СЗХ
он 2021 сар 01, 06 өдөр
БҮРТГЭВ
№ 01

# 9. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

## 9.1 Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааг зохицуулах хууль эрх зүйн зохицуулалт

Үнэт цаас гаргагч нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийн хувьд Монгол Улсын хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа дагаж мөрдөх бөгөөд дараах хууль тогтоомжийн холбогдох хэсэг нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааг зохицуулна. Үүнд:

| Эрх зүйн актын төрөл | Хууль тогтоомж |
|---|---|
| Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааг зохицуулах ерөнхий хууль тогтоомж | • Иргэний хууль, 2002<br>• Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, 2001<br>• Компанийн тухай хууль, 2011<br>• Татварын ерөнхий хууль, 2019<br>• Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, 2019<br>• Хувь хүний орлогын албан татварын тухай хууль 2019<br>• Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль, 2009<br>• Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, 2013 |
| Үнэт цаас гаргагчийн үнэт цаас гаргах үйл ажиллагааг зохицуулах хуулиуд | • Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, 2013<br>• Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, 2010 |
| Үнэт цаас гаргагчийн үнэт цаас гаргах үйл ажиллагааг зохицуулах Хорооны журмууд | • Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам, 2011<br>• Үнэт цаасны бүртгэлийн журам, 2015<br>• Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг тусгай тэмдэглэл хийж бүртгэх тухай журам, 2013<br>• Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам, 2015<br>• Үнэт цаасны зах зээл дэх дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээлэх журам, 2019<br>• Үнэт цаасанд нэгдсэн дугаар олгох журам, 2010 |
| Үнэт цаас гаргагчийн үнэт цаас гаргах үйл ажиллагааг зохицуулах Биржийн журмууд | • Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам, 2020<br>• Үнэт цаасны бүртгэлийн журам, 2018<br>• Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам, 2018<br>• Арилжааны журам, 2017 |
| Үнэт цаас гаргагчийн үнэт цаас гаргах үйл ажиллагааг зохицуулах ҮЦТХТ-ийн журмууд | • Үнэт цаасны хадгаламжийн журам, 2020<br>• Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бүртгэх үйл ажиллагааны журам, 2019 |

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

ИНВЕСКОР АКТИВ ХХК

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
Хууль эрх зүйн орчин
2020 -11- 12
БҮРТГЭВ-02

2021 .01. 06

## 9.2 Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон Хөрөнгийн багцтай холбоотой хууль эрх зүйн зохицуулалтууд

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид нь банк бус санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдүүдийн хувьд тэдгээрийн үйл ажиллагааг дараах нарийвчилсан хууль тогтоомжоор зохицуулдаг болно.

| Эрх зүйн актын төрөл | Хууль тогтоомж |
|---|---|
| Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн үйл ажиллагааг тусгайлан зохицуулах хуулиуд | • Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, 2002<br>• Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, 2001<br>• Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, 2013<br>• Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль, 2019<br>• Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль, 2015 |
| Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн үйл ажиллагааг зохицуулах Хорооны журмууд | • Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам, 2016<br>• Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хорогдуулах, шинээр хувьцаа гаргах, худалдах, шилжүүлэхэд мөрдөх журам , 2020<br>• Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журамд түр хугацаанд өөрчлөлт оруулах тухай журам, 2020<br>• "Банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам" батлах тухай журам, 2020<br>• Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам, 2019 |

Үнэт цаас гаргагчийн санал болгож буй баталгаат үнэт цаасыг баталгаажуулж буй Хөрөнгийн багцтай холбоотой харилцааг дараах хууль тогтоомжийн холбогдох хэсгээр зохицуулж байна.

- Иргэний хууль, 2002
- Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль, 2015
- Автотээврийн тухай хууль, 1999
- Автотээврийн хэрэгслийн бүртгэл, улсын дугаар олгох журам, 2019

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

ИНВЕСКОР АКТИВ ҮЦК ХХК
9020080794 6581463

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020 -11- 12
БҮРТГЭВ-02



СЗХ
2021 .01. 06
БҮРТГЭВ
01

### 9.2.1 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаастай холбоотой эрх зүйн зохицуулалт

Монгол Улсын хэмжээнд үнэт цаасыг нийтэд санал болгон гаргах, арилжих, бүртгэх, төлбөр, тооцоог гүйцэтгэх, хадгалахтай холбоотой харилцааг зохицуулж буй хууль тогтоомж нь 2013 онд батлагдсан Үнэт цаасны зах зээлийн тухай хууль бөгөөд тус хуулийн 3-р зүйлийн 3.2 дахь хэсэгт "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг гаргах, арилжихтай холбогдсон нийтлэг харилцааг энэ хуулиар, нарийвчилсан харилцааг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль тогтоомжийн дагуу зохицуулна" гэж заасны дагуу тус үйл ажиллагааг тусгайлан нарийвчилж зохицуулах зорилгоор Монгол Улсын Их Хурлаас 2011 онд Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийг баталжээ.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1дэх хэсэгт "Энэ хуулийн зорилт нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах,түүнд хяналт тавих, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино" гэж заасан байх ба уг хуулиар хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч болон оролцогч этгээдүүдэд тавигдах шаардлага, хөрөнгийн багцад тавигдах шаардлага, баталгаат болон барьцаат үнэт цаас гаргах оролцогчдын хоорондын эрх зүйн харилцаа, эрх үүрэг, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах асуудлыг тусгайлан зохицуулсан юм.

Үнэт цаас гаргах үйл ажиллагаанд зөвшөөрөл олгох, зохицуулах төрийн эрх бүхий байгууллага болон үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаа явуулагч байгууллага нь мөн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэхтэй холбоотой үйл ажиллагааг тусгайлсан журмаар зохицуулжээ.

Хорооны "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 1.3 дахь хэсэгт "Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, хадгаламжийн бичиг гаргах болон бусад үүсмэл санхүүгийн хэрэгслийг бүртгэх харилцаа нь тус тусын үйл ажиллагааг нь тусгайлан зохицуулсан Хорооны журмаар зохицуулагдана" гэж заасны дагуу "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-ыг баталсан ба тус журмаар хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэх, түүнд хяналт тавих, үнэт цаас гаргагч болон уг зах зээлийн харилцаанд оролцогчдод тусгай зөвшөөрөл олгох, шалгуур үзүүлэлтийг тогтоох, эрх олгохтой холбогдсон харилцааг тусгайлан зохицуулж байна.

Түүнчлэн Биржийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 1.4 дэх хэсэгт "Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, хадгаламжийн бичиг гаргах болон бусад үүсмэл санхүүгийн хэрэгслийг бүртгэхтэй холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулахгүй бөгөөд тусгайлсан журмаар зохицуулна" хэмээн заасны дагуу "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам"-ыг баталсан байна. Уг журмаар хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг тус биржийн бүртгэлд бүртгэх, бүртгэлийн шалгуур, шаардлагыг тогтоох, бүртгэлтэй байх хугацаанд үнэт цаас гаргагчийн гаргагчийн хүлээх үүрэг, түүнд хяналт тавих, бүртгэлээс хасахтай холбогдсон харилцааг зохицуулж байна.

### 9.2.2 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн зохицуулалт

Монгол Улсын Компанийн тухай хууль нь компани үүсгэн байгуулах, бүртгүүлэх, өөрчлөн байгуулах, компанийн удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтэц, хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг тогтоох, компани татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулдаг болно. Тус хуулиар хувьцаа компани болон хязгаарлагдмал хариуцлагатай компани буюу "ХХК"-ийн хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтын асуудлыг зохицуулж, харин тусгай зориулалтын компанийн талаарх нарийвчилсан зохицуулалтыг агуулаагүй байдаг.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК
9020080754 6581463

СЭХ
2021.01.06
өдөр
ЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020-11-12
БҮРТГЭВ-02

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргагч нь тусгай зориулалтын компани байх ба тусгай зориулалтын компанийн үүсгэн байгуулагчид тавигдах шаардлага, дүрэмд тусгагдах асуудал, хориглох болон зөвшөөрөх үйл ажиллагаа, тэдгээрийг хэрэгжүүлэх субъектийн талаар тусгайлан зохицуулсан нь Компанийн тухай хуулийн зохицуулалтаас илүү нарийвчилсан буюу тусгайлан зохицуулсан зохицуулалттай байна. Тухайлбал, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу тусгай зориулалтын компани нь хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажилтан авч ажиллуулахыг хориглох бөгөөд хувьцаа эзэмшигчид нь Хорооны зөвшөөрөлгүйгээр үнэт цаас гаргагчийн хувьцааг бусдад худалдах, шилжүүлэхгүй байх, Хорооны зөвшөөрөлгүйгээр компанийн дүрэмд өөрчлөлт оруулахгүй байх зэрэг зохицуулалтуудыг тусгасан нь Компанийн тухай хуульд тусгагдаагүй онцгой харилцааг зохицуулсан байна.

Мөн Хорооны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам"-ын 3 дугаар зүйлд үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаатай холбоотойгоор түүний үүсгэн байгуулагчид тавигдах шаардлага, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд тавигдах шаардлага, төлөөлөн удирдах зөвлөлийн эрх хэмжээ, зарчим, үйл ажиллагааны тайлан мэдээ хүргүүлэх болон хөндлөнгийн аудит хийлгэх тухай нарийвчлан зохицуулсан байх тул Үнэт цаас гаргагч нь өөрийн үйл ажиллагаандаа Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон Хорооны баталсан тусгайлсан зохицуулалттай журмыг тэргүүн ээлжид мөрдөн ажиллах үүрэгтэй байна.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК
9020080754

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020-11-12
БҮРТГЭВ-02



СЗХ
2021.01.06

# 10. ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА

## 10.1 Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах

Үнэт цаасыг анхдагч зах зээлд гаргах арилжаа нь Биржийн ТУЗ-ийн 2015 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 2015/14 дугаар тогтоолоор баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам", Хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам" болон Биржийн ТУЗ-ийн 2012 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 02 тоот тогтоолоор баталсан "Арилжааны журам"-д заасны дагуу явагдана. Олон нийтэд санал болгож буй 40,000 ширхэг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг Хорооны бүртгэсэн шийдвэр гарсан өдрөөс эхлэн ажлын 7 өдөр олон нийтэд танилцуулах ажлыг зохион байгуулах ба Үнэт цаасны захиалгыг ажлын 5 хоногт авч, анхдагч арилжааг 2020 оны 3-р улиралд багтаан явуулахаар төлөвлөж байна.

***Зураг 10-1*** *Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах явц*

**1 — Бүртгүүлэх**
ХБҮЦ-ыг Хороонд бүртгүүлэх
*Өдөр 1*

**2 — Олон нийтэд танилцуулах аян**
ХБҮЦ-ыг олон нийтэд танилцуулах
*Өдөр 1 - Өдөр 7*

**3 — Захиалга авах**
Анхдагч зах зээлийн захиалга авах, захиалгын санг бүрдүүлэх
*Өдөр 8 - Өдөр 12*

**4 — Арилжаа**
Анхдагч зах зээлийн захиалгыг хааж, үнэт цаасны нийлүүлэлт хийх
*~Өдөр 13*

**5 — Төлбөр тооцоо**
Арилжааны журмын дагуу арилжааны төлбөр тооцоог гүйцэтгэх
*~Өдөр 20*

**6 — Хоёрдогч арилжаа**
Хоёрдогч арилжааг эхлүүлэх
*~Өдөр 21*

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТББ ХХК
9020080754 6581463

СЭХ
БҮРТГЭВ
№ 01
2020 -12- 28

## 10.2 Үнэт цаасны арилжаанд оролцох, захиалга авах заавар

***Зураг 10-2** Үнэт цаасны арилжаанд оролцох заавар*

| 1 | 2 | 3 |
|---|---|---|
| **Үнэт цаасны данс нээлгэх** | **Мөнгө байршуулах** | **Захиалга өгөх** |
| МХБиржид бүртгэлтэй аль нэг үнэт цаасны компанид данс нээлгэх | Үнэт цаасны дансанд доорх зааврын дагуу мөнгөн дүн болон арилжааны шимтгэлийг хамт байршуулах | Өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанидаа үнэт цаас худалдаж авах захиалга өгөх |

### Гүйлгээний заавар

**Дансны нэр:** ҮЦК-ийн нэр

**Дансны дугаар:** ҮЦК-ийн номинал дансны дугаар /Брокероос авах/

**Банкны нэр:** /Брокероос авах/

**Гүйлгээний утга:** Нэр, Регистр, Инвескор Актив ХБҮЦ

Хэрэв та **"Инвескор Капитал ҮЦК"** дээр үнэт цаасны данстай бол доорх заавраар шилжүүлнэ үү

**Дансны нэр:** Инвескор Капитал ҮЦК

**Дансны дугаар:** 495086732

**Банкны нэр:** Худалдаа Хөгжлийн Банк

**Гүйлгээний утга:** Нэр, Регистр, Инвескор Актив ХБҮЦ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ... MONGOLIAN ...
2020-12-28
БҮРТГЭВ-02

СЗХ
он 2021 сар 01 өдөр 06
БҮРТГЭВ
№ 01

## 10.3 Үнэт цаасны арилжаа, хүүгийн төлбөр, эргэн төлөлтийн график

*Хүснэгт 10-3 Үнэт цаасны төлбөрийн график*

*/Сая төгрөгөөр/*

| Огноо | А Транч | | | Б Транч | | |
|---|---|---|---|---|---|---|
| | ХБҮЦ үлдэгдэл | Үндсэн төлбөр | Хүү | ХБҮЦ үлдэгдэл | Үндсэн төлбөр | Хүү |
| Улирал 0 | 3,400.0 | | | 600.0 | | 0.0 |
| Улирал I | 2,975.0 | 425.0 | 142.8 | 525.0 | 75.0 | 25.2 |
| Улирал II | 2,550.0 | 425.0 | 107.1 | 450.0 | 75.0 | 18.9 |
| Улирал III | 2,125.0 | 425.0 | 91.8 | 375.0 | 75.0 | 16.2 |
| Улирал IV | 1,700.0 | 425.0 | 76.5 | 300.0 | 75.0 | 13.5 |
| Улирал V | 1,275.0 | 425.0 | 61.2 | 225.0 | 75.0 | 10.8 |
| Улирал VI | 850.0 | 425.0 | 45.9 | 150.0 | 75.0 | 8.1 |
| Улирал VII | 425.0 | 425.0 | 30.6 | 75.0 | 75.0 | 5.4 |
| Улирал VIII | 0.0 | 425.0 | 15.3 | 0.0 | 75.0 | 2.7 |
| **Нийт** | | **3,400.0** | **571.2** | | **600.0** | **100.8** |

**График нь зөвхөн төсөөлөл, бодит байдал дээр өөр байх боломжтой*

## 10.4 Үнэт цаас эзэмшигчийн эрх

Үнэт цаас худалдан авагч нь дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

- Үнэт цаасны үнэ болон түүнийг худалдан авахтай холбоотой шимтгэл, хураамжийн үүргийг гүйцэтгэснээр Үнэт цаасыг эзэмшилдээ шилжүүлэхийг Үнэт цаас гаргагчаас шаардах;
- Үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийг тохиролцсон хугацаанд бүрэн төлөхийг шаардах;
- Үнэт цаасны хугацаанд Үнэт цаас гаргагчийн бизнесийн болон санхүүгийн үйл ажиллагааны талаар шаардлагатай мэдээ, мэдээлэлтэй танилцах;
- Үнэт цаас гаргагч нь төлбөр гүйцэтгэх үүргийн гүйцэтгэлийг бүрэн хангах боломжгүй тохиолдолд Үнэт цаасны холбогдох үндсэн болон хүүгийн төлбөр төлөхийг шаардах;
- Үнэт цаас гаргагч хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйн улмаас учирсан хохирлыг төлүүлэхээр шаардах;
- Үнэт цаас эзэмших эрхээ гуравдагч этгээдэд шилжүүлэх, захиран зарцуулах;
- Холбогдох хууль тогтоомж, гэрээгээр тодорхойлогдох бусад эрх.

## 10.5 Б Транч Үнэт цаас эзэмшигчийн арилжааны хязгаарлалт

А болон Б Транч үнэт цаас нь үндсэн нөхцөлийн хувьд ялгаагүй боловч Б Транч Үнэт цаас эзэмшигч нь ХБҮЦ-ны хугацааны турш эзэмшлийн үнэт цаасаа бусдад шилжүүлэхгүй байх үүрэг хүлээнэ.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК
9020080 75

MONГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020-11-12
БҮРТГЭВ-02

## 10.6 Үнэт цаас гаргагчийн эрх, үүрэг

Үнэт цаас гаргагч нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- Үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийг төлбөр гүйцэтгэх хуваарийн дагуу бүрэн төлж барагдуулах;
- Үнэт цаасны танилцуулгад тусгагдсаны дагуу Үнэт цаасны хүүгийн орлогод ногдох татварыг суутган төсөвт төлөх, тайлагнах;
- Холбогдох гэрээний дагуу хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас Үнэт цаас эзэмшигчид учруулсан аливаа хохирлыг үл маргах журмаар төлж барагдуулах;
- Хөрөнгө болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны санхүүгийн нөхцөлд нөлөөлөхүйц мэдээллийг Үнэт цаас гаргагчийн "Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах журам"-д заасны дагуу Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэх;
- Холбогдох хууль тогтоомж, Гэрээгээр тодорхойлогдох бусад үүрэг.

Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны хугацааны турш аль ч үед гаргасан үнэт цаасыг бүхлээр нь эсхүл хэсэгчлэн зах зээлийн үнээр нь худалдаж авах санал гаргаж болно.

## 10.7 Татвар

Нээлттэй ХБҮЦ-ны хүүгийн орлогод тухайн орлогын дүнгээс, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 20.2.5 дахь заалт болон Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 20.1.5 дахь заалтын дагуу 5 хувийн татвар ногдуулна. Нээлттэй ХБҮЦ-ыг худалдан авснаар хөрөнгө оруулагчид очих татварын дараах дотоод өгөөж 16% байхаар тооцоологдож байна. Үнэт цаас гаргагч нь энэхүү татварыг хүү олгохдоо Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 24.1 дүгээр заалт болон Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25.1.7 дахь заалтын дагуу суутган тооцно.

Нээлттэй ХБҮЦ-ны хугацааны туршид хөрөнгө оруулагч нь үнэт цаасаа хоёрдогч зах зээл дээр худалдах тохиолдолд хувь хүний хувьд худалдаж буй үнэ нь тухайн хөрөнгө оруулагчийн уг үнэт цаасыг худалдаж авсан үнэ болон тухайн хугацаанд хуримтлагдсан хүү, холбогдох арилжаанд оролцоход гарсан зардлуудын нийлбэрээс илүү гарсан тохиолдолд хувь хүний хувьд Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 17.1.3 болон 21.2.4 дэх заалтын дагуу 10 хувиар, аж ахуйн нэгжийн хувьд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 20.1 эсвэл 20.2.7-д заасан хувь хэмжээгээр албан татвар төлнө.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛ УЛС
УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ББСБ ХХК
9020080754 6581463

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020-11-12
БҮРТГЭВ-02



СЗХ
он сар өдөр
2021 01 06
БҮРТГЭВ
№ 01

# 11. ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУДЫН МЭДЭЭЛЭЛ

## 11.1 Андеррайтер

### 11.1.1 Андеррайтерийн танилцуулга

| | |
|---|---|
| InvesCore КАПИТАЛ ҮЦК | "Инвескор Капитал ҮЦК" ХХК |
| **Регистрийн дугаар:** | 6317839 |
| **Хаяг:** | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, Сөүлийн гудамж 10/1, Твин тауэр-1, 13 давхар |
| **Утас:** | 77090077(2) |
| **И-мэйл:** | info@icapital.mn |
| **Веб хуудас:** | www.icapital.mn |

"Инвескор Капитал ҮЦК" ХХК нь Монгол Улсын хөрөнгийн зах зээлд шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох, гадаадын хөрөнгө оруулалтыг татах замаар хөрөнгийн зах зээлийн эргэлтийг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулах, дотоодын хөрөнгө оруулагчдад олон улсын хөрөнгийн зах зээлээс өгөөж хүртэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор 2018 онд үүсгэн байгуулагдсан үнэт цаасны компани юм. Тус компани нь Хорооноос үнэт цаасны брокерын үйл ажиллагаа, үнэт цаасны дилерийн үйл ажиллагаа, үнэт цаасны андеррайтерийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авсан бөгөөд банк, санхүүгийн салбар, хөрөнгийн зах зээл, хууль эрх зүй, өмгөөллийн салбарт ажиллаж байсан чадварлаг хамт олонтой бөгөөд хөрөнгийн болон үнэт цаасны зах зээл, үнэт цаас, санхүүжилт татах, хувьцаа анх удаа нийтэд нээлттэй арилжаалах /IPO/, M&A, хөрөнгө оруулалт болон бизнесийн зөвлөгөө өгөх чиглэлээр мэргэшсэн туршлагатай юм.

### 11.1.2 Андеррайтертай байгуулсан гэрээ

Үнэт цаас гаргагч, Үүсгэн байгуулагчид нь "Инвескор Капитал ҮЦК" ХХК-тай 2020 оны 06 сарын 10-ны өдөр UWSA_200610/01 тоот "Андеррайтерийн болон зөвлөх үйлчилгээний гэрээ" байгуулах замаар Үнэт цаас гаргагч нь хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг Биржээр дамжуулан нээлттэй арилжаалах ажлыг зохион байгуулах андеррайтерийн болон зөвлөх үйлчилгээг үзүүлэхээр харилцан тохиролцжээ. Андеррайтер нь уг гэрээний дагуу үнэт цаас гаргах бэлтгэл хангах зөвлөх үйлчилгээ болон үнэт цаасыг Биржээр дамжуулан нийтэд санал болгох андеррайтерийн үйлчилгээг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Хорооны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам, Биржийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас бүртгэх тухай болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн үзүүлэхээр тохирсон байна. Гэрээг 6 сарын хугацаатай байгуулсан байх ба Гэрээнд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.4.3-д заасны дагуу хөрөнгө оруулагчид тухайн үнэт цаасыг танилцуулах замаар түүнийг худалдахад шаардлагатай бүх хүчин чармайлт гаргах хэлбэрээр андеррайтерийн үйлчилгээг үзүүлэхээр заажээ.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЭЗ ХХК
9020080754 6581463

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020 -11- 12
БҮРТГЭВ-02

2021 .01. 06

Үүсгэн байгуулагчдын зүгээс Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээлийн тухай хуульд зааснаы дагуу өөрсдийн автомашины зээлийн хөрөнгийг багцалж, дараах хэмжээ бүхий хөрөнгийг Хөрөнгө шилжүүлэх гэрээний үндсэн дээр Үнэт цаас гаргагчид шилжүүлэх ба 2 транчтай гаргасан үнэт цаасны эрсдэл өндөртэй транч болох 10 хувийг худалдан авах талаар тохиролцсон байна. Андеррайтер, зөвлөх үйлчилгээний хүрээнд андеррайтер нь үнэт цаас гаргах ажлын төлөвлөгөө боловсруулах, хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр ашгийн тооцоо хийх, үнэт цаасны танилцуулга бэлтгэх, эрх бүхий этгээдэд үнэт цаасыг бүртгүүлэх хүсэлт гаргах, үнэт цаасыг танилцуулах аяныг зохион байгуулах, анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулахаар заасан байна. Андеррайтер нь өөрийн үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулах, үнэт цаас гаргагчийн зөвлөхийн хувиар хандан ажиллаж, гуравдагч этгээдтэй харилцах аливаа харилцаанд үнэт цаас гаргагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, мэдээллийн нууцлалыг хадгалах, задруулахгүй байх, задруулсан тохиолдолд хариуцлага хүлээх, үйлчилгээг ямарваа нэг байдлаар доголдолтой үзүүлсэн тохиолдолд тухайн доголдлыг өөрийн зардлаар арилгах зэрэг үүргийг тус тус хүлээсэн байна.

Үнэт цаас гаргагч нь андеррайтерт ажил, үүргээ гүйцэтгэхэд шаардагдах аливаа зөвшөөрөл, түүнчлэн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай мэдээ мэдээлэл, баримт бичгүүдийг гаргаж өгөх, үнэт цаас гаргах бэлтгэл ажлыг хариуцан гүйцэтгэх ажилтныг томилон ажиллуулах, мэдээллийг нууцлах, гэрээний үүргээ зөрчсөний улмаас андеррайтер болон аливаа гуравдагч этгээдэд учирсан хохирлыг бүрэн хариуцах, үнэт цаас гаргах үйл ажиллагааны маркетинг сурталчилгаа, танилцуулах аяны ажлыг андеррайтертай хамтран боловсруулсан маркетингийн төлөвлөгөөний явуулах бүх шаардлагатай нөхцөлийг хангах, стратегийн хөрөнгө оруулагчид танилцуулга хийх болон үнэт цаасыг нийтэд санал болгохтой холбоотойгоор танилцуулах аянд оролцох, танилцуулга хийх удирдах албан тушаалтан болон шаардлагатай мэргэжилтнүүдийг тодорхойлж, андеррайтертай хамтран ажиллуулах зэрэг үүргийг хүлээжээ.

Түүнчлэн гэрээгээр дотоод мэдээлэл эзэмшигчийн асуудлыг зохицуулсан байх бөгөөд дотоод мэдээллийг аливаа гуравдагч этгээдэд дамжуулах, худалдах, шилжүүлэх, үнэт цаас гаргагчийн хувьцааг биржээр болон гуравдагч этгээдээр дамжуулан худалдан авах, борлуулах, ашиг олох, мөн санхүүжилт татах, эрх бүхий этгээдүүд болон андеррайтерийн зөвшөөрөлгүйгээр олон нийтэд мэдээлэхийг дотоод мэдээлэл эзэмшигчид хориглосон байна. Мөн үнэт цаас гаргагч нь тогтоосон хугацаанд аливаа дотоод мэдээллийг андеррайтертай зөвшилцөлгүйгээр олон нийтэд мэдээлсэн, түүний улмаас үнэт цаасны үнэлгээнд нөлөөлөх, хөрөнгө оруулалт, санхүүжилт татах ажиллагаанд саад учруулсан, хөрөнгө оруулагчдад буруу мэдээлэл хүргэсэн болон бусад байдлаар андеррайтерийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд саад учруулсан тохиолдолд учирсан хохирлыг хариуцахаар өөрөө зохицуулжээ.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ББСЗК ХХК

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020 11 12
БҮРТГЭВ-02

СЗХ
он сар өдөр
2021 01 06
БҮРТГЭВ
№ 01

### 11.2 Зээлийн шинжилгээ гаргагч

### 11.2.1 Зээлийн шинжилгээ гаргагчийн танилцуулга

| | |
|---|---|
| BDO | "БДО Аудит" ХХК |
| **Регистрийн дугаар:** | 2546442 |
| **Хаяг:** | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Нарны зам 62, Юнэскогийн гудамж, Юнион Бюлдинг, B блок, 1502 тоот |
| **Утас:** | 77404040, 77404041 |
| **И-мэйл:** | info@bdo.mn |

БДО Аудит" ХХК нь аудит, нягтлан бодох бүртгэл, зөвлөх үйлчилгээний дэлхийн тав дахь том сүлжээ юм. БДО-ийн дэлхий даяарх 60,000 гаруй ажилчид дэлхийн 152 орон дахь 1328 салбар оффисоороо дамжуулан зөвлөх үйлчилгээ үзүүлдэг бөгөөд Монгол Улс дахь оффис нь аудит, нягтлан бодох бүртгэл, зөвлөх үйлчилгээний салбарт 15 жилийн туршлагатай "Итгэлт Аудит" ХХК-ийн суурин дээр 2012 оны 12 дугаар сард Улаанбаатар хотод үүсгэн байгуулагдсан. Тус компани нь 2012 оны 8 сарын 08-ны өдөр Хорооны 259 тоот тогтоолын дагуу үнэт цаас гаргагчид аудитын үйлчилгээ үзүүлэх эрх авсан юм. "БДО Аудит" ХХК нь 2 партнер, 40 орчим мэргэжилтнүүдтэй бөгөөд аудит ба баталгаажуулалт, үнэлгээ ба шинжилгээ, бизнесийн зөвлөх үйлчилгээ, дотоод гадаад аутсорсинг, татвар ба хууль зүйн зөвлөгөө үзүүлэх үйл ажиллагаа явуулж байна. Тус компани нь Голомт Банк, Чингис Хаан Банк, Энэржи Ресурс, Эм Си Эс, Юнител, Витафит, Би Ди Сек, Багануур, Эрдэнэс Таван Толгой, Дархан Нэхий, Инвескор ББСБ зэрэг дотоодын шилдэг аж ахуйн нэгжүүдэд үйлчилгээ үзүүлсэн туршлагатай.

### 11.2.2 Зээлийн шинжилгээ гаргагчтай байгуулсан гэрээ

"БДО Аудит" ХХК нь үнэт цаас гаргагчтай 2020 оны 06-р сарын 10-ны өдөр "Тохиролцсон горимоор ажил гүйцэтгэх гэрээ"-г байгуулсан бөгөөд тус гэрээний дагуу зээлийн шинжилгээ гаргагч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон Хорооны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-ын шалгуур үзүүлэлтийн дагуу дөрвөн тэрбум хүртэлх үнийн дүнтэй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилгоор үйлчлүүлэгчийн гаргаж өгсөн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахад барьцаалагдах зээлийн багцаас түүвэрлэн шалгаж шалгуур хангаж буй эсэхийг тогтоох, өөрийн сонгосон аргачлалын дагуу гэрээгээр тохирсон ажлын холбогдох хууль тогтоомж, "Олон Улсын Стандарт 4400"-д нийцүүлэн гүйцэтгэхээр тохирчээ.

Гэрээний дагуу "БДО Аудит" ХХК нь гэрээний хавсралтаар батлагдсан Ажлын даалгаварт заасан үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд, хичээл зүтгэл, үр дүнтэй хугацаанд нь гүйцэтгэх, үйлчлүүлэгчийн гарган өгсөн санхүүгийн баримт мэдээллийг зөвхөн гэрээт ажлын зорилгоор ашиглах, чанд нууцлах үүрэг хүлээсэн байх ба Үйлчлүүлэгч буюу Үнэт цаас гаргагч нь Зээлийн шинжилгээ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК
9020080754 658463

гаргагчид шаардлагатай санхүүгийн болон бусад баримт бичгүүдийг тохирсон цаг хугацаанд нь үнэн зөв, иж бүрэн гаргаж өгөх, үйлчилгээний цар хүрээг хязгаарласан дарамт шахалт үзүүлэхгүй байх, үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай нөхцөлөөр хангах, төлбөрийг хугацаанд нь төлөх үүрэг хүлээсэн байна.

## 11.3 Хуулийн фирм

### 11.3.1 Хуулийн фирмийн танилцуулга

| | |
|---|---|
| MDSKhanLex | "Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН |
| **Регистрийн дугаар:** | 5495997 |
| **Хаяг:** | Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай гудамж, Сентрал Тауэр, 13 давхар, 1301 тоот |
| **Утас:** | 11330048 |
| **И-мэйл:** | info@mdsa.mn |

"Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН нь 2011 онд байгуулагдсан. Тус фирмийн хуульчид нь олон улсын эрх зүйг үндэсний хууль тогтоомж, туршлагатай уялдуулан үндэсний болон олон улсын хөрөнгө оруулагчдад төрөл бүрийн салбарт эрх зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг.

"Эм Ди Эс энд ХаанЛекс" ХХН нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33.2.1-д заасан үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээр бүртгэгдсэн, үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд бөгөөд тус зах зээлээс санхүүжилт татаж буй компаниудтай хамтран ажиллаж байсан арвин туршлагатай. Үүнд, тухайлбал "Эрдэнэс Таван Толгой" ХК-ийн үнэт цаасыг олон улсын түвшинд санал болгох, Монгол, Хонг Конг, Лондонгийн хөрөнгийн биржүүд дээр хувьцааг нийтэд анх удаа санал болгох Wolf Төслийн Монголын хууль тогтоомжтой холбоотой зөвлөгөөг өгөх, эрх зүйн магадлан шалгалт хийх, хууль зүйн дүгнэлтийн төсөл боловсруулах, Монгол Улсын Хөрөнгийн Бирж дээр гаргасан анхны 100% даатгагдсан Эрчим бонд гаргах ажилд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх, хууль зүйн магадлан шалгалт хийх, хууль зүйн дүгнэлт гаргах, "ЛэндМН ББСБ" ХХК "Инвескор ББСБ" ХХК болон "Түмэн шувуут" ХХК-ийн IPO, "Хөвсгөл алтандуулга" ХК, "Сүү" ХК-ийн нэмэлт хувьцаа гаргах, "Лэнд МН ББСБ" ХК-ийн бонд, Монголын ипотекийн корпорацийн 1-13, 21, 23, 24 дэх орон сууцны ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас гаргах төсөл дээр хууль зүйн судалгаа шинжилгээ хийж, хууль зүйн дүгнэлт гаргах ажлуудыг тус тус гүйцэтгэсэн туршлагатай.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2020-11-12 БҮРТГЭВ-02
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL 6317839 1119277128 УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ББСБ ХХК 9020080754 6581403

### 11.3.2 Хууль зүйн үйлчилгээний гэрээ

"Эм Ди Эс энд Хаан Лекс" ХХН нь Үнэт цаас гаргагчтай 2020 оны 06 сарын 10-ны өдөр Д-с06320/3 дугаар бүхий "Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх гэрээ"-г байгуулжээ. Гэрээний дагуу хуулийн фирм нь Үнэт цаас гаргагчийн Биржээр нийтэд санал болгох төслийн хүрээнд Монгол Улсын хуулийн дагуу төслийн бүтэц, оролцогч талууд, тэдгээрийн хооронд үүсэх харилцаа, хөрөнгөд тавигдах шаардлага зэргийг тодорхойлох, хөрөнгийн багцад шинжилгээ хийж тайлан гаргах, төслийн хүрээнд оролцогчдын хооронд байгуулах гэрээ/гэрээний төсөл хүчин төгөлдөр, хуульд нийцсэн эсэх, Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээлэл үнэн зөв, хуульд нийцсэн эсэх талаар хууль зүйн дүгнэлт гаргах, үнэт цаасыг МХБ-д бүртгүүлэх, Хорооноос холбогдох тусгай зөвшөөрөл авахтай холбогдсон асуудлаар хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр тохиролцсон байна.

Гэрээний дагуу хуулийн фирм нь өөрийн үүрэгт ажлаа тохиролцсон хугацаанд чанарын өндөр түвшинд гүйцэтгэх, гаргасан хөндлөнгийн шинжилгээний тайлан, хуулийн дүгнэлттэй холбогдуулан шаардлагатай тохиолдолд зөвлөмж гаргах, шалгасан материалын хүрээнд тайлбар, тодруулга өгөх, танилцуулга хийх, үйлчилгээ үзүүлэхдээ үнэн бодит мэдээллээр хангах, үйлчилгээ үзүүлсэн талаар бүртгэл хөтлөх, тайлан гаргах, Үйлчлүүлэгчийн нууцыг чандлан хадгалах үүргийг тус тус хүлээсэн байна. Үнэт цаас гаргагч нь Хуулийн фирмд гэрээгээр тохиролцсон хууль зүйн үйлчилгээний хөлсийг хугацаанд нь бүрэн төлөх, үнэн зөв бодит мэдээлэл, шаардлагатай баримт, материалыг гаргаж өгөх, шаардлагатай тохиолдолд хамтран ажиллах үүргийг хүлээжээ.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020 -11- 12
БҮРТГЭВ-02

# 12. ХЭЛЦЭЛТЭЙ ХОЛБООТОЙ ГЭРЭЭ, ЖУРМУУД

### 12.1.1 Үнэт цаасжуулах хэлцлийн оролцогчидтой байгуулах гэрээнүүд

- Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид болох "Инвескор ББСБ" ХК, "Микро Кредит ББСБ" ХХК нартай Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид болох "Инвескор ББСБ" ХК, "Микро Кредит ББСБ" ХХК нартай Фидуцийн барьцааны гэрээ
- Үйлчилгээ үзүүлэгчид болох "Инвескор ББСБ" ХК, "Микро Кредит ББСБ" ХХК нартай Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ
- Хөрөнгө итгэмжлэн удирдагч болох "Рэдбэрал Инвестмент энд Менежмент" ХХК-тай Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлэх гэрээ
- Үйлчилгээ үзүүлэгчид болох "Инвескор ББСБ" ХК, "Микро Кредит ББСБ" ХХК нартай Төлбөр цуглуулах дансны барьцааны гэрээ

### 12.1.2 Үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулсан гэрээнүүд

- Анхны үүрэг гүйцэтгүүлэгчдээс шилжүүлэн авах хөрөнгийн багцад Хорооны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-ын 2.9.11 дэх хэсэгт заасны дагуу зээлийн шинжилгээ хийлгэх гэрээг "БДО Аудит" ХХК-тай
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгчдээс шилжүүлэн авах хөрөнгийн багц болон баталгаат үнэт цаас гаргах төсөлтэй холбоотойгоор хууль зүйн дүн шинжилгээ хийж, тайлан гаргуулах тухай гэрээг "Эм Ди Эс Ханлекс" ХХН-тэй
- Үнэт цаас гаргах төсөлд андеррайтерийн үйлчилгээ авах зорилгоор Андеррайтерийн болон зөвлөх үйлчилгээний гэрээ "Инвескор Капитал ҮЦК" ХХК-тай

### 12.1.3 Бусад шаардлагатай гэрээ

- Хорооны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-ын 8.1 дэх хэсэгт заасны дагуу Компанийн үйл ажиллагаанд жилд нэгээс багагүй удаа аудит хийлгэхээр Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээг "Лидер Экаунт Аудит" ХХК-тай
- Хорооны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-ын 3.20 дахь хэсэгт заасны дагуу Компанийн хөрөнгийн мэдээлэл хадгалах нэгдсэн систем хөгжүүлэх ажлыг гүйцэтгүүлэхээр Систем хөгжүүлэлтийн гэрээг "Дижитал Воркс" ХХК-тай

### 12.1.4 Журмууд

- ТУЗ-ийн үйл ажиллагааны журам
- Хөндлөнгийн аудиторыг сонгох, солих журам
- Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих журам
- Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааны журам
- Багцын хөрөнгөд өөрчлөлт оруулах, хөрөнгийг багцаас хасах тухай журам
- Эрсдэлийн удирдлага, дотоод хяналт хэрэгжүүлэх, эрсдэлийн сан байгуулах, сангийн хөрөнгийг зарцуулах тухай журам
- Үнэт цаасны төлбөр цуглуулах төлөх тухай журам
- Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах журам

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

ИНВЕСКОР АКТИВ



# ХАВСРАЛТУУД

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТВК ХХК

СЗХ
2021 .04. 06 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020 -11- 12
БҮРТГЭВ-02

# ТОХИРОЛЦСОН ГОРИМ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭТ АЖЛЫН ТАЙЛАН - ХҮОУС 4400

"Инвескор Актив" ХХК

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
...17839 ...1119277128
УЛААНБААТАР ХОТ



УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ЗК ХХК
9020080754 ... 6581463

BDO

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК

InvesCore CAPITAL

6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ



УЛААНБААТАР ХОТ

ИНВЕСКОР АКТИВ ББСБ ХХК

9020080764 6581463

# АГУУЛГА


1. Гүйцэтгэсэн горимын үр дүнгийн тайлан ..... 3
2. Гүйцэтгэлийн хураангуй ..... 4
   2.1 Ажлын гүйцэтгэл ..... 4
   2.2 Мэдээллийн эх үүсвэр ..... 4
   2.3 Тайлангийн хэрэглээ ..... 4
3. Шалгуурууд болон тохиролцсон горимууд ..... 5
   3.1 Хөрөнгийн багцад хийж гүйцэтгэсэн тохиролцсон горимууд ..... 5
   3.2 Түүвэрлэлт ..... 6
   3.3 Түүврээр сонгогдсон зээлд хийж гүйцэтгэсэн тохиролцсон горимууд ..... 7
4. Гүйцэтгэсэн тохиролцсон горимуудын үр дүн ..... 11
   4.1 Хөрөнгийн багцад хийж гүйцэтгэсэн тохиролцсон горимуудын үр дүн ..... 11
   4.2 Түүврээр сонгогдсон зээлд хийж гүйцэтгэсэн тохиролцсон горимуудын үр дүн ..... 12
   4.3 Хангагдаагүй шалгуурууд ..... 15
5. Зөвлөмж ..... 16

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
| **1.4** | Төлбөрийн дараалал<br>**Үнэт цаасны хэвийн эргэн төлөлтийн үеийн төлбөрийн дараалал**<br>ТЗК-ийн аливаа төлбөр хийхэд мөнгөн урсгалын дараах дарааллыг баримтална:<br>1. А Транчийн үнэт цаасны хүүгийн төлбөр<br>2. А Транчийн үнэт цаасны үндсэн төлбөр<br>3. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний төлбөр<br>4. Аудитын үйлчилгээний төлбөр<br>5. ТЗК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин<br>6. Б Транчийн үнэт цаасны хүүгийн төлбөр<br>7. Б Транчийн үнэт цаасны үндсэн төлбөр<br>8. Төлбөр цуглуулах үйлчилгээний төлбөр<br>9. Бусад төлбөр<br>**Үнэт цаасны төлбөр төлөгдөж дуусах үеийн төлбөрийн дараалал**<br>Үнэт цаасны төлбөр төлөгдөж дуусах үед Үнэт цаас гаргагч нь дараах дарааллыг баримталж төлбөр гүйцэтгэнэ:.<br>1. А Транчийн үнэт цаасны хүүгийн төлбөрийн үлдэгдэл | Үнэн зөв | Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлөх журам 5.1, 5.2 |



000193

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Эрсдэлийн сан | 2. А Транчийн үнэт цаасны үндсэн төлбөрийн үлдэгдэл<br>3. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний төлбөрийн үлдэгдэл<br>4. Аудитын үйлчилгээний төлбөрийн үлдэгдэл<br>5. ТЗК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалингийн төлбөрийн үлдэгдэл<br>6. Б Транчийн үнэт цаасны хүүгийн төлбөрийн үлдэгдэл<br>7. Б Транчийн үнэт цаасны үндсэн төлбөрийн үлдэгдэл<br>8. Төлбөр цуглуулах үйлчилгээний төлбөрийн үлдэгдэл<br>9. Бусад төлбөрийн үлдэгдэл<br>10. Хувьцаа эзэмшигчдэд төлөх төлбөр<br>Үүсгэн байгуулагчид нь Үнэт цаасны нийт хугацааны турш Үнэт цаасны төлбөр тасалдахаас сэргийлж, 150,000,000 төгрөгийг Үнэт цаас гаргагчийн холбогдох журмын дагуу Эрсдэлийн санд байршуулна. | Үнэн зөв | Эрсдэлийн удирдлага, дотоод хяналт хэрэгжүүлэх, эрсдэлийн сан байгуулах, сангийн хөрөнгийг зарцуулах тухай журмын 3.1.3 |
| **1.5** | Бусад бичиг баримт<br>**Үнэт цаас гаргагчаас баталж мөрдөх журмууд** | Үнэт цаасжуулах үйл ажиллагаатай холбоотойгоор Үнэт цаас гаргагчаас доорх журмуудыг баталж мөрдүүлэх бөгөөд Үнэт цаасжуулах ажиллагаанд оролцогчид болон тэдгээрийн ажилтан, албан тушаалтан болон гэрээлэгчид заавал дагаж мөрдөх үүрэгтэй:<br>1. ТУЗ-ийн үйл ажиллагааны журам | | |



"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL 6317839 1119277128 УЛААНБААТАР ХОТ
2021.04.06 өдөр БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2020-11-12 БҮРТГЭВ-02
УЛААНБААТАР ХОТ ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК 9020080754 6581463
00019

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 2. Хөндлөнгийн аудиторыг сонгох, солих журам<br>3. Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих журам<br>4. Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааны журам<br>5. Багцын хөрөнгөд өөрчлөлт оруулах, хөрөнгийг багцаас хасах журам<br>6. Эрсдэлийн удирдлага, дотоод хяналт хэрэгжүүлэх, эрсдэлийн сан байгуулах, сангийн хөрөнгийг зарцуулах журам<br>7. Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлөх журам<br>8. Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах журам | Үнэн зөв | "Инвескор актив" ХХК-ийн ТУЗ-ийн 2020.08.05-ны өдрийн 20/04 тоот тогтоол |
| | **Үнэт цаасжуулах хэлцлийн оролцогчидтой байгуулах гэрээнүүд** | **Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасжуулах үйл ажиллагааны оролцогч нартай дор дурьдсан гэрээ, хэлцлүүдийг байгуулна:**<br>1. Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ /Анхны үүрэг гүйцэтгүүлэгчидтэй/<br>2. Фидуцийн барьцааны гэрээ /Анхны үүрэг гүйцэтгүүлэгчидтэй/<br>3. Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ /Үйлчилгээ үзүүлэгчидтэй/<br>4. Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлэх гэрээ /Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай/<br>5. Төлбөр цуглуулах дансны барьцааны гэрээ /Үйлчилгээ үзүүлэгчидтэй/ | Үнэн зөв | "Инвескор актив" ХХК-ийн ТУЗ-ийн 2020.08.05-ны өдрийн 20/04 тоот тогтоол |



000195

| | | | |
|---|---|---|---|
| **Үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулсан гэрээнүүд** | 1. Зээлийн шинжилгээ хийлгэх гэрээ /"БДО Аудит" ХХК/<br>2. Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ /"Өмгөөллийн Эм Ди Эс Хаанлекс" ХХН/<br>3. Андеррайтерийн болон зөвлөх үйлчилгээний гэрээ /Үүсгэн байгуулагчид болон "Инвескор Капитал ҮЦК" ХХК-тэй гурван талт гэрээ/ | Үнэн зөв | "Инвескор актив" ХХК-ийн ТУЗ-ийн 2020.06.09-ний өдрийн 20/02 тоот тогтоол |
| **Бусад гэрээ** | 1. Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ /"Лидер Экаунт Аудит" ХХК/<br>2. "Тусгай нөхцөлтэй байгууллагын мөнгөн хадгаламжийн гэрээ" /Худалдаа Хөгжлийн Банк/ | Үнэн зөв | "Инвескор актив" ХХК-ийн ТУЗ-ийн 2020.06.09-ний өдрийн 20/02 тоот тогтоол |
| | ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД<br><br>ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ НЬ МОНГОЛ УЛСЫН "КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛЬ", "ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ", "ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ ХУУЛЬ" БОЛОН МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО БОЛОН МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ХОЛБОГДОХ ЖУРМУУДЫН ДАГУУ ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС ГАРГАЖ БАЙГАА БОЛНО. | Үнэн зөв | Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6.1 дэх хэсэг |
| | Энэхүү Үнэт цаасны танилцуулгыг Үнэт цаас гаргагчаас нэг бүр нь 400,000 (дөрвөн зуун мянган) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 4,000,000,000 /дөрвөн тэрбум/ төгрөгийн үнийн дүн бүхий 10,000 (арван мянган) ширхэг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй гаргахтай холбоотойгоор хөрөнгө оруулагчдад зориулж бэлтгэсэн болно. Үнэт цаас гаргагч "Инвескор Актив ТЗК" ХХК нь энэхүү 4.0 тэрбум төгрөгийн үнэт цаасыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч "Инвескор ББСБ" ХК болон "Микро Кредит ББСБ" ХХК-иас зээлийн багц шилжүүлэн авахад ашиглах бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь өөрийн зах зээлийг тэлж зээл олгоход ашиглана.<br><br>Энэхүү Үнэт цаасны танилцуулга нь Хөрөнгө оруулагч таны хараат бус үнэлгээ гаргах, шинжилгээ хийх ажиллагааг орлохгүй, уг ажиллагаанд тооцогдохгүй. Хөрөнгө оруулагч та Үнэт цаас гаргагч | Андеррайтерийн шинжилгээ, мэдэгдэл | |

000196

| | | | |
|---|---|---|---|
| | болоод түүний гаргаж буй үнэт цаас, холбогдох мэдээллийн талаар бие даасан хөндлөнгийн судалгаа шинжилгээг хийн санхүү, хуулийн болон бусад зохих мэргэжлийн зөвлөхүүдтэй зөвлөлдсөний үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.<br><br>Энэхүү Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан зарим ирээдүйн болон зөвхөн одоогоор цаг хугацааны шинж чанартай гаргасан мэдээлэл, мэдэгдэл, тооцоолол, төсөөлөл нь Андеррайтерийн холбогдох эх сурвалжаас цуглуулсан мэдээлэл, итгэл үнэмшил дээр тулгуурласан бөгөөд санаатайгаар ямар нэгэн мэдээллийг орхигдуулаагүй болно. Андеррайтер нь эдгээр мэдээлэл, мэдэгдэл, тооцоолол, төсөөллийг гаргахдаа аль болох үнэн зөв, шийдвэр гаргахад шаардагдах магадлалтай гэж үзсэн мэдээллийг ашиглан бодит байдалд нийцүүлэхийг зорьсон боловч мэдээллийн үнэн зөв байдалд хариуцлага хүлээхгүй бөгөөд тооцоолол, ирээдүйн төсөөллийн биелэлтэд баталгаа өгөөгүй болно. | | |
| | ҮНЭТ ЦААСЫГ МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ БҮРТГЭСЭН НЬ УГ ҮНЭТ ЦААСНЫ ЭРСДЭЛИЙН ТАЛААР АЛИВАА БАТАЛГАА ГАРГААГҮЙ БОЛОХЫГ АНХААРАХ НЬ ЗҮЙТЭЙ. ҮНЭТ ЦААС ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНЫ ХУВЬД ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ ҮЙЛДЭЛ БАЙДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА, ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛСНЫ ҮНДСЭН ДЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА. | Үнэн зөв | Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны бүртгэлийн журмын 4.6.2 дахь заалт |
| | Энэхүү үнэт цаасны танилцуулгад хөрөнгө оруулагч танд тус үнэт цаасыг худалдан авах шийдвэр гаргахад туслах шаардлагатай бүхий л мэдээллийг агуулахыг зорьсон болно. Хөрөнгө оруулагч таны шийдвэр гаргалтад танилцуулгад тусгагдсан мэдээллээс илүү дэлгэрэнгүй, нэмэлт мэдээлэл шаардлагатай болох буюу лавлаж тодруулах зүйл байвал Үнэт цаас гаргагч болон Андеррайтерт хандаж тодруулна уу. | Андеррайтерийн шинжилгээ, мэдэгдэл | |
| 2 | ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦСОН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ<br><br>**Андеррайтер** — **“Инвескор Капитал ҮЦК” ХХК**<br>InvesCore CAPITAL<br>Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, Сөүлийн гудамж 10/1, Твин тауэр-1, 13 давхар<br>Утас: (976) 77090077(2)<br>Э-шуудан: info@icapital.mn | Нийтэд нээлттэй, ил тод мэдээлэл<br><br>https://www.icapital.mn/contact | |

| | | | |
|---|---|---|---|
| | | Веб хуудас: www.icapital.mn | |
| | **Зээлийн шинжилгээ гаргагч** BDO | **"БДО Аудит" ХХК**<br>Хаяг: Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Нарны зам-62, Юнескогийн гудамж, Юнион Бюлдинг, В Блок, 15-р давхар, 1502 тоот, Улаанбаатар хот, Монгол Улс<br>Утас: (976) 77404040, (976) 77404041<br>Э-шуудан: bdo@bdo.mn<br>Вэб хуудас: www.bdo.mn | Нийтэд нээлттэй, ил тод мэдээлэл<br>https://www.bdo.mn/mn-mn/contact-us<br>2020.07.29-ний өдрийн цахим шуудан |
| | **Хуулийн фирм** MDSKhanLex | **"Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН**<br>Хаяг: Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай гудамж, Сентрал Тауэр, 13 давхар, 1301 тоот<br>Утас: (976) 330048<br>Э-шуудан: info@mdsa.mn<br>Вэб хуудас: www.mdskhanlex.com | Нийтэд нээлттэй, ил тод мэдээлэл<br>https://mdskhanlex.com/mn/contact-us-2/ |
| 3.1 | ҮНЭТ ЦААС ГАРГАХ БОЛСОН ҮНДЭСЛЭЛ/ЗОРИЛГО<br><br>Макро хүчин зүйлс<br><br>Өрийн бичиг, санхүүгийн бусад үүсмэл хэрэгслүүдийн нэгэн адил хөрөнгийн зах зээлийг хөдөлгөгч томоохон хэрэгсэл нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас юм. Олон улсад банкнуудын хөрвөх чадварыг дэмжиж, зах зээлээ тэлэх боломжоор хангадаг бөгөөд хөрөнгө оруулагчдад тооцоолж болохуйц эрсдэлээр тогтвортой өгөөж амладаг учир маш хурдацтай хөгжиж ирсэн байна.<br><br>Монгол Улсын хувьд банк санхүүгийн байгууллагууд, хөрөнгө оруулагч, даатгалын компаниуд чөлөөт эх үүсвэрээ байршуулах бүтээгдэхүүний сонголт бага байдаг, Төвбанкны үнэт цаас, Засгийн газрын үнэт цаас эсвэл валютад хөрөнгө оруулах нь түгээмэл байдаг байна. Энэ нь зах зээлээс эргээд эх үүсвэр татаж, хөрөнгө оруулалтын боломжуудыг хязгаарладаг сул талтай юм. | | Андеррайтерийн шинжилгээ |

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL 6317839 1119277128 УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2020-11-12 БҮРТГЭВ-02
2021.01.06
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК УЛААНБААТАР ХОТ 9020080754 6581463
000199

| | | |
|---|---|---|
| | Түүнчлэн 2020 оны 1-р улирал үүссэн онцгой нөхцөл байдлаас шалтгаалан Төвбанкнаас бодлогын хүүгээ буулгах бодлого баримталж, дараалан бууруулсан нь хөрөнгө оруулагчдын өгөөжийг бууруулж гадаад валютад хөрөнгө оруулах хөдөлгөөнийг улам нэмэгдүүлж байна.<br><br>Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь тодорхой шалгуурыг хангаж нэгэнт байршсан авлага буюу хөрөнгөд хөрөнгө оруулж байгаа учир хөрөнгө оруулагч нь эрсдэлээ тооцоолох боломжтой байдаг давуу талтай. Нөгөө талаар, анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь суларсан эх үүсвэрээрээ дахин хөрөнгө оруулж зах зээлээ тэлэх боломжтой байдаг тул эдийн засгийн өсөлтөд өндөр ач холбогдолтой хурдасгуур болдог.<br><br>Иймд өнөөдрийн эдийн засгийн нөхцөл байдалд хөрөнгө оруулагчдын хэрэгцээг хангаж, компаниудын хөрвөх чадварыг сайжруулах ач холбогдолтой бүтээгдэхүүн гэж үзэж байна. | |
| **3.2** | Үндэслэл/Зорилго<br><br>2017 оноос хойш Засгийн газрын төгрөгийн бондод хөрөнгө оруулах хөрөнгө оруулагчдын сонирхол нэмэгдсэн бөгөөд 2017 оны 10-р сард бондын нийлүүлэлт зогссоноос хойш дотоодын аж ахуйн нэгжүүдийн бондод хөрөнгө оруулах эрэлт нэмэгдсэн билээ. Гэсэн хэдий ч бонд гаргахад аливаа барьцаа, баталгаа эсвэл төлбөрийн тасалдлын даатгал гэх мэт баталгаа заавал шаарддаг нь зах зээлд эрэлт их байгаа ч тэр хэмжээний итгэл төрөхгүй байгааг харуулж байгаа юм. Нөгөө талаар дийлэнх бондын хөрөнгө оруулагчид нь жижиглэнгийн буюу мэргэжлийн бус хөрөнгө оруулагчид байгаа нь мөн нөлөөлөх хүчин зүйл болж байгаа билээ. | Андеррайтерийн шинжилгээ |
| | ***График*** *Error! No text of specified style in document.***-1 *Нээлттэй бондын арилжааны статистик /тэрбум төгрөг/***<br> | МХБ, СЗХ, Сангийн яам |



000199

| | | |
|---|---|---|
| | *МХБ, СЗХ, Сангийн яам* | |
| | Түүнчлэн нэлттэй бонд анхдагч зах зээлд гаргахад хувьцаа гаргахтай ижил цаг хугацаа зарцуулдаг тул компаниуд хаалттай бонд гаргах явдал ихэссээр байгаа юм. Өөрөөр хэлбэл 2017 оноос хойш харьцангуй өндөр өгөөжтэй төгрөгийн үнэт цаасанд хөрөнгө оруулдаг хөрөнгө оруулагчдад зориулан гаргадаг Засгийн газрын бондын орон зайг хаалттай бондоор нөхөж ирсэн нь арилжааны банкны зээл, хадгаламжаас бусад санхүүгийн хэрэгслийн зах зээлийг тэлж байгаа боловч нээлттэй зах зээлийг хөгжүүлэхгүй, олон нийтэд хаалттай хэвээр байгаа нь олон нийтийн хөрөнгө оруулах хэрэгцээг хангахуйц хангалттай өндөр өгөөж бүхий, эргэн төлөлтийн баталгаатай санхүүгийн хэрэгслийг зах зээлд нийлүүлэх шаардлагыг бий болгож байгаа юм. Энэ ч утгаараа сүүлийн үед Компаниуд нээлттэй бонд гаргах нь ихсэж байна. | Андеррайтерийн шинжилгээ |
| **3.3.1** | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас /нээлттэй/<br><br>**Давуу тал**<br><br>Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зөвхөн тодорхой шалгуур хангасан авлагуудыг багцлан үнэт цаасжуулснаар хөрөнгө оруулагч нар ирээдүйн эрсдэлээ зөв тооцоолох боломж олгож, харьцангуй тогтвортой өгөөж амладаг.<br>✓ Хөрвөх чадвар сайн<br>✓ Эргэн төлөлтийн мөнгөн урсгал нь тодорхой<br>✓ Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа болон эрсдэл анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс үл хамаарна<br>✓ Хөрөнгө оруулагчдын эрсдэлийг хамгаалах мөнгөн урсгалын шатлал, төлбөрийн дараалалтай | Андеррайтерийн шинжилгээ |
| **3.3.2** | **Сул тал**<br><br>Авлагын төлөлт хугацаанаас өмнө хийгдвэл ХБҮЦ-наас хүлээгдэж байсан өгөөжөөс бага өгөөж бодогдох боломжтой. Гэвч энэ нөхцөлийг түүхэн статистик, олон шатлалт үнэт цаасжуулалтын замаар бууруулдаг. Инвескор Актив ТЗК-ийн ХБҮЦ-ны хувьд Багц дахь зээлийн эргэн төлөлт хугацаанаас өмнө төлөлт хийгдэж ТЗК-ийн мөнгөн урсгалд нөлөөлөхөөр байх нөхцөлд зээлийн чанарыг алдагдуулахгүйгээр холбогдох журмын дагуу солих үүргийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид хүлээлгэсэн байна. /ҮЦТ-ын 5.7.1/ | Андеррайтерийн шинжилгээ<br><br>Багцын хөрөнгөд өөрчлөлт оруулах, хөрөнгийн багцаас хасах тухай журам |

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL 6317839 ☎1119277128 УЛААНБААТАР ХОТ
2021.01.06 өдөр БҮРТГЭВ
000200
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2020-11-12 БҮРТГЭВ-02
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК УЛААНБААТАР ХОТ 9020080754 ☎ 658463

| | | | |
|---|---|---|---|
| 3.3.3 | Олон улсын чиг хандлага<br><br>Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны баталгаа болж буй хөрөнгөөр нь 4 ангилж болно. Үүнд:<br>✓ ***Consumer*** - сургалтын, кредит картын болон авто машины зээл зэрэг хувь хүний хэрэглээний зээлийн эргэн төлөлтөөр баталгаажсан<br>✓ ***Corporate*** – олон тооны ипотекийн эсхүл бизнесийн зээлийн багцын эргэн төлөлтөөр баталгаажсан<br>✓ ***Commercial*** – үйл ажиллагааны авлага болон усан онгоц, нисдэг тэрэг зэрэг ашиг олох зорилготой техникийн лизингийн эргэн төлөлтөөр баталгаажсан<br>✓ ***Whole Business*** – франчайз, брэнд нэр зэргийн роялти эсхүл зарын самбарын түрээс гэх мэт тухайн бизнесийн үйл ажиллагааны мөнгөн урсгалаар баталгаажсан | Андеррайтерийн шинжилгээ | |
| 3.3.4 | Монгол улсын туршлага<br><br>Монгол Улсад Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль 2010 онд батлагдаж, Хорооны 2011 оны 266 дугаар тогтоолоор “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам” батлаcнаар хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах эрх зүйн орчин бүрдсэн. | Үнэн зөв | СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам |
| | 2020 оны байдлаар “МИК ОССК” ХХК-ийн үүсгэн байгуулсан тусгай зориулалтын компаниудын 23 удаагийн үнэт цаасжуулалтаар нийт 4 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас болон “Жимобайл вексель ТЗК” ХХК-ийн 7 тэрбумын үнэт цаасыг Хороонд бүртгүүлсэн байна. | Андеррайтерийн шинжилгээ | |
| | Банк, санхүүгийн байгууллагаас бусад төрлийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуй нэгжүүдэд, тухайлбал үүрэн холбоо, интернэт, телевизийн суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргаж санхүүжилт татах боломжийг Хорооны дээрх журмын 3.2[1].2.-т олгосон байна. | Үнэн зөв | СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмын 3.2[1].2 |
| | Хорооны 2018 оны 310 дугаар тогтоолоор “Санхүүгийн зохицуулах хорооны стратеги, төлөвлөгөө (2018-2021 он)”-г баталсан бөгөөд уг төлөвлөгөөний 4.1.-т “Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлж санхүүгийн зах зээлийг тэлэх зорилт” дэвшүүлсэн байна. Уг зорилтын хүрээнд “Хөрөнгөөр | Үнэн зөв | Санхүүгийн зохицуулах хорооны стратеги, төлөвлөгөө (2018-2021 он)-ний |



000201

| | | | |
|---|---|---|---|
| | баталгаажсан үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийг сонгодог хэлбэрээр хөгжүүлэх чиглэлээр талуудтай хамтран ажиллана" хэмээн тусгажээ. | | 4.1, хавсралт "Үйл ажиллагааны төлөвлөгөө ба хэмжүүр үзүүлэлтүүд"-ийн 4.1.2.9<br>http://www.frc.mn/resource/frc/uploads/file/c419590c8158306d7410b718e967542086bcf0d9.pdf |
| | Өнөөгийн байдлаар Засгийн газрын дотоодын үнэт цаасны нийлүүлэлт зогссон учир арилжааны банкнууд Төвбанкны үнэт цаас худалдаж авах нь ихэссэн бөгөөд 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн Монгол банкнаас гаргадаг мэдээгээр нийт 4,5 их наяд төгрөгт хүрсэн. Энэ нь хөрөнгийн зах зээлд бодлогын хүүгээс илүү өгөөжтэй тогтмол орлоготой бүтээгдэхүүнд хөрөнгө оруулалт хийх бүрэн боломж байгааг харуулна. | Андеррайтерийн шинжилгээ<br>https://www.mongolbank.mn/documents/brochure/brochure26.pdf | |
| **4.** | | | |
| 4.1 | **ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ**<br>**Үнэт цаас гаргагчийн мэдээлэл**<br>Үнэт цаас гаргагч "Инвескор Актив ТЗК" ХХК нь 2020 оны 05-р сарын 29-ний өдөр үүсгэн байгуулагдсан хуулийн этгээд бөгөөд Хорооны 2020 оны 08 сарын 12 өдрийн 754 тоот тогтоолоор Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг авсан болно. | Үнэн зөв | "Инвескор актив" ХХК-ийн ХЭХ-ын 2020.05.29-ний өдрийн 01 тоот шийдвэр<br>Санхүүгийн зохицуулах хорооны 2020.08.12-ны өдрийн 754 тоот тогтоол<br>2020.08.12-ны өдрийн ТЗ 315/30 тоот Тусгай |

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 ☎ 1119277128
УЛААНБААТАР ХОТ
000202
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК
УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020-11-12
БҮРТГЭВ-02
2021.01.06

| | | | |
|---|---|---|---|
| | | | зөвшөөрлийн гэрчилгээ |
| | *Хүснэгт* ***Error! No text of specified style in document.****-1 1Үнэт цаас гаргагчийн бүртгэлийн мэдээлэл*<br>**Үнэт цаас гаргагч:** "Инвескор Актив ТЗК" ХХК<br>**Байгуулагдсан огноо:** 2020 оны 05 дугаар сарын 29-ний өдөр<br>**Улсын бүртгэлд бүртгүүлсэн огноо:** 2020 оны 06 дугаар сарын 07-ны өдөр<br>**Регистрийн дугаар:** 6581463<br>**Үйл ажиллагааны үндсэн чиглэл:** Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах<br>**Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ:** 62,500,000 (Жаран хоёр сая таван зуун мянган төгрөг)<br>**Хаяг:** Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2 дугаар хороо, Сөүлийн гудамж, Твин Тауэр-1, 13 давхар<br>**Утас:** 90060254<br>**Э-шуудан:** | Үнэн зөв | "Инвескор актив" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ<br>"Инвескор актив" ХХК-ийн дүрэм<br>"Инвескор актив ТЗК" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ<br>"Инвескор актив ТЗК" ХХК-ийн дүрэм |
| **4.2.1** | **Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагчийн тухай**<br>**Үүсгэн байгуулагч, тэдгээрийн хувь эзэмшил**<br>Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсэгт заасны дагуу баталгаат үнэт цаас гаргах тусгай зориулалтын компанийг банк, банк бус санхүүгийн байгууллага, орон сууцны санхүүжилтийн компани болон Хорооноос зөвшөөрсөн санхүүгийн бусад байгууллага байгуулж болохоор заасан бөгөөд Үнэт цаас гаргагчийг Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан банк бус санхүүгийн байгууллагууд болох "Инвескор ББСБ" ХК, "Микро Кредит ББСБ" ХХК нар 2020 оны 05-р сарын 29-ний өдөр үүсгэн байгуулсан болно. | Үнэн зөв | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.4<br>"Инвескор актив" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм |



"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL 6317839 УЛААНБААТАР ХОТ
СЗХ 2021.01.06 БҮРТГЭВ
ХӨРӨНГИЙН БИРЖ STOCK EXCHANGE 2020-11-12 БҮРТГЭВ-02
000203

<table>
<tr>
<td></td>
<td>
Уг үүсгэн байгуулагчид нь Үнэт цаас гаргагчийн нийт гаргасан 62,500 ширхэг хувьцааг дараах байдлаар эзэмшиж байна. Үүнд:
Хүснэгт Error! No text of specified style in document.-2 Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчид
<table>
<tr><th>№</th><th>Хувьцаа эзэмшигч</th><th>Эзэмшиж буй хувьцааны тоо</th><th>Эзэмшлийн хувь</th></tr>
<tr><td>1</td><td>“Инвескор ББСБ” ХК</td><td>46,875</td><td>75%</td></tr>
<tr><td>2</td><td>“Микро Кредит ББСБ” ХХК</td><td>15,625</td><td>25%</td></tr>
<tr><td colspan="2">Нийт</td><td>62,500</td><td>100%</td></tr>
</table>
</td>
<td>Үнэн зөв</td>
<td>“Инвескор актив” ХХК-ийн дүрэм</td>
</tr>
<tr>
<td>4.2.2</td>
<td>
Үүсгэн байгуулагчдын мэдээлэл
InvesCore “ИНВЕСКОР ББСБ” ХК
Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагч болох “Инвескор ББСБ” ХК нь 2016 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг Монгол Улсын хуулийн этгээд юм. “Инвескор ББСБ” ХК нь 2019 оны 06-р сард Биржээр дамжуулан хувьцаагаа анх удаа нийтэд нээлттэй арилжаалж, хувьцаат компани болсон.
</td>
<td colspan="2">
Олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлэл
http://mse.mn/mn/company/553
http://old.mse.mn/mn/news/6322
</td>
</tr>
<tr>
<td></td>
<td>
Хүснэгт Error! No text of specified style in document.-3 Инвескор ББСБ ХК танилцуулга
<table>
<tr><td>Үүсгэн байгуулагч</td><td>“Инвескор ББСБ” ХК</td></tr>
<tr><td>Үүсгэн байгуулагдсан огноо</td><td>2016.03.29</td></tr>
<tr><td>Регистрийн дугаар</td><td>6060854</td></tr>
</table>
</td>
<td>Үнэн зөв</td>
<td>
“Инвескор ББСБ” ХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ
“Инвескор ББСБ” ХК-ийн улсын бүртгэлийн дэлгэрэнгүй лавлагаа
“Инвескор ББСБ” ХК-ийн ТЗ 101/554
</td>
</tr>
</table>

000204

2021 10 14 06 он сар өдөр БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2020-11-12 БҮРТГЭВ-02

“ИНВЕСКОР КАПИТАЛ” ҮЦК InvesCore CAPITAL 6317839 ☎ 1119277128 УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК 9020080 54 ☎ 581463

<table>
<tr><td></td><td><table>
<tr><td>Санхүүгийн Зохицуулах Хорооноос тусгай зөвшөөрөл олгосон огноо, дугаар</td><td>2016.05.17<br>ТЗ 101/554 Банк бус санхүүгийн үйл ажиллагаа</td></tr>
<tr><td>Тусгай зөвшөөрөл хүчинтэй эсэх</td><td>Хүчинтэй</td></tr>
<tr><td>Үйл ажиллагааны чиглэл</td><td>• Зээлийн үйл ажиллагаа<br>• Факторингийн үйлчилгээ<br>• Итгэлцлийн үйлчилгээ<br>• Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх<br>• Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх<br>• Итгэлцлийн үйлчилгээ<br>• Төлбөрийн баталгаа гаргах</td></tr>
<tr><td>Гүйцэтгэх удирдлагын мэдээлэл</td><td>Гүйцэтгэх захирал Д.Баясгалан</td></tr>
<tr><td>Хаяг</td><td>Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2 дугаар хороо, Сөүлийн гудамж, Твин Тауэр-1, 13 давхар</td></tr>
<tr><td>5 болон түүнээс дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч, эзэмшлийн хувь хэмжээ</td><td>Монгол улсын хуулийн этгээд “Эс Ай Би Жэй Капитал” ХХК 85%</td></tr>
</table></td><td></td><td>тоот тусгай зөвшөөрлийн гэрчилгээ<br>http://mse.mn/mn/company/553</td></tr>
<tr><td></td><td>Микро кредит<br>“МИКРО КРЕДИТ ББСБ” ХХК<br>Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагч болох “Микро Кредит ББСБ” ХХК нь 2014 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг Монгол Улсын хуулийн этгээд</td><td>Үнэн зөв</td><td>“Микро кредит ББСБ” ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ</td></tr>
</table>

000206

<table>
<tr><td></td><td>болно.</td><td></td><td></td></tr>
<tr><td></td><td>Хүснэгт Error! No text of specified style in document.-4 Микро Кредит ББСБ ХХК танилцуулга
<table>
<tr><td>Үүсгэн байгуулагч</td><td>“Микро Кредит ББСБ” ХХК</td></tr>
<tr><td>Үүсгэн байгуулагдсан огноо</td><td>2014.09.01</td></tr>
<tr><td>Регистрийн дугаар</td><td>5877997</td></tr>
<tr><td>Санхүүгийн Зохицуулах Хорооноос тусгай зөвшөөрөл олгосон огноо, дугаар</td><td>2014.10.21<br>ТЗ 101/414 Банк бус санхүүгийн үйл ажиллагаа</td></tr>
<tr><td>Тусгай зөвшөөрөл хүчинтэй эсэх</td><td>Хүчинтэй</td></tr>
<tr><td>Үйл ажиллагааны чиглэл</td><td>• Зээлийн үйл ажиллагаа<br>• Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх<br>• Итгэлцлийн үйлчилгээ</td></tr>
<tr><td>Гүйцэтгэх удирдлагын мэдээлэл</td><td>Гүйцэтгэх захирал Г.Булганчимэг</td></tr>
<tr><td>Хаяг</td><td>Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө, 7/2 байр, 101 тоот</td></tr>
<tr><td>5 болон түүнээс дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч, эзэмшлийн хувь хэмжээ</td><td>Монгол улсын иргэн Т.Батзул – 50%<br>Монгол улсын иргэн Т.Тэлмэн – 50%</td></tr>
</table>
</td><td>Үнэн зөв</td><td>“Микро кредит ББСБ” ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ<br>“Микро кредит ББСБ” ХХК-ийн улсын бүртгэлийн дэлгэрэнгүй лавлагаа<br>“Микро кредит ББСБ” ХХК-ийн ТЗ 101/414 тоот тусгай зөвшөөрлийн гэрчилгээ</td></tr>
<tr><td>4.3</td><td>Үнэт цаас гаргагчийн удирдлага<br>Үнэт цаас гаргагч нь Компанийн тухай хуулийн дагуу Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр үүсгэн байгуулагдаж байгаа тул удирдлагын тогтолцоо нь Компанийн тухай хуулиар</td><td>Үнэн зөв</td><td>Компанийн тухай хуулийн 9-р бүлэг</td></tr>
</table>

| | | | |
|---|---|---|---|
| | Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлага гэсэн үндсэн тогтолцоотой байх боловч ХБҮЦ гаргах зорилгоор байгуулагдаж буй Тусгай зориулалтын компани болохын хувьд эдгээрийн эдлэх эрх, үүрэг болон хэрэгжүүлэх субъект нь ХБҮЦ-ны тухай хуулиар нарийвчлан зохицуулагдаж байна. | | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль |
| | Компанийн тухай хууль, Хорооны "ХБҮЦ гаргах бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-ын 3.11 дэх хэсэгт заасны дагуу болон Үнэт цаас гаргагчийн Дүрмийн 6.1 дэх хэсэгт заасны дагуу Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байх бөгөөд дараах асуудлыг бүрэн эрхийн хүрээнд хэлэлцэн шийдвэрлэнэ.<br>✓ Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;<br>✓ Компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;<br>✓ ТУЗ-ийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;<br>✓ Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;<br>✓ ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;<br>✓ ТУЗ-аас хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал. | Үнэн зөв | Компанийн тухай хуулийн 59.1, 62.1<br>СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмын 3.11<br>"Инвескор актив" ХХК-ийн дүрмийн 6.1 |
| | Хувьцаа эзэмшигчдийн хурал нь дээрх бүрэн эрхийг хэрэгжүүлэхдээ ХБҮЦ-ны тухай хууль, Хорооны "ХБҮЦ гаргах бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам", Үнэт цаас гаргагчийн Дүрмийг дагаж мөрдөх бөгөөд ХБҮЦ-ны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.12.6-д заасны дагуу Хорооны зөвшөөрөлгүйгээр компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно | Үнэн зөв | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль<br>СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам<br>"Инвескор актив" ХХК-ийн дүрэм |
| | **Түүнчлэн Хувьцаа эзэмшигчид нь ХБҮЦ-ны тухай хуулиар зохицуулагдах тусгай зориулалтын компанийн хувьцаа эзэмшигчийн хувьд Компанийн тухай хуульд заасан хувьцаа эзэмшигчийн** | Үнэн зөв | 2020.06.09-ний өдрийн Инвескор |

000209

| | | | |
|---|---|---|---|
| | **зарим эрхийг хязгаарлагдмал хүрээнд эдлэх болохоо гэрээгээр хүлээн зөвшөөрсөн /Хувьцаа эзэмшигчдийн гэрээний 4.2.4/** бөгөөд ХБҮЦ-ны тухай хууль, Хорооны "ХБҮЦ гаргах бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам", Үнэт цаас гаргагчийн Дүрэмд заасан дор дурдсан болон бусад хязгаарлалтын хүрээнд эрхээ хэрэгжүүлнэ. Үүнд: | | актив ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн гэрээний 4.2.4<br>Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль<br>СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам<br>"Инвескор актив ТЗК" ХХК-ийн дүрмийн төсөл |
| | ✓ Хорооноос урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр өөрийн хувьцаагаа худалдах, арилжих, барьцаалах эсхүл шилжүүлэх эрхгүй байна. / ХБҮЦ-ны тухай хуулийн 12.7, Үнэт цаас гаргагчийн Дүрмийн 3.3/ | Үнэн зөв | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.7<br>"Инвескор актив ТЗК" ХХК-ийн дүрмийн 3.3 |
| | ✓ ХБҮЦ-ны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Компанийн эсрэг өөрийн гаргасан шаардлага эсхүл түүний өмнө Компанийн хүлээх аливаа үүрэг, хариуцлагатай холбоотойгоор ямар нэгэн хууль зүйн маргаан үүсгэх, хянан шийдвэрлэх ажиллагаа эхлүүлэх, Компанид хариуцлага хүлээлгэхээр санал гаргах буюу санал өгөх, эсхүл Дүрэмд зааснаас бусад тохиолдолд Компанийг татан буулгахаар хүсэлт гаргахыг хориглоно. /Үнэт цаас гаргагчийн дүрмийн 3.4/ | Үнэн зөв | "Инвескор актив ТЗК" ХХК-ийн дүрмийн 3.4 |
| **4.3.1** | **Төлөөлөн удирдах зөвлөл** | Үнэн зөв | Хөрөнгөөр баталгаажсан үнэт |

| | | | |
|---|---|---|---|
| | **Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх**<br>ХБҮЦ-ны тухай хууль болон Хорооны "ХБҮЦ гаргах бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-д Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн талаар зохицуулсан бөгөөд уг журмын 3.12 дахь хэсэгт "ТЗК-ийн үйл ажиллагааг ТУЗ удирдаж, хяналт тавих бөгөөд энэхүү үүргийг тодорхой гэрээний дагуу бусад этгээдээр гүйцэтгүүлж болно. ТУЗ-ийн гишүүн нь 3 болон түүнээс дээш байх ба нийт гишүүдийн олонх нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.8-д заасан шаардлага хангасан хараат бус этгээд байна" гэж заасан байдаг. | | цаасны тухай хуулийн 12.8<br>СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмын 3.12 |
| | Үнэт цаас гаргагчийн Дүрмийн 4.2 дахь хэсэгт заасны дагуу Компани нь 3 (гурав) гишүүн бүхий Төлөөлөн удирдах зөвлөлтэй байх бөгөөд бүрэн эрх нь Компани татан буугдах буюу "ТУЗ-ийн үйл ажиллагааны журам"-д заасан үндэслэлээр бүрэн эрхийг дуусгавар болгох хүртэл хугацаанд үргэлжлэхээр зохицуулсан байна. | Үнэн зөв | "Инвескор актив ТЗК" ХХК-ийн дүрмийн 4.2.2, 4.2.4 |
| | Үнэт цаас гаргагчийн Дүрмийн 4.2.1 дэх хэсэгт заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээний асуудлаас гадна дүрэмд заасан дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.<br>✓ Компанийн дүрмийн хэрэгжилтийг хангуулах;<br>✓ Хэлцэл эрхлэн гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсны үндсэн дээр Компанийн өдөр тутмын удирдлагыг гүйцэтгүүлэх;<br>✓ Компанийн хөрөнгийг Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн эзэмшил, удирдлагад шилжүүлэх, хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээг байгуулснаас хойш хууль тогтоомжид заасны дагуу хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглоно;<br>✓ Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасан эрх үүргийн хэрэгжилтэд хяналт тавих;<br>✓ Дүрэмд заасан Компанийн зөвшөөрөгдсөн ажил хэрэг болон үйл ажиллагаатай холбоотой гэрээ болон бусад баримт бичиг байгуулах;<br>✓ Компанийн нэр дээр банкны данс нээлгэх, аудит болон нягтлан бодох бүртгэлийг удирдан хянахтай холбоотой болон Компанийн зардлын төлбөрийн төсвийг батлах;<br>✓ Компанийн худалдан авсан зээлийн хөрөнгөд үйлчилгээ үзүүлж буй этгээдийн гүйцэтгэлийг хянах, шаардлагатай бол тэдгээрийг солих санал гаргах;<br>✓ Компани нь өөрийн байгуулсан гэрээ болон бусад баримт бичгүүдээр хүлээсэн үүргээ чанд | Үнэн зөв | "Инвескор актив ТЗК" ХХК-ийн дүрмийн 4.2.1, 4.2.6 |

<table>
<tr><td></td><td>мөрдөж, гүйцэтгэж байгаад хяналт тавьж, хангуулах;<br>✓ Компанийн байгуулсан гэрээ болон бусад баримт бичгүүдээр Компанид олгогдсон бүх эрх болон эрх хамгаалах хэрэгслийг хэрэгжүүлэх;<br>✓ Хууль, СЗХ-ны журам болон Дүрэм, "ТУЗ-ийн үйл ажиллагааны журам"-д заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэх.</td><td></td><td></td></tr>
<tr><td></td><td>Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам<br><br>Үнэт цаас гаргагчийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2020 оны 06-р сарын 09-ний 20/01 тоот шийдвэрээр "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ыг баталсан бөгөөд ТУЗ-ийн үндсэн чиг үүрэг, бүрэн эрх, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх этгээдэд тавигдах шаардлага, гишүүдийг сонгох журам, хараат бус гишүүний шалгуур үзүүлэлт, ТУЗ-ийн гишүүдийн эрх, үүрэг, ТУЗ-ийн хурлын зарыг хүргэх, хуралд оролцох, санал өгөх, үүргээ зохих түвшинд хэрэгжүүлээгүй гишүүнд хүлээлгэх хариуцлага болон ТУЗ-ийн бусад үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулсан байна.</td><td>Үнэн зөв</td><td>"Инвескор актив" ХХК-ийн ХЭХ-ын 2020.06.09-ний өдрийн 2020/01 тоот шийдвэр<br><br>"Инвескор актив" ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын 1.1</td></tr>
<tr><td></td><td>Тус журмын 6.1 дэх хэсэгт заасан дагуу Төлөөлөн удирдах зөвлөл нь сард нэг удаа ээлжит хурал хуралдуулах бөгөөд ээлжит бус хурлыг ТУЗ-ийн дарга, түүний гишүүд, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч, Хэлцэл эрхлэн гүйцэтгэгчийн санаачилга, шаардлагаар хэдийд ч зарлан хуралдуулж болохоор байна.</td><td>Үнэн зөв</td><td>"Инвескор актив" ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын 6.1, 6.2</td></tr>
<tr><td></td><td>Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд<br><br>"Инвескор Актив ТЗК" ХХК-ийн үүсгэн байгуулагчдын 2020 оны 05-р сарын 29-ний өдрийн 01 тоот шийдвэрээр тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг томилсон байна.<br><br>Хүснэгт Error! No text of specified style in document.-5 Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд<br><br><table><tr><th>№</th><th>ТУЗ-ийн гишүүдийн нэр</th><th>Албан тушаал</th></tr><tr><td>1</td><td>Батдэлгэр овогтой Хишигтөр</td><td>ТУЗ-ийн дарга, Хараат бус гишүүн</td></tr></table></td><td>Үнэн зөв</td><td>"Инвескор актив" ХХК-ийн ХЭХ-ын 2020.05.29-ний өдрийн 01 тоот шийдвэр<br><br>Инвескор актив" ХХК-ийн ХЭХ-ын 2020.06.09-ний өдрийн 2020/03 тоот шийдвэр</td></tr>
</table>



000210

| | | | |
|---|---|---|---|
| | 2 Шанив овогтой Цэрэндаваа — ТУЗ-ийн гишүүн<br>3 Батхуяг овогтой Энхмарал — ТУЗ-ийн хараат бус гишүүн | | Инвескор актив" ХХК-ийн ТУЗ-ийн 2020.06.02-ны өдрийн 2020/01 тоот тогтоол |
| | Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн товч танилцуулга<br><br>ТУЗ-ийн дарга, хараат бус гишүүн Б.Хишигтөр<br><br>Б.Хишигтөр нь Монгол Улсын Их Сургуульд Хүний генетикийн чиглэлээр бакалавр, БНСУ-ын Сонмун Их Сургуульд Олон Улсын эдийн засаг чиглэлээр бизнесийн удирдлагын магистрын зэрэг хамгаалсан. Тэрээр АНУ-ын American Insurance Corp, Тэнгэр Даатгал, Монгол Даатгал зэрэг байгууллагад ажиллаж байсан туршлагатай бөгөөд одоогоор Амар Даатгалд Даатгалын газрын захирлаар ажилладаг. | Үнэн зөв | ТУЗ-ийн гишүүн Б.Хишигтөрийн товч танилцуулга |
| | ТУЗ-ийн гишүүн Ш.Цэрэндаваа<br><br>Ш.Цэрэндаваа нь Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийг нягтлан бодох бүртгэлийн бакалавр, МУИС-Эдийн Засгийн Сургуулийг Банк санхүүгийн чиглэлээр Бизнесийн удирдлагын магистрын зэрэг тус тус хамгаалсан. Банк санхүүгийн салбарт 24 жил ажилласан туршлагатай тэрээр Ардын банк, СББ Банк, Анод Банк, Кредит Монгол ББСБ, Голомт Банканд тус тус ажилласан байсан туршлагатай, "Инвескор ББСБ" ХК-д Санхүүгийн газрын захирлаар ажилладаг. | Үнэн зөв | ТУЗ-ийн гишүүн Ш.Цэрэндаваагийн товч танилцуулга |
| | ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Энхмарал<br><br>Б.Энхмарал нь МУИС-Хууль Зүйн Сургуульд Олон улсын эрх зүйн чиглэлээр бакалавр, Английн Лондон Хотын Их Сургуульд Олон улсын худалдааны эрх зүйн чиглэлээр хууль зүйн магистрын зэрэг тус тус хамгаалсан. "Өмгөөлийн И Эл Би Партнерс" ХХН-д хуульч, өмгөөлөгч, нөхөрлөлийн гишүүнээр ажиллаж байсан туршлагатай бөгөөд "Инвескор Капитал ҮЦК" ХХК-д Хөрөнгө оруулалтын зөвлөхөөр ажилладаг. | Үнэн зөв | ТУЗ-ийн гишүүн Б.Энхмаралын товч танилцуулга |
| | ТУЗ-ийн нарийн бичгийн дарга<br><br>Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.12.5 дахь хэсэг, Хорооны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-ын 3.17 дахь хэсэгт тус тус заасны дагуу Үнэт цаас гаргагч нь хөдөлмөрийн гэрээгээр ажилтан авч ажиллуулах | Үнэн зөв | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.12.5 |

<table>
<tr>
<td></td>
<td>хориотой бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийг Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Үнэт цаас гаргагчтай байгуулсан Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлэх гэрээ болон Үнэт цаас гаргагчийн баталсан “Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааны журам”, “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-д заасны дагуу хэрэгжүүлнэ.</td>
<td></td>
<td>СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмын 3.17<br><br>Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын 6<br><br>Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааны журмын 4<br><br>Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлэх гэрээний 4.1</td>
</tr>
<tr>
<td>4.4</td>
<td>Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан/эхлэлтийн тайлан<br><br>Хүснэгт Error! No text of specified style in document.-6 Үнэт цаас гаргагчийн эхлэлтийн тайлан<br><br>
<table>
<tr><th>№</th><th>Үзүүлэлтийн нэр</th><th>Актив</th><th>Пассив</th></tr>
<tr><td>1</td><td>Мөнгөн хөрөнгө</td><td>62,500,000</td><td></td></tr>
<tr><td>2</td><td>Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө</td><td></td><td>62,500,000</td></tr>
<tr><td colspan="2">Тэнцэл</td><td>62,500,000</td><td>62,500,000</td></tr>
</table>
</td>
<td></td>
<td>Санхүүгийн мэдээлэл</td>
</tr>
</table>

000212

4.5 **Санхүүгийн төсөөлөл**

ТЗК-ийн Үйлчилгээ үзүүлэгчдээс сар тутам хүлээн авах Хөрөнгийн багцын эргэн төлөлтийн орлого, төлөвлөгдсөн зардалд үндэслэн мөнгөн урсгалын төсөөллийг боловсруулсан болно. Мөнгөн урсгалын төсөөллийн дагуу ТЗК нь ирээдүйд үүсэх хуваарьт төлбөрүүдийг тасалдалгүй төлөх боломжтой бөгөөд, тасалдал үүсэхээс сэргийлэх арга хэрэгслүүдийг авсан болно. Гэвч төсөөлөлд нөлөөлж болохуйц эрсдэлүүд үүсэж болох бөгөөд мөнгөн урсгалын төсөөлөл нь заавал биелэх албагүй, зөвхөн төсөөлөл өгөх зорилготой юм.

Андеррайтерийн шинжилгээ

4.5.1 **Орлогын төсөөлөл**

*Хүснэгт* ***Error! No text of specified style in document.****-7 Үнэт цаас гаргагчийн Орлогын төсөөлөл /сая төгрөг/*

| | Улирал 0 | Улирал 1 | Улирал 2 | Улирал 3 | Улирал 4 | Улирал 5 | Улирал 6 | Улирал 7 | Улирал 8 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Зээлийн хүү төлөлтийн орлого | 84.4 | 332.2 | 302.8 | 270.8 | 235.9 | 197.9 | 163.7 | 137.6 | 97.6 |
| А Транч ХБҮЦ-ийн хүүгийн төлбөр | | (162.5) | (121.9) | (104.5) | (87.1) | (69.6) | (52.2) | (34.8) | (17.4) |
| Б Транч ХБҮЦ-ийн | | (28.7) | (21.5) | (18.4) | (15.4) | (12.3) | (9.2) | (6.1) | (3.1) |

Андеррайтерийн шинжилгээ

Санхүүгийн мэдээлэл

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| хүүгийн төлбөр | | | | | | | | | |
| Удирдлагын зардал | (62.4) | (22.3) | (19.8) | (17.3) | (20.7) | (12.4) | (9.9) | (7.4) | (10.7) |
| Төлбөр цуглуулах үйлчилгээний зардал | | (16.0) | (13.2) | (13.2) | (13.2) | (13.2) | (13.1) | (12.7) | (10.8) |
| **Үйл ажиллагааны ашиг** | **22.0** | **102.7** | **126.3** | **117.3** | **99.6** | **90.3** | **79.3** | **76.6** | **55.7** |
| Хүүгийн орлого | | 10.5 | 9.3 | 9.4 | 9.8 | 10.6 | 11.7 | 13.8 | 14.9 |
| **Татварын өмнөх ашиг** | 22.0 | 113.2 | 135.6 | 126.6 | 109.4 | 101.0 | 91.0 | 90.3 | 70.6 |
| Татварын зардал | | (13.5) | | | | (47.3) | | | (25.2) |
| **Цэвэр ашиг** | 22.0 | 99.7 | 135.6 | 126.6 | 109.4 | 53.7 | 91.0 | 90.3 | 45.4 |



000214

InvesCore CAPITAL "ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК 6317839 111927128 УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР АКТИВ ТЭЛ" ХХК УЛААНБААТАР ХОТ 9020080754 5581463

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ-02 2020-11-12

2021.01.06 өдөр

| Хуримтлагдсан ашиг | 22.0 | 121.7 | 257.3 | 383.9 | 493.3 | 547.0 | 638.0 | 728.3 | 773.8 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|

** Улирал гэдгээр 3 сар тутмыг тодорхойлон оруулсан бөгөөд хуанлийн улирлаас зөрүүтэй байж болно.*

4.5.2

**Зардлын төсөөлөл**

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ТЗК-ийн гаргах бүх зардлыг урьдчилан тохирсон үнийн дүн, хуваарийн дагуу холбогдох гэрээнд үндэслэн зарцуулна. Хугацааны турш ТЗК нь зөвхөн дараах зардлуудыг гаргана. Үүнд:

**Удирдлагын зардал**

*Хүснэгт **Error! No text of specified style in document.**-8 ТЗК-ийн хөрөнгө багцлах үйл ажиллагаатай холбоотой гол зардлууд (нэг удаагийн)*

| | Зардлын зүйл | Дүн |
|---|---|---|
| 1 | Зээлийн шинжилгээ гаргагчийн хөлс | 31,500,000 (НӨАТ багтсан) |
| 2 | Хуулийн үйлчилгээний хөлс | 27,500,000 (НӨАТ багтсан) |
| 3 | ТЗК-ийн тусгай зөвшөөрөл авахтай холбоотой хураамж | 3,000,000 |
| | **Нийт** | **62,000,000** |

Андеррайтерийн шинжилгээ

Санхүүгийн мэдээлэл

Түүнчлэн ТЗК нь "Рэдбэрал Инвестмент энд Менежмент" ХХК-тай Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ байгуулан ТЗК-ийн бүхий л мөнгөн хөрөнгө, авлагыг захиран зарцуулах эрхийг олгосон. Энэхүү гэрээний дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдагчид дараах төлбөрийг төлнө.

Үнэн зөв

Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлэх гэрээ

*Хүснэгт **Error! No text of specified style in document.**-9 Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний зардал (улирал бүр)*

| Зардлын зүйл | Давтамж | Утга |
| --- | --- | --- |
| Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн хөлс | Улирал бүр ХБҮЦ үлдэгдлээс | 0.5% |

** Улирал гэдгээр 3 сар тутмыг тодорхойлон оруулсан бөгөөд хуанлийн улирлаас зөрүүтэй байж болно.*

Санхүүгийн мэдээлэл

Хорооны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-ын дагуу жилд 1-ээс доошгүй удаа аудит хийлгэх шаардлагатай.

Үнэн зөв

СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмын 8.1

Аудитын үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулсан гэрээний дагуу жилд 4,000,000 төгрөг төсөвлөгдсөн ба шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн шийдвэрээр нэмэлт аудит хийлгэх боломжтой.

*Хүснэгт **Error! No text of specified style in document.**-10 ТЗК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн зардал*

| Зардлын зүйл | Төлөлт | Дүн | ХБҮЦ хугацааны туршид нийт дүн |
| --- | --- | --- | --- |
| ТУЗ-ийн гишүүдийн нийт цалин | Улирал тутам | 2,100,000 | 16,800,000 |
| НДШ (үндсэн цалингийн) | Улирал тутам | 262,500 | 2,100,000 |

** Улирал гэдгээр 3 сар тутмыг тодорхойлон оруулсан бөгөөд хуанлийн улирлаас зөрүүтэй байж болно.*

Андеррайтерийн шинжилгээ

Санхүүгийн мэдээлэл

<table>
<tr><td></td><td>Төлбөр цуглуулах үйлчилгээний зардал<br><br>Үйлчилгээ үзүүлэгчид нь зээлийн эргэн төлөлтийг өөрсдийн Төлбөр цуглуулах дансанд цуглуулах бөгөөд сар тутам ТЗК-ийн Төлбөр гүйцэтгэх дансанд шилжүүлнэ. ТЗК нь Сарын төлбөр төлөх хуваарийн дагуу бүрэн төлөгдсөн Багцын эргэн төлөлт (зээлийн хүүгийн болон үндсэн төлбөр)-ийн дүнгийн 2%-тай тэнцэх хэмжээгээр Төлбөр цуглуулах үйлчилгээний хөлсийг Үйлчилгээ үзүүлэгчид төлнө. Энэхүү үйлчилгээний төлбөрийг Төлбөр цуглуулах гэрээнд заасан нөхцөлөөр 3 сар тутамд төлөх ба уг гэрээнд заасан нөхцөлөөр төлбөр хойшлуулах боломжтой.</td><td>Үнэн зөв</td><td>Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээний 2.1.1, 4.1.1, 4.1.4</td></tr>
<tr><td></td><td>Хөндлөнгийн аудитын зардал<br>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд Хорооны “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам”-ын 8.1 дэх хэсэгт заасны дагуу жилд нэгээс багагүй удаа аудит хийлгэх зорилгоор “Лидер Экаунт Аудит” ХХК-тай “Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г 2 жилийн хугацаатай байгуулсан болно. Тус гэрээний дагуу “Лидер Экаунт Аудит” ХХК-д 1 удаагийн ээлжит аудитын үйлчилгээний төлбөрт 4,000,000 /дөрвөн сая/ төгрөг төлөхөөр байна.</td><td>Үнэн зөв</td><td>“Лидер экаунт аудит” ХХК-тай 2020.06.10-ны өдөр байгуулсан “Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ”-ний 2.1, 2.2</td></tr>
<tr><td></td><td>Хүснэгт 4-11 ТЗК-ийн хөндлөнгийн аудитын зардал<br><br>Хүснэгт Error! No text of specified style in document.-11 Аудитын зардал<br><table><tr><th>Зардлын зүйл</th><th>Давтамж</th><th>Дүн</th><th>ХБҮЦ хугацааны туршид нийт дүн</th></tr><tr><td>Ээлжит хөндлөнгийн аудит хийлгэх зардал</td><td>Жилд 1 удаа</td><td>4,000,000</td><td>8,000,000</td></tr></table></td><td colspan="2">Санхүүгийн мэдээлэл</td></tr>
<tr><td>4.5.3</td><td>Мөнгөн гүйлгээний төсөөлөл<br>Хүснэгт Error! No text of specified style in document.-12 ТЗК-ийн мөнгөн урсгалын төсөөлөл /сая төгрөг/<br><table><tr><th></th><th>Улирал 0</th><th>Улирал 1</th><th>Улирал 2</th><th>Улирал 3</th><th>Улирал 4</th><th>Улирал 5</th><th>Улирал 6</th><th>Улирал 7</th><th>Улирал 8</th></tr></table></td><td colspan="2"></td></tr>
</table>

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Зээлийн эргэн төлөлтийн мөнгөн урсгал | 136.2 | 661.7 | 661.7 | 661.7 | 661.7 | 661.7 | 657.5 | 633.2 | 537.6 |
| А Транч хүүгийн төлбөр | | (162.5) | (121.9) | (104.5) | (87.1) | (69.6) | (52.2) | (34.8) | (17.4) |
| А Транч үндсэн төлбөр төлбөр | | (424.6) | (424.6) | (424.6) | (424.6) | (424.6) | (424.6) | (424.6) | (424.6) |
| Б Транч хүүгийн төлбөр | | (28.7) | (21.5) | (18.4) | (15.4) | (12.3) | (9.2) | (6.1) | (3.1) |
| Б Транч үндсэн төлбөр төлбөр | | (74.9) | (74.9) | (74.9) | (74.9) | (74.9) | (74.9) | (74.9) | (74.9) |
| Удирдлагын зардал төлсөн | (62.4) | (22.3) | (19.8) | (17.3) | (20.7) | (12.4) | (9.9) | (7.4) | (10.7) |
| Үйлчилгээний | | (16.0) | (13.2) | (13.2) | (13.2) | (13.2) | (13.1) | (12.7) | (10.8) |



000219

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| төлбөр төлсөн | | | | | | | | | |
| **Үйл ажиллагааны мөнгөн урсгал** | **73.8** | **(67.3)** | **(14.3)** | **8.7** | **25.9** | **54.6** | **73.5** | **72.6** | **(3.9)** |
| Богино хугацаат өр төлбөр авсан (Эрсдэлийн сан) | 150.0 | | | | | | | | (150.0) |
| Өөрийн хөрөнгө хөрөнгө оруулалт | 62.5 | | | | | | | | |
| Хадгаламжийн хүүгийн орлого | | 10.5 | 9.3 | 9.4 | 9.8 | 10.6 | 11.7 | 13.8 | 14.9 |
| Татварын зардал төлсөн | | (13.5) | | | | (47.3) | | | (25.2) |

Андеррайтерийн шинжилгээ

Санхүүгийн мэдээлэл

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Тайлант хугацааны цэвэр мөнгөн урсгал** | **286.3** | **(70.3)** | **(5.0)** | **18.0** | **35.6** | **18.0** | **85.2** | **86.4** | **(164.1)** |
| **Хуримтлагдсан мөнгөн урсгал** | **286.3** | **216.0** | **211.0** | **229.0** | **264.6** | **282.7** | **367.9** | **454.3** | **290.1** |
| ***Зээл төлөх чадварын харьцаа*** | | 1.37 | 1.37 | 1.40 | 1.48 | 1.59 | 1.68 | 1.85 | 1.91 |

** Улирал гэдгээр 3 сар тутмыг тодорхойлон оруулсан бөгөөд хуанлийн улирлаас зөрүүтэй байж болно.*

Андеррайтерийн шинжилгээ

Санхүүгийн мэдээлэл

Төлбөрийн дараалалд үндэслэсэн ТЗК-ийн мөнгөн урсгалын төсөөллийг Хүснэгт 4-12-д харуулав. Үндсэн орлого болох Багцын эргэн төлөлт сар бүр орж, 3 сар тутам хуримтлагдсан мөнгөн хөрөнгөнөөс зардлуудыг төлнө.

Мөнгө урсгалын төсөөлөлд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчдийн оруулах 150 сая төгрөгийн эрсдэлийн санг "Богино хугацаат өр төлбөр"-өөр бүртгэсэн. Эрсдэлийн сангийн хөрөнгийг ашиглаагүй тохиолдолд хугацааны эцэст Үүсгэн байгуулагчдад буцаан олгоно.

Мөнгөн урсгалын төсөөллийн гол үзүүлэлт болох Зээл төлөх чадварын харьцаа (хуримтлагдсан мөнгөн урсгал / нийт зээл, хүүгийн төлбөр) нь зээлжих жишиг үзүүлэлт болох 1.3х-аас их байх шалгуурыг хангаж байна.

Андеррайтерийн шинжилгээ

| | | | |
|---|---|---|---|
| 4.6 | Зөвшөөрөгдсөн дансууд<br><br>Үнэт цаас гаргагч нь Үнэт цаас гаргах өдрөөс хойш зөвхөн дор дурдсан зөвшөөрөгдсөн дансуудыг ашиглах эрхтэй байна:<br><br>✓ **Төлбөр гүйцэтгэх данс:** Төлбөр цуглуулагчийн шилжүүлсэн зээлийн төлбөрийг зөвхөн нэг тодорхой дансаар хүлээж авна. Энэхүү данс нь хуримтлалын эрхтэй, сарын дундаж үлдэгдлээс жилийн 8.4 хувийн хүү тооцогдоно.<br>✓ **Харилцах данс:** Орлого цуглуулах, хуримтлалын данснаас 3 сар тутам Үнэт цаасны хүүгийн болон үндсэн төлбөрүүд, Үйлчилгээний төлбөр, Аудитын төлбөр, ТЗК-ийн цалингийн зардал, бусад зардлыг Харилцах данс руу шилжүүлнэ. Энэ данснаас бүх төлбөрүүд хийгдэнэ. | Үнэн зөв | Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааны журмын 1.3<br><br>Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлөх тухай журмын 1.1, 3.2, 3.3, 3.4<br><br>Тусгай нөхцөлтэй байгууллагын мөнгөн хадгаламжийн гэрээний 2.1 |
| 4.7 | Үнэт цаас гаргагчийн саналаар хугацаанаас өмнө эргүүлэн худалдаж авах боломж<br><br>Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны хугацааны турш аль ч үед гаргасан үнэт цаасыг Үнэт цаас эзэмшигчээс бүхэлд нь эсхүл хэсэгчлэн зах зээлийн үнээр нь худалдаж авах санал гаргаж болно. | | Компанийн тухай хуулийн 49.1, 49.2<br><br>СЗХ-ны ХБҮЦ гаргах бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмын 2.9.4 |
| 5.1 | **ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ**<br><br>**Санал болгож буй хүүгийн түвшин болон үндэслэл**<br><br>Зах зээл дээр идэвхтэй санал болгож буй ижил төрлийн хөрөнгө оруулалтын хэрэгслүүдтэй харьцуулахад Инвескор Актив ХБҮЦ нь хугацааны турш үндсэн төлбөрийн эргэн төлөлт хийгдэх, нээлттэй арилжих зэрэг давуу талтай. Энэ нь хөрөнгө оруулагчдын эрсдэлийг бууруулж, өгөөжийг хянах, хамгийн өндөр байлгах боломжийг өгч байна. | Андеррайтерийн шинжилгээ | |

| | | |
|---|---|---|
| | *График* ***Error! No text of specified style in document.**-2 Хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн өгөөжийн харьцуулалт*<br><br>Инвескор Капитал судалгаа | Инвескор Капитал судалгаа |
| | Танилцуулгын 3.2-д дурдсанчлан хаалттай хүрээнд банк бус санхүүгийн байгууллагуудын бондын нийлүүлэлт өндөр байгаа боловч хөрөнгө оруулагчид баталгаа, үүргийн гүйцэтгэлийн бусад хэрэгслээр хангагдсан байхыг шаардаж байна. Мөн түүнчлэн хөрөнгө оруулагчдын хувьд банк бус санхүүгийн байгууллагаас гаргах компанийн бондод хөрөнгө оруулах нь хэрэглээний зээл, бизнесийн зээл гэх мэт бусад эрсдэл өндөртэй зээлүүдийн эрсдэлийг мөн хүлээх болдог. СЗХ-ны статистик мэдээллээр салбарын дундаж чанаргүй зээлийн хувь 8.4% байна. | Андеррайтерийн шинжилгээ |
| | *График* ***Error! No text of specified style in document.**-3 ББСБ Зах зээлийн мэдээлэл*<br> | СЗХ |

| | | | |
|---|---|---|---|
| | *Санхүүгийн зохицуулах хороо* | | |
| | Харин Инвескор Актив ХБҮЦ нь зөвхөн автомашины зээлийн багцаас хэвийн зээлүүдийг багцлан үнэт цаасжуулж байгаа тул эрсдэл хамгийн бага байх бөгөөд зээлийн ангилал өөрчлөгдсөн тохиолдолд анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь солих нөхцөлтэй юм. Өөрөөр хэлбэл, ТЗК-д шилжин ирэх зээлийн багцын чанаргүй зээлийн хувь үргэлж 0% байх юм. Энэ нь хөрөнгө оруулагчдын эрсдэлийг бууруулж байгаа тул өгөөжийн түвшнийг тогтоохдоо банк бус санхүүгийн байгууллагуудын бондын хүүгээс бага тогтоолоо. | Андеррайтерийн шинжилгээ<br>Багцын хөрөнгөд өөрчлөлт оруулах, хөрөнгийн багцаас хасах тухай журмын 2.2 | |
| **5.1.1** | Хөрөнгө оруулалтын өгөөж<br>А, Б транчийн хөрөнгө оруулагчдад санал болгох хүү жилийн 16.4% байна. | Үнэн зөв | "Инвескор актив ТЗК" ХХК-ийн ТУЗ-ийн 2020.08.20-ны өдрийн 20/09 тоот тогтоол |
| | Хөрөнгө оруулагчдын өгөөжийн дэлгэрэнгүй задаргааг дараах хүснэгтээс харна уу. Өгөөжийн задаргаа нь зөвхөн төсөөлөл өгөх зорилготой бөгөөд бодит утгаас зөрөх боломжтой. | Андеррайтерийн мэдэгдэл, шинжилгээ | |
| | Татварын дараах хүүгийн өгөөж 16.4%*(100-5%) 15.58% байгаа боловч хугацааны турш улирал тутам үндсэн төлбөрийн эргэн төлөлт хийгдэх учир дотоод өгөөжийн хувь 16% болно. | Андеррайтерийн шинжилгээ | |
| | *Хүснэгт **Error! No text of specified style in document.**-13 А Транч хөрөнгө оруулалтын өгөөж*<br>Анхны хөрөнгө оруулалт — 3,400.00 сая төгрөг<br>Хүүгийн орлого — 650.02 сая төгрөг<br>Хүүгийн татварын зардал 5% — 32.5* сая төгрөг<br>Дотоод өгөөжийн хувь — 16%<br>**Нээлттэй зах зээл дээр арилжигдах үнэт цаасны Хүүгийн орлогын татвар нь 5% байна.* | Андеррайтерийн шинжилгээ<br>Санхүүгийн мэдээлэл | |

| | | | |
|---|---|---|---|
| | *Хүснэгт* ***Error! No text of specified style in document.****-14 Б Транч хөрөнгө оруулалтын өгөөж*<br><br>Анхны хөрөнгө оруулалт — 600.00 сая төгрөг<br>Хүүгийн орлого — 114.71 сая төгрөг<br>Хүүгийн татварын зардал 5% — 5.73* сая төгрөг<br>Дотоод өгөөжийн хувь — 16%<br><br>**Нээлттэй зах зээл дээр арилжигдах үнэт цаасны Хүүгийн орлогын татвар нь 5% байна.* | | |
| 5.2 | **Үнэт цаасжуулах хэлцлийн зураглал**<br>Үнэт цаас гаргах үеийн Үнэт цаасжуулах хэлцлийн бүтцийг доорх зургаар дүрслэв. Хөрөнгө оруулагчдад энэхүү Үнэт цаасжуулах үйл ажиллагааны гол оролцогч, тэдгээрийн хоорондын харилцааг тоймлон харуулах зорилготой болно. | Андеррайтерийн мэдэгдэл, шинжилгээ | |
| | *Зураг* ***Error! No text of specified style in document.****-1 Үнэт цаасжуулах хэлцлийн зураглал*<br> | Үнэн зөв | Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ<br><br>Төлбөр цуглуулах үйлчилгээний гэрээ<br><br>Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээний гэрээ<br><br>Төлбөр цуглуулах дансны барьцааны гэрээ<br><br>"Инвескор актив" ХХК-ийн ТУЗ-ийн 2020.08.05-ны |

| | | | |
|---|---|---|---|
| | | | өдрийн 20/05 тоот тогтоол<br>“Инвескор актив ТЗК” ХХК-ийн ТУЗ-ийн 2020.08.20-ны өдрийн 20/09 тоот тогтоол |
| 5.3.1 | **Үнэт цаас эзэмшигчдэд төлөх төлбөрийн эх үүсвэр, төлбөрийн хуваарь**<br>**Үнэт цаас эзэмшигчдэд төлөх төлбөрийн эх үүсвэр**<br>Үнэт цаасны хүү, үндсэн төлбөрийг зөвхөн Багцын зээлийн хүү болон үндсэн төлбөрийн эргэн төлөлтийн мөнгөн урсгалаас гүйцэтгэнэ. | Үнэн зөв | Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлөх тухай журмын 5.1 |
| | Хэрэв Багцын зээлийн мөнгөн урсгалаас төлөх боломжгүй тохиолдолд Үүсгэн байгуулагчдаас байршуулсан эрсдэлийн сангийн эх үүсвэрээр төлбөрийг гүйцэтгэнэ. | Үнэн зөв | Эрсдэлийн удирдлага, дотоод хяналт хэрэгжүүлэх, эрсдэлийн сан байгуулах, сангийн хөрөнгийг зарцуулах тухай журмын 3.2 |
| | *График **Error! No text of specified style in document.**-4 Багцын зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийн төсөөлөл*<br><br> | Андеррайтерийн шинжилгээ | |

000226

| 5.3.2 | **Үнэт цаасны төлбөрийн хуваарь**<br><br>Үнэт цаасны үндсэн төлбөрийг тэнцүү төлөлттэй 8 хувааж, 3 сар тутам төлөх ба үнэт цаасны хүүг мөн 3 сар тутам үндсэн төлбөрийн үлдэгдлээс тооцож төлнө. | Үнэн зөв | "Инвескор актив ТЗК" ХХК-ийн ТУЗ-ийн 2020.08.20-ны өдрийн 20/09 тоот тогтоол |
|---|---|---|---|
| | | Андеррайтерийн шинжилгээ<br><br>Санхүүгийн мэдээлэл | |

*Хүснэгт **Error! No text of specified style in document.**-15 Хүү тооцох аргачлал*

| Үнэт цаасны төлбөрийн бодолт | |
|---|---|
| Төлбөр төлөгдөх хугацаа | Өмнөх төлбөрийн огноо (анхны төлбөрийн хувьд Худалдаж авсан өдөр) + 3 сар (хуанлийн) |
| Хүүгийн төлбөр (татварын өмнө) | (Тоо ширхэг * Нэрлэсэн үнэ * 16.4%/365 хоног ) *3 сар |
| Хүүгийн төлбөр (татварын дараа) | (Тоо ширхэг * Нэрлэсэн үнэ * 15.58%/365 хоног ) *3 сар |
| Үндсэн төлбөр | 8 тэнцүү төлөлттэй |
| Нийт төлөгдөх дүн | (1 ш * Нэрлэсэн үнэ * 15.58%/365 хоног ) *3 сар + Үндсэн төлбөр |

*Хүснэгт **Error! No text of specified style in document.**-16 Үнэт цаасны төлбөрийн график*

| Огноо | А Транч | | | Б Транч | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Нэрлэсэн үнэ | Үндсэн төлбөр | Хүү | Нэрлэсэн үнэ | Үндсэн төлбөр | Хүү |
| 2020-09 | 3,400,000,000 | | | 600,000,000 | | |



"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL 6317839 ☎ 11927128 УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК 9020080 ☎ 658446 ХОТ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2020-11-12 ЛУРПТЭБ-02
2021.01.06 өдөр БҮРТГЭВ СЗХ

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2020-12 | 2,975,000,000 | 425,000,000 | 163,460,822 | 525,000,000 | 75,000,000 | 28,846,027 |
| 2021-03 | 2,550,000,000 | 425,000,000 | 120,304,110 | 450,000,000 | 75,000,000 | 21,230,137 |
| 2021-06 | 2,125,000,000 | 425,000,000 | 104,263,562 | 375,000,000 | 75,000,000 | 18,399,452 |
| 2021-09 | 1,700,000,000 | 425,000,000 | 87,841,096 | 300,000,000 | 75,000,000 | 15,501,370 |
| 2021-12 | 1,275,000,000 | 425,000,000 | 70,272,877 | 225,000,000 | 75,000,000 | 12,401,096 |
| 2022-03 | 850,000,000 | 425,000,000 | 51,558,904 | 150,000,000 | 75,000,000 | 9,098,630 |
| 2022-06 | 425,000,000 | 425,000,000 | 34,754,521 | 75,000,000 | 75,000,000 | 6,133,151 |
| 2022-09 | 0 | 425,000,000 | 17,568,219 | 0 | 75,000,000 | 3,100,274 |
| Нийт | | 3,400,000,00<br>0 | 650,024,110 | | 600,000,000 | 114,710,137 |

*График нь зөвхөн төсөөлөл, бодит байдал дээр өөр байх боломжтой*

Андеррайтерийн шинжилгээ

Санхүүгийн мэдээлэл

| | | | |
|---|---|---|---|
| 5.4 | **Хөрөнгийн багц, багцад тавигдах шаардлага**<br>Үнэт цаасны баталгаа болох Багц нь 100% Анхны үүрэг гүйцэтгүүлэгчдийн олгосон, Багц бүрдүүлэх үед хэвийн ангилалд байгаа Автомашины зээлийн багцаас бүрдэх бөгөөд энэ Танилцуулгад агуулсан Шалгуур үзүүлэлтийг хангасан байна. | Үнэн зөв | "Инвескор актив" ХХК-ийн ТУЗ-ийн 2020.08.05-ны өдрийн 20/05 тоот тогтоол |
| | Үнэт цаасны хугацааны турш уг багцын чанар өөрчлөгдөх боломжтой бөгөөд энэ тохиолдолд энэ Танилцуулгын 5-7-д заасны дагуу багцын чанарыг сайжруулах, багцад багтсан зээлийн хөрөнгийг солих арга хэмжээ авна. | Андеррайтерийн мэдэгдэл, шинжилгээ | |
| | Зээлийн шинжилгээ гаргагч болон Хуулийн фирм нь дээрх шалгуурын дагуу Багцын бүрдэлд түүвэр шалгалт хийж тайлан гаргасан бөгөөд энэхүү Танилцуулгад тэдгээр тайланг хавсаргасан болно. | Андеррайтерийн мэдэгдэл, шинжилгээ | |
| 5.5 | **Багцын тойм**<br>Үнэт цаасжуулах хөрөнгийн багцын тасалбар болгох өдрийн байдлаарх мэдээллийг доорх байдлаар тоймлов. Шалгуур үзүүлэлт хангасан нийт 420 зээлдэгчийн 4,859,794,000 үнийн дүн бүхий 420 зээлийн гэрээг багцлахаар төлөвлөсөн болно. Эдгээр зээлийн үнэт цаас гаргах өдрийн байдлаарх үлдэгдэл нь 4.0 тэрбум төгрөгтэй тэнцэнэ гэж төлөвлөлөө. | | |

*Хүснэгт **Error! No text of specified style in document.**-17 Үнэт цаасжуулах багцын тойм*

| Үнэт цаас гаргах өдрийн байдлаарх үнэт цаасны үндсэн үзүүлэлтүүд | |
|---|---|
| Нийт зээлийн үлдэгдэл (Үнэт цаас гаргах үед) | 4,000,000,000 |
| Нийт анх олгосон зээлийн дүн | 4,859,794,000 |
| Зээлийн гэрээний тоо | 420 |
| Зээлдэгчийн тоо | 420 |
| Зээлийн дундаж үлдэгдэл | 9,639,180 |
| Хамгийн том 1 зээлийн нийт багцад эзлэх % | 1.24% |
| Хамгийн том 10 зээлийн нийт багцад эзлэх % | 8.33% |
| Хамгийн том 50 зээлийн нийт багцад эзлэх % | 28.33% |
| **Жигнэсэн дундаж** | |
| Жигнэсэн дундаж хүү | 2.9% |
| Жигнэсэн дундаж зээлийн анхны хугацаа | 35.8 |
| Жигнэсэн дундаж зээлийн төлөгдсөн хугацаа | 7.9 |
| Жигнэсэн дундаж зээлийн үлдсэн хугацаа | 26.8 |
| Жигнэсэн дундаж LTV | 66% |

*Хүснэгт **Error! No text of specified style in document.**-18 Багцын анх олгосон хугацааны мэдээлэл*

| Анх олгосон огноо | | Зээлийн тоо | | Анх олгосон дүн | |
|---|---|---|---|---|---|
| | | Тоо | % | Дүн | % |
| | 4/1/2019 - 6/30/2019 | 23 | 5% | 323,290,000 | 7% |

Андеррайтерийн шинжилгээ

Санхүүгийн мэдээлэл



"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL 6317839 1119277128 УЛААНБААТАР ХОТ
000229
СЗХ 2021.01.06
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2020-11-12 БҮРТГЭВ-02
УЛААНБААТАР ХОТ ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2019 | 7/1/2019 - 9/30/2019 | 50 | 12% | 640,390,000 | 13% |
| | 10/1/2019 - 12/31/2019 | 120 | 29% | 1,296,710,000 | 27% |
| 2020 | 1/1/2020 - 3/31/2020 | 171 | 41% | 2,015,714,000 | 41% |
| | 4/1/2020 - 6/30/2020 | 56 | 13% | 583,690,000 | 12% |
| **Нийт** | | **420** | **100 %** | **4,859,794,000** | **100 %** |

Андеррайтерийн шинжилгээ

Санхүүгийн мэдээлэл

Багцын дийлэнх буюу 80%-ийг 2019 оны 3-р улирлаас хойш олгосон, шинэ зээлүүд ээлж байна.

*Хүснэгт **Error! No text of specified style in document.**-19 Багцын анх олгосон зээлийн хугацаа*

| Зээлийн анхны хугацаа (сар) | Зээлийн тоо | | Анх олгосон дүн | |
|---|---|---|---|---|
| | Тоо | % | Дүн | % |
| 24 - 30 | 8 | 1.9% | 122,214,000 | 2.5% |
| 30 - 36 | 26 | 6.2% | 234,050,000 | 4.8% |
| 36 - 42 | 384 | 91.4% | 4,450,530,000 | 91.6% |
| 42 - 48 | 2 | 0.5% | 53,000,000 | 1.1% |
| **Нийт** | **420** | **100%** | **4,859,794,000** | **100%** |
| **Хамгийн их** | **48** | | | |
| **Хамгийн бага** | **24** | | | |
| **Жинлэсэн дундаж** | **35.8** | | | |



СЗХ 2021 .01. 06 өдөр БҮРТГЭВ № 01
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL 6317839 1119277128 УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЭК ХХК УЛААНБААТАР ХОТ
...-11- 12 ...ГЭВ-02
000229

Андеррайтерийн шинжилгээ

Санхүүгийн мэдээлэл

Зээлийн хугацаа хамгийн багадаа 24 сар буюу багцын шаардлагыг хангаж байна. Түүнчлэн багцын 91.6% нь 36-42 сарын хугацаатай олгогдсон зээлүүд байна. Өөрөөр хэлбэл Хүснэгт 5-6, 5-7 харуулснаар Зээлийн багц нь ХБҮЦ-ийн хугацааны турш зээлийн болон хүүгийн төлөлт хийгдэх нөхцөлийг хангасан.

*Хүснэгт **Error! No text of specified style in document.**-20 Багцын анх олгосон дүн*

| Анх олгосон дүн /мян.төг/ | Зээлийн тоо: Тоо | Зээлийн тоо: % | Анх олгосон дүн: Дүн | Анх олгосон дүн: % |
|---|---|---|---|---|
| 0 - 6,000 | 26 | 6% | 125,270,000 | 3% |
| 6,000 - 10,000 | 149 | 35% | 1,225,815,000 | 25% |
| 10,000 - 14,000 | 160 | 38% | 1,845,650,000 | 38% |
| 14,000 - 18,000 | 47 | 11% | 716,635,000 | 15% |
| 18,000 - 22,000 | 16 | 4% | 305,010,000 | 6% |
| 22,000 - дээш | 22 | 5% | 641,414,000 | 13% |
| **Нийт** | **420** | **100%** | **4,859,794,000** | **100%** |
| **Хамгийн их** | **50,000,000** | | | |
| **Хамгийн бага** | **3,000,000** | | | |
| **Дундаж** | **11,356,008** | | | |

Зээлийн тооны хувьд 6-14 сая төгрөгийн зээл нийт багцын 73% нь бол зээлийн дүнгийн 63% нь буюу харьцангуй жижиг зээлүүдэд багц тархаж байршсан байна. Энэ нь аливаа өндөр дүнтэй зээлд багц хэт төвлөрөхөөс сэргийлсэн тухайн зээл эрсдэсэн тохиолдолд ХБҮЦ-ийн эргэн төлөлтөд нөлөөлөхгүй.

*Хүснэгт **Error! No text of specified style in document.**-21 Багцын барьцаа хангалт*

| LTV харьцаа | Зээлийн тоо | Анх олгосон дүн |
|---|---|---|



СЗХ БҮРТГЭВ 2021.01.06
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2020-11-12 БҮРТГЭВ-02
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL 6317839 1119277128 УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК УЛААНБААТАР ХОТ
000230

| | | Тоо | % | Дүн | % |
|---|---|---|---|---|---|
| 0 | 40% | 24 | 6% | 179,500,000 | 4% |
| 40% | 55% | 85 | 20% | 901,220,000 | 19% |
| 55% | 65% | 49 | 12% | 506,950,000 | 10% |
| 65% | 75% | 177 | 42% | 2,158,245,000 | 44% |
| 75% | 87% | 85 | 20% | 1,113,879,000 | 23% |
| **Нийт** | | **420** | **100%** | **4,859,794,000** | **100%** |
| **Хамгийн их** | | **15%** | | | |
| **Хамгийн бага** | | **86%** | | | |
| **Жигнэсэн дундаж** | | **65%** | | | |

Багцад тавигдах шаардлагын дагуу Хөрөнгийн багцын жигнэсэн дундаж барьцаа хангалт 65% буюу түүнээс их байна. Барьцаа хөрөнгийн хүрэлцээ нь тухайн зээлийн чанарт нөлөөлөх үзүүлэлт бөгөөд зээлийн эргэн төлөлт төлөгдөх тусам барьцаа хангалт өндөр болдог.

*Хүснэгт **Error! No text of specified style in document.**-22 Зээлийн хүүгийн тархалт*

| **Хүүгийн тархалт** | **Зээлийн тоо** | | **Анх олгосон дүн** | |
|---|---|---|---|---|
| | Тоо | % | Дүн | % |
| 2.0% - 3.0% | 383 | 91% | 4,290,564,000 | 88% |
| 3.0% - 3.2% | 37 | 9% | 569,230,000 | 12% |
| **Нийт** | **420** | **100%** | **4,859,794,000** | **100%** |
| **Хамгийн их** | **3.1%** | | | |
| **Хамгийн бага** | **2.5%** | | | |



СЗХ 2021.01.06 өдөр БҮРТГЭВ №31
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2020-11-12 БҮРТГЭВ-02
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL 6317839 1119277128 УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК
000231

| Жигнэсэн дундаж | 2.9% | | |
|---|---|---|---|

Хөрөнгийн багцын жигнэсэн дундаж хүү нь Багцад тавигдах шаардлагын дагуу 2.9% байна. Энэ нь анхны үүрэг гүйцэтгүүлэгчдийн олдогдор дундаж зээлийн хүүтэй дүйцэж байгаа юм.

*Хүснэгт Error! No text of specified style in document.-23 **Барьцаа автомашины төрөл***

| Машины төрөл | Нийт зээл | | Зээлийн тоо | | Дундаж зээл |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | % | Тоо | % | |
| Minivan | 177,660,000 | 4% | 8 | 2% | 22,207,500 |
| SUV | 153,600,000 | 3% | 6 | 1% | 25,600,000 |
| Compact-SUV | 885,440,000 | 18% | 55 | 13% | 16,098,909 |
| Sedan | 3,643,094,000 | 75% | 351 | 84% | 10,379,185 |
| *Үүнээс Prius* | *1,811,420,000* | *37%* | *165* | *39%* | *10,978,303* |
| | **4,859,794,000** | | **420** | | |

Нийт барьцааны 75% нь седан загварын дундаж зээлийн дүн нь 10.4 сая төгрөгийн автомашинд тархсан байна. Үүнээс 50% (нийт багцын 37%) нь приус маркийн автомашин байна.

Андеррайтерийн шинжилгээ

Санхүүгийн мэдээлэл

**5.6.1 Үнэт цаасанд нөлөөлөх эрсдэлийн шинжилгээ**

**Зээлийн эрсдэл**

Үнэт цаасны эргэн төлөлт нь үнэт цаас гаргагчийн Багцын эргэн төлөлтийн орлогоос шууд хамааралтай. Өөрөөр хэлбэл, хөрөнгийн Багц дахь зээлийн эргэн төлөлттэй шууд хамааралтай тул зээлийн эрсдэлийг Үнэт цаас эзэмшигч хүлээн авч байна.

Андеррайтерийн шинжилгээ



"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL 6317839 1119277128 УЛААНБААТАР ХОТ
СЭХ 2021 01 06 БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2020-11-12 БҮРТГЭВ-02
УЛААНБААТАР ХОТ ИНВЕСКОР АКТИВ ТЭК ХХК
000232

| | | | |
|---|---|---|---|
| | Зээлийн багц нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ердийн зээлийн журам, шаардлагуудыг хангасан хэвийн ангилалтай зээлүүд байна. /Хуулийн дүгнэлтийн Хуудас 16, График 6/ | Үнэн зөв | Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс ХХН-ийн 2020.07.24-ний өдрийн "Автомашины зээлийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах хэлцлийн хүрээнд сонгогдсон зээлийн дансдын хуулийн шалгуур үзүүлэлтэд нийцсэн эсэх талаарх хуулийн хөндлөнгийн дүн шинжилгээний тайлан" |
| | Андеррайтер нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн автомашины зээлийн багцтай холбоотой түүхэн мэдээллүүдийг нэгтгэж гаргасан бөгөөд энэ нь Үнэт цаасны багцтай шууд холбоогүй боловч ижил багцуудын түүхэн мэдээллийг харуулах зорилготой юм. Хүснэгт 5-12, Хүснэгт 5-13 харахад анх олгосон хугацаагаар нь ангилсан зээлүүдийн чанаргүй зээлийн эрсдэл хамгийн ихдээ 2.35% байна. Энэ нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн автомашины зээлийн багц нь чанаргүйтэх магадлал бага, төлбөр тасалдлын эрсдэл мөн бага байгааг харуулж байна. | Андеррайтерийн шинжилгээ | |
| | Автомашины зээлийн багцын түүхэн мэдээллүүд<br>*Хүснэгт 5-242 Инвескор автомашины зээлийн багц (зээлийн багцаас)* | | |

| Он | | Зээлийн багц | Зээлийн тоо | Жигнэсэн дундаж хүү | Дундаж хугацаа (жил) | NPL % |
|---|---|---|---|---|---|---|
| 2017 | Q2 | 6,911,833 | 1 | 3.50% | 1.60 | |
| 2017 | Q3 | 6,045,661 | 1 | 3.50% | 1.60 | |



"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL 6317839 1119277128 УЛААНБААТАР ХОТ
СЗХ он 2021 сар 01 өдөр 06 БҮРТГЭВ
2020-11-12 БҮРТГЭВ
000233

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2017 | Q4 | 697,238,916 | 80 | 3.50% | 1.60 | |
| 2018 | Q1 | 3,939,650,958 | 436 | 3.43% | 1.15 | 0.00% |
| 2018 | Q2 | 8,061,095,999 | 935 | 3.18% | 1.66 | 0.00% |
| 2018 | Q3 | 12,919,890,578 | 1,532 | 3.05% | 1.82 | 0.14% |
| 2018 | Q4 | 14,104,601,922 | 1,779 | 3.04% | 1.94 | 0.52% |
| 2019 | Q1 | 16,537,040,545 | 2,093 | 3.03% | 2.06 | 1.33% |
| 2019 | Q2 | 21,164,884,934 | 2,526 | 3.03% | 2.16 | 1.13% |
| 2019 | Q3 | 25,491,429,874 | 3,028 | 3.02% | 1.84 | 2.35% |
| 2019 | Q4 | 24,800,463,839 | 3,075 | 3.01% | 2.32 | 1.16% |

*Хүснэгт 5-13 Микрокредит автомашины зээлийн түүх (анх олгосон дүнгээс)*

| Он | | Олгосон дүн | Зээлийн тоо | Жигнэсэн дундаж хүү | Дундаж хугацаа (жил) | NPL % |
|---|---|---|---|---|---|---|
| 2018 | Q1 | 99,110,000 | 12 | 2.9% | 3.00 | 0.0% |
| 2018 | Q2 | 235,450,000 | 30 | 2.9% | 3.00 | 0.0% |
| 2018 | Q3 | 92,070,000 | 9 | 2.9% | 3.00 | 0.0% |
| 2018 | Q4 | 324,030,000 | 29 | 2.9% | 3.00 | 0.0% |
| 2019 | Q1 | 523,310,000 | 45 | 2.9% | 3.00 | 0.4% |
| 2019 | Q2 | 633,000,000 | 54 | 2.9% | 3.00 | 0.6% |
| 2019 | Q3 | 753,125,000 | 69 | 2.9% | 3.00 | 0.8% |



Андеррайтерийн шинжилгээ

Санхүүгийн мэдээлэл



СЗХ 2021.01.06 өдөр БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2020-11-12 БҮРТГЭВ-02
InvesCore CAPITAL 6317839 1119277128 УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЭК ХХК 9020080754 6581463 УЛААНБААТАР ХОТ
000734

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2019 | Q4 | 920,620,000 | 86 | 2.9% | 3.00 | 1.1% |
| 2020 | Q1 | 971,734,000 | 79 | 2.9% | 3.00 | 1.3% |

| | | | |
|---|---|---|---|
| | Банк Бус Санхүүгийн Байгууллагуудын дундаж чанаргүй зээлийн үзүүлэлт 8.4% байдаг бөгөөд зөвхөн автомашины зээлийн багцыг тусгаарласнаар бусад зээлийн эрсдэлээс мөн тусгаарлаж байгаа юм. | Андеррайтерийн шинжилгээ<br>Санхүүгийн зохицуулах хороо 2020 оны 1-р улирал статистик мэдээлэл | |
| | Нөгөө талаар 2020 оны 2-р улирлын байдлаар анхны үүрэг гүйцэтгүүлэгч болох Инвескор ББСБ нь 27.6 тэрбум, Микро Кредит ББСБ нь 2.9 тэрбум төгрөгийн автомашины зээлийн багцтай, шинэ зээл олголт улиралд дунджаар Инвескор ББСБ 4 тэрбум, Микро Кредит ББСБ 0.9 тэрбум төгрөг байгаа нь Үнэт цаасны хугацааны турш цаашид Багцын хөрөнгийг нэмэгдүүлэх шаардлага үүсэхэд хангалттай зээлийн нөөц байгааг илтгэж байна. | Андеррайтерийн шинжилгээ | |
| **5.6.2** | **Үнэт цаасны схемийн эрсдэл**<br><br>Үнэт цаасжуулах ажиллагаанд хэд хэдэн субъектүүд оролцож байгаа тул тэдгээр оролцогчдын үйл ажиллагаанаас үүдэлтэй зээлийн хөрөнгийн багцын эргэн төлөлт хийгдэхгүй байх, үнэт цаасны төлбөр төлөгдөхгүй байх эрсдэл бий болж болзошгүй бөгөөд Үнэт цаас гаргагч нь уг эрсдэлүүдийг бууруулах зорилгоор 2020 оны 08-р сарын 05-ны өдөр "Эрсдэлийн удирдлага, дотоод хяналт хэрэгжүүлэх, эрсдэлийн сан байгуулах, сангийн хөрөнгийг захиран зарцуулах журам"-ыг баталсан байна. | Андеррайтерийн шинжилгээ<br>"Инвескор актив" ХХК-ийн ТУЗ-ийн 2020.08.05-ны өдрийн 20/04 тоот тогтоол | |
| | Тус журмаар Зээлдэгчтэй холбоотой эрсдэл, оролцогчидтой холбоотой эрсдэл болон бусад эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэх журам болон эрсдэлийг бууруулах арга хэмжээ, хариуцах субъектийг тодорхойлжээ. | Үнэн зөв | Эрсдэлийн удирдлага, дотоод хяналт хэрэгжүүлэх, эрсдэлийн сан байгуулах, сангийн хөрөнгийг захиран зарцуулах журам |
| | Мөн ТЗК нь "Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох солих журам" болон Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай байгуулсан гэрээний дагуу уг этгээдүүдийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, тайлан мэдээ авах замаар татан буугдах, дампуурах эрсдэл байгаа | Үнэн зөв | Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн |

| | | | |
|---|---|---|---|
| | эсэхийг хянах бөгөөд уг нөхцөл байдал үүсэх болон гэрээний зөрчил үүссэн тохиолдолд тэдгээрийг солих, хохирол нэхэмжлэх зэрэг арга хэмжээг тодорхойлжээ. | | удирдагчийг сонгох солих журам<br><br>Хөрөнгө итгэмжлэн улирдах үйлчилгээний гэрээний 8.2 |
| | Түүнчлэн ТЗК нь үнэт цаасжуулах ажиллагаанд оролцож буй оролцогчидтой холбоотой хөрөнгийн зээлийн багцын эргэн төлөлт хийгдэхгүй байх, үнэт цаасны төлбөр төлөгдөхгүй байх эрсдэлийг бууруулах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. | Андеррайтерийн шинжилгээ | |
| | **Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс шилжүүлэх хөрөнгийн багцтай холбоотой эрсдэл**<br><br>Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь ТЗК-д энэхүү Танилцуулгын 5.4-д тусгагдсаны дагуу шаардлага хангасан хөрөнгийг шилжүүлж өгөх бөгөөд хэрэв тухайн хөрөнгө нь шаардлага хангахгүй тохиолдолд сольж өгөх үүрэг хүлээсэн /Танилцуулгын 5.7-г харна уу/. | Андеррайтерийн шинжилгээ<br><br>Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний 2.3.1, 5.3 | |
| | ТЗК нь мөн хөрөнгийн багц дах хөрөнгийн эргэн төлөлтийн үүргийн гүйцэтгэлийн хангуулах зорилгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй Фидуцийн барьцааны гэрээг байгуулсан бөгөөд тус гэрээгээр Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд буй фидуцийн хөрөнгүүдийг барьцаалж, талуудын хооронд байгуулагдсан Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ зөрчигдсөн нөхцөлд уг барьцаагаар үүргийн гүйцэтгэл хангуулахаар тохиролцсон байна. | Үнэн зөв | Фидуцийн барьцааны гэрээний 1.1, 4 |
| | **Хөрөнгийн багцын эргэн төлөлттэй холбоотой эрсдэл бууруулах арга хэмжээ**<br><br>Үйлчилгээ үзүүлэгч нь Багцын Зээлийн эргэн төлөлтийг цуглуулан Худалдаа Хөгжлийн Банк дахь Төлбөр цуглуулах дансанд байршуулах бөгөөд уг дансанд цугларсан мөнгөн хөрөнгийг ТЗК-д шилжүүлэхээс өөр зорилгоор ашиглах, захиран зарцуулахаас сэргийлэх зорилгоор Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон Үйлчилгээ үзүүлэгч нь Төлбөр цуглуулах дансны хөрөнгийн барьцааны гэрээг байгуулсан. Тус гэрээний дагуу данс дахь бүхий л мөнгөн хөрөнгийг барьцаалж, уг данснаас зөвхөн ТЗК-ийн төлбөр гүйцэтгэх данс руу зарлагын гүйлгээ гаргах тухай болон Үйлчилгээ үзүүлэгч буюу | Үнэн зөв | Төлбөр цуглуулах дансны хөрөнгийн барьцааны гэрээний 2.1, 2.3, 3.1 |



000236

| | | | |
|---|---|---|---|
| | Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь татан буугдах, төлбөрийн чадваргүй болох зэрэг тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь данс дахь мөнгөн хөрөнгийг ТЗК-д шилжүүлэх тухай харилцан тохиролцсон байна. | | |
| | Түүнчлэн Үйлчилгээ үзүүлэгчид төлөх үйлчилгээний хөлсийг урьдчилан тогтоосон төлбөр төлөх өдөр шилжүүлсэн дүнгээс тооцох тухай ТЗК болон Үйлчилгээ үзүүлэгчийн хооронд байгуулагдах Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээнд заасан нь Үйлчилгээ үзүүлэгч Анхны үүрэг гүйцэтгэгчдийн зээлийн төлбөрийг хугацаанд нь бүрэн цуглуулан авч, ТЗК-д шилжүүлэх хөшүүрэг болох юм. | Андеррайтерийн шинжилгээ<br>Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээний 4.1 | |
| | **ТЗК-ийн Төлбөр гүйцэтгэх данс дахь мөнгөн хөрөнгийн зарцуулалттай холбоотой эрсдэл бууруулах арга хэмжээ**<br>Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ТЗК-ийн Төлбөр гүйцэтгэх дансанд цугларсан мөнгөн хөрөнгийг үр ашиггүй, зориулалтын бусаар захиран зарцуулсны улмаас үнэт цаас эзэмшигчдэд үнэт цаасны төлбөр төлөгдөхгүй байх эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Худалдаа Хөгжлийн Банктай "Тусгай нөхцөлтэй байгууллагын мөнгөн хадгаламжийн гэрээ"-г байгуулсан бөгөөд тус гэрээгээр Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь зөвхөн ТЗК-аас урьдчилан Банканд өгсөн "Үнэт цаасны төлбөрийн график" /Танилцуулгын 3.5.2-т тусгасан/-ийн дагуу Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төвийн данс руу болон энэхүү Танилцуулгын 4.5 дахь хэсэгт заасан зардлыг ТУЗ-өөс урьдчилан баталсан "Зардлын хуваарь"-д заасан хувь хэмжээгээр ТЗК-ийн харилцах данс руу шилжүүлэхээр заажээ. | Үнэн зөв | Тусгай нөхцөлтэй байгууллагын мөнгөн хадгаламжийн гэрээний 2.9 |
| | **Үнэт цаасны төлбөр төлөхтэй холбоотой эрсдэл бууруулах арга хэмжээ**<br>Үнэт цаас гаргагч нь Үйлчилгээ үзүүлэгчийн төлбөр цуглуулах үйл ажиллагаатай холбоотой доголдлын улмаас үнэт цаас эзэмшигчдэд үнэт цаасны төлбөр бүрэн төлөгдөхгүй байх эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Эрсдэлийн сан байгуулсан бөгөөд уг санг байгуулах, сангийн хөрөнгийг захиран зарцуулах болон хөрөнгө нөхөж байршуулах тухай асуудлыг "Эрсдэлийн удирдлага, дотоод хяналт хэрэгжүүлэх, эрсдэлийн сан байгуулах, сангийн хөрөнгийг захиран зарцуулах журам"-аар зохицуулжээ. | Үнэн зөв | Эрсдэлийн удирдлага, дотоод хяналт хэрэгжүүлэх, эрсдэлийн сан байгуулах, сангийн хөрөнгийг захиран зарцуулах журам |



СЗХ 2021.01.06 БҮРТГЭВ № 01
MONGOLIAN STOCK EXCHANGE 2020-11-12
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL 6317839 1119277128 УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК УЛААНБААТАР ХОТ
000237

| | | | |
|---|---|---|---|
| | | | |
| | Үнэт цаастай холбоотой эрсдэлийг бууруулах зорилгоор Үнэт цаасыг 2 транчтай (А Транч, Б Транч) зохион байгуулсан бөгөөд Үнэт цаас гаргагчийн мөнгөн орлогоос А Транч үнэт цаас эзэмшигчийн хүүгийн төлбөр, үндсэн төлбөрийг тэргүүн ээлжинд төлнө. | Үнэн зөв | "Инвескор актив ТЗК" ХХК-ийн ТУЗ-ийн 2020.08.20-ны өдрийн 20/09 тоот тогтоол<br>Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлөх тухай журмын 5 |
| | Б Транч эзэмшигч нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид болон Андеррайтер байх бөгөөд нийт багцын 15%-ийг Үнэт цаасны нийт хугацааны турш бусдад худалдахгүй эзэмших үүрэг хүлээнэ. Хүүгийн төлбөр болон үндсэн төлбөр нь А Транчийн тухайн хугацаанд тооцогдох хүүгийн төлбөр, үндсэн төлбөр болон бусад заавал төлөгдөх зардлууд төлөгдсөний дараа төлөгдөх юм. | Үнэн зөв | "Инвескор актив ТЗК" ХХК-ийн ТУЗ-ийн 2020.08.20-ны өдрийн 20/09 тоот тогтоол<br>Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлөх тухай журмын 5<br>Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний 4.1 |
| **5.6.3** | **Эдийн засаг, улс төрийн орчин**<br>**Ковид-19 Нөлөөлөл**<br>БНХАУ-аас эхлэлтэй CoVid-19 вирусийн тархалт нь 2020 оны 8 сарын байдлаар 21 сая батлагдсан тохиолдолтой, 766 мянган нас баралттай Дэлхийн хэмжээний цар тахал болон өргөжсөн нь Дэлхийн эдийн засагт ч урд үзэгдээгүй том нөлөөллийг үзүүлж байна. | | |

Эдийн засагчид, олон улсын бизнес шинжээчид цар тахлын эдийн засагт үзүүлэх нөлөөллийг олон хувилбараар тооцоолж байгаагаас дараах хувилбарууд хамгийн магадлал өндөр байна.

***А3: Улирлын нөлөөлөл болон эрүүл мэндийн оновчтой арга хэмжээний үр дүнд Европ, Ойрх дорнод, АНУ-д тархалт 2-р улирал дуустал үргэлжлэн саарна.***

Андеррайтерийн шинжилгээ

БНХАУ-д Эдийн засгийн огцом боловч агшин зуурын хямрал мэдрэгдэнэ. Европ болон АНУ-д мөнгөний бодлогын хүчтэй арга хэмжээ авснаар вирусийн тархалт саарах 2-р улирлаас эхлэн Эдийн засаг сэргэж эхэлнэ.

*Хүснэгт **Error! No text of specified style in document.**-14 А3 Дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл Mckinsey&Company*

| | 2020 оны ДНБ өсөлт | ЭЗ сэргэлт эхлэх хугацаа |
|---|---|---|
| БНХАУ | -0.5% | 2020 4-р улирал |
| АНУ | -2.4% | 2020 4-р улирал |
| Дэлхий | -1.8% | 2021 1-р улирал |

***А1: Тархалт улирлын нөлөөлөлгүйгээр үргэлжилж Дэлхийн олон орнууд, тэр дундаа буурай хөгжилтэй орнууд эдийн засгийн болон эрүүл мэндийн томоохон хохирол амсана.***

Андеррайтерийн шинжилгээ

БНХАУ-ын экспорт буурснаар эдийн засгийн сэргэлт удаан үргэлжилнэ. Европ болон АНУ-д эдийн засгийн огцом уналт 2-р улиралд тохиож ихэнх улсууд хямралаас өмнөх үедээ ортол 2 жил зарцуулна.

*Хүснэгт **Error! No text of specified style in document.**-255 А1 Дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл Mckinsey&Company*

| | 2020 оны ДНБ өсөлт | ЭЗ сэргэлт эхлэх хугацаа |
|---|---|---|
| БНХАУ | -2.3% | 2021 2-р улирал |



СЗХ
он сар өдөр 2021 01 06
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020 -11- 12
ГЭВ-02
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК
УЛААНБААТАР ХОТ
000239

<table>
<tr><td></td><td>
<table>
<tr><td>АНУ</td><td>-8.7%</td><td>2024 2-р улирал</td></tr>
<tr><td>Дэлхий</td><td>-5.7%</td><td>2022 4-р улирал</td></tr>
</table>
Энэ шалтгаанаас Монгол улсын 2020 оны эдийн засгийн төсөөлөл ихээхэн хэлбэлзэхээр байна. 2020 оны 1-р улиралд экспорт өмнөх оноос 30% бага байсан нь цаашид эдийн засагт үзүүлэх нөлөөлөл ч энэ хэмжээгээр өндөр байхаар байна. Одоогийн байдлаар улсын төсвийн биелэлт 8% тасалдалтай байгаа ч нүүрс, зэсийн экспортыг эрчимжүүлэх замаар эдийн засгийн бууралтыг саармагжуулж өсөлтийг дэмжих боломжтой гэж харагдаж байна.<br><br>Эдийн засгийн тодорхойгүй энэ нөхцөлд хөрөнгө оруулагчид харьцангуй тогтмол өгөөжтэй санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах сонирхолтой хүлээлттэй байна. Нөгөө талаас макро эдийн засгийн тодорхойгүй өнөөдрийн нөхцөлд жижиг хөрөнгө оруулагчид идэвхгүй байх магадлалтай боловч институционал хөрөнгө оруулагчид мөнгөн хөрөнгийн менежмент хэлбэрээр хоёрдогч зах зээлийг дэмжих боломжтой.</td><td colspan="2"></td></tr>
<tr><td>5.6.4</td><td>Хөрвөх чадварын хангалттай байдал<br><br>Дийлэнх үнэт цаасны бүтээгдэхүүний хувьд дотоодын институционал хөрөнгө оруулагч цөөн бөгөөд хөгжөөгүй байгаа зэрэг шалтгаанаар уг үнэт цаасны хөрвөх чадвар муу байх хандлагатай байдаг. Харин ХБҮЦ-ийн хувьд хамгийн том институционал хөрөнгө оруулагч болох даатгалын компаниудын нөөц хөрөнгийг байршуулах боломж өндөр, татвар болон хууль эрх зүйн таатай зохицуулалттай байдаг тул хөрвөх чадварын харьцангуй таатай нөхцөлтэй байх боломжтой.</td><td colspan="2">Андеррайтерийн шинжилгээ</td></tr>
<tr><td>5.7</td><td>Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах, багцаас хасах журам<br><br>ТЗК нь Багцтай холбоотой эрсдэлийг бууруулах зорилгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс худалдан авсан хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах, хасах, нэмэгдүүлэх эрхтэй. Үүнтэй холбоотойгоор “Багцын хөрөнгөд өөрчлөлт оруулах, багцаас хасах тухай журам”-ыг баталсан бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй байгуулсан “Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ”-нд мөн уг асуудлыг тусгасан байна</td><td>Үнэн зөв</td><td>Багцын хөрөнгөд өөрчлөлт оруулах, багцаас хасах тухай журмын 2<br><br>Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний 5.1</td></tr>
<tr><td>5.7.1</td><td>Хөрөнгө солих журам</td><td>Үнэн зөв</td><td>Багцын хөрөнгөд өөрчлөлт оруулах,</td></tr>
</table>

| | | | |
|---|---|---|---|
| | Багц дахь хөрөнгүүд нь энэхүү Танилцуулгын 5.4 дэх хэсэгт заасан шаардлагыг хангасан байх ба дараах тохиолдолд хөрөнгийг шаардлага хангахгүй болсонд тооцохоор байна. Үүнд:<br>✓ Зээлийн эргэн төлөлтийн хугацаа нь 15 болон түүнээс дээш хоногоор хэтэрсэн;<br>✓ Зээл хугацаанаасаа өмнө эргэн төлөгдсөн;<br>✓ Зээлийн авлагын эрхийг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн (Зээлдэгч нас барсан, сураггүй алга болсон, төлбөрийн чадваргүй болсон, зээл болон түүнтэй холбоотой асуудлаар шүүхэд маргаан үүсгэсэн зэрэг);<br>✓ Зээлдэгчийн хүсэлтээр Зээлийн гэрээнд өөрчлөлт оруулсан нь Үнэт цаас гаргагчийн Үнэт цаас эзэмшигчдэд төлөх Үнэт цаасны төлбөрт нөлөөлөхүйц байна гэж Үнэт цаас гаргагч үзсэн;<br>✓ Шалгуур үзүүлэлттэй холбоотойгоор Анхны Үүрэг гүйцэтгүүлэгчийн "Хөрөнгө худалдах худалдан авах гэрээ"-нд гаргасан баталгаа, мэдэгдэл зөрчигдсөн. | | багцаас хасах тухай журмын 2.2<br><br>Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний 5.1 |
| | Дээрх нөхцөл үүссэн тохиолдолд ТЗК болон түүнийг төлөөлж Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид мэдэгдэл хүргүүлэх бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь тухайн мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногт багтаан Орлуулах хөрөнгийн жагсаалтыг ТЗК болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчид гарган өгөх ба ТЗК, Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь уг хөрөнгийг шаардлага хангаж байна гэж үзэн зөвшөөрсөн тохиолдолд ажлын 3 хоногт багтаан сольж өгөх үүрэг хүлээнэ. Орлуулах хөрөнгө нь дараах шаардлагыг хангасан байна:<br>✓ Шалгуур үзүүлэлт хангаж байгаа;<br>✓ Зээлийн үлдэгдэл хугацаа нь Үнэт цаасны эргэн төлөлт хийгдэж дуусах хугацаанаас багагүй;<br>✓ Шаардлага хангахгүй хөрөнгүүдийн зээлийн үндсэн төлбөрийн үлдэгдлийн нийлбэртэй тэнцүү буюу илүү хэмжээ бүхий үндсэн төлбөрийн үлдэгдэл дүнтэй;<br>✓ Шаардлага хангахгүй хөрөнгийн сарын хуваарьт төлбөрийн нийлбэртэй тэнцүү буюу илүү хэмжээ бүхий хуваарьт төлбөртэй.<br>✓ ТЗК нь орлуулах хөрөнгийг шилжүүлэн авч холбогдох бүртгэлийг хийлгэснээр тэдгээрийг худалдан авсанд тооцогдох ба шаардлага хангахгүй хөрөнгийг хөрөнгийн багцаас хасаж, Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан шилжүүлнэ. | Үнэн зөв | Багцын хөрөнгөд өөрчлөлт оруулах, багцаас хасах тухай журмын 3.2<br><br>Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний 5.3 |
| | ТЗК буюу түүнийг төлөөлөн Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь "Хөрөнгө худалдах худалдан авах гэрээ" болон "Багцын хөрөнгөд өөрчлөлт оруулах, хөрөнгийг багцаас хасах тухай журам"-д заасан нөхцөл | Үнэн зөв | Багцын хөрөнгөд өөрчлөлт оруулах, багцаас хасах тухай журмын 3.2.1 |



СЗХ 2021 .04.06 БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2020-11-12 БҮРТГЭВ-02
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL 6317839 1119277128 УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК УЛААНБААТАР ХОТ 9020000754 6581463
000241

| | | | |
|---|---|---|---|
| | байдал үүссэн тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид мэдэгдэл хүргүүлэх замаар хөрөнгийг буцаан худалдах эсхүл багцын хөрөнгийг нэмэгдүүлэх боломжтой. | | Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний 5.1 |
| | Талууд хөрөнгө Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах тухай шаардлагыг хэрэгжүүлэхэд хөрөнгийн үнэлгээг зах зээлийн үнээр тогтоох бөгөөд хэрэв зах зээлийн үнийн талаар санал нэгдэж чадаагүй тохиолдолд хөндлөнгийн шинжээчээр үнэлгээ хийлгэнэ. | Үнэн зөв | Багцын хөрөнгөд өөрчлөлт оруулах, багцаас хасах тухай журмын 3.5.2, 3.5.3<br><br>Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний 9.2 |
| 5.7.2 | **Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зээлийн багцын хангалттай байдал**<br><br>Автомашины зээл нь банк бус санхүүгийн байгууллагуудын үндсэн бүтээгдэхүүнүүдийн нэг бөгөөд зах зээл дээр эрэлт харьцангуй өндөр байдаг. 2020 оны 2-р улирлын байдлаар анхны үүрэг гүйцэтгүүлэгч болох Инвескор ББСБ нь 27.6 тэрбум, Микро Кредит ББСБ нь 2.9 тэрбум төгрөгийн автомашины зээлийн багцтай байна. Зээл олголт улиралд дунджаар Инвескор ББСБ 4 тэрбум, Микро Кредит ББСБ 0.9 тэрбум төгрөг байгаа нь Үнэт цаасны хугацааны турш цаашид Багцын хөрөнгийг нэмэгдүүлэх шаардлага үүсэхэд хангалттай зээлийн нөөц байгааг илтгэж байна. | Андеррайтерийн шинжилгээ | |
| 6.1 | **АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ**<br><br>Инвескор ББСБ<br><br>“Инвескор ББСБ” ХК нь 2016 онд банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаагаа эхлүүлж, салбартаа шинэлэг, шуурхай үйлчилгээ болон дэвшилтэт технологийг нэвтрүүлж, харилцагчдынхаа санхүүгийн хариуцлагатай дэмжигч байх зорилго тавин ажилласаар салбартаа манлайлагчдын нэг болж чаджээ.<br><br>Үнэт цаас гаргагч нь нээлттэй хувьцаат компани болж, хувьцаа нь Бирж дээр арилжаалагдаж эхэлснээс хойш нийт 52 долоо хоногийн арилжаагаар 3.3 тэрбум төгрөгийн хувьцаа арилжаалагдсан нь биржийн хөрвөх чадвар өндөртэй хувьцаануудын нэг болоод байна. 2020 оны 2-р улирлын байдлаар хувьцааны | Андеррайтерийн шинжилгээ<br><br>http://mse.mn/mn/company/553 | |

000242

| | | |
|---|---|---|
| | үнэ хувьцааг анх олон нийтэд санал болгосон үнээс 49%-аар өсжээ. | |
| 6.1.1 | Инвескор ББСБ санхүүгийн үзүүлэлт<br>*График* ***Error! No text of specified style in document.****-5 Инвескор ББСБ санхүүгийн байдал*<br><br><br>*График* ***Error! No text of specified style in document.****-6 Инвескор ББСБ зээлийн багц, ашигт ажиллагаа*<br>**Зээлийн багцын хэмжээ /сая.төг/** **Цэвэр ашиг /сая.төг/** | Санхүүгийн мэдээлэл |







Санхүүгийн мэдээлэл

*Хүснэгт **Error! No text of specified style in document.**-26 Инвескор ББСБ Санхүүгийн байдлын тайлан*

| Баланс /сая.төгрөг/ | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020Q2 |
|---|---|---|---|---|---|
| Мөнгөн хөрөнгө | 223.0 | 1,104.0 | 2,320.0 | 5,146.1 | 5,286.0 |
| Богино хугацаат хөрөнгө оруулалт | | | | 3,599.7 | 3,867.4 |
| Харилцагчдад олгосон зээл | 4,294.0 | 17,860.0 | 34,868.0 | 60,645.3 | 72,811.8 |
| Бусад авлага | | | | 1,662.6 | 3,633 |
| Бусад хөрөнгө | 5.0 | 40.0 | 811.0 | 3,365.4 | 4,368.5 |
| Биет болон биет бус хөрөнгө | 29.0 | 640.0 | 1,027.0 | 7,483.0 | 7,477.0 |
| **Нийт хөрөнгийн дүн** | **4,551.0** | **19,644.0** | **39,026.0** | **81,902.1** | **97,413.7** |
| Итгэлцлийн үйлчилгээний өглөг | 2,109.0 | 2,508.0 | 10,374.0 | 18,981.1 | 24,811.0 |
| Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл | | 7,897.0 | 13,867.0 | 10,533.6 | 11,533.6 |



"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК
УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020 -11- 12
БҮРТГЭВ-02
СЗХ
2021 .01. 06
БҮРТГЭВ
000244

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Бусад санхүүгийн өр төлбөр | 43.0 | 401.0 | 891.0 | 11,998.7 | 14,575.8 |
| Нийт өр төлбөрийн дүн | 2,152.0 | 10,806.0 | 25,132.0 | 41,513.4 | 50,920.4 |
| Дүрмийн сан | 2,000.0 | 6,097.0 | 6,097.0 | 16,282.3 | 16,282.3 |
| Эрсдэлийн сангийн нөөц | | 109.0 | | | |
| Хуримтлагдсан ашиг | 399.0 | 2,632.0 | 7,794.0 | 8,728.7 | 14,833.3 |
| Нэмж төлөгдсөн капитал | | | 3.0 | 15,377.7 | 15,377.7 |
| Нийт эздийн өмчийн дүн | 2,399.0 | 8,838.0 | 13,894.0 | 40,388.7 | 46,493.3 |
| **Өр төлбөр, эздийн өмчийн дүн** | **4,551.0** | **19,644.0** | **39,026.0** | **81,902.1** | **97,413.7** |

*Хүснэгт **Error! No text of specified style in document.**-27 Инвескор ББСБ Орлого үр дүнгийн тайлан*

| Орлого, үр дүнгийн тайлан /сая.төг/ | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020Q2 |
|---|---|---|---|---|---|
| Хүүгийн орлого | 665.0 | 4,476.0 | 10,794.0 | 19,362.9 | 11,678.6 |
| Бусад орлого | 135.0 | 149.0 | 402.0 | 3,349.6 | 3,577.3 |
| Үйл ажиллагааны зардал | 236.0 | 1,007.0 | 3,475.0 | 10,990.8 | 7,324.0 |
| Бусад зардал | 43.0 | 244.0 | 572.0 | 177.5 | 84.8 |
| Зээлийн болзошгүй эрсдэлийн сан байгуулахаас өмнөх ү/а ашиг | 521.0 | 3,374.0 | 7,149.0 | 11,544.2 | 7,847.1 |
| Зээлийн болзошгүй эрсдэлийн зардал | 78.0 | 312.0 | 972.0 | 336.6 | 1,125.4 |
| Татварын өмнөх ашиг | 443.0 | 3,062.0 | 6,177.0 | 11,207.6 | 6,721.7 |
| Орлогын татварын зардал | 44.0 | 326.0 | 1,124.0 | 2,548.9 | 617.2 |
| Эрсдэлийн сангийн нөөц | | 109.0 | | | |
| **Татварын дараах цэвэр ашиг** | **399.0** | **2,628.0** | **5,054.0** | **8,658.7** | **6,104.5** |

Санхүүгийн мэдээлэл



СЭХ он сар өдөр 2021 01 06 БҮРТГЭВ № 01
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL 6317839 1119277128 УЛААНБААТАР ХОТ
2020-11-12 БҮРТГЭВ-02 ... K EXCHANGE
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК УЛААНБААТАР ХОТ
000245

<table>
<tr>
<td>6.1.2</td>
<td>Инвескор ББСБ эрсдэлийн удирдлага<br>"Инвескор" ББСБ ХК нь эрсдэлийн удирдлагын тогтолцоог бий болгох, бизнесийн үндсэн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх, бууруулах, хянах замаар хүлээж болзошгүй алдагдлыг бууруулах, хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээг ханган ажиллах үр дүнтэй, үр ашигтай хяналтын тогтолцоог бий болгоход чиглэсэн бодлогын бичиг баримтыг ТУЗ-с баталсан байна.</td>
<td>Үнэн зөв</td>
<td>"Инвескор ББСБ" ХК-ийн эрсдэлийн удирдлагын бодлого, тус бодлогын 1.1</td>
</tr>
<tr>
<td></td>
<td>Компани нь хамгаалалтын гурван бүсийн зарчимд тулгуурлан эрсдэлийн оновчтой удирдлагыг хэрэгжүүлэн ажилладаг. Бодлогын бичиг баримтад эрсдэлийг дараах байдлаар ангилан үздэг байна.
<table>
<tr><th>Эрсдэлийн хүчин зүйл</th><th>Эрсдэлийн удирдлага</th></tr>
<tr><td>Макро эдийн засгийн эрсдэл</td><td>Зах зээл, эдийн засгийн хямрал, ханш, хүү, инфляцын огцом өөрчлөлтүүд гэх макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг хянан шаардлагатай арга хэмжээг авч ажилладаг. Мөн шинэ бүтээгдэхүүн хөгжүүлж орлогын тогтвортой суурийг бий болгохыг зорин ажилладаг.</td></tr>
<tr><td>Хууль эрх зүйн орчин, хяналт зохицуулалтын эрсдэл</td><td>Хууль тогтоомж, дүрэм журам, ёс зүйн стандарт, байгууллагын дотоод бодлогыг даган мөрдөн, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааг хэрэгжүүлэн, харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг ханган ажиллаж байна.</td></tr>
<tr><td>Хүүгийн эрсдэл</td><td>Компани нь зээлийн бодлого, эрсдэлийн удирдлагын бодлого болон холбогдох бусад дотоод дүрэм, журмынхаа хүрээнд хүүгийн эрсдэлийг удирдлагыг хэрэгжүүлдэг. Энэхүү үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ зах зээлийн хүүгийн нөхцөл байдлын шинжилгээ болон бусад зохистой харьцаа, хязгаар үзүүлэлтийг харгалзан зээлийн хүүг эх үүсвэрийн өртөгтэй уялдуулан тогтоодог.</td></tr>
<tr><td>Зээлийн эрсдэл</td><td>Компани нь зээлийн үйл ажиллагаанд нөлөөлж болох гадаад хүчин зүйлсийн нөлөөллийг үнэлж, учирч болох эрсдэлийн түвшнийг тооцон, хязгаар үзүүлэлтийг тогтоож, зээлийн үнэ цэний бууралт,</td></tr>
</table>
</td>
<td colspan="2">Андеррайтерийн шинжилгээ<br>https://www.invescore.mn/view/article/?page=item&id=236</td>
</tr>
</table>

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | чанарын удирдлагын арга аргачлалыг сайжруулан, эрсдэлтэй зээлд баримтлах зарчим, арга ажиллагааг тодорхойлж, хэрэгжүүлэн ажилладаг. Мөн зээлийн хяналт, мониторингийн системийг автоматжуулан зээлийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг бууруулан ажилладаг. | | |
| | Үйл ажиллагааны эрсдэл | Дотоод процесс, хүний нөөц болон системийн үйл ажиллагааны доголдлоос бий болж болзошгүй аливаа эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, хянах, бууруулах, тайлагнах зэргээр эрсдэлийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэн ажилладаг. Мөн зээлийн үйл ажиллагааг бүрэн автоматжуулсан Smart LOS системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр хүний хүчин зүйлээс хамааран бий болж болзошгүй механик алдаа, харилцагчийн хуурамч бичиг баримт бүрдүүлэх зэрэг эрсдэлүүдийг бууруулж байна. | | |
| | Хөрвөх чадварын болон төлбөрийн чадварын эрсдэл | Компани нь валютын ханшийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор валютаар илэрхийлэгдсэн эх үүсвэрийн позицоо хянах, хэджинг хийх, валютын зээл гаргах замаар ханшийн эрсдэлийг тэнцвэржүүлж ажилладаг. Мөн ББСБ-ын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтмол ханган ажилладаг бөгөөд санхүүгийн мөнгөн урсгалаа тогтмол төлөвлөж, гүйцэтгэлд хяналт тавих болон санхүүгийн байгууллагад зээлийн эрх нээлгэх замаар хөрвөх чадварын эрсдэлээс сэргийлэн ажилладаг. | | |
| **6.2** | Микрокредит ББСБ<br>"Микро Кредит" ББСБ ХХК нь 2014 оноос хойш зээлийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт санхүүгийн зөвлөх үйлчилгээ, 2020 оноос итгэлцлийн үйлчилгээг тус тус явуулж байгаа. | | Үнэн зөв | "Микро кредит ББСБ" ХХК-ийн ТЗ 101/414 тоот тусгай зөвшөөрлийн гэрчилгээ |
| | Компани нь өнгөрсөн 5 жилийн хугацаанд Хорооны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтмол хангаж, банк санхүүгийн байгууллагаас авсан зээлийн үлдэгдлийг цаг хугацаанд нь тогтмол төлж чадсан байна. | | Андеррайтерийн шинжилгээ | |
| **6.2.1** | Микро Кредит ББСБ санхүүгийн үзүүлэлт | | | |



СЗХ он сар өдөр 2021 01 06 Б4 Г 1 9 В № 01
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL 6317839 УЛААНБААТАР ХОТ
000247
ХӨРӨНГИЙН БИРЖ STOCK EXCHANGE 2020 -11- 12 ЭВ-02
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК УЛААНБААТАР ХОТ

График **Error! No text of specified style in document.**-7 *Микро Кредит ББСБ санхүүгийн байдал*

| Нийт хөрөнгө /сая.төг/ | Өөрийн хөрөнгө /сая.төг/ |
|---|---|







*График* **Error! No text of specified style in document.**-8 *Микро Кредит ББСБ зээлийн багц, ашигт ажиллагаа*

| Зээлийн багцын хэмжээ /сая.төг/ | Цэвэр ашиг /сая.төг/ |
|---|---|

Санхүүгийн мэдээлэл

000248







*Хүснэгт* ***Error! No text of specified style in document.****-28 Микро Кредит ББСБ Санхүүгийн байдлын тайлан*

| Баланс /сая.төгрөг/ | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020Q2 |
|---|---|---|---|---|---|
| Мөнгөн хөрөнгө | 100.2 | 103.4 | 216.0 | 119.9 | 279.7 |
| Богино хугацаат хөрөнгө оруулалт | | | | | 15.6 |
| Зээл /цэврээр/ | 872.3 | 1,765.2 | 2,275.6 | 3,990.9 | 4,260.4 |
| Бусад авлага | 61.8 | 130.3 | 139.9 | 440.4 | 337.6 |
| Урьдчилж төлсөн зардал | 1.5 | 23.1 | 4.5 | 7.8 | 4.8 |
| Бусад хөрөнгө | 5.5 | 8.7 | 53.4 | 49.5 | 47.4 |
| **Нийт хөрөнгийн дүн** | **1,041.3** | **2,030.6** | **2,689.4** | **4,608.6** | **4,945.5** |
| | | | | | |
| Богино хугацаат өр төлбөр | 325.0 | 350.0 | 525.0 | 750.0 | 1,667.3 |
| Урт хугацаат өр төлбөр | | 500.0 | 706.3 | 600.0 | 200.0 |
| Өрийн бичгийн хүүгийн өглөг | 7.1 | 13.1 | 28.1 | 36.3 | 66.3 |
| Бусад өглөг | 5.6 | 19.5 | 15.2 | 30.4 | 43.6 |
| Нийт өр төлбөрийн дүн | 337.7 | 882.6 | 1,274.6 | 1,416.8 | 1,977.2 |

Санхүүгийн мэдээлэл



000249

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Хуримтлагдсан ашиг | 293.6 | 348.1 | 414.8 | 691.8 | 468.3 | |
| Энгийн хувьцаа | 410.0 | 800.0 | 1,000.0 | 2,500.0 | 2,500.0 | |
| **Өр төлбөр, эздийн өмчийн дүн** | **1,041.3** | **2,030.6** | **2,689.4** | **4,608.6** | **4,945.5** | |

*Хүснэгт* ***Error! No text of specified style in document.****-29 Микро Кредит ББСБ Орлого үр дүнгийн тайлан*

| **Орлого, үр дүнгийн тайлан /сая.төг/** | **2016** | **2017** | **2018** | **2019** | **2020Q2** |
|---|---|---|---|---|---|
| Хүүгийн орлого | 385.8 | 661.3 | 897.3 | 1,212.9 | 793.0 |
| Бусад орлого | | 3.3 | 0.3 | | 79.6 |
| Үйл ажиллагааны зардал | 145.6 | 259.1 | 372.8 | 359.5 | 315.2 |
| Бусад зардал | | 1.5 | 3.2 | | |
| Зээлийн болзошгүй эрсдэлийн сан байгуулахаас өмнөх у/а ашиг | 240.2 | 403.9 | 521.6 | 853.4 | 557.4 |
| Зээлийн болзошгүй эрсдэлийн зардал | 18.7 | 17.2 | 60.4 | 84.8 | 53.4 |
| Татварын өмнөх ашиг | 221.5 | 386.7 | 461.2 | 768.7 | 504.0 |
| Орлогын татварын зардал | 22.1 | 38.7 | 46.4 | 76.9 | 35.8 |
| **Татварын дараах цэвэр ашиг** | **199.3** | **348.1** | **414.8** | **691.8** | **468.2** |

Санхүүгийн мэдээлэл

**6.2.2** Микро Кредит ББСБ эрсдэлийн удирдлага

| **Эрсдэлийн хүчин зүйл** | **Эрсдэлийн удирдлага** |
|---|---|
| Хууль эрх зүйн орчин, хяналт зохицуулалтын эрсдэл | Хорооноос баталсан "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам", "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт тооцож, хяналт тавих тухай журам", Монгол банкны Ерөнхийлөгч, Санхүү Эдийн Засгийн сайдын хамтарсан тушаалаар баталсан "Активыг ангилах, активын |

Андеррайтерийн шинжилгээ



СЗХ 2021.01.06 өдөр БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2020-11-12
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL 6317839 1119277128 УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК 9020080754 6581463
000250

| | | |
|---|---|---|
| | эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-ыг мөрдлөг болгон ажилладаг. | Андеррайтерийн шинжилгээ |
| Хүүгийн эрсдэл | Хүүгийн өөрчлөлт нь хүүд мэдрэмжтэй актив, пассив болон хүүгийн ба хүүгийн бус цэвэр орлогын хэмжээнд нөлөөлдөг. Мөн өр төлбөрийн төлөгдөх хугацаа болон тэдгээрийн ирээдүйн мөнгөн урсгалын өртгийн үнэ цэнээр тооцдог. Түүнчлэн зээлийн хүү нь мөнгөний бодлого, инфляцын түвшин, төгрөгийн гадаад валюттай харьцах харьцаа, мөнгөний нийлүүлэлтийн хэмжээ, бизнес эрхлэгчдэд таатай орчин бүрдсэн эсэхээс ч хамааралтай учраас бүх хүчин зүйлсийг зээлийн хүүгийн бодлогод тусгах, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан шинэчилж байх чиглэл баримталдаг. | |
| Зээлийн эрсдэл | Зээлдэгчийн зээл авахыг хүссэн өргөдлийн эрсдэлийн түвшинд шинжилгээ хийж, зөвшөөрөгдөхүйц эрсдэл бүхий зээлийг сонгох болно. Зээлийн эрсдэлийг урьдчилан тооцоолох, болзошгүй эрсдэлээс сэргийлэх үүднээс зээлийн үнэлгээг тогтмол хийдэг. Зээлийн үйл ажиллагааны болзошгүй эрсдэлийг нарийн тодорхойлох, түүнийг хэрхэн зайлуулах талаар арга хэмжээ авч хэрэгжүүлдэг.Зээлийг хянахдаа дараах хүчин зүйлүүдийг анхаарна. Үүнд:<br>· Эрсдэлийн талаарх үнэлгээ<br>· Зээл төлөлт графикийн дагуу явж байгаа эсэх<br>· Олгогдсон зээлийн зориулалт<br>· Зээлдэгчийн бизнесийн үйл ажиллагааны явц<br>· Зээлийн гэрээний үүргийг дагаж мөрдөж байгаа эсэх | |



000251

| | | | |
|---|---|---|---|
| | Үйл ажиллагааны эрсдэл | Зээлийн үйл ажиллагааг бүрэн автоматжуулсан Марс системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн болзошгүй эрсдэлээс хамгаалан ажиллаж байна. | Андеррайтерийн шинжилгээ | |
| 7 | **ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ**<br><br>Үйлчилгээ үзүүлэгч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д заасны дагуу Зээлдэгчтэй харилцаж, хөрөнгийн багцтай холбоотой төлбөрийг цуглуулан ТЗК-д шилжүүлэх, бүртгэх, тайлагнах болон Үйлчилгээ үзүүлэх гэрээнд заасан хөрөнгийн багцтай холбоотой бусад үйлчилгээ, үйл ажиллагаа эрхлэхээр ТЗК-тай Үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулсан хуулийн этгээд байх ба Инвескор Актив ТЗК нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нартай харилцан тохирсны үндсэн дээр тэдгээр компаниуд болох Инвескор ББСБ, Микро Кредит ББСБ нартай Үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулсан байна. Багцын зээлийн хүүгийн болон үндсэн төлбөрийг Зээлдэгчдээс цуглуулж Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу ТЗК-ийн тогтсон дансанд шилжүүлэх үйлчилгээг Үйлчилгээ үзүүлэгчийн хувиар Инвескор ББСБ, Микро Кредит ББСБ нар үзүүлнэ. | Үнэн зөв | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19.1<br><br>Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ, тус гэрээний 2.1<br><br>"Инвескор актив" ХХК-ийн ТУЗ-ийн 2020.08.05-ны өдрийн 20/04 тоот тогтоол |
| | Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу Үйлчилгээ үзүүлэгчид нь зээлийн эргэн төлөлтийг өөрсдийн Төлбөр цуглуулах дансанд цуглуулж, сар тутам ТЗК-ийн Төлбөр гүйцэтгэх дансанд шилжүүлэх ба ТЗК нь Сарын төлбөр төлөх хуваарийн дагуу бүрэн төлөгдсөн Багцын эргэн төлөлт (зээлийн хүүгийн болон үндсэн төлбөр)-ийн дүнгийн 2%-тай тэнцэх хэмжээгээр Төлбөр цуглуулах үйлчилгээний хөлсийг улирлаар буюу сараар хуримтлуулан Үйлчилгээ үзүүлэгчид төлнө. | | Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээний 2.1.1, 4.1.1 |
| | Хэрэв Үйлчилгээ үзүүлэгч нь "Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих журам"-д заасан шаардлагыг хангахгүй болсон эсвэл журамд заасан бусад үндэслэл бий болсон тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Үйлчилгээ үзүүлэх гэрээг цуцлан 1 сараас ихгүй хугацаанд багтаан уг журамд заасан шаардлага хангахуйц дараагийн Үйлчилгээ үзүүлэгчийг сонгон Үйлчилгээ үзүлэх гэрээ байгуулан ажиллуулна. | | Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих журмын 4.1, 5.2 |
| 8.1 | **ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧ**<br><br>**Ерөнхий танилцуулга** | Андеррайтерийн шинжилгээ | |



000252

<table>
<tr><td></td><td>Хөрөнгө итгэмжлэн удирдагч болох “Рэдбэрал инвестмент энд менежмент” ХХК нь 2011 онд хөрөнгө оруулалт менежментийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх зорилготойгоор үүсгэн байгуулагдсан.</td><td colspan="2">“Рэдбэрал инвестмент энд менежмент” ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ</td></tr>
<tr><td></td><td>2013 оны 3-р сарын 13-нд Хорооны 74 дугаар тогтоолоор үнэт цаасны зах зээл дээр “Харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил үйлчилгээ” эрхлэх тусгай зөвшөөрлийг авч, үйл ажиллагаа явуулж байгаад 2016 оноос эхлэн зөвлөх үйлчилгээг түлхүү үзүүлж ирсэн байна. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, харилцагчийн үнэт цаас болон бусад хөрөнгийг итгэмжлэн удирдах үйл ажиллагааны чиглэлээр ажиллаж байгаа болно.</td><td colspan="2">Андеррайтерийн шинжилгээ<br><br>Санхүүгийн зохицуулах хорооны 2013.03.13-ны өдрийн 74 дүгээр тогтоол<br><br>http://www.frc.mn/resource/frc/uploads/file/d2df56050acc65174e1620c0686af299a6a176f8.pdf</td></tr>
<tr><td></td><td>
<table>
<tr><td>Хөрөнгө итгэмжлэн удирдагч</td><td>Рэдбэрал Инвестмент энд Менежмент” ХХК</td></tr>
<tr><td>Үүсгэн байгуулагдсан огноо</td><td>2011.10.03</td></tr>
<tr><td>Регистрийн дугаар</td><td>5520266</td></tr>
<tr><td>Санхүүгийн Зохицуулах Хорооноос тусгай зөвшөөрөл олгосон огноо, дугаар</td><td>2020 оны 08-р сарын 12<br>752</td></tr>
<tr><td>Тусгай зөвшөөрөл хүчинтэй эсэх</td><td>Хүчинтэй</td></tr>
<tr><td>Үйл ажиллагааны чиглэл</td><td>Хөрөнгө итгэмжлэн удирдах</td></tr>
<tr><td>Гүйцэтгэх удирдлагын мэдээлэл</td><td>Гүйцэтгэх захирал Б.Намуугэрэл</td></tr>
<tr><td>Хаяг</td><td>Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дугаар хороо, Олимп гудамж-5, Аюуд Тауэр 1503 тоот</td></tr>
<tr><td>5 болон түүнээс дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч, эзэмшлийн хувь хэмжээ</td><td>Монгол улсын иргэн С.Оргилмаа – 100%</td></tr>
</table>
</td><td>Үнэн зөв</td><td>“Рэдбэрал инвестмент энд менежмент” ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ,<br><br>“Рэдбэрал инвестмент энд менежмент” ХХК-ийн дүрэм<br><br>Санхүүгийн зохицуулах хорооны 2020.08.12-ны өдрийн ТЗ 316/16 дугаар тусгай зөвшөөрлийн гэрчилгээ</td></tr>
</table>



000253

“Рэдбэрал Инвестмент энд Менежмент” ХХК нь дараах бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлдэг болно.

✓ ***Баталгаат үнэт цаас гаргах ТЗК-ийн хөрөнгийг итгэмжлэн удирдах***

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн дагуу Тусгай зориулалтын компанийн гаргасан Баталгаат үнэт цаасыг хөрөнгө оруулагчийн эрх ашигт нийцүүлэн эзэмших, удирдах, хөрөнгө оруулагчид шаардлагатай тайлан, мэдээг гаргаж өгөх, хөрөнгийг удирдах буюу хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах, түүний хүсэл сонирхолд нийцүүлэн худалдан авах ажиллагааг хянах, хэрэгжүүлэх үйлчилгээ.

✓ ***Харилцагчийн үнэт цаас болон бусад хөрөнгийг итгэмжлэн удирдах***

Гадаад, дотоодын иргэн болон хуулийн этгээдийн олгосон итгэмжлэл, даалгаврын дагуу эзэмшиж буй хөрөнгөнд нь хяналт тавих, холбогдох тайлан мэдээллийг тогтмол илгээх, хууль журмаар хориглоогүй аливаа хэлцэл арилжаанд харилцагчийг төлөөлөн оролцох, холбогдох судалгаа шинжилгээг хийх, хөрөнгийн өгөөжийг өсгөн нэмэгдүүлэх, шинээр хөрөнгө оруулалт хийхэд зуучлах, хууль эрхзүй болон татварын асуудлуудыг шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх зэрэг үйлчилгээ багтана.

Андеррайтерийн шинжилгээ

8.2

**Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн санхүүгийн байдал**

*(төгрөгөөр)*

| Санхүүгийн үзүүлэлт | 2017.12.31 | 2018.12.31 | 2019.12.31 |
|---|---|---|---|
| Хөрөнгө | | | |
| Эргэлтийн хөрөнгийн дүн | 351,982,067.22 | 1,042,450,179.75 | 795,346,505.13 |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 26,077,456.90 | 183,159,082.99 | 168,047,703.98 |
| **Нийт хөрөнгийн дүн** | **378,059,524.12** | **1,225,609,262.74** | **963,394,209.11** |
| Богино хугацаат өр төлбөрийн дүн | 185,199,550.40 | 158,690,779.62 | 170,479,016.22 |
| Урт хугацаат өр төлбөрийн дүн | 0.00 | 123,416,404.23 | 114,395,460.71 |

Санхүүгийн мэдээлэл

000254

<table>
<tr><td></td><td><table><tr><td>Өр төлбөрийн нийт дүн</td><td>185,199,550.40</td><td>282,107,183.85</td><td>284,874,476.93</td></tr><tr><td>Өмч</td><td>400,000,000.00</td><td>1,150,000,000.00</td><td>1,150,000,000.00</td></tr><tr><td>Эздийн өмчийн дүн</td><td>192,859,973.72</td><td>943,502,078.89</td><td>678,519,732.18</td></tr><tr><td>Өр төлбөр ба эздийн өмчийн дүн</td><td>378,059,524.12</td><td>1,225,609,262.74</td><td>963,394,209.11</td></tr></table></td><td colspan="2">Санхүүгийн мэдээлэл</td></tr>
<tr><td>8.3</td><td>Компанийн Удирдлага<br><br>Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Компанийн тухай хуулийн дагуу хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр үүсгэн байгуулагдсан бөгөөд удирдлагын тогтолцоо нь тус компанийн дүрэмд заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага гэсэн бүтэцтэй байна.</td><td>Үнэн зөв</td><td>"Рэдбэрал инвестмент энд менежмент" ХХК-ийн дүрмийн 2.1, 8, 9, 10</td></tr>
<tr><td>8.3.1</td><td>Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх<br><br>Компанийн тухай хууль, Хорооны "ХБҮЦ гаргах бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-ын 3.11 дэх хэсэгт заасны дагуу болон Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байх бөгөөд Компанийн дүрэмд заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хувьцаа эзэмшигч өөрөө хэрэгжүүлэхээр байна.</td><td>Үнэн зөв</td><td>Компанийн тухай хуулийн 59.1<br><br>СЗХ-ны "ХБҮЦ гаргах бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-ын 3.11<br><br>"Рэдбэрал инвестмент энд менежмент" ХХК-ийн дүрмийн 8.1</td></tr>
<tr><td>8.3.2</td><td>Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх<br><br>Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн дүрэмд заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн эрх барих дээд байгууллага байхаар заасан байх бөгөөд 3 болон түүнээс дээш тооны гишүүнтэй байхаар заажээ. Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурлыг улиралд</td><td>Үнэн зөв</td><td>"Рэдбэрал инвестмент энд менежмент" ХХК-</td></tr>
</table>

<table>
<tr><td></td><td>1-ээс доошгүй удаа хийхээр заасан байх ба ээлжит бус хурлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга зарлан хуралдуулахаар заасан байна.</td><td></td><td>ийн дүрмийн 9.1, 9.6, 9.8, 9.9</td></tr>
<tr><td></td><td>Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн дүрэмд заасны дагуу Компанийн хэтийн чиглэл стратегийг тодорхойлох, хянаж үзэх, эрсдэлийн удирдлагын бодлого болон бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийг батлах, гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөх, гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөл, цалин урамшууллыг тогтоох, аудитын байгууллага сонгон аудит хийлгэх, ногдол ашиг хуваарилах болон бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр байна.</td><td>Үнэн зөв</td><td>“Рэдбэрал инвестмент энд менежмент” ХХК-ийн дүрмийн 9.15</td></tr>
<tr><td>8.3.3</td><td>ТУЗ-ийн гишүүд<br><br>“Рэдбэрал Инвестмент энд Менежмент” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь дараах гишүүдтэй байна.<br><br>
<table>
<tr><th>№</th><th>ТУЗ-ийн гишүүдийн нэр</th><th>Албан тушаал</th></tr>
<tr><td>1</td><td>Галсан овогтой Сурахбаяр</td><td>ТУЗ-ийн дарга</td></tr>
<tr><td>2</td><td>Пүрэв овогтой Ариунаа</td><td>ТУЗ-ийн хараат бус гишүүн</td></tr>
<tr><td>3</td><td>Төмөрбаатар овогтой Энхболд</td><td>ТУЗ-ийн гишүүн</td></tr>
</table></td><td>Үнэн зөв</td><td>“Рэдбэрал инвестмент энд менежмент” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчийн 2020.07.22-ны өдрийн ХЭ-20/02 дугаар шийдвэр</td></tr>
<tr><td>8.3.4</td><td>Удирдлагын багийн товч танилцуулга<br><br>ТУЗ-ийн дарга Г.Сурахбаяр<br><br>Г.Сурахбаяр нь МУИС - Хууль зүйн сургуулийн бакалавр, Япон Улсын Ёшива Их Сургуулийн Бенжамин Н.Кардозо хуулийн сургуулийн магистрын зэргийг тус тус хамгаалж, МУИС - Хууль зүйн сургуульд докторантаар суралцаж байгаа. Хууль эрх зүйн салбарт 20 жил ажилласан тэрээр Монгол Шуудан ТӨҮГ, Кью Жи Экс Монгол ХХК, Монголиан Барристерс энд Солиситорс ХХК-иудад тус тус ажиллаж байсан туршлагатай бөгөөд одоогоор БлакРок Партнерс ХХК-ийн гүйцэтгэх захирлаар ажилладаг.</td><td>Үнэн зөв</td><td>“Рэдбэрал инвестмент энд менежмент” ХХК-ийн 2020.08.20-ны өдрийн А20/14 дугаар албан бичиг</td></tr>
<tr><td></td><td>ТУЗ-ийн хараат бус гишүүн П.Ариунаа</td><td>Үнэн зөв</td><td>“Рэдбэрал инвестмент энд менежмент” ХХК-ийн 2020.08.20-ны</td></tr>
</table>

| | | | |
|---|---|---|---|
| | П.Ариунаа нь Хөдөө аж ахуйн их сургуулийн бакалавр, магистрын зэргийг тус тус хамгаалж, Монгол Улсын Их Сургуульд докторантаар суралцаж байгаа. Тэрээр аудитын салбарт 23 жил ажилласан туршлагатай бөгөөд одоогоор Конфиденсе аудит ХХК-ийн захирлаар ажилладаг. | | өдрийн А20/14 дугаар албан бичиг |
| | **ТУЗ-ийн гишүүн Т.Энхболд**<br><br>Т.Энхболд нь Банк, санхүү менежментийн дээд сургуулийн бакалавр зэрэгтэй бөгөөд банк санхүүгийн салбарт 14 жил ажилласан туршлагатай. Банкны салбарт эдийн засагч, ахлах ажилтан, хэлтсийн захирлын албыг тус тус хашиж байсан бөгөөд одоогоор РУС Финанс ББСБ-ын гүйцэтгэх захирлаар ажилладаг. | Үнэн зөв | “Рэдбэрал инвестмент энд менежмент” ХХК-ийн 2020.08.20-ны өдрийн А20/14 дугаар албан бичиг |
| | **Гүйцэтгэх захирал Б.Намуугэрэл**<br><br>Б.Намуугэрэл нь Тайвань Улсын И-Шоу Их Сургуулийн бакалавр зэрэгтэй. Банк санхүүгийн салбарт 5 жил ажилласан туршлагатай тэрээр “Эрдэнэс-Тавантолгой Майнинг ХХК”, “Силвер Лайт Секюритиз ҮЦК” ХХК, “Голомт Капитал ҮЦК” ХХК-иудад тус тус ажиллаж байсан бөгөөд одоогоор “Рэдбэрал Инвестмент энд Менежмент” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар ажилладаг. | Үнэн зөв | “Рэдбэрал инвестмент энд менежмент” ХХК-ийн 2020.08.20-ны өдрийн А20/14 дугаар албан бичиг |
| **8.4** | **Хөрөнгө итгэмжлэн удирдах журам**<br><br>Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь “Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааны журам”-ыг 2020 оны 08-р сарын 05-ны өдөр баталсан байна.<br><br>Уг журмын дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Үнэт цаас эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, хөрөнгийг холбогдох гэрээ болон журамд заасны дагуу шударгаар, зохих ёсоор итгэмжлэн удирдах, аливаа байдлаар зүй бусаар захиран зарцуулах, ашиглахгүй байх, өөрийн үйл ажиллагааг ТЗК-ийн ТУЗ-д тогтмол тайлагнаж байх, зөвхөн зөвшөөрөгдсөн үйл ажиллагааг явуулж, өөрт олгогдсон эрх хэмжээг хэтрүүлэн ашиглахгүй байх, хэлцэл эрхлэн гүйцэтгэгчийн хувиар болон хөрөнгө итгэмжлэн удирдагчийн хувиар ТЗК-ийг төлөөлж, ТЗК-д үйлчилгээ үзүүлэхдээ Компани болон түүнтэй холбоотой этгээдүүдийн эрх ашгийг өөрийн эрх ашгийн урд тавих зарчмыг үйл ажиллагаандаа удирдлага болгохоор заасан байна.<br><br>Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь дараах үйл ажиллагааг явуулж, Үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлнэ. Үүнд:<br><br>✓ Хөрөнгийн багцыг удирдах, хяналт тавих; | <br><br><br><br><br><br>Үнэн зөв | “Инвескор актив” ХХК-ийн ТУЗ-ийн 2020.08.05-ны өдрийн 20/04 тоот тогтоол<br><br>Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааны журмын 2.1 |

| | | | |
|---|---|---|---|
| | ✓ Хөрөнгө багц дахь хөрөнгөд өөрчлөлт оруулах хасах;<br>✓ Хөрөнгийн багц дах хөрөнгийг зохих журмын дагуу солих, багцаас хасах, Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах зэргээр захиран зарцуулах;<br>✓ Үнэт цаас эзэмшигчид болон эрх бүхий этгээдэд тайлан мэдээлэл өгөх;<br>✓ Үнэт цаас гаргагчид тайлан мэдээлэл өгөх;<br>✓ Төлбөр гүйцэтгэх дансанд цугларсан хөрөнгөд хяналт тавих;<br>✓ Үнэт цаас эзэмшигчдэд Үнэт цаасны төлбөр төлөх;<br>✓ Компанийн үйл ажиллагаанд зориулж зардал гаргах;<br>✓ Үйлчилгээ үзүүлэгчийн Төлбөр цуглуулах дансыг барьцаалах | | Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааны журмын 3.1 |
| | Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ТЗК-ийн өмнөөс Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс хөрөнгө хүлээн авах ба хөрөнгийн багц дахь данс бүртгэлийг өөрийн бусад зээлийн данс бүртгэлээс тусад нь хөтөлж, Үйлчилгээ үзүүлэгчээс зээлийн хөрөнгийн эргэн төлөлт, данс бүртгэлтэй холбоотой тайланг авч, тулган баталгаажуулах бөгөөд багцын хөрөнгөд өөрчлөлт оруулах, хасах, нэмэх ажиллагааг Үнэт цаас гаргагчийг төлөөлөн хийж гүйцэтгэнэ. | Үнэн зөв | Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааны журмын 3.2.2, 3.2.4, 3.3 |
| | Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ТЗК-ийн ТУЗ-өөс 2020 оны 08-р сарын 05-ны өдөр баталсан "Үнэт цаасны төлбөр төлөх, цуглуулах журам"-д заасны дагуу ТЗК-ийн дансанд цугларсан мөнгөн хөрөнгийг энэхүү танилцуулгын 4.5.2 дахь хэсэгт бичсэний дагуу захиран зарцуулах, үнэт цаас эзэмшигчдэд үнэт цаасны төлбөр төлөх ажиллагааг хийж гүйцэтгэнэ. | Үнэн зөв | Үнэт цаасны төлбөр төлөх, цуглуулах журмын 3.4, 4.6 |
| | ТЗК нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу гүйцэтгэх удирдлага болон ажилтангүй тул Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг дараах байдлаар удирдлагаар хангана. Үүнд:<br>✓ Компанийн нягтлан бодох бүртгэл хөтөлж, тайлан гаргах зэргээр нягтлан бодогчийн үүрэг гүйцэтгэх, Компанийн ТУЗ, холбогдох эрх бүхий байгууллага болон үнэт цаас эзэмшигчдэд тайлан мэдээ хүргэх ажиллагааг хийж гүйцэтгэнэ.<br>✓ Компанийн нарийн бичгийн үйлчилгээг үзүүлэх, Төлөөлөн удирдах зөвлөлийн болон хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах, хурлаас гарах шийдвэр тогтоолын төслийг боловсруулах, тэмдэглэл хөтлөх, хурлаар батлагдсан тогтоол шийдвэрийг хадгалах, хувийг эрх бүхий байгууллагад хүргүүлэх зэрэг ажиллагааг хийж гүйцэтгэнэ.<br>✓ "Эрсдэлийн удирдлага, дотоод хяналт хэрэгжүүлэх, эрсдэлийн сан байгуулах, сангийн хөрөнгийг зарцуулах тухай журам"-д заасны дагуу эрсдэлийн удирдлага хэрэгжүүлж, уг журамд заасны дагуу эрсдэлийг үнэлэн тодорхойлж, Үнэт цаас гаргагчийн ТУЗ-д мэдэгдэх бөгөөд уг ажиллагааг хийж гүйцэтгэх орон тооны Эрсдэл хариуцсан ажилтан ажиллуулна. | Үнэн зөв | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.12.5<br><br>Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааны журмын 4.1 |



"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL 6317839 1119277128 УЛААНБААТАР ХОТ
2021.01.06
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2020-11-12 БҮРТГЭВ-02
УЛААНБААТАР ХОТ ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК 9020080
000259

| | | | |
|---|---|---|---|
| | ✓ Компанийн шаардсан болон Компанитай гэрээгээр тохиролцсон бусад үйлчилгээг үзүүлнэ.<br><br>Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь өөрийн ажлыг ТЗК-ийн ТУЗ-д сар тутам тайлагнаж байх бөгөөд ТУЗ нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйл ажиллагаа, ажлын гүйцэтгэлд тогтмол хяналт тавьж, үүрэг өгч, биелэлтийг нь шалгана. | | Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааны журмын 5.1 |
| 8.5 | **Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг солих, үйл ажиллагааг зохицуулах журам**<br><br>Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь "Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн сонгох, солих журам"-ыг 2020 оны 08-р сарын 05-ны өдөр баталсан байна. | Үнэн зөв | Инвескор актив" ХХК-ийн ТУЗ-ийн 2020.08.05-ны өдрийн 20/04 тоот тогтоол |
| | ТЗК болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн байгуулсан Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлэх гэрээнд заасны дагуу дараах үндэслэлээр ТЗК-ийн санаачилгаар Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай байгуулах гэрээг цуцлахаар заажээ. Үүнд:<br><br>✓ Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тусгай зөвшөөрөл цуцлагдах, татан буугдах нөхцөл байдал үүссэн;<br>✓ Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлэх гэрээнд заасан ноцтой зөрчил гаргасан, эсхүл үүргээ биелүүлээгүй бөгөөд үүргийн зөрчил арилгах тухай ТЗК-ийн мэдэгдлийг хүлээн авсан болов зөрчлийг арилгаагүй;<br>✓ Гэрээнд заасан үйлчилгээг цаашид үзүүлэх боломжгүй болсон;<br>✓ "Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн сонгох, солих журам"-д заасан хөрөнгө итгэмжлэн удирдагчид тавигдах шаардлагыг хангахгүй болсон. | Үнэн зөв | Хөрөнгө итгэмжлэх удирдах үйлчилгээний гэрээний 8.2.1, 9.2.2 |
| | ТЗК нь "Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн сонгох, солих журам"-д заасны дагуу дээр заасан үндэслэл болон хууль тогтоомж, төрийн эрх бүхий байгууллагаас шаардсанаас бусад тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай байгуулсан гэрээг цуцлахгүй бөгөөд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ТЗК-ийн урьдчилан бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр гэрээг цуцлах эрхгүй тийнхүү цуцалсан тохиолдолд ТЗК болон үнэт цаас эзэмшигчдэд учирсан хохирлыг төлж барагдуулах үүрэг хүлээсэн байна. | Үнэн зөв | Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн сонгох, солих журмын 5.1, 5.4 |
| | Уг журам болон гэрээнд заасны дагуу ТЗК нь гэрээ цуцлах тухай мэдэгдэл хүргүүлснээс хойш 1 сараас ихгүй хугацаанд багтаан шинэ хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгон томилох бөгөөд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь тийнхүү шинээр томилогдох хүртэл хугацаанд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь | Үнэн зөв | Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн сонгох, |



000259

<table>
<tr><td></td><td>хууль тогтоомж болон энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ хэвийн, урьдын адил гүйцэтгэх бөгөөд шинэ хөрөнгө итгэмжлэн удирдагчтай хөрөнгийн багцын данс бүртгэл болон банк дахь дансны үлдэгдлийг тулган баталгаажуулж, үнэт цаас болон Хөрөнгийн багцтай холбоотой баримт бичгийг шилжүүлэх үүрэгтэй байна</td><td></td><td>солих журмын 5.2, 5.4<br><br>Хөрөнгө итгэмжлэх удирдах үйлчилгээний гэрээний 8.2.2</td></tr>
<tr><td>9.1</td><td>ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН<br><br>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааг зохицуулах хууль эрх зүйн зохицуулалт<br><br>Үнэт цаас гаргагч нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийн хувьд Монгол Улсын хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа дагаж мөрдөх бөгөөд дараах хууль тогтоомжийн холбогдох хэсэг нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааг зохицуулна. Үүнд:<br><br>
<table>
<tr><th>Эрх зүйн актын төрөл</th><th>Хууль тогтоомж</th></tr>
<tr><td>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааг зохицуулах ерөнхий хууль тогтоомж</td><td>✓ Иргэний хууль, 2002<br>✓ Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, 2001<br>✓ Компанийн тухай хууль, 2011<br>✓ Татварын ерөнхий хууль, 2019<br>✓ Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, 2019<br>✓ Хувь хүний орлогын албан татварын тухай хууль 2019<br>✓ Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль, 2009<br>✓ Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, 2013</td></tr>
<tr><td>Үнэт цаас гаргагчийн үнэт цаас гаргах үйл ажиллагааг зохицуулах хуулиуд</td><td>✓ Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, 2013<br>✓ Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, 2010</td></tr>
</table></td><td>Үнэн зөв<br><br>Үнэн зөв</td><td>Иргэний хууль<br><br>Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль<br><br>Компанийн тухай хууль<br><br>Татварын ерөнхий хууль<br><br>Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль<br><br>Хувь хүний орлогын албан татварын тухай хууль<br><br>Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль<br><br>Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль<br><br>Үнэт цаасны зах зээлийн тухай хууль<br><br>Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль<br><br>Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам</td></tr>
</table>

000260

| | | | |
|---|---|---|---|
| | <table><tr><td>Үнэт цаас гаргагчийн үнэт цаас гаргах үйл ажиллагааг зохицуулах Хорооны журмууд</td><td>✓ Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам, 2011<br>✓ Үнэт цаасны бүртгэлийн журам, 2015<br>✓ Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг тусгай тэмдэглэл хийж бүртгэх тухай журам, 2013<br>✓ Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам, 2015<br>✓ Үнэт цаасны зах зээл дэх дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээлэх журам, 2019<br>✓ Үнэт цаасанд нэгдсэн дугаар олгох журам, 2010</td></tr><tr><td>Үнэт цаас гаргагчийн үнэт цаас гаргах үйл ажиллагааг зохицуулах Биржийн журмууд</td><td>✓ Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам, 2020<br>✓ Үнэт цаасны бүртгэлийн журам, 2018<br>✓ Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам, 2018<br>✓ Арилжааны журам, 2017</td></tr><tr><td>Үнэт цаас гаргагчийн үнэт цаас гаргах үйл ажиллагааг зохицуулах ҮЦТХТ-ийн журмууд</td><td>✓ Үнэт цаасны хадгаламжийн журам, 2020<br>✓ Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бүртгэх үйл ажиллагааны журам, 2019</td></tr></table> | Үнэн зөв | Үнэт цаасны бүртгэлийн журам<br><br>Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг тусгай тэмдэглэл хийж бүртгэх тухай журам<br><br>Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам<br><br>Үнэт цаасны зах зээл дэх дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээлэх журам<br><br>Үнэт цаасанд нэгдсэн дугаар олгох журам<br><br>Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам<br><br>Үнэт цаасны бүртгэлийн журам<br><br>Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам<br><br>Арилжааны журам<br><br>Үнэт цаасны хадгаламжийн журам<br><br>Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бүртгэх үйл ажиллагааны журам |

СЗХ 2021.07.06 өдөр БҮРТГЭВ № 01

2020-11-12

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL 6317839 1119277128 УЛААНБААТАР ХОТ

ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК УЛААНБААТАР ХОТ

000261

**9.2** **Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон Хөрөнгийн багцтай холбоотой хууль эрх зүйн зохицуулалтууд**

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид нь банк бус санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдүүдийн хувьд тэдгээрийн үйл ажиллагаар дараах нарийвчилсан хууль тогтоомжоор зохицуулдаг болно.

| Эрх зүйн актын төрөл | Хууль тогтоомж |
|---|---|
| Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн үйл ажиллагаар тусгайлан зохицуулах хуулиуд | ✓ Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, 2002<br>✓ Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, 2001<br>✓ Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, 2013<br>✓ Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль, 2019<br>✓ Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль, 2015 |
| Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн үйл ажиллагаар зохицуулах Хорооны журмууд | ✓ Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам, 2016<br>✓ Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хорогдуулах, шинээр хувьцаа гаргах, худалдах, шилжүүлэхэд мөрдөх журам , 2020<br>✓ Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журамд түр хугацаанд өөрчлөлт оруулах тухай журам, 2020<br>✓ "Банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагаар тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам" батлах тухай журам, 2020<br>✓ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам, 2019 |

Үнэн зөв

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль

Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль

Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль

Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам

Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хорогдуулах, шинээр хувьцаа гаргах, худалдах, шилжүүлэхэд мөрдөх журам

Үнэн зөв

Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журамд түр хугацаанд өөрчлөлт оруулах тухай журам

"Банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2020 -11- 12
СЗХ 2021 01 06
000263

| | | | |
|---|---|---|---|
| | ✓ | | ажиллагаа тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам" батлах тухай журам<br>Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам |
| | Үнэт цаас гаргагчийн санал болгож буй баталгаат үнэт цаасыг баталгаажуулж буй Хөрөнгийн багцтай холбоотой харилцааг дараах хууль тогтоомжийн холбогдох хэсгээр зохицуулж байна.<br>✓ Иргэний хууль, 2002<br>✓ Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль, 2015<br>✓ Автотээврийн тухай хууль, 1999<br>✓ Автотээврийн хэрэгслийн бүртгэл, улсын дугаар олгох журам, 2019 | Үнэн зөв | Иргэний хууль<br>Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль<br>Автотээврийн тухай хууль<br>Автотээврийн хэрэгслийн бүртгэл, улсын дугаар олгох журам |
| 9.2.1 | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаастай холбоотой эрх зүйн зохицуулалт<br>Монгол Улсын хэмжээнд үнэт цаасыг нийтэд санал болгон гаргах, арилжих, бүртгэх, төлбөр, тооцоог гүйцэтгэх, хадгалахтай холбоотой харилцааг зохицуулж буй хууль тогтоомж нь 2013 онд батлагдсан Үнэт цаасны зах зээлийн тухай хууль бөгөөд тус хуулийн 3-р зүйлийн 3.2 дахь хэсэгт "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг гаргах, арилжихтай холбогдсон нийтлэг харилцааг энэ хуулиар, нарийвчилсан харилцааг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль тогтоомжийн дагуу зохицуулна" гэж заасны дагуу тус үйл ажиллагааг тусгайлан нарийвчилж зохицуулах зорилгоор Монгол Улсын Их Хурлаас 2011 онд Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийг баталжээ. | Үнэн зөв | Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, тус хуулийн 1.1, 3.2<br>Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль |
| | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт "Энэ хуулийн зорилт нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, түүнд хяналт тавих, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино" гэж заасан байх ба уг хуулиар хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч болон оролцогч этгээдүүдэд тавигдах шаардлага, хөрөнгийн багцад тавигдах шаардлага, баталгаат болон барьцаат үнэт цаас гаргах оролцогчдын хоорондын эрх | Үнэн зөв | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, тус хуулийн 1.1 |

СЗХ 2021.01.06 БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН MONGOLIAN STOCK EXC 2020-11-12 БҮРТГЭВ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL 6317839 1119277128 УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК УЛААНБААТАР ХОТ
000263

| | | | |
|---|---|---|---|
| | зүйн харилцаа, эрх үүрэг, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах асуудлыг тусгайлан зохицуулсан юм. | | |
| | Үнэт цаас гаргах үйл ажиллагаанд зөвшөөрөл олгох, зохицуулах төрийн эрх бүхий байгууллага болон үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаа явуулагч байгууллага нь мөн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэхтэй холбоотой үйл ажиллагааг тусгайлсан журмаар зохицуулжээ.<br><br>Хорооны "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 1.3 дахь хэсэгт "Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, хадгаламжийн бичиг гаргах болон бусад үүсмэл санхүүгийн хэрэгслийг бүртгэх харилцаа нь тус тусын үйл ажиллагааг нь тусгайлан зохицуулсан Хорооны журмаар зохицуулагдана" гэж заасны дагуу "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-ыг баталсан ба тус журмаар хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэх, түүнд хяналт тавих, үнэт цаас гаргагч болон уг зах зээлийн харилцаанд оролцогчдод тусгай зөвшөөрөл олгох, шалгуур үзүүлэлтийг тогтоох, эрх олгохтой холбогдсон харилцааг тусгайлан зохицуулж байна. | Үнэн зөв | СЗХ-ны Үнэт цаасны бүртгэлийн журам<br><br>СЗХ-ны Үнэт цаасны бүртгэлийн журмын 1.3<br><br>Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмын 1.1 |
| | Түүнчлэн Биржийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 1.4 дэх хэсэгт "Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, хадгаламжийн бичиг гаргах болон бусад үүсмэл санхүүгийн хэрэгслийг бүртгэхтэй холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулахгүй бөгөөд тусгайлсан журмаар зохицуулна" хэмээн заасны дагуу "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам"-ыг баталсан байна. Уг журмаар хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг тус биржийн бүртгэлд бүртгэх, бүртгэлийн шалгуур, шаардлагыг тогтоох, бүртгэлтэй байх хугацаанд үнэт цаас гаргагчийн гаргагчийн хүлээх үүрэг, түүнд хяналт тавих, бүртгэлээс хасахтай холбогдсон харилцааг зохицуулж байна. | Үнэн зөв | МХБ-ийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 1.4 |
| **9.2.2** | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн зохицуулалт<br>Монгол Улсын Компанийн тухай хууль нь компани үүсгэн байгуулах, бүртгүүлэх, өөрчлөн байгуулах, компанийн удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтэц, хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг тогтоох, компани татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулдаг болно. | Үнэн зөв | Компанийн тухай хуулийн 1.1 |
| | Тус хуулиар хувьцаа компани болон хязгаарлагдмал хариуцлагатай компани буюу "ХХК"-ийн хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтын асуудлыг зохицуулж, харин тусгай зориулалтын компанийн талаарх нарийвчилсан зохицуулалтыг агуулаагүй байдаг. | Үнэн зөв | Компанийн тухай хууль |



000264

| | | | |
|---|---|---|---|
| | | | |
| | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргагч нь тусгай зориулалтын компани байх ба тусгай зориулалтын компанийн үүсгэн байгуулагчид тавигдах шаардлага, дүрэмд тусгагдах асуудал, хориглох болон зөвшөөрөх үйл ажиллагаа, тэдгээрийг хэрэгжүүлэх субъектийн талаар тусгайлан зохицуулсан нь Компанийн тухай хуулийн зохицуулалтаас илүү нарийвчилсан буюу тусгайлан зохицуулсан зохицуулалттай байна. | Үнэн зөв | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 11.1 |
| | Тухайлбал, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу тусгай зориулалтын компани нь хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажилтан авч ажиллуулахыг хориглох бөгөөд хувьцаа эзэмшигчид нь Хорооны зөвшөөрөлгүйгээр үнэт цаас гаргагчийн хувьцааг бусдад худалдах, шилжүүлэхгүй байх, Хорооны зөвшөөрөлгүйгээр компанийн дүрэмд өөрчлөлт оруулахгүй байх зэрэг зохицуулалтуудыг тусгасан нь Компанийн тухай хуульд тусгагдаагүй онцгой харилцааг зохицуулсан байна. | Үнэн зөв | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.7, 12.12.5, 12.12.6 |
| | Мөн Хорооны “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам”-ын 3 дугаар зүйлд үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаатай холбоотойгоор түүний үүсгэн байгуулагчид тавигдах шаардлага, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд тавигдах шаардлага, төлөөлөн удирдах зөвлөлийн эрх хэмжээ, зарчим, үйл ажиллагааны тайлан мэдээ хүргүүлэх болон хөндлөнгийн аудит хийлгэх тухай нарийвчлан зохицуулсан байх тул Үнэт цаас гаргагч нь өөрийн үйл ажиллагаандаа Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон Хорооны баталсан тусгайлсан зохицуулалттай журмыг тэргүүн ээлжид мөрдөн ажиллах үүрэгтэй байна. | Үнэн зөв | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журмын 1.3, 3 |
| **10.1** | **ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА**<br><br>**Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах**<br><br>Үнэт цаасыг анхдагч зах зээлд гаргах арилжаа нь Биржийн ТУЗ-ийн 2015 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 2015/14 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”, Хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам” болон Биржийн ТУЗ-ийн 2012 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 02 тоот тогтоолоор баталсан “Арилжааны журам”-д заасны дагуу явагдана. | Үнэн зөв | МХБ-ийн Үнэт цаасны бүртгэлийн журам<br><br>СЗХ-ны Үнэт цаасны бүртгэлийн журам<br><br>МХБ-ийн Арилжааны журам |



СЗХ 2021.01.06 өдөр БҮРТГЭВ №11
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ... MONGOLIAN STOCK EX... 2020-11-1... БҮРТГЭВ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL 6317839 1119277128 УЛААНБААТАР ХОТ
000265
УЛААНБААТАР ХОТ ИНВЕСКОР АКТИВ ҮЗК ХХК 9020080754 6581463

| | | |
|---|---|---|
| | | |
| | Олон нийтэд санал болгож буй 40,000 ширхэг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг Хороо бүртгэсэн шийдвэр гарсан өдрөөс эхлэн ажлын 10 өдөр олон нийтэд танилцуулах ажлыг зохион байгуулах ба Үнэт цаасны захиалгыг ажлын 5 хоногт авч, анхдагч арилжааг 2020 оны 3-р улиралд багтаан явуулахаар байна.<br><br>*Зураг **Error! No text of specified style in document.**-2 Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах явц*<br><br> | Андеррайтерийн шинжилгээ, төлөвлөлт |
| 10.2 | **Үнэт цаасны арилжаанд оролцох, захиалга авах заавар**<br><br>*Зураг **Error! No text of specified style in document.**-3 Үнэт цаасны арилжаанд оролцох заавар* | Андеррайтерийн шинжилгээ<br><br>МХБ-ийн "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"<br><br>ҮЦТХТ-ын Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 04 сарын 30-ны өдрийн 06 тоот тогтоолоор баталсан "Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчдөх эрхийг бүртгэх үйл ажиллагааны журам"-ын 3.1<br><br>ҮЦТХТ-ын Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны 07 сарын 05-ны |



"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL 6317839 1119277128 УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2020 -11- 12 БҮРТГЭВ-02
2021 01 06
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК УЛААНБААТАР ХОТ
000266




өдрийн 7 тоот тогтоолоор баталсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг хадгалах, биржийн бус арилжаагаар өмчлөх эрх бүртгэх журам"-ын 4

10.3

**Үнэт цаасны арилжаа, хүүгийн төлбөр, эргэн төлөлтийн график**

*Хүснэгт **Error! No text of specified style in document.**-30 Үнэт цаасны төлбөрийн график*

| Огноо | А Транч | | | Б Транч | | |
|---|---|---|---|---|---|---|
| | ХБҮЦ үлдэгдэл | Үндсэн төлбөр | Хүү | ХБҮЦ үлдэгдэл | Үндсэн төлбөр | Хүү |
| 2020-09 | 3,400,000,000 | | | 600,000,000 | | |
| 2020-12 | 2,975,000,000 | 425,000,000 | 163,460,822 | 525,000,000 | 75,000,000 | 28,846,027 |
| 2021-03 | 2,550,000,000 | 425,000,000 | 120,304,110 | 450,000,000 | 75,000,000 | 21,230,137 |
| 2021-06 | 2,125,000,000 | 425,000,000 | 104,263,562 | 375,000,000 | 75,000,000 | 18,399,452 |

Андеррайтерийн шинжилгээ

Санхүүгийн мэдээлэл



000267

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2021-09 | 1,700,000,000 | 425,000,000 | 87,841,096 | 300,000,000 | 75,000,000 | 15,501,370 |
| 2021-12 | 1,275,000,000 | 425,000,000 | 70,272,877 | 225,000,000 | 75,000,000 | 12,401,096 |
| 2022-03 | 850,000,000 | 425,000,000 | 51,558,904 | 150,000,000 | 75,000,000 | 9,098,630 |
| 2022-06 | 425,000,000 | 425,000,000 | 34,754,521 | 75,000,000 | 75,000,000 | 6,133,151 |
| 2022-09 | 0 | 425,000,000 | 17,568,219 | 0 | 75,000,000 | 3,100,274 |
| Нийт | | 3,400,000,000 | 650,024,110 | | 600,000,000 | 114,710,137 |

**График нь зөвхөн төсөөлөл, бодит байдал дээр өөр байх боломжтой*

| | | | |
|---|---|---|---|
| 10.4 | **Үнэт цаас эзэмшигчийн эрх**<br><br>Үнэт цаас худалдан авагч нь дараах эрхийг эдэлнэ. Үүнд:<br>✓ Үнэт цаасны үнэ болон түүнийг худалдан авахтай холбоотой шимтгэл, хураамжийн үүргийг гүйцэтгэснээр Үнэт цаасыг эзэмшилдээ шилжүүлэхийг Үнэт цаас гаргагчаас шаардах;<br>✓ Үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийг тохиролцсон хугацаанд бүрэн төлөхийг шаардах;<br>✓ Үнэт цаасны хугацаанд Үнэт цаас гаргагчийн бизнесийн болон санхүүгийн үйл ажиллагааны талаар шаардлагатай мэдээ, мэдээлэлтэй танилцах;<br>✓ Үнэт цаас гаргагч нь төлбөр гүйцэтгэх үүргийн гүйцэтгэлийг бүрэн хангах боломжгүй тохиолдолд Үнэт цаасны холбогдох үндсэн болон хүүгийн төлбөр төлөхийг шаардах;<br>✓ Үнэт цаас гаргагч хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйн улмаас учирсан хохирлыг төлүүлэхээр шаардах;<br>✓ Үнэт цаас эзэмших эрхээ гуравдагч этгээдэд шилжүүлэх, захиран зарцуулах;<br>✓ Холбогдох хууль тогтоомж, гэрээгээр тодорхойлогдох бусад эрх. | Үнэн зөв | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлөх журам, болон Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах журмын холбогдох заалтууд |
| 10.5 | **Б Транч Үнэт цаас эзэмшигчийн арилжааны хязгаарлалт** | | "Инвескор актив ТЗК" ХХК-ийн ТУЗ-ийн 2020.08.20-ны |



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2020-11-12 БҮРТГЭВ-02
2021.01.06
InvesCore CAPITAL 6317839 1119277128 УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК УЛААНБААТАР ХОТ

| | | | |
|---|---|---|---|
| | А болон Б Транч үнэт цаас нь үндсэн нөхцөлийн хувьд ялгаагүй боловч Б Транч Үнэт цаас эзэмшигч нь ХБҮЦ-ны хугацааны турш эзэмшлийн үнэт цаасаа бусдад шилжүүлэхгүй байх үүрэг хүлээнэ. | | өдрийн 20/09 тоот тогтоол<br><br>Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний 4.1 |
| 10.6 | **Үнэт цаас гаргагчийн эрх, үүрэг**<br><br>Үнэт цаас гаргагч нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:<br>✓ Үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийг төлбөр гүйцэтгэх хуваарийн дагуу бүрэн төлж барагдуулах;<br>✓ Үнэт цаасны танилцуулгад тусгагдсаны дагуу Үнэт цаасны хүүгийн орлогод ногдох татварыг суутган төсөвт төлөх, тайлагнах;<br>✓ Холбогдох гэрээний дагуу хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас Үнэт цаас эзэмшигчид учруулсан аливаа хохирлыг үл маргах журмаар төлж барагдуулах;<br>✓ Хөрөнгө болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны санхүүгийн нөхцөлд нөлөөлөхүйц мэдээллийг Үнэт цаас гаргагчийн “Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах журам”-д заасны дагуу Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэх;<br>✓ Холбогдох хууль тогтоомж, Гэрээгээр тодорхойлогдох бусад үүрэг.<br><br>Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны хугацааны турш аль ч үед гаргасан үнэт цаасыг бүхлээр нь эсхүл хэсэгчлэн зах зээлийн үнээр нь худалдаж авах санал гаргаж болно. | | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлөх журам, болон Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах журмын холбогдох заалтууд |
| 10.7 | **Татвар**<br><br>Нэлттэй ХБҮЦ-ны хүүгийн орлогод тухайн орлогын дүнгээс, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 20.2.5 дахь заалт болон Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 20.1.5 дахь заалтын дагуу 5 хувийн татвар ногдуулна. | Үнэн зөв | Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль болон Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн холбогдох заалтууд |

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL 6317839 УЛААНБААТАР ХОТ
СЗХ 2021.04.06 өдөр БҮРТГЭВ № 01
ХӨРӨНГИЙН БИРЖ STOCK EXCHANGE 2020-11-12 ГЭВ-02
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК УЛААНБААТАР ХОТ
000269

| | | | |
|---|---|---|---|
| | Нээлттэй ХБҮЦ-ыг худалдан авснаар хөрөнгө оруулагчид очих татварын дараах дотоод өгөөжийн хувь 16% байхаар тооцоологдож байна. | Андеррайтерийн шинжилгээ | |
| | Үнэт цаас гаргагч нь энэхүү татварыг хүү олгохдоо Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 24.1 дүгээр заалт болон Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25.1.7 дахь заалтын дагуу суутган тооцно | Үнэн зөв | Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль болон Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн холбогдох заалтууд |
| | Нээлттэй ХБҮЦ-ны хугацааны туршид хөрөнгө оруулагч нь үнэт цаасаа хоёрдогч зах зээл дээр худалдах тохиолдолд худалдаж буй үнэ нь тухайн хөрөнгө оруулагчийн уг үнэт цаасыг худалдаж авсан үнэ болон тухайн хугацаанд хуримтлагдсан хүү, холбогдох арилжаанд оролцоход гарсан зардлуудын нийлбэрээс илүү гарсан тохиолдолд хувь хүний хувьд Хувь хүний орлогын албан татварын тухайн хуулийн 17.1.3 болон 21.2.4 дэх заалтын дагуу 10 хувиар, аж ахуйн нэгжийн хувьд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 20.1 эсвэл 20.2.7-д заасан хувь хэмжээгээр хөрөнгө борлуулсны орлогод ногдох албан татвар төлнө. | Үнэн зөв | Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль болон Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн холбогдох заалтууд |
| 11.1.1 | ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУДЫН МЭДЭЭЛЭЛ<br>Андеррайтер<br><br>Андеррайтерийн танилцуулга<br><br>InvesCore CAPITAL — “Инвескор Капитал ҮЦК” ХХК<br>Регистрийн дугаар: 6317839 | Олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэл<br>https://www.icapital.mn/contact | |

| | | | |
|---|---|---|---|
| | Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, Сөүлийн гудамж 10/1, Твин тауэр-1, 13 давхар<br>Утас: 77090077(2)<br>И-мэйл: info@icapital.mn | “Инвескор Капитал ҮЦК” ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ | |
| | “Инвескор Капитал ҮЦК” ХХК нь Монгол Улсын хөрөнгийн зах зээлд шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох, гадаадын хөрөнгө оруулалтыг татах замаар хөрөнгийн зах зээлийн эргэлтийг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулах, дотоодын хөрөнгө оруулагчдад олон улсын хөрөнгийн зах зээлээс өгөөж хүртэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор 2018 онд үүсгэн байгуулагдсан үнэт цаасны компани юм. Тус компани нь Хорооноос үнэт цаасны брокерын үйл ажиллагаа, үнэт цаасны дилерийн үйл ажиллагаа, үнэт цаасны андеррайтерийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авсан бөгөөд банк, санхүүгийн салбар, хөрөнгийн зах зээл, хууль эрх зүй, өмгөөллийн салбарт ажиллаж байсан чадварлаг хамт олонтой бөгөөд хөрөнгийн болон үнэт цаасны зах зээл, үнэт цаас, санхүүжилт татах, хувьцаа анх удаа нийтэд нээлттэй арилжаалах /IPO/, M&A, хөрөнгө оруулалт болон бизнесийн зөвлөгөө өгөх чиглэлээр мэргэшсэн туршлагатай юм. | https://www.icapital.mn/company<br>“Инвескор Капитал ҮЦК” ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ<br>“Инвескор Капитал ҮЦК” ХХК-ийн 3/113 тоот тусгай зөвшөөрлийн гэрчилгээ<br>Андеррайтерийн шинжилгээ | |
| **11.1.2** | Андеррайтертай байгуулсан гэрээ<br>Үнэт цаас гаргагч, Үүсгэн байгуулагчид нь “Инвескор Капитал ҮЦК” ХХК-тай 2020 оны 06 сарын 10-ны өдөр UWSA_200610/01 тоот “Андеррайтерийн болон зөвлөх үйлчилгээний гэрээ” байгуулах замаар Үнэт цаас гаргагч нь хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг Биржээр дамжуулан нээлттэй арилжаалах ажлыг зохион байгуулах андеррайтерийн болон зөвлөх үйлчилгээг үзүүлэхээр харилцан тохиролцжээ. Андеррайтер нь уг гэрээний дагуу үнэт цаас гаргах бэлтгэл хангах зөвлөх үйлчилгээ болон үнэт цаасыг Биржээр дамжуулан нийтэд санал болгох андеррайтерийн үйлчилгээг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Хорооны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам, Биржийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас бүртгэх тухай болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн үзүүлэхээр тохирсон байна. Гэрээг 6 сарын хугацаатай байгуулсан байх ба Гэрээнд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.4.3-д заасны дагуу хөрөнгө оруулагчид тухайн үнэт цаасыг танилцуулах замаар түүнийг худалдахад шаардлагатай бүх хүчин чармайлт гаргах хэлбэрээр андеррайтерийн үйлчилгээг үзүүлэхээр заажээ. | Үнэн зөв | 2020.06.10-ны өдрийн VWSA_200610/01 тоот Андеррайтерийн болон зөвлөх үйлчилгээний гэрээ |



СЗХ 2021 .04. 0 өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ STOCK EXCHANGE 2020 -11- 12 БҮРТГЭВ-02
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL 6317839 1119277128 УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК 9020080754 6581463
000271

| | | |
|---|---|---|
| Үүсгэн байгуулагчдын зүгээс Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу өөрсдийн автомашины зээлийн хөрөнгийг багцалж, дараах хэмжээ бүхий хөрөнгийг Хөрөнгө шилжүүлэх гэрээний үндсэн дээр Үнэт цаас гаргагчид шилжүүлэх ба 2 транчтай гаргасан үнэт цаасны эрсдэл өндөртэй транч болох 10 хувийг худалдан авах талаар тохиролцсон байна. | Үнэн зөв | Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний 4.1 |
| Андеррайтер, зөвлөх үйлчилгээний хүрээнд андеррайтер нь үнэт цаас гаргах ажлын төлөвлөгөө боловсруулах, хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр ашгийн тооцоо хийх, үнэт цаасны танилцуулга бэлтгэх, эрх бүхий этгээдэд үнэт цаасыг бүртгүүлэх хүсэлт гаргах, үнэт цаасыг танилцуулах аяныг зохион байгуулах, анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулахаар заасан байна. Андеррайтер нь өөрийн үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулах, үнэт цаас гаргагчийн зөвлөхийн хувиар хандан ажиллаж, гуравдагч этгээдтэй харилцах аливаа харилцаанд үнэт цаас гаргагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, мэдээллийн нууцлалыг хадгалах, задруулахгүй байх, задруулсан тохиолдолд хариуцлага хүлээх, үйлчилгээг ямарваа нэг байдлаар доголдолтой үзүүлсэн тохиолдолд тухайн доголдлыг өөрийн зардлаар арилгах зэрэг үүргийг тус тус хүлээсэн байна.<br>Үнэт цаас гаргагч нь андеррайтерт ажил, үүргээ гүйцэтгэхэд шаардагдах аливаа зөвшөөрөл, түүнчлэн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай мэдээ мэдээлэл, баримт бичгүүдийг гаргаж өгөх, үнэт цаас гаргах бэлтгэл ажлыг хариуцан гүйцэтгэх ажилтныг томилон ажиллуулах, мэдээллийг нууцлах, гэрээний үүргээ зөрчсөний улмаас андеррайтер болон аливаа гуравдагч этгээдэд учирсан хохирлыг бүрэн хариуцах, үнэт цаас гаргах үйл ажиллагааны маркетинг сурталчилгаа, танилцуулах аяны ажлыг андеррайтертай хамтран боловсруулсан маркетингийн төлөвлөгөөний явуулах бүх шаардлагатай нөхцөлийг хангах, стратегийн хөрөнгө оруулагчид танилцуулга хийх болон үнэт цаасыг нийтэд санал болгохтой холбоотойгоор танилцуулах аянд оролцох, танилцуулга хийх удирдах албан тушаалтан болон шаардлагатай мэргэжилтнүүдийг тодорхойлж, андеррайтертай хамтран ажиллуулах зэрэг үүргийг хүлээжээ.<br>Түүнчлэн гэрээгээр дотоод мэдээлэл эзэмшигчийн асуудлыг зохицуулсан байх бөгөөд дотоод мэдээллийг аливаа гуравдагч этгээдэд дамжуулах, худалдах, шилжүүлэх, үнэт цаас гаргагчийн хувьцааг биржээр болон гуравдагч этгээдээр дамжуулан худалдан авах, борлуулах, ашиг олох, мөн санхүүжилт татах, эрх бүхий этгээдүүд болон андеррайтерийн зөвшөөрөлгүйгээр олон нийтэд мэдээлэхийг дотоод мэдээлэл эзэмшигчид хориглосон байна. Мөн үнэт цаас гаргагч нь тогтоосон хугацаанд аливаа дотоод мэдээллийг андеррайтертай зөвшилцөлгүйгээр олон нийтэд мэдээлсэн, түүний улмаас үнэт цаасны үнэлгээнд нөлөөлөх, хөрөнгө оруулалт, санхүүжилт татах ажиллагаанд саад учруулсан, хөрөнгө оруулагчдад буруу мэдээлэл хүргэсэн болон бусад байдлаар андеррайтерийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд саад учруулсан тохиолдолд учирсан хохирлыг хариуцахаар өөрөө зохицуулжээ. | Үнэн зөв | 2020.06.10-ны өдрийн VWSA_200610/01 тоот Андеррайтерийн болон зөвлөх үйлчилгээний гэрээ |

| | | | |
|---|---|---|---|
| 11.2.1 | Зээлийн шинжилгээ гаргагч<br>Зээлийн шинжилгээ гаргагчийн танилцуулга<br>BDO — "БДО Аудит" ХХК<br>Регистрийн дугаар: 2546442<br>Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Нарны зам 62, Юнэскогийн гудамж, Юнион Бюлдинг, В блок, 1502 тоот<br>Утас: 77404040, 77404041<br>И-мэйл: info@bdo.mn<br>БДО Аудит" ХХК нь аудит, нягтлан бодох бүртгэл, зөвлөх үйлчилгээний дэлхийн тав дахь том сүлжээ юм. БДО-ийн дэлхий даяарх 60,000 гаруй ажилчид дэлхийн 152 орон дахь 1328 салбар оффисоороо дамжуулан зөвлөх үйлчилгээ үзүүлдэг бөгөөд Монгол Улс дахь оффис нь аудит, нягтлан бодох бүртгэл, зөвлөх үйлчилгээний салбарт 15 жилийн туршлагатай "Итгэлт Аудит" ХХК-ийн суурин дээр 2012 оны 12 дугаар сард Улаанбаатар хотод үүсгэн байгуулагдсан. Тус компани нь 2012 оны 8 сарын 08-ны өдөр Хорооны 259 тоот тогтоолын дагуу үнэт цаас гаргагчид аудитын үйлчилгээ үзүүлэх эрх авсан юм. "БДО Аудит" ХХК нь 2 партнер, 40 орчим мэргэжилтнүүдтэй бөгөөд аудит ба баталгаажуулалт, үнэлгээ ба шинжилгээ, бизнесийн зөвлөх үйлчилгээ, дотоод гадаад аутсорсинг, татвар ба хууль зүйн зөвлөгөө үзүүлэх үйл ажиллагаа явуулж байна. Тус компани нь Голомт Банк, Чингис Хаан Банк, Энэржи Ресурс, Эм Си Эс, Юнител, Витафит, Би Ди Сек, Багануур, Эрдэнэс Таван Толгой, Дархан Нэхий, Инвескор ББСБ зэрэг дотоодын шилдэг аж ахуйн нэгжүүдэд үйлчилгээ үзүүлсэн туршлагатай. | Олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэл<br>https://www.bdo.mn/mn-mn/about-us/bdo-history<br>2020.07.29-ний өдрийн цахим шуудан<br>"БДО Аудит" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ | |
| 11.2.2 | Зээлийн шинжилгээ гаргагчтай байгуулсан гэрээ<br>"БДО Аудит" ХХК нь үнэт цаас гаргагчтай 2020 оны 06-р сарын 10-ны өдөр "Тохиролцсон горимоор ажил гүйцэтгэх гэрээ"-г байгуулсан бөгөөд тус гэрээний дагуу зээлийн шинжилгээ гаргагч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон Хорооны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-ын шалгуур үзүүлэлтийн дагуу дөрвөн тэрбум хүртэлх үнийн дүнтэй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилгоор үйлчлүүлэгчийн гаргаж өгсөн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахад барьцаалагдах зээлийн багцаас түүвэрлэн шалгаж | Үнэн зөв | 2020.06.10-ны өдрийн Тохиролцсон |



СЗХ 2021.01.06 БҮРТГЭВ №31
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН MONGOLIAN STOCK EXC 2020-11-12 БҮРТГЭВ
"ИНВЕСКОР КАПИТАЛ" ХХК InvesCore CAPITAL 6317839 1119277128 УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК УЛААНБААТАР ХОТ
000273

| | | | |
|---|---|---|---|
| | шалгуур хангаж буй эсэхийг тогтоох, өөрийн сонгосон аргачлалын дагуу гэрээгээр тохирсон ажлын холбогдох хууль тогтоомж, "Олон Улсын Стандарт 4400"-д нийцүүлэн гүйцэтгэхээр тохирчээ.<br>Гэрээний дагуу "БДО Аудит" ХХК нь гэрээний хавсралтаар баталсан Ажлын даалгаварт заасан үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд, хичээл зүтгэл, үр дүнтэй хугацаанд нь гүйцэтгэх, үйлчлүүлэгчийн гарган өгсөн санхүүгийн баримт мэдээллийг зөвхөн гэрээт ажлын зорилгоор ашиглах, чанд нууцлах үүрэг хүлээсэн байх ба Үйлчлүүлэгч буюу Үнэт цаас гаргагч нь Зээлийн шинжилгээ гаргагчид шаардлагатай санхүүгийн болон бусад баримт бичгүүдийг тохирсон цаг хугацаанд нь үнэн зөв, иж бүрэн гаргаж өгөх, үйлчилгээний цар хүрээг хязгаарласан дарамт шахалт үзүүлэхгүй байх, үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай нөхцөлөөр хангах, төлбөрийг хугацаанд нь төлөх үүрэг хүлээсэн байна. | | горим гүйцэтгэх гэрээт ажлын захидал |
| **11.3. 1** | Хуулийн фирм<br>Хуулийн фирмийн танилцуулга<br><br>**MDSKhanLex** "Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН<br>Регистрийн дугаар: 5495997<br>Хаяг: Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай гудамж, Сентрал Тауэр, 13 давхар, 1301 тоот<br>Утас: 11330048<br>И-мэйл: info@mdsa.mn<br><br>"Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН нь 2011 онд байгуулагдсан. Тус фирмийн хуульчид нь олон улсын эрх зүйг үндэсний хууль тогтоомж, туршлагатай уялдуулан үндэсний болон олон улсын хөрөнгө оруулагчдад төрөл бүрийн салбарт эрх зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг. | Олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэл<br>https://mdskhanlex.com/mn/contact-us-2/<br>https://mdskhanlex.com/mn/home-2/<br>https://mdskhanlex.com/mn/knowledge-2/capital-market/<br>"Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ | |



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2020-11-12 БҮРТГЭВ-02
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL 6317839 1119277128 УЛААНБААТАР ХОТ
000274

| | | | |
|---|---|---|---|
| | “Эм Ди Эс энд ХаанЛекс” ХХН нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33.2.1-д заасан үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээр бүртгэгдсэн, үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд бөгөөд тус зах зээлээс санхүүжилт татаж буй компаниудтай хамтран ажиллаж байсан арвин туршлагатай. Үүнд, тухайлбал “Эрдэнэс Таван Толгой” ХК-ийн үнэт цаасыг олон улсын түвшинд санал болгох, Монгол, Хонг Конг, Лондонгийн хөрөнгийн биржүүд дээр хувьцааг нийтэд анх удаа санал болгох Wolf Төслийн Монголын хууль тогтоомжтой холбоотой зөвлөгөөг өгөх, эрх зүйн магадлан шалгалт хийх, хууль зүйн дүгнэлтийн төсөл боловсруулах, Монгол Улсын Хөрөнгийн Бирж дээр гаргасан анхны 100% даатгагдсан Эрчим бонд гаргах ажилд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх, хууль зүйн магадлан шалгалт хийх, хууль зүйн дүгнэлт гаргах, “ЛэндМН ББСБ” ХХК “Инвескор ББСБ” ХХК болон “Түмэн шувуут” ХХК-ийн IPO, “Хөвсгөл алтандуулга” ХК, “Сүү” ХК-ийн нэмэлт хувьцаа гаргах, “Лэнд МН ББСБ” ХК-ийн бонд, Монголын ипотекийн корпорацийн 1-13, 21, 23, 24 дэх орон сууцны ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас гаргах төсөл дээр хууль зүйн судалгаа шинжилгээ хийж, хууль зүйн дүгнэлт гаргах ажлуудыг тус тус гүйцэтгэсэн туршлагатай. | | |
| 11.3.2 | Хууль зүйн үйлчилгээний гэрээ<br>“Эм Ди Эс энд Хаан Лекс” ХХН нь Үнэт цаас гаргагчтай 2020 оны 06 сарын 10-ны өдөр Д-С06320/3 дугаар бүхий “Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г байгуулжээ. Гэрээний дагуу хуулийн фирм нь Үнэт цаас гаргагчийн Биржээр нийтэд санал болгох төслийн хүрээнд Монгол Улсын хуулийн дагуу төслийн бүтэц, оролцогч талууд, тэдгээрийн хооронд үүсэх харилцаа, хөрөнгөд тавигдах шаардлага зэргийг тодорхойлох, хөрөнгийн багцад шинжилгээ хийж тайлан гаргах, төслийн хүрээнд оролцогчдын хооронд байгуулах гэрээ/гэрээний төсөл хүчин төгөлдөр, хуульд нийцсэн эсэх, Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээлэл үнэн зөв, хуульд нийцсэн эсэх талаар хууль зүйн дүгнэлт гаргах, үнэт цаасыг МХБ-д бүртгүүлэх, Хорооноос холбогдох тусгай зөвшөөрөл авахтай холбогдсон асуудлаар хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр тохиролцсон байна..<br>Гэрээний дагуу хуулийн фирм нь өөрийн үүрэгт ажлаа тохиролцсон хугацаанд чанарын өндөр түвшинд гүйцэтгэх, гаргасан хөндлөнгийн шинжилгээний тайлан, хуулийн дүгнэлттэй холбогдуулан шаардлагатай тохиолдолд зөвлөмж гаргах, шалгасан материалын хүрээнд тайлбар, тодруулга өгөх, танилцуулга хийх, үйлчилгээ үзүүлэхдээ үнэн бодит мэдээллээр хангах үйлчилгээ үзүүлсэн талаар бүртгэл хөтлөх, тайлан гаргах, Үйлчлүүлэгчийн нууцыг чандлан хадгалах үүргийг тус тус хүлээсэн байна. Үнэт цаас гаргагч нь Хуулийн фирмд гэрээгээр тохиролцсон хууль зүйн үйлчилгээний хөлсийг хугацаанд нь бүрэн төлөх, үнэн зөв бодит мэдээлэл, шаардлагатай баримт, материалыг гаргаж өгөх, шаардлагатай тохиолдолд хамтран ажиллах үүргийг хүлээжээ. | Үнэн зөв | 2020.06.10-ны өдрийн Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ |

СЗХ он сар өдөр 2021.01.06 БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН MONGOLIAN STOCK EX 2020-11-12 БҮРТГЭВ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL 6317839 1119277128 УЛААНБААТАР ХОТ

ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК УЛААНБААТАР ХОТ

000775

| | | | |
|---|---|---|---|
| 12.1.1 | ХАВСРАЛТУУД: ХЭЛЦЭЛТЭЙ ХОЛБООТОЙ ГЭРЭЭ, ЖУРМУУД<br>Үнэт цаасжуулах хэлцлийн оролцогчидтой байгуулах гэрээнүүд<br>▪ Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид болох “Инвескор ББСБ” ХК, “Микро Кредит ББСБ” ХХК нартай Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ;<br>▪ Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид болох “Инвескор ББСБ” ХК, “Микро Кредит ББСБ” ХХК нартай Фидуцийн барьцааны гэрээ;<br>▪ Үйлчилгээ үзүүлэгчид болох “Инвескор ББСБ” ХК, “Микро Кредит ББСБ” ХХК нартай Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ;<br>▪ Хөрөнгө итгэмжлэн удирдагч болох “Рэдбэрал Инвестмент энд Менежмент” ХХК-тай Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлэх гэрээ;<br>▪ Үйлчилгээ үзүүлэгчид болох “Инвескор ББСБ” ХК, “Микро Кредит ББСБ” ХХК нартай Төлбөр цуглуулах дансны барьцааны гэрээ. | Үнэн зөв | Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ<br>Фидуцийн барьцааны гэрээ<br>Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ<br>Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлэх гэрээ<br>Төлбөр цуглуулах дансны барьцааны гэрээ |
| 12.1.2 | Үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулсан гэрээнүүд<br>▪Анхны үүрэг гүйцэтгүүлэгчдээс шилжүүлэн авах хөрөнгийн багцад Хорооны “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ын 2.9.11 дэх хэсэгт заасны дагуу зээлийн шинжилгээ хийлгэх гэрээг “БДО Аудит” ХХК-тай;<br>▪Анхны үүрэг гүйцэтгүүлэгчдээс шилжүүлэн авах хөрөнгийн багц болон баталгаат үнэт цаас гаргах төсөлтэй холбоотойгоор хууль зүйн дүн шинжилгээ хийж, тайлан гаргуулах тухай гэрээг “Эм Ди Эс Ханлекс” ХХН-тэй;<br>▪Үнэт цаас гаргах төсөлд андеррайтерийн үйлчилгээ авах зорилгоор Андеррайтерийн болон зөвлөх үйлчилгээний гэрээ “Инвескор Капитал ҮЦК” ХХК-тай. | Үнэн зөв | 2020.06.10-ны өдрийн Тохиролцсон горим гүйцэтгэх гэрээт ажлын захидал<br>2020.06.10-ны өдрийн Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ<br>2020.06.10-ны өдрийн Андеррайтерийн болон зөвлөх үйлчилгээний гэрээ |
| 12.1.3 | Бусад шаардлагатай гэрээ | | 2020.06.10-ны өдрийн Аудитын |

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ
000276
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК
УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020 -11- 12
БҮРТГЭВ-02
СЗХ 2021 01 06

| | | | |
|---|---|---|---|
| | ▪Хорооны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-ын 8.1 дэх хэсэгт заасны дагуу Компанийн үйл ажиллагаанд жилд нэгээс багагүй удаа аудит хийлгэхээр "Лидер Экаунт Аудит" ХХК-тай Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ;<br>▪Хорооны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-ын 3.20 дахь хэсэгт заасны дагуу Компанийн хөрөнгийн мэдээлэл хадгалах нэгдсэн систем хөгжүүлэх ажлыг гүйцэтгүүлэхээр "Дижитал Воркс" ХХК-тай Систем хөгжүүлэлтийн гэрээ. | | үйлчилгээ үзүүлэх гэрээ<br>2020.06.10-ны өдрийн ҮГ-200610-1 тоот Хөрөнгийн мэдээллийн систем хөгжүүлэлтийн ажил гүйцэтгэх гэрээ |
| 14.1.4 | Журмууд<br>▪ТУЗ-ийн үйл ажиллагааны журам<br>▪Хөндлөнгийн аудиторыг сонгох, солих журам<br>▪Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих журам<br>▪Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааны журам<br>▪Багцын хөрөнгөд өөрчлөлт оруулах, хөрөнгийг багцаас хасах тухай журам<br>▪Эрсдэлийн удирдлага, дотоод хяналт хэрэгжүүлэх, эрсдэлийн сан байгуулах, сангийн хөрөнгийг зарцуулах тухай журам<br>▪Үнэт цаасны төлбөр цуглуулах төлөх тухай журам<br>▪Компанийн Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах журам | Үнэн зөв | ТУЗ-ийн үйл ажиллагааны журам<br>Хөндлөнгийн аудиторыг сонгох, солих журам<br>Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих журам<br>Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааны журам<br>Багцын хөрөнгөд өөрчлөлт оруулах, хөрөнгийг багцаас хасах тухай журам<br>Эрсдэлийн удирдлага, дотоод хяналт хэрэгжүүлэх, эрсдэлийн сан байгуулах, сангийн |

| | | | |
|---|---|---|---|
| | | | хөрөнгийг зарцуулах тухай журам<br>Үнэт цаасны төлбөр цуглуулах төлөх тухай журам<br>Компанийн Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах журам |

~oOo~

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore
CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ



УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР
АКТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020 -11- 12

# АВТОМАШИНЫ ЗЭЭЛИЙН ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС (АЗХББ) ГАРГАХ ХЭЛЦЛИЙН ХҮРЭЭНД СОНГОГДСОН ЗЭЭЛИЙН ДАНСДЫН ХУУЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД НИЙЦСЭН ЭСЭХ ТАЛААРХ

## ХУУЛИЙН ХӨНДЛӨНГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

| | |
|---|---|
| **Хаана:** | **"Инвескор Актив" ХХК-д** |
| **Хаяг:** | **Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, Сөүл, 10/1, Твин тауэр-1, 13 давхар** |
| **Утас/Факс:** | **(976) 99099593, (976) 99119283** |

| | |
|---|---|
| **Хаанаас:** | **"Өмгөөллийн Эм Ди Эс энд ХаанЛекс" ХХН** |
| **Хаяг:** | **Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Сүхбаатарын талбай 2 Сэнтрал Тауэр, 13 давхар, 1301 тоот** |
| **Утас/Факс:** | **(976-11) 330048, (976-11) 330049** |

**Огноо:** **2020 оны 07-р сарын 24-ний өдөр**

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ХХК

СЗХ
2021 ... 0
БҮРТГЭВ
№ 01

MDSKhanLex

Монгол Улс, Улаанбаатар хот 14200
Сүхбаатар дүүрэг, Сүхбаатарын талбай 2
Сэнтрал Тауэр, 13 давхар, 1301 тоот

Утас: +976 11 330048
Факс: +976 11 330049
Олон улс: +1 (978) 9033574

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН
MONGOLIAN STOCK EXC
2020 -11- 1 2
БҮРТГЭВ-0

2020.07.24 № Ø-20/172

**“ИНВЕСКОР АКТИВ” ХХК-д**

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, Сөүл, 10/1, Твин тауэр-1, 13 давхар

**АВТОМАШИНЫ ЗЭЭЛИЙН ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС (АЗХББ)-ЫН ХЭЛЦЛИЙН ХҮРЭЭНД СОНГОГДСОН ЗЭЭЛИЙН ДАНСДЫН ХУУЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД НИЙЦСЭН ЭСЭХ ТАЛААРХ ХУУЛИЙН ХӨНДЛӨНГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Хүндэт Үнэт цаас гаргагч болон Хэлцэл эрхлэн гүйцэтгэгч танаа,

Тус “Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс” ХХН нь (цаашид “МДСХ” гэх) нь “Инвескор Актив” ХХК (цаашид “Инвескор Актив” буюу “Үнэт цаас гаргагч” гэх)-ийн хэрэгжүүлж буй автомашины зээлээр баталгаажсан баталгаат үнэт цаас (цаашид “**АЗББ**” гэх) гаргах үйл ажиллагаатай холбоотойгоор Үнэт цаас гаргагчийн хөндлөнгийн шинжээч, хуулийн зөвлөхөөр ажиллаж байна.

Хуулийн хөндлөнгийн шинжээчийн үйлчилгээ үзүүлэх ажлын даалгаврын хүрээнд МДСХ нь түүврийн аргаар сонгогдсон 62 зээлийн дансдад Инвескор Актив-аас ирүүлсэн ажлын даалгаварт заасан хуулийн шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхэд Инвескор ББСБ болон Микро Кредит ББСБ нар (цаашид хамтад нь “ББСБ” гэх)-ын зээлийн дансдад анхдагч шинжилгээгээр тодорхойлсон “ялгаатай шийдвэрлэгдсэн” асуудлыг харгалзан хөндлөнгийн хуулийн дүн шинжилгээ хийх (цаашид “Тайлан”, эсхүл “Дүн шинжилгээ”), түүнийг Инвескор Актив-д гарган өгөх үүрэг хүлээсэн.

Иймд дээр дурдсан үндэслэлээр МДСХ нь Үнэт цаас гаргагчийн хөндлөнгийн шинжээчийн хувиар энэхүү Тайланг гаргаж байгаа болно. Энэхүү Тайлан нь тухайлан зориулж гаргасан этгээдүүдээс бусад этгээдийн өмнө ямар нэгэн үүрэг хариуцлага бий болгохгүй. Энэхүү Тайлан нь зөвхөн Инвескор Активын шаардлага, тодруулгын дагуу гүйцэтгэгдсэн бөгөөд энэ нь аливаа гуравдагч этгээдэд ашигтай байх, эсхүл давуу байдлыг бий болгох мэдээлэл, баталгаа өгөх зорилгогүй болно.

Сонгогдсон зээлийн дансдын хувийн хэргийн бүрдүүлбэр материал, баримтуудад агуулагдсан дараах асуудлаар МДСХ нь хариуцлага хүлээхгүй болно. Үүнд:

1. Фидуцийн зүйлийн үнэлгээ нь зөв эсэх;
2. Зээлийн хувийн хэрэгт авагдсан гүйлгээний, кассын баримт, төлбөрийн баримтууд, бусад санхүүгийн анхан шатны баримтууд нь бодитоор үйлдэгдсэн, хүчин төгөлдөр, зохих шаардлага хангаж буй эсэх;
3. Зээлдэгч болон бусад холбогдох этгээдийн зээлийн хувийн хэрэгт авагдсан депозит дансны хуулга, хөрөнгийн жагсаалт, картын гүйлгээ, орлого тодорхойлох болон бусад санхүүгийн баримт бичгүүд, мэдээллүүд нь үнэн зөв, хүчин төгөлдөр, зохих шаардлага хангаж буй эсэх;
4. Фидуцийн зүйл болох тээврийн хэрэгслийн болон жолоочийн хариуцлагын даатгалын нөхцөлүүд нь эрсдлийг бүрэн хаасан, хүчин төгөлдөр эсэх;
5. Зээлдэгч автомашины зээлийг авах үед болон авснаас хойш санхүүгийн тооцоолол буюу ӨОХ, ЗҮХ нь зохих шаардлагыг хангасан эсэх;
6. Зээлдүүлэгч буюу ББСБ-ыг төлөөлөн гэрээ байгуулсан этгээд, эсхүл бусад үйл ажиллагаанд төлөөлөх этгээд (төлөөлөх гэдэгт гэрээ болон бусад аливаа шийдвэрт

“ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК” ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ



ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК
9020080754

гарын үсэг зурах, шийдвэр гаргах, тухайн харилцаанд үр дагавар бий болгосон үйлдэл, эс үйлдлийг хамааруулах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй) нь зээлдүүлэгчийг бүрэн төлөөлөх эрхтэй эсэх нь хууль ёсны байсан эсэх, итгэмжлэгдсэн эрх бүхий этгээд мөн эсэх;

7. Фидуцийн зүйл нь ашиглахыг хориглосон эвдрэл, гэмтэл, техникийн зөрчилтэй эсэх, ашиглахыг хориглосон тээврийн хэрэгслийн жагсаалтад багтсан эсэх;
8. Тээврийн хэрэгсэл /автомашин/ худалдах худалдан авах гэрээ нь зах зээлийн зарчмаар, бодитой хийгдсэн эсэх;
9. Зээлийн хувийн хэрэгт байгаа нотлох баримтуудыг гэрчилсэн нотариат, улсын бүртгэгчийн үйлдэл, тэмдэглэл нь үнэн зөв, хүчин төгөлдөр эсэх;
10. Зээлийн хувийн хэрэгт авагдсан зээлийн мэдээллийн сангийн лавлагаа нь үнэн зөв, алдаагүй, хүчин төгөлдөр эсэх, зээлдэгч нь шүүхийн шийдвэрийн дагуу төлбөл зохих өр төлбөртэй эсэх;
11. Зээлийн гэрээний хавсралт, зээлийн хэсэгчилсэн хуваарь, эргэн төлөлтийн хуваарь нь үнэн зөв, алдаагүй, зохих шаардлага хангасан, өөрчлөлт орох бүрт шинэчлэгдэж байгаа эсэх;
12. Түүврийн аргаар сонгосон зээлүүдээс бусад зээлтэй холбоотой асуудал;
13. Нотариатын гэрчилсэн, улсын бүртгэлд бүртгэгдсэн үйлдэл нь бодит эсэх.

Мөн ББСБ-ын зүгээс ач холбогдол бүхий баримт, мэдээллийг нуусан, орхигдуулсан, дүн шинжилгээний явцад танилцуулаагүй, буруу, дутуу танилцуулсан нөхцөлд үүсэх асуудлаар МДСХ хариуцлага хүлээхгүй.

Энэхүү албан бичиг Тайлангийн салшгүй хэсэг байна.

ХҮНДЭТГЭСЭН,

"ӨМГӨӨЛЛИЙН ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС" ХХН-ИЙН
ГИШҮҮН, ХУУЛЬЧ

Д.ДҮГЭРЖАВ

СЗХ
он сар өдөр
2021.01.06
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН Б
MONGOLIAN STOCK EXCH
2020-11-12
БҮРТГЭВ-02

АГУУЛГА


**НЭГ. УДИРТГАЛ** ..... 6

Дүн шинжилгээний зорилго ..... 6

Ажлын хийж гүйцэтгэсэн хугацаа, баг ..... 6

Тайлангийн үр өгөөж ..... 6

Сонгогдсон зээлийн дансдын мэдээлэл ..... 6

Дүн шинжилгээ хийсэн аргачлал ..... 8

Дүн шинжилгээ хийсэн арга зүй ..... 8

Тайлан гаргахад үндэслэл болгон ашигласан баримт бичиг ..... 8

Хангагдсанд тооцох нөхцөл ..... 10

Материал хадгалах хугацаа ..... 11

**ХОЁР. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ХОЛБОГДОХ ДҮГНЭЛТ** ..... 11

Шалгуур үзүүлэлт 1. Зээлийн хөрөнгө нь хууль зүйн хувьд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүрэн өмчлөлд байх бөгөөд Анхны зээлдүүлэгчээс бусад этгээдийн хувьд аливаа байдлаар үүргээс ангид байх ..... 11

Шалгуур үзүүлэлт 2. Зээлийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэсэн байх ..... 12

Шалгуур үзүүлэлт 3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид байгаа мэдээллээр, тасалбар болгох өдрийн байдлаар зээлийн гэрээ нь Үүрэг гүйцэтгэгчийн хувьд үүргээ хугацаанаас өмнө дуусгавар болгох/урьдчилан төлөх нөхцөл, хэлцлээс татгалзах, харилцан суутгал хийх замаар үүргийг дуусгавар болгох, сөрөг нэхэмжлэл гаргах, эсхүл үүргээс татгалзах (илт хохиролтой хэлцлийн улмаас үүргээс татгалзах нөхцөлийг хамааруулан) эрх үүсээгүй, эсхүл эрхээ хэрэгжүүлэх хүсэл зориг илэрхийлээгүй байх ..... 13

Шалгуур үзүүлэлт 4. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс тогтоосон хэмжээний урьдчилгаа төлбөр, холбогдох хураамж, шимтгэл, төлбөрийг төлсөн байх ..... 13

Шалгуур үзүүлэлт 5. Зээл нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд хууль, гэрээ эсхүл бусад байдлаар аливаа үүргээс ангид, бусдад шилжихийг хориглогдоогүй, эсхүл хязгаарлаагүй байх. ..... 14

Шалгуур үзүүлэлт 6. Холбогдох зээлийн гэрээний дагуу эсхүл түүнтэй холбоотойгоор үүсгэсэн фидуцийн эрх нь (а) үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргаар баталгаажсан, барьцаалсан, батлан даалт гаргасан болон үүргийн гүйцэтгэлийн хангуулах аргаар хамгаалагдаагүй аливаа бусад шаардлагаас давуу, тэргүүн ээлжинд шаардлага хангуулах боломжтой байх, (б) зохих ёсоор үүсгэгдэж хүчин төгөлдөр болсон, (в) тухайн үүргийн гүйцэтгэлийн хангуулах аргыг үүсгэхэд болон хүчин төгөлдөр болгоход Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ердийн практикт мөрддөг бүх дүрэм журмыг дагаж мөрдсөн, (г) тухайн үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргыг нотолж буй бүх баримт бичиг нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшил, хадгалалт хамгаалалтад байх. ..... 14

Шалгуур үзүүлэлт 7. Зээлтэй холбоотойгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон зээлдэгчийн хооронд байгуулсан фидуцийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд


"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЭХ ХХК

нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэсэн зээлдэгч үүргээ биелүүлээгүй тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч өмчлөгчийн эрхээ хэрэгжүүлж, худалдан борлуулж зээл, үүнтэй холбоотой бүх төлбөрийг гаргуулах боломжтой байх. ........ 15

Шалгуур үзүүлэлт 8. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь "Инвескор Актив" ХХК-тай байгуулах Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулах зорилгоор уг гэрээг байгуулах үед Хөрөнгийн жагсаалтад дурдагдсан фидуцийн хөрөнгүүдийг Инвескор Актив" ХХК-д барьцаалах агуулга бүхий гэрээ байгуулах болохоо батлан баталгаа гаргасан байх. ........ 15

**Нэгдсэн дүгнэлт.** ........ 16

ГУРАВ. САНАЛ/ЗӨВЛӨМЖ........ 17

Хавсралт 1. Түүврийн аргаар сонгогдсон зээлийн статус ........ 18

Хавсралт 2. Инвескор актив багцын өөрийн шинжилгээний явцад анхаарах банк бус санхүүгийн байгууллагад ялгаатай шийдвэрлэгдсэн асуудлын жагсаалт ........ 20



000284

СЭХ
2021 .01 сар 06 өдөр
БҮРТГЭВ
№ 31

...ОЛЫН ХӨРӨНГИ...
...LIAN STOCK EX...
2020 -11- 12
...ТГЭВ-...

## НЭГ. УДИРТГАЛ

### Дүн шинжилгээний зорилго

МДСХ нь АЗББ-ын хэлцэлд Инвескор Актив-аас жагсаалтаар ирүүлсэн санхүүгийн байгууллага (цаашид "Анхны үүрэг гүйцэтгүүлэгч", эсхүл "Зээлдүүлэгч" гэх)-уудаас худалдахаар санал болгосон нийт зээлийн хөрөнгийн нэгдсэн багцаас санамсаргүй түүврийн аргаар 95%-ийн итгэлцлийн түвшин, 5%-ийн хүлээгдэж буй алдааны хязгаартай байхаар сонгогдсон 62 зээлийн дансдад Инвескор Актив-аас ирүүлсэн ажлын даалгаварт дурдсан хуулийн шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхэд хөндлөнгийн хуулийн дүн шинжилгээ хийж, дүн шинжилгээний материалыг үндэслэн Тайлан гаргах зорилготой.

### Ажлын хийж гүйцэтгэсэн хугацаа, баг

МДСХ нь Хөндлөнгийн дүн шинжилгээг 2020 оны 06 дугаар сарын 17-ны өдрөөс 2020 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн хооронд ББСБ-уудын байранд ажиллаж гүйцэтгэлээ.

МДСХ-ийн хөндлөнгийн хуулийн дүн шинжилгээг 6 хүний бүрэлдэхүүнтэйгээр гүйцэтгэсэн. Үүнд:

| № | Овог | Нэр | Албан тушаал |
|---|---|---|---|
| 1. | Даш-Онолт | Дүгэржав | Нөхөрлөлийн гишүүн, хуульч, багийн ахлагч |
| 2. | Сүхээ | Сүрэнхүү | Ахлах хуульч |
| 3. | Мөнгөн | Ариунзул | Ассошейт |
| 4. | Нямдорж | Номин | Ассошейт |
| 5. | Жадамба | Нямбаяр | Ассошейт |
| 6. | Галбадрах | Номингоо | Ассошейт |

### Тайлангийн үр өгөөж

Энэхүү Тайланг үнэт цаасжуулах ажиллагаатай нь холбогдуулан зөвхөн Үнэт цаас гаргагч болон Хэлцэл эрхлэн гүйцэтгэгчид зориулан гаргасан бөгөөд энэхүү Тайлангийн үр өгөөжийг Үнэт цаас гаргагч, Хэлцэл эрхлэн гүйцэтгэгч хүртэх эрхтэй байна.

### Сонгогдсон зээлийн дансдын мэдээлэл

МДСХ нь Хөндлөнгийн дүн шинжилгээг хийхдээ санхүүгийн дүн шинжилгээ хийх хөндлөнгийн этгээдийн сонгосон зээлийн дансдтай давхардаагүй зээлийн дансдыг сонгож дүн шинжилгээ хийсэн. Зээлийн дансдыг сонгохдоо Инвескор Актив-аас хүргүүлсэн багцын жагсаалтаас дараахь зохистой гэж үзсэн харьцаагаар нийт 2 ББСБ-ын 515 зээлийн дансдаас санамсаргүй байдлаар түүвэрлэн нийт 62 зээлийг сонгож авсан. Санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон дансдын хамаарах мэдээллийг авч үзвэл:

Багцад хамрагдаж буй хуулийн этгээдүүдийн зээлийн дансдаас сонгосон зээлийн тоо нь нийт багцын бүтэцтэй ойролцоо буюу Зураг 1-д заасан байдлаар ББСБ-уудын зээлийн дансдыг сонгосон. *График 1. Санамсаргүй түүврийн аргаар ББСБ тус бүрээс сонгосон зээлийн дансдын тоо*

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ



000285

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЭК ХХК




Түүврээр сонгогдсон багцын зээл төлөгдөж дуусах огноо аль болох их буюу 2022 оны 08 дугаар сараас хойш төлөгдөж дуусах нийт 62 зээлийг сонгож шалгав. *График 2. 2022 оны 08 дугаар сараас хойш болон өмнө төлөгдөж дуусах зээлийн дансдын харьцаа*




Түүврээр сонгогдсон багцын зээл олгогдсон дундаж хугацаа 33 сараас их нийт 62 зээлийг сонгосон байна. *График 3. Зээл олгогдсон хугацаа 36 сараас их болон бага зээлийн дансдын харьцаа*




Зээлийн үлдэгдлийн хэмжээ 10,000,000 (арван сая) төгрөгөөс их нийт 62 зээлийг сонгон авсан. *График 4. Зээлийн үлдэгдлийн хэмжээ 10,000,000 төгрөгөөс их болон бага байх зээлийн дансдын тоо*



СЗХ
2021 .04 .06
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020 -11- 12

## Дүн шинжилгээ хийсэн аргачлал

Хөндлөнгийн дүн шинжилгээ хийхдээ сонгогдсон зээлийн дансны зээлийн хувийн хэрэг, түүнд агуулагдсан ББСБ-ын дотоод мэдээлэл, дүгнэлт, шийдвэр, бусад нотлох баримт, үйл баримтыг Инвескор Активтай урьдчилан тохиролцож, баталгаажуулан бэлтгэсэн шалгуур болон МДСХ-ийн зүгээс боловсруулсан шалгуурын дагуу шалгах, үнэлэх замаар санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон зээлийн дансдыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч буюу ББСБ-уудын байранд биечлэн гүйцэтгэсэн.

## Дүн шинжилгээ хийсэн арга зүй

Дүн шинжилгээ хийхдээ Инвескор Активын Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 20/03 дугаар "Хөндлөнгийн аудиторыг сонгох, солих журам, Хөрөнгийн багцад тавигдах шалгуур үзүүлэлтүүдийг батлах, эрх олгох тухай" тогтоолын Гуравдугаар хавсралтад тодорхойлсон АЗББ гаргах хэлцлийн хүрээнд худалдан авах хөрөнгийн багцад тавигдах хуулийн 8 шалгуур үзүүлэлт, тэдгээрийн хүрээнд МДСХ-ийн зүгээс боловсруулсан 69 шалгуур асуултын дагуу хууль тогтоомжийн хүрээнд ББСБ-уудын гаргаж өгсөн зээлийн дансны хувийн хэрэг, түүнд агуулагдсан материал болон Тайлан гаргахад үндэслэл болгон ашигласан баримт бичиг, хууль тогтоомжид тулгуурлан бэлтгэлээ. Инвескор Активын зүгээс өгсөн хөндлөнгийн шинжилгээнд зөрчилд тооцохгүй буюу "Инвескор Актив багцын өөрийн шинжилгээний явцад анхаарах банк бус санхүүгийн байгууллагад ялгаатай шийдвэрлэгдсэн асуудлын жагсаалт"-ыг Хавсралт 2-т тусгав.

Дүн шинжилгээ хийх явцад нэмэлт тодруулга, тайлбар, нотлох баримт шаардлагатай асуудлаар ББСБ бүрт тухай бүр цахим шуудан илгээж хариу тайлбар, нотлох баримтуудыг хүлээн авсан болно.

МДСХ нь сонгогдсон зээлийн дансыг шалгуур үзүүлэлтийн асуултын дагуу шалгаж шалгуур үзүүлэлтийн асуултад хариулах замаар үнэлсэн. Зээлийн данс нь шалгуур үзүүлэлтийг хангасан түвшингээр нь улаан, шар, ногоон өнгөөр ялгаж тодруулсан. Үүнд:

★ - Зээлийн гэрээ, фидуцийн гэрээний аль нэг нь, эсхүл түүний гол нөхцөлийг тодорхойлсон заалт нь хүчин төгөлдөр бусад тооцогдох эрсдэлтэй, хуулийн шаардлага хангаагүй зээлийн дансыг улаан өнгөөр тэмдэглэсэн.

☆ - Зээлийн гэрээ, фидуцийн гэрээний аль нэг нь, эсхүл түүний гол нөхцөлийг тодорхойлсон заалт нь эрсдэлтэй байж болзошгүй, эрсдлийн зэргийг дахин үнэлэх шаардлагатайг шар өнгөөр тэмдэглэсэн.

★ - Зээлийн гэрээ, фидуцийн гэрээ нь зээлийн дансны шалгуур үзүүлэлт, хуулийн шаардлага хангасан, хүчин төгөлдөр зээлийн дансыг ногоон өнгөөр тэмдэглэсэн.

Нэгдсэн дүгнэлтийг гаргахдаа зээлийн дансыг бүрдүүлж буй зээлийн гэрээ, фидуцийн гэрээний аль нэг нь улаан, шар өнгөөр тэмдэглэгдсэн нөхцөлд зээлийн данс нь эрсдэлтэй бүлэгт орохоор тооцож үнэлсэн.

Зарим зээлийн хувийн хэргийн бүрдүүлбэрийн талаар анхаарах асуудлыг Инвескор Активд мэдээлэл өгөх зорилгоор энэхүү Тайлангийн санамж/зөвлөмж хэсэгт дурдсан болно.

## Тайлан гаргахад үндэслэл болгон ашигласан баримт бичиг

Энэхүү Тайланг дор дурдсан материалуудын үндсэн дээр гаргасан болно. Үүнд:

1. Бидэнд нээлттэй, ил болгон өгөгдсөн Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс гаргаж өгсөн материалууд;
2. Хууль тогтоомж:

*Хууль*

2.1. Иргэний хууль (2002);
2.2. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль (2002);

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ



000287

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК

2.3. Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажилагааны тухай хууль (1995);
2.4. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль (2010);
2.5. Автотээврийн тухай хууль (2017);
2.6. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль (2015);
2.7. Зөрчлийн тухай хууль (2017);
2.8. Хөрөнгийн үнэлгээний тухай хууль (2010);
2.9. Зээлийн мэдээллийн тухай хууль (2011);
2.10. Нотариатын тухай хууль (2011);
2.11. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль (2017);
2.12. Даатгалын тухай хууль (2004);
2.13. Жолоочийн даатгалын тухай (2011);
2.14. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль (2009).

*Журам*

2.15. Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам (2011);
2.16. Монголын хөрөнгийн биржээс баталсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам (2020);
2.17. Монгол Улсын Шадар сайд, Зам, тээврийн хөгжлийн сайдын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2018 оны 192 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам (2018);
2.18. Засгийн газраас баталсан Замын хөдөлгөөний дүрэм (2018);
2.19. Бусад холбогдох хууль тогтоомж.



000289

СЗХ
2021.01.06
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГ
MONGOLIAN STOCK E
2020 -11- 1
БҮРТГЭВ



Энэхүү Тайланг боловсруулахдаа бид дараах нөхцөл хангагдсан гэж үзсэн болно. Үүнд:

1. Бидний судлан шинжилсэн бүх баримт бичгийн хуулбар, эсхүл маягтууд нь үнэн зөв, тэдгээр дээрх тэмдэгтийн хураамжийн төлбөр нь төлөгдсөн гэсэн тэмдэглэгээ болон бусад аливаа тэмдэглэгээ, гарын үсэг, тамга тэмдэг нь үнэн;
2. Бүх баримт бичгүүд нь тэдгээрийг үйлдсэн талуудын бүрэн эрхийн хүрээнд үйлдэгдсэн бөгөөд, одоо хүчин төгөлдөр байгаа, цаашид хүчин төгөлдөр хэвээр байх бөгөөд тэрхүү баримт бичгийн талуудын тухайн баримт бичгийн дагуу хүлээсэн үүрэг нь бүх холбогдох хуулийн хүрээнд бүрэн хүчин төгөлдөр хэрэгжинэ;
3. Бидэнд өгөгдсөн аливаа баримт бичгийн хуулбар нь тухайн баримт бичгийн эх хувьтайгаа нийцсэн бөгөөд тэдгээрийг бүрэн хуулбарласан, цаашид ямар нэгэн өөрчлөлт орохгүйгээр хүчин төгөлдөр хэрэгжинэ;
4. Зээлийн хувийн хэрэгт авагдсан зээлийн гэрээ, фидуцийн гэрээ нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид эх хувиар хадгалагдаж байгаа;
5. Бидэнд өгөгдсөн баримт бичгийн дагуу үүсэх аливаа үүрэг нь Монгол Улсаас бусад эрх зүйн тогтолцоонд хүчин төгөлдөр байх ба тэдгээр үүргийн хэрэгжилт хууль бус, хүчин төгөлдөр бус, эсхүл хэрэгжих боломжгүй биш байна;
6. Монгол Улсаас өөр улсад үйлдэгдсэн аливаа баримт бичиг нь тийнхүү үйлдэгдсэн улсын хуулийн шаардлагыг хэлбэрийн болон агуулгын хувьд бүрэн хангасан, хүчин төгөлдөр баримт бичиг ба тэдгээрийн хэрэгжилт нь тийнхүү хэрэгжих улсын хуулийн шаардлагыг мөн хангасан болно;
7. Тухайн баримт бичгүүд дээр шүүх, төрийн байгууллага болон бусад эрх бүхий байгууллагаас авах шаардлагатай зөвшөөрөл, батламжийг авсан, зохих шийдвэр гарсан, тэдгээр баримт бичгийг хүчин төгөлдөр болгоход шаардагдах аливаа бусад хэлцэл хийгдсэн, бусад баримт бичгүүд үйлдэгдсэн;
8. Шүүхийн шийдвэрийн өр төлбөртэй эсэх талаарх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын албан ёсны тамга тэмдэг, хэвлэмэл хуудас бүхий лавлагаа, эсхүл Төрийн үйлчилгээний цахим (ТҮЦ) машины албан ёсны хэвлэмэл хуудас бүхий лавлагаа нь зээлийн хувийн хэрэгт байх тохиолдолд тус лавлагааг авахад шаардлагатай аливаа хураамж, төлбөрийг төлсөн;
9. ББСБ, түүний ажилтнуудаас аливаа хэлбэрээр хүлээн авсан аливаа мэдээлэл нь үнэн зөв, бодитой;
10. Зээлдэгчид зээл олгохын өмнө ББСБ-ууд фидуцийн зүйл болох тээврийн хэрэгсэл, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, гаалийн мэдүүлгийг авч шалгадаг.

Бид дараах нөхцөлөөр тайланг боловсруулсан болно. Үүнд:

1. Энэхүү Тайланд өөрөөр дурдсанаас бусад тохиолдолд энэхүү судалгаа шинжилгээ нь зөвхөн хууль зүйн асуудлаар хийгдсэн бөгөөд автомашины зээлтэй холбоотой дурдагдсан аливаа тоон мэдээллүүдийн талаар бид нарийн мэдлэггүй, тэдгээрийн үнэн зөв байдлыг тогтоохгүй болно;
2. Энэхүү Тайланд өөрөөр дурдсанаас бусад тохиолдолд бидний хийсэн ажил энэхүү Тайлангийн тайлбар хэсгийн судалгаа шинжилгээний ажлын хүрээгээр хязгаарлагдаж байгаа болно;
3. Энэхүү Тайланд тусгайлан дурдсанаас бусад аливаа судалгаа, шинжилгээ, асуулга хийгдээгүй болно. Тийнхүү хийгдээгүй судалгаа, шинжилгээ, асуулгын үндэс болсон аливаа мэдээлэл, бүртгэл нь бүрэн биш, шинэчлэгдээгүй, жишээ нь, тухайн баримт бичиг нь холбогдох эрх бүхий байгууллагад бүртгэгдээгүй, хувийн хэргээс устсан, алга болсон эсхүл бусад байдлаар хувийн хэрэгт байхгүй болсон байж болно;
4. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүх баримт бичиг, гэрээ, төлөвлөгөө, харилцаа холбоо, зөвшөөрөл, хувийн хэрэгтэй танилцсан, тэдгээрийг судалсан гэх амлалтыг энэхүү судалгаа шинжилгээтэй холбоотой бид гаргахгүй болно;

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ



000289

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЭК ХХК

5. Бидний судалгаа шинжилгээ нь энэхүү Тайлан гарах үед хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа Монгол Улсын хуулийн хүрээнд хийгдсэн бөгөөд бид өөр бусад эрх зүйн тогтолцооны холбоо, хамаарал, нөлөөллийн талаар ямар нэгэн үзэл бодол илэрхийлээгүй болно;
6. Түүврийн аргаар сонгосон зээлийн дансдаас бусад зээлийн данстай холбоотой дүгнэлт гаргаагүй болно;
7. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ажлын байранд гаргуулан үзсэн автомашины зээлийн хувийн хэргүүдэд хийсэн судалгаа нь зээлийн хувийн хэргүүдийн ерөнхий төлөөлөл, эсхүл тэрхүү хувийн хэргүүдийн багцын төлөөлөл, эсхүл аливаа ерөнхий дүгнэлт, санал гаргахад хангалттай статистик мэдээлэл болж тайлбарлагдахгүй, тооцогдохгүй болно.
8. Фидуцийн зүйл болох автомашины бүрэн бүтэн байдал, эдэлгээ, чанарын талаар бид нарийн мэдлэггүй, тэдгээрийн болон түүний эзэмшлийн талаарх нөхцөл байдлыг тогтоохгүй болно.

Энэхүү Тайланг гаргахдаа Холбогдох гэрээнүүд хуульд заасны дагуу зохих ёсоор, үнэн зөв, бүрэн гүйцэд байдлаар байгуулагдаж, эрх бүхий этгээдээр батлуулан, автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа байгууллага (Авто тээврийн үндэсний төв)-д бүртгүүлсэн гэж үзсэн болно.

### Материал хадгалах хугацаа

МДСХ нь Тайлан гаргахад ашигласан болон судалгаа шинжилгээнд хамруулсан зээлийн данс бүрийг шалгаж баримтжуулсан баримт бичиг, эцсийн тайланг Үнэт цаас гаргагчид хүлээлгэж өгснөөс хойш 2 (хоёр) жилийн хугацаанд хадгална.

## ХОЁР. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ХОЛБОГДОХ ДҮГНЭЛТ

### Шалгуур үзүүлэлт 1. Зээлийн хөрөнгө нь хууль зүйн хувьд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүрэн өмчлөлд байх бөгөөд Анхны зээлдүүлэгчээс бусад этгээдийн хувьд аливаа байдлаар үүргээс ангид байх.

МДСХ нь нэгдүгээр шалгуур үзүүлэлтийн хүрээнд санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон нийт 62 зээлийн дансны зээлийн гэрээ, фидуцийн гэрээ нь хүчин төгөлдөр эсэх, фидуцийн гэрээний дагуу тээврийн хэрэгсэл буюу автомашин нь улсын бүртгэлд бүртгэгдсэн эсэх, мөнгөн төлбөрийн үүрэг болон фидуцийн зүйлийг шаардах эрх нь аливаа үүргээс ангид байсан эсэхийг нягталж шалгалаа.

ББСБ-ын үндсэн зээлдэгч, эсхүл хамтран зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, фидуцийн гэрээг нотариатаар гэрчлүүлсэн эх хувийг, фидуцийн зүйлийн өмчлөгчөөр бүртгэгдсэн авто тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбар хувийг шалгасан. Фидуцийн гэрээний дагуу фидуцийн зүйл болох автомашиныг Зээлдүүлэгч өмчилж буй боловч автомашиныг Зээлдэгч эзэмшиж ашигладаг байна. Монгол Улсын замын хөдөлгөөний дүрмийн 3.1, Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 8[1]-д зааснаар механикжсан тээврийн хэрэгслийн жолооч нь тухайн тээврийн хэрэгслийн бүртгэлийн гэрчилгээтэй байх ба тээврийн хэрэгслийн гэрчилгээ холбогдох бусад баримт бичгийн хамт тээврийн хэрэгслийг жолоодохоор заажээ. Ийнхүү тус хууль тогтоомжийн дагуу ББСБ нь тээврийн хэрэгслийн гэрчилгээг эх хувиар нь хадгалах ба хуулийн хөндлөнгийн шинжээчид үзүүлэх боломжгүй байна.

Автотээврийн тухай хуулийн 17.1, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 21.2-д тус тус заасны дагуу бүх тээврийн хэрэгслийн гэрчилгээг авто тээврийн хэрэгслийн бүртгэлийн байгууллагаас олгосон байна. Тээврийн хэрэгслийн гэрчилгээ (хуулбар хувь)-г бүртгэлийн байгууллага бүртгэж, баталгаажуулсан эсэхийг бүртгэгчийн тамга, тэмдэглэгээгээр гэрчилснээс үзвэл фидуцийн зүйл тээврийн хэрэгсэл нь зохих ёсоор бүртгэгдэж, тээврийн хэрэгслийн гэрчилгээ "Инвескор ББСБ" болон "Микро Кредит ББСБ" нарт олгогдсон байна. Түүнчлэн,

[1] Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 8.*Замын хөдөлгөөний дүрэмд заасан баримт бичиггүй тээврийн хэрэгсэл жолоодсон бол хүнийг хорин таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно*



000290

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 21.2-т "Импортоор оруулж ирсэн тээврийн хэрэгсэл, түүний хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөх хийцийн бүрэлдэхүүн хэсэг, нэмэлт тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл нь зохих техникийн норм, дүрэм, стандарт, замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагыг бүрэн хангасан байх бөгөөд холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу техникийн хяналтын үзлэг, оношилгооны дүгнэлт буюу гэрчилгээгээр баталгаажсан байна", 21.4-д "Замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлага хангасныг гэрчлэх шинжлэх ухааны холбогдох байгууллага, эсхүл техникийн хяналтын үзлэг, оношилгооны дүгнэлтгүйгээр тухайн тээврийн хэрэгслийг бүртгэхийг хориглоно", Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журмын 2.7.3-д "техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй, тэнцээгүй, жолоочийн хариуцлагын даатгалд даатгуулаагүй бол автотээврийн хэрэгслийг бүртгэхээс татгалзана" гэж тус тус заасны дагуу фидуцийн зүйл болох тээврийн хэрэгсэл нь хуульд заасан техник хяналтын үзлэгт хамрагдсан гэж үзэж байна.

Иймд дүн шинжилгээ хийх явцад зээлийн дансны хувийн хэрэгт авагдсан материал, ББСБ-ын өгсөн нэмэлт мэдээллийн дагуу зээлийн дансыг бусад гуравдагч этгээдэд худалдах, уг зээлийн мөнгөн хөрөнгө, зээлийн хүүгийн төлбөрийн шаардах эрх, фидуцийн зүйлийн шаардлагыг бусдын өмнө үүрэг хүлээсэн аливаа хэлцлийн үүргийн гүйцэтгэлд тавьсан нөхцөл байдал илрээгүй учир сонгогдсон зээлийн дансдын фидуцийн зүйл болох авто машин нь анхны зээлдүүлэгчээс бусад этгээдийн хувьд аливаа байдлаар үүргээс ангид байх шалгуур хангагдаж байна гэж дүгнэлээ.

Иймд МДСХ нь санамсаргүй түүврээр сонгогдсон 62 зээлийн дансанд хамаарах ипотекийн зээл нь хууль зүйн хувьд анхны зээлдүүлэгч буюу ББСБ-ын бүрэн өмчлөлд байгаа бөгөөд анхны зээлдүүлэгчээс бусад этгээдийн хувьд аливаа байдлаар үүргээс ангид байна гэж үзлээ.

### Шалгуур үзүүлэлт 2. Зээлийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэсэн байх.

Уг шалгуур үзүүлэлтийн хүрээнд ББСБ-ын зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ хуулиар тодорхойлсон хэлбэрийн шаардлагыг хангасан, хуульд нийцсэн, хүчин төгөлдөр эсэх, тээврийн хэрэгсэл худалдах худалдан авах гэрээний үндсэн дээр үүссэн эсэх, хуульд зааснаар, эсхүл итгэмжлэлээр төлөөлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх зэрэг асуудлыг шалгаж үзлээ.

Нийт дүн шинжилгээнд хамрагдсан зээлийн дансны зээлийн гэрээ, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлтөд зээлдүүлэгч болон хамтран зээлдэгч гарын үсэг зурсан нь Иргэний хуулийн 42.2, 281-286-р зүйл, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 22-р зүйлд тус тус тодорхойлсон шаардлагыг хангасан буюу зээлийн гэрээ нь хуульд нийцсэн, хүчин төгөлдөр байна.

Инвескор ББСБ-ын B15019102401 тоот зээлийн дансны зээлийн эргэн төлөлтийн хуваарьт хамтран зээлдэгч гарын үсэг зураагүй бөгөөд үндсэн зээлийн гэрээнд зээлдэгч, хамтран зээлдэгч нар гарын үсэг зурсан байдаг. Үндсэн зээлийн гэрээнд хавсралтууд нь түүний салшгүй хэсэг болохыг дурдсан байх тул энэ нь зээлийн гэрээний хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй, үүнээс үүдэн гарах хууль зүйн эрсдэл бага гэж үзлээ.

Сонгогдсон нийт 62 зээлийн дансны тээврийн хэрэгсэл/автомашин худалдан авах, эсхүл хэрэглээний зориулалтаар зээл олгох хэлцэл нь зээлдэгч (үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэх бөгөөд зээлийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэсэн байх шалгуурыг хангаж байна гэж үзлээ.

СЗХ 2021 .07. 06 БҮРТГЭВ № 01
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL 6317839 1119277128 УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК

Шалгуур үзүүлэлт 3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид байгаа мэдээллээр, тасалбар болгох өдрийн байдлаар зээлийн гэрээ нь Үүрэг гүйцэтгэгчийн хувьд үүргээ хугацаанаас өмнө дуусгавар болгох/урьдчилан төлөх нөхцөл, хэлцлээс татгалзах, харилцан суутгал хийх замаар үүргийг дуусгавар болгох, сөрөг нэхэмжлэл гаргах, эсхүл үүргээс татгалзах (илт хохиролтой хэлцлийн улмаас үүргээс татгалзах нөхцөлийг хамааруулан) эрх үүсээгүй, эсхүл эрхээ хэрэгжүүлэх хүсэл зориг илэрхийлээгүй байх.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд МДСХ нь түүврийн аргаар сонгосон 62 зээлийн дансдын зээлийн гэрээ, фидуцийн гэрээнд тусгагдсан үүрэг хугацаанаас өмнө дуусгавар болох, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзах нөхцөлүүд болон үүргээ хугацаанаас өмнө дуусгавар болгох тухай хүсэл зориг илэрхийлсэн эсэх талаар шалгаж үзлээ.

Иргэний хуулийн 283.3-д заасны "талууд урьдчилан тохирсон буюу зээлдүүлэгч зөвшөөрсөн тохиолдолд" зээлдэгч зээлээ урьдчилан төлөх боломжтой тухай зохицуулсан байдаг. Үүний дагуу ББСБ-ын зээлийн гэрээнд төлбөрийг хугацаанаас нь өмнө гүйцэтгэж болох, эсхүл ББСБ-д мэдэгдэж зөвшөөрөл авсны үндсэн дээр урьдчилан төлөх боломжтой тухай нөхцөл тусгагдсан байна.

Тайлан гаргах өдрийн байдлаар анхны үүрэг гүйцэтгүүлэгчид байгаа мэдээллээр сонгогдсон 62 зээлийн дансдын автомашины зээл олгох хэлцэл нь үүрэг гүйцэтгэгчийн хувьд үүргээ хугацаанаас өмнө дуусгавар болгох/урьдчилан төлөх нөхцөл, хэлцлээс татгалзах, харилцан суутгал хийх замаар үүргийг дуусгавар болгох, сөрөг нэхэмжлэл гаргах, эсхүл үүргээс татгалзах (илт хохиролтой хэлцлийн улмаас үүргээс татгалзах нөхцөлийг хамааруулан) эрх үүсээгүй, эсхүл эрхээ хэрэгжүүлэх хүсэл зориг илэрхийлээгүй байх шалгуур үзүүлэлтийг хангаж байна.

Шалгуур үзүүлэлт 4. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс тогтоосон хэмжээний урьдчилгаа төлбөр, холбогдох хураамж, шимтгэл, төлбөрийг төлсөн байх.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд МДСХ нь зээлдэгч хөдлөх хөрөнгийн урьдчилгаа төлбөрийг бүрэн төлж барагдуулсан эсэх, ББСБ-ын зүгээс олгосон санхүүжилтийг хөдлөх эд хөрөнгийн худалдан борлуулсан этгээдэд бүрэн төлсөн эсэх, зээлийн шимтгэл, зээлийн өргөдлийн хураамж, даатгалын хураамж, холбогдох төрийн байгууллагуудын лавлагаа, тодорхойлолтыг авахад шаардлагатай төлбөрийг төлсөн эсэхийг шалгаж үзлээ.

Нийт зээлийн дансдын зээлдэгч нар болон ББСБ зүгээс олгосон санхүүжилтийг хөдлөх эд хөрөнгийг худалдан борлуулсан этгээдэд бүрэн төлсөн төлбөрийн баримт зээлийн хувийн хэрэгт авагдсан байсан. Харин хөдлөх эд хөрөнгө худалдан авах урьдчилгаа төлбөрийг бүрэн төлж барагдуулсан төлбөрийн баримт зээлийн хувийн хэрэгт хавсаргагдаагүй боловч уг хөдлөх эд хөрөнгө ББСБ-д шилжсэнээс үзвэл урьдчилгаа төлбөрийг бүрэн төлж барагдуулсан гэж үзэх боломжтой байна.

Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журмын 2.7.2-т "хуулийн дагуу оногдуулсан торгуулийг төлөөгүй бол автотээврийн хэрэгслийг бүртгэхээс татгалзана" гэсний үндсэн дээр фидуцийн зүйл болох автотээврийн хэрэгслийн бүх торгуулийг төлсөн гэж үзэв.

Автотээврийн хэрэгслийн болон жолоочийн хариуцлагын даатгалын хураамж төлсөн баримтыг бүх зээлийн дансдын хувийн хэрэгт хавсаргагдаагүй. "Амар даатгал" ХХК-ийн 2020 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 20/07-028 тоот албан бичиг, "Монгол даатгал" ХК-ийн 2020 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 01/1095 тоот албан бичигт "..... хавсралтад дурдагдсан тээврийн хэрэгслүүдийн, жолоочийн хариуцлагын даатгал болон тээврийн хэрэгслийн даатгал хийгдэж, хураамж бүрэн төлөгдсөн болно" гэсний дагуу даатгалын хураамжийг бүрэн төлсөн гэж үзэв.

Зээлийн хувийн хэрэгт байсан гэрээ, хэлцлүүд нь нэгэнт нотариатаар гэрчлүүлсэн, бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн, даатгалын баталгааг авсан байсан учир нотариат, улсын бүртгэлийн үйлчилгээний тэмдэгтийн хураамж, албан татвар (хөрөнгө борлуулсны орлогод ногдох албан татвар г.м) зэрэг төлбөрүүдийг төлсөн гэж тооцож болохоор байна. Түүнчлэн төрийн байгууллагуудын лавлагааны хувьд зээлдэгч нар нь лавлагааны хураамж төлсөн баримтаа тухайн төрийн байгууллагад хураалгасны үндсэн дээр албан ёсны тамга тэмдэг, хэвлэмэл хуудас бүхий лавлагаа авдаг тул лавлагааны хураамж, төлбөрийг төлсөн гэж тооцож болохоор байна. Төрийн

үйлчилгээний цахим машинаас авсан лавлагааны хувьд тухайн иргэн хураамж, төлбөрийг төлснөөр лавлагаа авах боломжтой тул лавлагааны хураамж, төлбөрийг төлсөн гэж тооцов.

Ийнхүү Дүн шинжилгээний явцад энэ хэсэгт дурдсанаас өөр төлбөрийн баримт зээлийн дансдын хувийн хэрэгт хавсаргагдаагүй байсныг дурдах нь зүйтэй.

Иймд санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон 62 зээлийн дансдын фидуцийн зүйл буюу автомашин худалдан авахад төлбөл зохих төлбөрийг төлсөн байх шалгуур үзүүлэлтийг хангасан гэж үзэв.

### Шалгуур үзүүлэлт 5. Зээл нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд хууль, гэрээ эсхүл бусад байдлаар аливаа үүргээс ангид, бусдад шилжихийг хориглогдоогүй, эсхүл хязгаарлаагүй байх.

Уг шалгуур үзүүлэлтийн хүрээнд МДСХ нь анхны үүрэг гүйцэтгүүлэгч ББСБ нь фидуци болон зээлийн мөнгөн хөрөнгийг эргүүлэн шаардах эрхийг гуравдагч этгээдэд шилжүүлэхэд хууль болон гэрээгээр хориглосон, хязгаарласан нөхцөл байгаа эсэх, фидуцийн зүйл хамтран өмчлөгчтэй тохиолдолд хамтран өмчлөгчийн зөвшөөрөл байгаа эсэх, хамтран өмчлөгч фидуцийн гэрээнд гарын үсэг зурсан эсэх зэрэг асуудлыг шалган үзлээ.

ББСБ нь зээлдүүлэгч зээлийн гэрээний шаардах эрхийг үүргийн гүйцэтгэлийг хангуулах эрхийн хамт бусдад шилжүүлэхийг хориглоогүй, аливаа байдлаар хязгаарлаагүй байх талаар зээлийн гэрээнд тусгаагүй байна. Гэвч Иргэний хуулийн 123.3-т заасны дагуу үүрэг гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд шаардах эрхийг шилжүүлэхийг хязгаарласан нөхцөл байхгүй тохиолдолд шаардах эрх эзэмшигч нь уг эрхээ Иргэний хуулийн 123.2-т заасны дагуу үүргийн мөн чанарт харшлаагүй нөхцөлд үүрэг гүйцэтгэгчийн зөвшөөрлийг авахгүйгээр бусдад шилжүүлэх эрхийг олгосон байна.

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд буй фидуцийн зүйл болох автомашиныг зээлдэгч (эсхүл түүний итгэмжилсэн этгээд) эзэмшдэг болохыг дурдахын зэрэгцээ дүн шинжилгээнд хамрагдсан 62 зээлийн дансдаас 62 зээлийн дансдын хувьд автомашины зээл нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд хууль, гэрээ, эсхүл бусад байдлаар аливаа үүргээс ангид, бусдад шилжихийг хориглогдоогүй, эсхүл хязгаарлаагүй байх шалгуур үзүүлэлтийг хангасан гэж үзэв. Түүнчлэн фидуцийн гэрээний дагуу фидуцийн зүйл болох автомашиныг Зээлдүүлэгч(Анхны үүрэг гүйцэтгүүлэгч) өмчилж буй боловч автомашиныг Зээлдэгч эзэмшиж ашигладаг. Зээл төлүүлэх зорилгоор автомашиныг барьцаалуулах, худалдан борлуулах, бусдад шилжүүлэх эрхийг фидуцийн гэрээний дагуу түүнийг өмчилж буй Анхны үүрэг гүйцэтгүүлэгч эдэлнэ. Харин эзэмших, ашиглах эрхийг өөр этгээд хэрэгжүүлж байгаа нь ажиллагааны шуурхай байдалд нөлөөлж болох талтайг дурдах нь зүйтэй.

### Шалгуур үзүүлэлт 6. Холбогдох зээлийн гэрээний дагуу эсхүл түүнтэй холбоотойгоор үүсгэсэн фидуцийн эрх нь (а) үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргаар баталгаажсан, барьцаалсан, батлан даалт гаргасан болон үүргийн гүйцэтгэлийн хангуулах аргаар хамгаалагдаагүй аливаа бусад шаардлагаас давуу, тэргүүн ээлжинд шаардлага хангуулах боломжтой байх, (б) зохих ёсоор үүсгэгдэж хүчин төгөлдөр болсон, (в) тухайн үүргийн гүйцэтгэлийн хангуулах аргыг үүсгэхэд болон хүчин төгөлдөр болгоход Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ердийн практикт мөрддөг бүх дүрэм журмыг дагаж мөрдсөн, (г) тухайн үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргыг нотолж буй бүх баримт бичиг нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшил, хадгалалт хамгаалалтад байх.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд фидуцийн гэрээ нь хүчин төгөлдөр эсэх, хүчин төгөлдөр нөхцөлд тэргүүн ээлжинд хангагдах эсэх, ББСБ сонгогдсон зээлийг ердийн практикт мөрддөг бүх дүрэм журмын дагуу олгосон эсэх, нотлох баримт бичгүүд нь ББСБ-ын хадгалалт, хамгаалалтад байгаа эсэхийг шалгалаа.

Бидний шалгасан зээлийн гэрээ, фидуцийн гэрээ нь эх хувиар, тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн гэрчилгээ нь хуулбараар хувийн хэрэгт хадгалагдаж байв. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд буй фидуцийн зүйл болох автомашиныг зээлдэгч (эсхүл түүний итгэмжилсэн этгээд) эзэмшиж, ашиглаж байна. Тээврийн хэрэгслийн гэрчилгээг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч өөрийн эзэмшил, хадгалалтад эх хувиар байлгадаггүй нь Автотээврийн тухай



000293

хуулийн 17.1, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 21.2-д заасан хууль зүйн үндэслэлтэй, хуулбарыг хувийн хэрэгт хадгалдаг байна.

Зээлийн гэрээний дагуу, эсхүл түүнтэй холбоотойгоор үүсгэсэн фидуци нь тухайн үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргыг үүсгэхэд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ердийн практикт мөрддөг бүх дүрэм журмын дагуу үүссэн байна.

МДСХ-ийн сонгосон зээлийн хувийн хэргүүдийн хувьд фидуци нь Иргэний хуулийн 235.1-д заасны дагуу тэргүүн ээлжинд шаардлага хангуулах фидуци байх ба зохих ёсоор үүсгэгдэж, баталгаажин, хүчин төгөлдөр болсон байна.

Шалгуур үзүүлэлт 7. Зээлтэй холбоотойгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон зээлдэгчийн хооронд байгуулсан фидуцийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэсэн зээлдэгч үүргээ биелүүлээгүй тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч өмчлөгчийн эрхээ хэрэгжүүлж, худалдан борлуулж зээл, үүнтэй холбоотой бүх төлбөрийг гаргуулах боломжтой байх.

Уг шалгуур үзүүлэлтийн хүрээнд ББСБ-ын зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ хуулиар тодорхойлсон хэлбэрийн шаардлагыг хангасан, хуульд нийцсэн, хүчин төгөлдөр эсэх, тээврийн хэрэгсэл худалдах худалдан авах гэрээний үндсэн дээр үүссэн эсэх, хуульд зааснаар, эсхүл итгэмжлэлээр төлөөлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх зэрэг асуудлыг шалгаж үзлээ.

Тайлангийн шалгуур 2-т дурдсаны дагуу түүврийн аргаар сонгосон зээлүүдийн зээлийн гэрээ нь хуульд нийцсэн, хүчин төгөлдөр байна. Зээлдэгч зохих ёсоор үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд фидуцийн зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар ББСБ зээлийн гэрээ, эсхүл фидуцийн гэрээгээр зохицуулсан байгаа нь фидуцийн зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулахыг зөвшөөрсөн байна.

Инвескор ББСБ-ын фидуцийн гэрээний 3.2.3-т "Үүрэг Гүйцэтгэгч зээлийн болон энэхүү гэрээнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлж байгаа тохиолдолд Фидуцийн зүйлийн өмчлөх эрхийг гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй байх"-аар зохицуулсан байна.

Сонгогдсон нийт 62 зээлийн дансны тээврийн хэрэгсэл/автомашин худалдан авах, эсхүл хэрэглээний зориулалтаар зээл олгох хэлцэл нь зээлдэгч (үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэх бөгөөд үүрэг гүйцэтгэгчийн зээлийг фидуци/автомашинаар гаргуулан төлүүлэх боломжтой байх шалгуурыг хангаж байна гэж үзлээ.

Шалгуур үзүүлэлт 8. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь "Инвескор Актив" ХХК-тай байгуулах Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулах зорилгоор уг гэрээг байгуулах үед Хөрөнгийн жагсаалтад дурдагдсан фидуцийн хөрөнгүүдийг Инвескор Актив" ХХК-д барьцаалах агуулга бүхий гэрээ байгуулах болохоо батлан баталгаа гаргасан байх.

Инвескор ББСБ, Микро кредит ББСБ-ын баталгаа гаргахтай холбоотой албан бичигт Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь "Инвескор Актив" ХХК-тай байгуулах Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулах зорилгоор уг гэрээг байгуулах үед Хөрөнгийн жагсаалтад дурдагдсан фидуцийн хөрөнгүүд, фидуцийн эрхийг “Инвескор Актив" ХХК-д барьцаалах агуулга бүхий гэрээ байгуулах баталгаа гаргасан байна.

Иймд дүн шинжилгээнд хамрагдсан 62 зээлийн дансдаас 62 зээлийн дансдын хувьд автомашины зээл нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь "Инвескор Актив" ХХК-тай байгуулах Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулах зорилгоор уг гэрээг байгуулах үед Хөрөнгийн жагсаалтад дурдагдсан фидуцийн хөрөнгүүлийг Инвескор Актив" ХХК-д барьцаалах агуулга бүхий гэрээ байгуулах болохоо батлан баталгаа гаргасан байх шалгуур үзүүлэлтийг хангасан байна.

## Нэгдсэн дүгнэлт.

Хуулийн хөндлөнгийн дүн шинжилгээ хийсний үндсэн дээр 62 зээлийн дансдын хувьд шинжилгээ хийх өдрийн байдлаар зээлийн гэрээ, фидуцийн гэрээ нь хүчин төгөлдөр, эрсдэлгүй байна.

Энэхүү Тайлангийн Хавсралт 2-т заасан Инвескор Актив багцын өөрийн шинжилгээний явцад анхаарах банк бус санхүүгийн байгууллагад ялгаатай шийдвэрлэгдсэн асуудлын жагсаалтад заасны дагуу бид тус зөрүүтэй зохицуулалтыг илрүүлсэн хэдий ч хүлээн зөвшөөрсөн бөгөөд дүн шинжилгээ хийх явцад гарсан алдаа, зөрчлийг тухай бүр засуулсан болно.

1. Шалгуур үзүүлэлтүүдийг хангасан дансдууд.

Энэ ангилалд багтсан нийт данс Инвескор Активаас тавигдсан шалгуур үзүүлэлтүүдийг хангасан (Хавсралт 1. Түүврийн аргаар сонгогдсон зээлийн статус) бөгөөд Зээлийн гэрээ, Фидуцийн гэрээ, Тээврийн хэрэгслийн гэрчилгээ нь хүчин төгөлдөр байгаа утгыг илэрхийлнэ. Энд гарсан алдаа нь эрх зүйн эрсдэл үүсгэхгүй, хууль тогтоомжоор заасан шаардлага зөрчөөгүй зээлийг ойлгоно. Гэвч энд зарим эрсдэл болох тухайн зээл авахад шаардлага хангаж байсан боловч хөндлөнгийн дүн шинжилгээ хийх үед өөрчлөгдсөн нөхцөл байдал орж байгаа болно. Тухайлбал, зээл авах үед үйл ажиллагаа явуулах эрхийн зөвшөөрөл, эсхүл хөдөлмөрийн гэрээ, зээлдэгчийн амь насны даатгалын гэрээ, эд хөрөнгийн даатгалын гэрээ нь хүчинтэй байсан боловч энэхүү тайлан гаргах өдрийн байдлаар хугацаа нь дууссан байх магадлалтай зээлийн данс орсон байж болно.

2. Эрсдэлийн зэргийг дахин үнэлэх шаардлагатай данс.

Дүн шинжилгээ хийж тайлан гаргах өдрийн байдлаар зээлийн гэрээ, фидуцийн гэрээний аль нэг нь эсхүл түүний гол нөхцөлийг тодорхойлсон заалт нь эрсдэлтэй байж болзошгүй, эрсдэлийн зэргийг дахин үнэлэх шаардлагатай зээлийн данс илрээгүй болно.

3. Хүчин төгөлдөр бусад тооцогдох эрсдэлтэй данс.

Дүн шинжилгээ хийж тайлан гаргах өдрийн байдлаар зээлийн гэрээ, фидуцийн гэрээний аль нэг нь эсхүл түүний гол нөхцөлийг тодорхойлсон заалт нь хүчин төгөлдөр бусад тооцогдох эрсдэлтэй, хуулийн шаардлага хангаагүй зээлийн данс илрээгүй болно.

*График 6.Зээлийн гэрээ, фидуцийн гэрээний хүчин төгөлдөр байдлын үзүүлэлт.*




Энэхүү Тайлан нь түүнийг тухайлан зориулж гаргасан этгээдүүдээс бусад этгээдийн өмнө ямар нэгэн үүрэг хариуцлага бий болгохгүй.



СЗХ 2021.01.06 БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2020 11 12 БҮРТГЭВ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL 6317839 1119277128 УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ ИНВЕСКОР АКТИВ ББСБ ХХК
000295

## ГУРАВ. САНАЛ/ЗӨВЛӨМЖ

Бүх Анхны үүрэг гүйцэтгүүлэгчдийн зээлийн дансдын хувийн хэрэгт зээлийн хяналтын тайлан үйлдсэн нь цөөн байна. Зээл олгосноос хойш тодорхой хугацаа өнгөрсний дараа зээлийг эргэн шалгадаг байх шаардлагатай учраас зээл олгосноос хойш тодорхой хугацаа өнгөрсөн тохиолдолд зээлийн хяналтын тайлан үйлдэн хувийн хэрэгт хавсаргадаг байх шаардлагатай гэж үзлээ.

Энэхүү Дүн шинжилгээний явцад холбогдох ажилтнуудаас тодруулга мэдээллийг газар дээр нь авч ажилласнаас гадна нэмэлт мэдээлэл тодруулга шаардлагатай дансдын талаар цахим шуудан илгээж холбогдох нотлох баримт, тодруулгыг авч ажилласан.

Мөн автотээврийн хэрэгслийн болон жолоочийн хариуцлагын даатгалын гэрээнүүдэд хамтран зээлдэгч гарын үсэг зурахгүй зөвхөн үндсэн зээлдэгч гарын үсэг зурсан байна. Иргэний хуулийн 431.3-т зааснаар "даатгалын гэрээг бичгээр хийх бөгөөд энэ шаардлагыг хангаагүй гэрээ хүчин төгөлдөр бус байна.", тус хуулийн 42.2-т зааснаар "... бичгийн хэлцэл нь хүсэл зоригоо илэрхийлэгч этгээд гарын үсэг зурснаар...." оролцогч талууд хүсэл зоригоо илэрхийлэн гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

МДСХ нь Дүн шинжилгээний явцад Инвескор ББСБ-ийн B15020021703, B15020040503 тоот зээлийн дансдуудад тээврийн хэрэгслийн даатгалын гэрээ дээрх гарын үсэг, Зээлийн гэрээ дээрх гарын үсэгтэй таарахгүй байгаа зөрчил илрүүлсэн. Иргэний хуулийн 437.2-т "Даатгуулагч даатгалын хураамжийг хугацаанд нь төлөөгүй байхад даатгалын тохиолдол бий болсон бол даатгагч гэрээнд заасан үүрэг хүлээхгүй" байхыг зохицуулсан тул цаашид зээлийн хувийн хэрэгт даатгалын хураамж төлсөн баримтыг хавсаргаж байх, тогтмол хугацаанд шалгаж байх нь зүйтэй. Түүнчлэн тайлангийн шалгуур үзүүлэлт 5-д заасны дагуу Иргэний хуулийн 123.3-т заасны дагуу үүрэг гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд шаардах эрхийг шилжүүлэхийг хязгаарласан нөхцөл байхгүй тохиолдолд шаардах эрх эзэмшигч нь уг эрхээ Иргэний хуулийн 123.2-т заасны дагуу үүргийн мөн чанарт харшлаагүй нөхцөлд үүрэг гүйцэтгэгчийн зөвшөөрлийг авахгүйгээр бусдад шилжүүлэх эрхийг олгосон байна. Гэвч Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 09 дүгээр сарын 14-ны 266 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-ын 2.9-т Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасанаас гадна баталгаат үнэт цаасны танилцуулгад тусгавал зохих мэдээллийг тодорхойлсны дотор 2.9.6-д:" ...багцын хөрөнгөд ашиглагдах зээлийн шинжилгээний шалгуур, багцын хөрөнгөтэй холбоотой барьцааны эрхийн тодорхойлолт"; 2.9.7-д "хөрөнгийн болон урьдчилгаа төлбөрийн эрсдэл, баталгаат үнэт цаасанд нөлөөлөх бусад эрсдэлийн шинжилгээ" гэж заасан байдаг. Энэ үүднээс ТЗК буюу үнэт цаас гаргагчийн зүгээс зээлийн багцад хийх дүн шинжилгээгээр "Зээл нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд хууль, гэрээ эсхүл бусад байдлаар аливаа үүргээс ангид, бусдад шилжихийг хориглогдоогүй, эсхүл хязгаарлаагүй байх" гэдэг шалгуур тавигддаг. Энэ үүднээс авч үзвэл хожим маргаан гарсан тохиолдолд шүүхээс тус маргааныг хэрхэн шийдвэрлэх талаар дүгнэлт гаргах боломжгүй тул ББСБ-ын гэрээндээ Инвескор актив, эсхүл гуравдагч этгээдэд шилжихийг зөвшөөрсөн заалтыг Зээлийн болон фидуцийн гэрээнд оруулж байх нь эрсдэлээс сэргийлэх ач холбогдолтойг дурдах нь зүйтэй.

НӨХӨРЛӨЛИЙН ГИШҮҮН, ХУУЛЬЧ Д.ДҮГЭРЖАВ

СЗХ
2021.07.06
БҮРТГЭВ
№ 01

...ИЙ ХӨРӨНГИЙН Б...
...STOCK EXCH...
... - 12



| № | Банк бус санхүүгийн байгууллага | Зээлийн дансны дугаар | Статус |
|---|---|---|---|
| 1. | Инвескор ББСБ ХК | B15019083104 | ★ |
| 2. | Инвескор ББСБ ХК | B15019091701 | ★ |
| 3. | Инвескор ББСБ ХК | B15019121403 | ★ |
| 4. | Инвескор ББСБ ХК | B15019121501 | ★ |
| 5. | Инвескор ББСБ ХК | B15019120102 | ★ |
| 6. | Инвескор ББСБ ХК | B15019101502 | ★ |
| 7. | Инвескор ББСБ ХК | B15019102401 | ★ |
| 8. | Инвескор ББСБ ХК | B15019102503 | ★ |
| 9. | Инвескор ББСБ ХК | B15019110403 | ★ |
| 10. | Инвескор ББСБ ХК | B15019120402 | ★ |
| 11. | Инвескор ББСБ ХК | B15020012202 | ★ |
| 12. | Инвескор ББСБ ХК | B15020011905 | ★ |
| 13. | Инвескор ББСБ ХК | B15020012605 | ★ |
| 14. | Инвескор ББСБ ХК | B15020020304 | ★ |
| 15. | Инвескор ББСБ ХК | B15020020701 | ★ |
| 16. | Инвескор ББСБ ХК | B15020020804 | ★ |
| 17. | Инвескор ББСБ ХК | B15020021703 | ★ |
| 18. | Инвескор ББСБ ХК | B15020021904 | ★ |
| 19. | Инвескор ББСБ ХК | B15020022301 | ★ |
| 20. | Инвескор ББСБ ХК | B15020022302 | ★ |
| 21. | Инвескор ББСБ ХК | B15020022901 | ★ |
| 22. | Инвескор ББСБ ХК | B15020030701 | ★ |
| 23. | Инвескор ББСБ ХК | B15020032701 | ★ |
| 24. | Инвескор ББСБ ХК | B15020040501 | ★ |
| 25. | Инвескор ББСБ ХК | B15020040503 | ★ |
| 26. | Инвескор ББСБ ХК | B15020040601 | ★ |
| 27. | Инвескор ББСБ ХК | B15020040801 | ★ |
| 28. | Инвескор ББСБ ХК | B15020040901 | ★ |
| 29. | Инвескор ББСБ ХК | B15020041301 | ★ |
| 30. | Инвескор ББСБ ХК | B15020042302 | ★ |
| 31. | Инвескор ББСБ ХК | B15020042601 | ★ |
| 32. | Инвескор ББСБ ХК | B15020042703 | ★ |
| 33. | Инвескор ББСБ ХК | B15020050202 | ★ |
| 34. | Инвескор ББСБ ХК | B15020050204 | ★ |
| 35. | Инвескор ББСБ ХК | B15020050301 | ★ |
| 36. | Инвескор ББСБ ХК | B15020050603 | ★ |
| 37. | Инвескор ББСБ ХК | B15020020305 | ★ |
| 38. | Инвескор ББСБ ХК | B15020020901 | ★ |
| 39. | Инвескор ББСБ ХК | B15020050103 | ★ |
| 40. | Инвескор ББСБ ХК | B16020020503 | ★ |
| 41. | Инвескор ББСБ ХК | B16020020201 | ★ |

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1110277128
УЛААНБААТАР ХОТ



000297

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЭН ХХК
9020030754 6581463

он сар өдөр 2021 01 06
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020 -11- 12
БҮРТГЭВ-02

| | | | |
|---|---|---|---|
| 42. | Инвескор ББСБ ХК | B16020020105 | ★ |
| 43. | Инвескор ББСБ ХК | B16020012605 | ★ |
| 44. | Инвескор ББСБ ХК | B16020011705 | ★ |
| 45. | Инвескор ББСБ ХК | B16020011505 | ★ |
| 46. | Инвескор ББСБ ХК | B15020052102 | ★ |
| 47. | Микро Кредит ББСБ ХХК | 1100005810 | ★ |
| 48. | Микро Кредит ББСБ ХХК | 1100006026 | ★ |
| 49. | Микро Кредит ББСБ ХХК | 1100006053 | ★ |
| 50. | Микро Кредит ББСБ ХХК | 1100006073 | ★ |
| 51. | Микро Кредит ББСБ ХХК | 1100006130 | ★ |
| 52. | Микро Кредит ББСБ ХХК | 1100006203 | ★ |
| 53. | Микро Кредит ББСБ ХХК | 1100006335 | ★ |
| 54. | Микро Кредит ББСБ ХХК | 1100006378 | ★ |
| 55. | Микро Кредит ББСБ ХХК | 1100005451 | ★ |
| 56. | Микро Кредит ББСБ ХХК | 1100005573 | ★ |
| 57. | Микро Кредит ББСБ ХХК | 1100005778 | ★ |
| 58. | Микро Кредит ББСБ ХХК | 1100006326 | ★ |
| 59. | Микро Кредит ББСБ ХХК | 1100006441 | ★ |
| 60. | Микро Кредит ББСБ ХХК | 1100005837 | ★ |
| 61. | Микро Кредит ББСБ ХХК | 1100005648 | ★ |
| 62. | Микро Кредит ББСБ ХХК | 1100006438 | ★ |

-ooOoo-

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 ... 1119277128
УЛААНБААТАР ХОТ



000293
УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК
9020000754 ... 6581463

СЭХ
2021.01.06 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН Б
MONGOLIAN STOCK EXCHA
2020-11-17
БҮРТГЭВ-02



**Инвескор Актив багцын өөрийн шинжилгээний явцад анхаарах банк бус санхүүгийн байгууллагад ялгаатай шийдвэрлэгдсэн асуудлын жагсаалт**

Нэг. Эдгээр Инвескор Актив нь ББСБ-уудтай харилцан тохиролцсон, хөндлөнгийн хуулийн дүн шинжилгээний явцад анхаарах асуудлууд нь Захиалагч буюу Үнэт цаас гаргагчийн өгсөн ажлын даалгаврын салшгүй хэсэгт тооцогдоно.

Хоёр. Хөндлөнгийн хуулийн дүн шинжилгээний явцад эдгээр харилцан тохиролцож шийдвэрлэсэн асуудлууд үүссэн нөхцөлд тухайн дансыг хуулийн шаардлага хангасан (зөвхөн энэхүү харилцан тохиролцсон асуудлын хувьд) гэж тооцох ба ялгаатай шийдвэрлэгдсэн байдлаас үүсэх асуудлыг ББСБ хариуцна.

Гурав. Инвескор актив багцад ялгаатай шийдвэрлэгдсэн асуудлын тайлбартай давхцсан зээл байж болно.

Дөрөв. Ялгаатай шийдвэрлэгдсэн асуудлуудын дэлгэрэнгүй тайлбар, жагсаалт

| № | Асуудал | Анхны үүрэг гүйцэтгүүлэгч /ББСБ/ нэр | Тохиролцсон байдал |
|---|---|---|---|
| 1. | Бүх зээл шинээр олгосон | Бүх ББСБ-ын зээлийн данс | Зээлийн хувийн хэргээс шинэ зээл эсэхийг нотлох боломжгүй тул бүх зээл нь шинэ зээл болно. |
| 2. | Тасалбар болгосон өдөр | Бүх ББСБ-ын зээлийн данс | Тасалбар болгосон өдөр нь 2020 оны 05 дугаар сарын 31-ний өдөр, Хөндлөнгийн шинжээчийн хувьд зээл олгосон өдрөөр. |
| 3. | Оршин суугаа хаяг | Бүх ББСБ-ын зээлийн данс | Бүх зээлийн гэрээ, фидуцийн гэрээ нь зээлдэгч нарын "оршин суугаа хаяг"-аар байж болно. Зээлийн хувийн хэрэгт байгаа Зээл хүсэгчийн анкет болон зээлийн шийдвэрийн баримт дээр оршин суугаа хаягийг нь бичиж, уг хаяг нь иргэний үнэмлэх дээрхээс өөр байх тохиолдолд анкет шийдвэрийн баримт бичиг дээрээ "иргэний үнэмлэхийн хаяг", "оршин суугаа хаяг" гэж тусдаа хүснэгтэд бүртгэж, хадгалдаг. Оршин суугаа хаягийг оршин суугаа хаягийн тодорхойлолт, эсхүл зээлдэгчийн аман мэдүүлгээр тодорхойлж зээл хүсэгчийн анкет, шийдвэрт дурдсан. Харилцагчийн "албан ёсны бүртгэлтэй хаяг" нь Иргэний үнэмлэх болон Улсын бүртгэлийн лавлагаа, ХУР системийн тодорхойлолтод тусгагдаж, Зээлийн материалд хадгалагдаж байгаа бол "оршин суугаа хаяг" нь Зээлдэгчийн гарын үсэг, нотариатаар гэрчлүүлсэн Зээлийн гэрээнд тусгагдсан. Эдгээр хаягууд зөрүүтэй байж болно. |
| 4. | Орлого нотлох баримт | Бүх ББСБ-ын зээлийн данс | ББСБ нь харилцагчийн орлого нотлох зорилгоор тэргүүн ээлжид дансны хуулга байхыг шаарддаг. Шаардлагатай тохиолдолд бусад орлого нотлох баримтууд болох нийгмийн даатгалын шимтгэлийн тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээ, бизнесийн хар дэвтэр зэргийг авдаг учир зарим зээлд тус материал байхгүй байж болно. |
| 5. | Зээлийн дансны дугаар | Инвескор ББСБ | Зээлийн дансны дугаар зээлийн гэрээнд тусгагдаагүй, зээлийн гэрээний дугаар нь зээлийн дансны дугаар байж болно. |
| 6. | Тээврийн хэрэгслийн | Инвескор ББСБ | Тээврийн хэрэгсэл өмчлөгчийн нэр "Инвескор ББСБ", "Инвескор ББСБ ХХК", "Инвескор ББСБ ХК" гэж, хаяг нь Инвескор салбар хаяг буюу |



"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

000299

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК
9020080758

| | | | |
|---|---|---|---|
| | өмчлөгчийн нэр, хаяг | | Улаанбаатар хот, БЗД, 17-р хороо, Да хүрээ зах Үйлчилгээний 3-р төвийн залгаа эсхүл Улаанбаатар хот, СБД, 2-р хороо, Сөүлийн гудамж 10/1, Твин Тауэр-1, 13 давхарт гэсэн байж болно. |
| 7. | Төлбөр, хураамж | Бүх ББСБ-ын зээлийн данс | Фидуцийн зүйлтэй холбоотой бүх төлбөрийг төлсөн баримт /зээлийн өргөдлийн хураамж, тээврийн хэрэгслийн албан татвар, эрх бүхий байгууллагын ногдуулсан торгууль/ байхгүй байж болно. |
| 8. | Зээлийн мэдээллийн сан | Инвескор ББСБ | Инвескор ББСБ нь өөрийн SMART LOS зээлийн цахим системийг Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн системтэй холбосон бөгөөд хайлт хийн зээлийн мэдээллийг татаж авдаг. Иймд зээлийн хувийн хэрэгт зээлийн мэдээллийн сангийн лавлагаа байхгүй байж болох ба харин Зээлийн шийдвэрт дурдсан нь үнэн зөв болно. Инвескор ББСБ нь зээлийн мэдээллийн сангийн лавлагааг хэвлэж, хувийн хэрэгт тусгайлан оруулдаггүй. |
| 9. | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанаас авсан өр төлбөргүй тухай лавлагаа | Бүх ББСБ-ын зээлийн данс | Инвескор ББСБ-ийн SMART LOS зээлийн цахим систем нь Төрийн мэдээллийн ХУР систем, Шүүхийн ерөнхий зөвлөлийн shuukh.mn шүүхийн шийдвэрийн мэдээллийн цахим сантай холбогдсон тул зээлдэгч хурууны хээгээ уншуулж хайлт хийхэд түүнд холбогдох ямар нэг шүүхийн шийдвэр, өр төлбөртэй бол зээл олгодоггүй бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанаас өр төлбөргүй тухай лавлагаа авахыг зээл хүсэгчээс ихэнх тохиолдолд шаарддаггүй. Зээлийн бүтээгдэхүүний нөхцөлтэй уялдуулан судлах боломжтой тул ШШГЕГ-н лавлагааг зайлшгүй авах шаардлагагүй болно. |
| 10. | Техникийн алдаа | Инвескор ББСБ | **B16020020105** тоот зээлийн дансны Фидуцийн гэрээний 1.2-т Өмчлөх эрхийг бүртгэсэн байгууллагын нэр /огноо/ хэсэгт "АТҮТ 2020.01.07" гэж бичсэн. Гаалийн мэдүүлэг, ХХАГ дэх гэрчилгээ олгосон огноо нь 2020.01.17 гэсэн бөгөөд харин Инвескорын нэр дээр өмчлөх эрх бүртгэгдсэн гэрчилгээ нь 2020.02.02 гэж зөрүүтэй бичигдсэн.. Арлын дугаар дээр гараар засвар оруулж нотариатын тамга дарсныг үнэн зөв гэж үзнэ. |
| 11. | Техникийн алдаа | Инвескор ББСБ | **B16020020105** тоот зээлийн дансны Зээлийн мэдээллийн сангийн баримт хамтран зээлдэгчийнх байгаа боловч үндсэн зээлдэгчийнх байхгүй бөгөөд зээл олгох шийдвэрт шалгасан гэсэн тэмдэглэгээтэй, доор нь ямар нэгэн дата байхгүй бол зээлийн аливаа түүхгүй гэж ойлгоно. |
| 12. | Техникийн алдаа | Инвескор ББСБ | **B16020020201** тоот зээлийн дансны Зээлийн өргөдөлд хугацааны талаар дурдаагүй зээлийн зориулалт, үнэ, дансны талаар тусгаж гарын үсэг зурсан. |
| 13. | Зээлийн эргэн төлөлтийн хуваарь | Инвескор ББСБ | **B15019102401** тоот зээлийн дансны зээлийн гэрээнд Хамтран зээлдэгч эргэн төлөлтийн хуваарьт гарын үсэг зураагүй байж болно. |
| 14. | Зээлийн зориулалт | Микро кредит ББСБ | Бүх зээлийн дансдын зээлийн хүсэлт, өргөдөлд зээлийн зориулалтын талаар үгчлэн тусгаагүй ч зээлийн хэмжээ, дүнг тусгасан байж болно. |
| 15. | Алдаа | Микро кредит ББСБ | **1100006130** тоот зээлийн дансны Зээлийн, фидуцийн гэрээнд зээлдэгчийн хаягийг гэрээнд "улаанбаатар хот, баянзүрх дүүрэг 27-р хороо, дунд дарь эх 1 гудамж 2195 тоот" гэж бичсэн нь оршин суугаа хаягийн тодорхойлолт дахь "улаанбаатар хот, баянзүрх дүүрэг 27-р хороо, дунд дарь эх 1 гудамж 744 тоот" гэж бичсэнээс зөрүүтэй байна. |



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020 11 12
БҮРТГЭВ-02
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК
000300

| | | | |
|---|---|---|---|
| 16. | Жолоочийн хариуцлагын даатгалын гэрээ | Микро кредит ББСБ | Жолоочийн хариуцлагын даатгал нь албан журмын даатгал тул автотээврийн хэрэгслийн даатгал хийгдсэний үндсэн дээр гэрчилгээ гарч баталгаажсан тул даатгалын баримт байхгүй байж болно. |
| 17. | Хаяг | Микро кредит ББСБ | **1100006073** тоот зээлийн дансны зээлийн болон фидуцийн гэрээний зээлдэгч нар нь гэрлэлтийн гэрчилгээтэй бөгөөд хамтран зээлдэгч үндсэн зээлдэгчтэй хамт амьдардаг тул ижил хаяг бичсэн. |
| 18. | Зөрүүтэй байдал | Микро кредит ББСБ | **1100006073** тоот зээлийн дансны Бизнесийн орлогын талаар нотолж 2015, 2019 оны 2 түрээсийн гэрээ байх бөгөөд 2015 оны гэрээний түрээслэгч тал нь хамтран зээлдэгч байна. Харин 2019 оны Түрээсийн гэрээнд үндсэн зээлдэгч болон хамтран зээлдэгч аль нь ч гэрээний тал болж оролцоогүй тэдгээрийн хүүхэд нь оролцсон. |
| 19. | Зөрүүтэй байдал | Микро кредит ББСБ | **1100006203** тоот зээлийн дансны зээлийн болон фидуцийн гэрээнд үндсэн зээлдэгчийн үл хөдлөх эд хөрөнгийн хаягаар оршин суугаа хаягийг бичсэн. |

~oOo~



000301

MDSKhanLex
Монгол Улс, Улаанбаатар хот 14200
Сүхбаатар дүүрэг, Сүхбаатарын талбай 2
Сэнтрал Тауэр, 13 давхар, 1301 тоот

Утас: +976 11 330048
Факс: +976 11 330049
Олон улс: +1 (978) 9033574

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020 -11- 12
БҮРТГЭВ-02

2020.09.29 № Д-20/192

**"ИНВЕСКОР АКТИВ ТЗК" ХХК-Д**

***Хууль зүйн нэмэлт дүгнэлт хүргүүлэх тухай***

Тус хуулийн фирмээс 2020 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн Д-20/181 тоот бичгээр хүргүүлсэн ""Инвескор актив ТЗК" ХХК-аас автомашины зээлийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган нийтэд санал болгох үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээлэл нь үнэн зөв, хууль зүйн хувьд хүчин төгөлдөр эсэх талаарх" хууль зүйн дүгнэлтийн Хавсралт 3-д тусгасан "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ (Үндсэн дүгнэлтийн Хавсралт 3.1), Фидуцийн барьцааны гэрээ (Үндсэн дүгнэлтийн Хавсралт 3.3)"-ний төслүүдэд өөрчлөлт орсон тул тус өөрчлөлттэй холбоотой нэмэлт дүгнэлтийг гарган хүргүүлж байна.

***Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний төсөл*** (Энэхүү дүгнэлтийн Хавсралт 1.2). Компанийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргахтай холбоотой Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, Үнэт цаас гаргагч нарын хооронд байгуулагдах "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-ний төсөлд доорх өөрчлөлтийг оруулжээ.

a) Гэрээний 2.1.1.1-д Хэлцэл биелэх өдөр Зээлийн хөрөнгө болон түүнд холбогдох эрхүүдийг худалдахаар тохиролцсон хөрөнгийн жагсаалтад тусгагдсан "....Зээлдэгчийн төлбөл зохих үндсэн төлбөр, хүү, нэмэгдүүлсэн хүү, *алданги, торгууль* зэрэг..." гэснээс "...алданги, торгууль..." гэснийг хасаж засварласан байна.
b) "Хэлцэл амжилттай биелэх дүн" гэх хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний төслийн 3.2.1 дэх заалт буюу "Анхдагч зах зээлийн арилжаа дуусахад Хөрөнгө оруулалтаас босгосон дүн нь Хөрөнгө оруулалтаас босгох дээд дүнгийн 80 хувь буюу 2,400,000,000 (хоёр тэрбум дөрвөн зуун сая) төгрөг буюу түүнээс дээш дүнтэй байх тохиолдолд Хэлцэл амжилттай биелсэн гэж үзнэ" нь холбогдох шийдвэртэй зөрчилдөж буйг хассан, мөн "хэлцэл амжилттай биелэх дүн" гэх нэр томьёог "Хөрөнгө оруулалтаас босгох дүн" болгож өөрчилсөн байна.

Энэхүү өөрчлөлтийг тусгасан Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний төсөл нь Иргэний хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн ба "Инвескор Актив ТЗК" ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

000302

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК
9020080754 6561463

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК

InvesCore CAPITAL

6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ



УЛААНБААТАР ХОТ

ИНВЕСКОР АКТИВ ҮЦК ХХК

20/12 тоот тогтоол (Энэхүү дүгнэлтийн Хавсралт 1.1)-ын нэгдүгээр хавсралтаар батлахаар сайшаасан.

***Фидуцийн барьцааны гэрээний төсөл*** (Энэхүү дүгнэлтийн Хавсралт 1.3). ББСБ болон Үнэт цаас гаргагч нарын хооронд байгуулагдах "Фидуцийн барьцааны гэрээ"-ний төслийн 3.2.2 дахь заалтад "Барьцааны мэдэгдлийг .............................. Барьцаалуулагч хариуцна" гэсний дараах "Барьцааны мэдэгд" гэж дутуу бичигдсэн нь техникийн шинжтэй алдаа байх тул хассан өөрчлөлт оруулжээ. Энэ нь Иргэний хууль, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2020 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 5/3906 тоот "Тодруулга авах тухай"-д тусгасан дээрх зөрчлүүдийг арилгасан нь хууль тогтоомжийн дагуу хийгдсэн байна.

НӨХӨРЛӨЛИЙН ГИШҮҮН
ХУУЛЬЧ Д.ДҮГЭРЖАВ



000304

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore
CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ



УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР
АКТИВ ТЗ
ХХК

**Хавсралт 1.**

| No. | Баримт бичгийн нэр | Дугаар | Огноо | Олгосон байгууллага/ Гэрээний нөгөө тал |
|---|---|---|---|---|
| 1 | Компанийн үйл ажиллагаанд ач холбогдол бүхий гэрээ хэлцлүүд | | | |
| 1.1 | Гэрээ шинэчлэн батлах тухай | 20/12 | 2020.09.28 | “Инвескор актив” ХХК-ийн ТУЗ-ийн хурал |
| 1.2 | Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний төсөл | 20/12 | 2020.09.28 | “Инвескор актив” ХХК-ийн ТУЗ-ийн хурал |
| 1.3 | Фидуцийн барьцааны гэрээний төсөл | 20/04 | 2020.08.05 | “Инвескор актив” ХХК-ийн ТУЗ-ийн хурал |

~oOo~



"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 ☏1119277128
УЛААНБААТАР ХОТ

000303

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК
9020080754 ☏581463

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

000307

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ... ХХК

2021 .01 06 өдөр БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020 -11- 12
БҮРТГЭВ-02

**“ИНВЕСКОР АКТИВ ТЗК” ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ**

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 09-р сарын 28-ны өдөр № 20/12 Улаанбаатар хот

*Гэрээний төслийг шинэчлэн батлах тухай*

“Инвескор Актив ТЗК” ХХК (цаашид “Компани” гэх)-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал нь Компанийн тухай 76 дугаар зүйл, Компанийн дүрмийн 7.3.5, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын 5.1.1, 5.1.2 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 08-р сарын 28-ны өдрийн 20/10 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Санхүүгийн Зохицуулах Хорооны 2020 оны 09-р сарын 22-ны өдрийн 5/3906 тоот албан бичигт дурдсан ёсоор Компанийн Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид болох “Инвескор ББСБ” ХК, “Микро Кредит ББСБ” ХХК нартай байгуулах “Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ”-ний төсөлд өөрчлөлт оруулж, Нэгдүгээр хавсралтаар шинэчлэн батлсугай.
2. Гэрээний төсөл шинэчлэн батлагдсантай холбоотойгоор Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 08-р сарын 05-ны өдрийн 20/05 тоот тогтоолын Хөрөнгө худалдах худалдан авах гэрээ баталсан хэсгийг хүчингүй болгож, бусад заалтууд нь хүчин төгөлдөр хэрэгжих болохыг дурдсугай.

**“ИНВЕСКОР АКТИВ ТЗК” ХХК-ИЙН**
**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД**

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК
9020080754 ☎ 6581463

_________________ /Б.Хишигтөр/

_________________ /Ш.Цэрэндаваа/

_________________ /Б.Энхмарал/

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 ☎ 1119277128
УЛААНБААТАР ХОТ

000309

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК
9020080754 ☎ 6581463

MDS & KHANLEX
ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД АШИГЛАСАН БОЛНО.
29 SEP 2020

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore
CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

000309

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР
АКТИВ ...
ХХК

*"Инвескор Актив ТЗК" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 20/12 дугаар тогтоолын Нэгдүгээр Хавсралт*

# ХӨРӨНГӨ ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

ГЭРЭЭНИЙ ДУГААР

№ ....

....

<u>"ИНВЕСКОР ББСБ" ХК</u>

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч

болон

<u>"ИНВЕСКОР АКТИВ ТЗК" ХХК</u>

Үнэт цаас гаргагч

Огноо: 2020 оны ... дугаар сарын ... -ний өдөр

Улаанбаатар хот

ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД АШИГЛАСАН БОЛНО. 29 SEP 2020



000310

СЗХ
он сар өдөр
2021 01 06
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020 -11- 12
БҮРТГЭВ-02

ГАРЧИГ


НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ ..... 4

1.1. Гэрээгээр зохицуулах харилцаа ..... 4

1.2. Нэр томьёо ..... 4

1.3. Хавсралтууд ..... 6

ХОЁР. ХӨРӨНГӨ ХУДАЛДАХ ҮНДСЭН НӨХЦӨЛ ..... 6

2.1. Худалдах хөрөнгө ..... 6

2.2. Худалдах хөрөнгийн хэмжээ ..... 7

2.3. Хөрөнгөд тавигдах шалгуур ..... 7

2.4. Хөрөнгө шилжүүлэх ..... 7

2.5. Фидуцийн зүйлийн өмчлөх эрхийн барьцаа ..... 7

2.6. Хөрөнгийн бүртгэл ..... 8

ГУРАВ. ҮНЭ ТӨЛӨХ ..... 8

3.1. Хөрөнгө худалдан авах үнэ ..... 8

3.2. Үнэ төлөх хугацаа ..... 9

3.3. Нэмэгдсэн өртгийн албан татвар ..... 9

3.4. Хөрөнгө оруулалтаас босгох дүнд хүрэхгүй байх ..... 9

3.5. Гэрээ хэрэгжүүлэх зардал ..... 9

ДӨРӨВ. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧ БАТАЛГААТ ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ ..... 10

4.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн Баталгаат үнэт цаас худалдан авах үүрэг ..... 10

ТАВ. ХӨРӨНГӨ СОЛИХ, ХӨРӨНГИЙН БАГЦАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ..... 10

5.1. Хөрөнгө солих тохиолдол ..... 10

5.2. Хөрөнгө солих мэдэгдэх хүргүүлэх ..... 10

5.3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч Хөрөнгө солих ..... 11

5.4. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч хөрөнгө солих боломжгүй байх ..... 11

5.5. Багцын хөрөнгийг нэмэгдүүлэх ..... 12

ЗУРГАА. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ..... 12

6.1. Үйлчилгээ үзүүлэх гэрээ ..... 12

6.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн үүрэг ..... 12

6.3. Зээлийн баримт бичгийг хадгалах ..... 13

ДОЛОО. ЗЭЭЛИЙН ДАНС БҮРТГЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ, ТУЛГАН ШАЛГАХ ..... 13

7.1. Зээлийн данс бүртгэл хөтлөх ..... 13

НАЙМ. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧИЙН БАТАЛГАА, МЭДЭГДЭЛ ..... 14

8.1. Хөрөнгөтэй холбоотой баталгаа ..... 14


"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК



000311

СЗХ
өн сар өдөр
БҮРТГЭВ 2021.01.06

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020-11-12
БҮРТГЭВ-02

8.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн мэдэгдэл.....15
8.3. Мэдэгдэл, баталгаа хангагдах.....15
8.4. Баталгаа, мэдэгдэл зөрчигдөх.....15
ЕС. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧ ХӨРӨНГӨ БУЦААН.....16
ХУДАЛДАН АВАХ.....16
9.1 Анхны үүрэг гүйцэтгүүлэгч хөрөнгө буцаан худалдаж авах нөхцөл.....16
9.2 Хөрөнгө буцаан худалдан авах үнэ тогтоох.....16
9.3 Хөрөнгийг гуравдагч этгээдэд худалдах.....17
АРАВ. ЗӨРЧИЛ.....17
10.1 Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ноцтой зөрчил.....17
10.2 Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зөрчил.....18
АРВАН НЭГ. НУУЦЛАЛ.....18
11.1 Нууц мэдээлэл.....18
11.2 Нууцлал хадгалах.....18
11.3 Нууц мэдээлэл задруулах.....18
АРВАН ХОЁР. ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ, ДУУСГАВАР БОЛОХ.....19
12.1 Гэрээ хүчин төгөлдөр болох.....19
12.2 Гэрээний хугацаа.....19
12.3 Гэрээ цуцлагдах.....19
АРВАН ГУРАВ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ.....19
13.1 Давагдашгүй хүчин зүйл.....19
АРВАН ДӨРӨВ. ХЭРЭГЛЭГДЭХ ХУУЛЬ, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ.....19
14.1 Хэрэглэгдэх хууль.....19
14.2 Маргаан шийдвэрлэх.....19
14.3 Маргаан үүсгэхийг хязгаарлах.....20
АРВАН ТАВ. ТАЛУУД ХАРИЛЦАХ.....20
15.1 Бичгээр харилцах.....20
15.2 Талуудын харилцах хаяг.....20
АРВАН ЗУРГАА. БУСАД.....21
16.1 Өмнөх тохиролцоо.....21
16.2 Нэмэлт өөрчлөлт.....21
16.3 Эрх, үүрэг шилжих.....21
16.4 Гэрээний хүчин төгөлдөр байдал.....21

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

000312

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ЗЗК ХХК
9020080754 6581463

MDS & KHANLEX
ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД АШИГЛАСАН БОЛНО.
29 SEP 2020

СЗХ
он сар өдөр
2021.01.06
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН...
MONGOLIAN STOCK EX...
2020-11-12
БҮРТГЭВ-0...

Энэхүү ХӨРӨНГӨ ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ (цаашид "Гэрээ" гэх)-г,

1) Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан 6060854 тоот регистрийн, 9015003118 тоот улсын бүртгэлийн дугаартай, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2 дугаар хороо, Сөүлийн гудамж, Твин Тауэр-1 хаягт байрлах "ИНВЕСКОР ББСБ" ХК (цаашид "Анхны үүрэг гүйцэтгүүлэгч" гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Д.Баясгалан;

2) Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан 6581463 тоот регистрийн, 9011818840 тоот улсын бүртгэлийн дугаартай, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2 дугаар хороо, Сөүлийн гудамж, Твин Тауэр-1 хаягт байрлах "ИНВЕСКОР АКТИВ ТЗК" ХХК (цаашид "ТЗК" эсхүл "Үнэт цаас гаргагч" гэх), түүнийг төлөөлж Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Хишигтөр;

(Гэрээнд оролцогч талуудыг дангаар нь "Тал", хамтад нь "Талууд" гэх) нар Иргэний хуулийн 243 дугаар зүйл, дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав. Үүнд:

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

**1.1. Гэрээгээр зохицуулах харилцаа**

Энэхүү Гэрээгээр Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчид Шалгуур үзүүлэлтийг хангасан Автомашины зээлийн авлагын эрх болон түүнд дагалдах эрхүүдийг Үнэт цаас гаргагчид худалдах, Үнэт цаас гаргагч нь хэлэлцэн тохирсон үнийг төлөх болон бусад холбогдох харилцаанд талуудын эдлэх эрх, үүргийг зохицуулна.

**1.2. Нэр томьёо**

1.2.1. Гэрээнд хэрэглэсэн нэр томьёог дараах агуулгаар ойлгоно. Үүнд:

**"Зээл",** эсхүл **"Автомашины зээл"** гэж Зээлдүүлэгч буюу Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Зээлдэгчид автомашин худалдан авахад нь зориулан Зээлийн гэрээний дагуу зээл олгож, тухайн автомашиныг уг зээлийн үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар Фидуцийн гэрээ байгуулсныг.

**"Авлага"** гэж Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Зээлдэгчид олгосон зээлийн дагуу хүлээн авах эрх бүхий сар тутмын хүү, үндсэн төлбөр, нэмэгдүүлсэн хүү болон бусад төлбөрийг;

**"Анхдагч зах зээлийн арилжаа"** гэж Монголын Хөрөнгийн Биржийн анхдагч зах зээлийн арилжааг;

**"Баталгаат үнэт цаас"** эсхүл **"Үнэт цаас"** гэж Үнэт цаас гаргагчийн гарган арилжаалах Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан үнэт цаасыг;

**"Зээл олгогч"** гэж Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийг;

**"Зээлдэгч"** гэж Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн холбогдох журамд заасан шалгуурыг хангаж автомашины зээл авсан, уг зээлийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид төлөх үүрэгтэй этгээдийг;

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

000313

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК
9020080754 6581463

СЗХ
он сар өдөр
2021-01-06
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020-11-12
БҮРТГЭВ-02

**"Зээлдэгчийн хамааралтай этгээд"** гэдэгт хамтран зээлдэгч, барьцаа эсхүл баталгаа гаргагч, фидуцийн зүйлийг эзэмшигч зэргийг;

**"Зээлийн баримт бичгүүд"** гэж Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Зээлдэгчид зээл олгосон зээлийн гэрээ, зээлийн хувийн хэрэг, даатгалын гэрээний баталгаа, Фидуцийн гэрээ болон Фидуцийн хөрөнгөтэй холбоотой баримт бичгүүдийг;

**"Зээлийн данс бүртгэл"** гэж Зээлдэгч тус бүрийн Зээлийн эргэн төлөлт, үлдэгдэл, хүү, нэмэгдүүлсэн хүүг тооцоолж, эргэн төлөлтийг хугацаатай нь бүртгэсэн мэдээллийг;

**"Зээлийн хувийн хэрэг"** гэж Анхны үүрэг гүйцэтгүүлэгч өөрийн Зээлийн үйл ажиллагааны журмын дагуу цуглуулан хадгалдаг Зээлдэгчийн зээл, Фидуцийн зүйл, болон Хөрөнгийн багцын хэсэг болж буй хөрөнгөд хамаарах бүх гүйлгээ, мэдээллийг бүртгэж буй дансны бүртгэл, Зээлдэгчийн зээл олголтын баримт бичгүүд, бүртгэлийн бичиг баримт (электрон, программ хангамж болон бичмэл хэлбэртэй) болон эдгээр дансны бүртгэл, бүртгэлийн бичиг баримтын хамтаар хэрэглэх мэдэгдэл, мэдээ мэдээллийг;

**"Зээлийн эргэн төлөлт"** гэж Зээлдэгчийн Үйлчилгээ үзүүлэгчид сар тутам Зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөх Зээлийн үндсэн төлбөр, хүү болон Зээлийн гэрээний дагуу тооцогдох нэмэгдүүлсэн хүүг;

**"Орлуулах хөрөнгө"** гэж энэ Гэрээний 5.3.1 дэх хэсэгт заасан хөрөнгийг;

**"Сарын хуваарьт төлбөр"** гэж Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Үнэт цаас гаргагчид Үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу сар бүр шилжүүлэх төлбөрийг ойлгоно.

**"Үйлчилгээ"** гэж Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчтай байгуулсан Үйлчилгээ үзүүлэх гэрээний хүрээнд хөрөнгөтэй холбоотой төлбөр цуглуулан шилжүүлэхтэй холбоотойгоор үзүүлж буй үйлчилгээг;

**"Үнэ"** гэж Гэрээний 3.1.1 дэх хэсэгт заасан шалгуурыг хангасан, Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан Баталгаат үнэт цаасыг гаргаж, Монголын Хөрөнгийн Биржийн Анхдагч зах зээлийн арилжаагаар арилжаалах замаар Хөрөнгө оруулалтаас босгосон дүнг;

**"Үнэт цаасны танилцуулга"** гэж Үнэт цаас гаргагчаас Баталгаат үнэт цаасыг олон нийтэд танилцуулж, арилжаалах зорилгоор холбогдох хууль, журамд нийцүүлэн боловсруулсан проспектусыг;

**"Фидуцийн зүйл"** гэж Зээлдэгчийн Анхны Үүрэг гүйцэтгүүлэгчтэй байгуулсан Фидуцийн гэрээний дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжүүлсэн автомашиныг;

**"Фидуцийн барьцааны гэрээ"** гэж энэ Гэрээний 2.5.1 дэх хэсэгт заасан Фидуцийн зүйлийн өмчлөх эрхийн барьцааны гэрээг;

**"Хөрөнгө"** гэж Гэрээний 2.1.1 дэх хэсэгт тодорхойлсон Зээлийн хөрөнгө болон түүнд холбогдох эрхийг;

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

000314

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ХХК
9020080756 6981463

MDS & KHANLEX
ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД АШИГЛАСАН БОЛНО.
29 SEP 2020

СЗХ
2021 .01. 06
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН
MONGOLIAN STOCK EX
2020-11-12
БҮРТГЭВ

**"Хөрөнгийн багц"** гэж Гэрээний 2.1.1 дэх хэсэгт заасан, Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Үнэт цаас гаргагчид худалдсан хөрөнгүүдийн багцыг;

**"Хөрөнгө итгэмжлэн удирдагч"** гэж Үнэт цаас гаргагчтай Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ байгуулсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасан этгээдийг;

**"Хөрөнгийн жагсаалт"** гэж энэ Гэрээний Нэгдүгээр Хавсралтад тусгагдсан, худалдаж буй Хөрөнгийн жагсаалтыг;

**"Хөрөнгө оруулалтаас босгосон дүн"** гэж Баталгаат үнэт цаасыг гаргаж, Монголын Хөрөнгийн Биржийн Анхдагч зах зээлийн арилжаагаар арилжаалах замаар олон нийт болон Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид арилжаалсан дүнгийн нийлбэрийг;

**"Хөрөнгө оруулалтаас босгох дүн"** гэж 3,000,000,000 (гурван тэрбум) төгрөгийг;

**"Хэлцэл биелэх өдөр"** гэж Үнэт цаас гаргагч нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид Гэрээний 3.3.1 дэх хэсэгт заасны дагуу Үнийг төлж, 2.4.1 дэх хэсэгт заасны дагуу Хөрөнгийн багцыг Үнэт цаас гаргагчид шилжсэнд тооцох өдрийг;

**"Шаардлага хангахгүй хөрөнгө"** гэж энэ Гэрээний 5.1 дэх хэсэгт заасан хөрөнгийг;

**"Шалгуур үзүүлэлт"** гэж Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор баталсан, энэ Гэрээнд хавсаргасан Хөрөнгийг багцад тавигдах хуулийн болон санхүүгийн шалгуур үзүүлэлтийг тус тус ойлгоно.

**1.3. Хавсралтууд**

1.3.1. Нэгдүгээр Хавсралт – Хөрөнгийн жагсаалт
1.3.2. Хоёрдугаар Хавсралт – Фидуцийн зүйлийн өмчлөх эрхийн барьцааны гэрээний төсөл
1.3.3. Гуравдугаар Хавсралт – Хөрөнгө солих мэдэгдэл
1.3.4. Дөрөвдүгээр Хавсралт – Зээлийн данс бүртгэлийн тайлан

## ХОЁР. ХӨРӨНГӨ ХУДАЛДАХ ҮНДСЭН НӨХЦӨЛ

**2.1. Худалдах хөрөнгө**

2.1.1. Үнэт цаас гаргагч нь Хэлцэл биелэх өдөр дор дурдсан Зээлийн хөрөнгө болон түүнд холбогдох эрх (хамтад нь "Хөрөнгө" гэх)-үүдийг багц болгон (цаашид "Хөрөнгийн багц" гэх) худалдан авч, гэрээнд заасан Үнийг төлөх, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь уг Хөрөнгийн багцыг худалдахаар харилцан тохиролцов.

2.1.1.1. Хөрөнгийн жагсаалтад тусгагдсан Зээлийн хувьд Зээл олгогчийн авлагын болон бусад бүхий л эрхүүд, үүнд тухайн зээлийн дагуу Зээлдэгчийн төлбөл зохих үндсэн төлбөр, хүү, нэмэгдүүлсэн хүү зэрэг төлбөрийг шаардах, төлбөр цуглуулах, нэхэмжлэл гаргах, Зээлийн төлөлтийг хүлээж авах, эдгээртэй холбоотой Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эдлэх бүхий л эрх;

2.1.1.2. Автомашины болон жолоочийн хариуцлагын даатгалтай холбоотой хохирол нөхөн төлөхийг шаардах эрх;

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК



000315

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020 -11- 12
БҮРТГЭВ-02

СЗХ
2021.01.06 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2.1.1.3. Хөрөнгийн жагсаалтад тусгагдсан Автомашины зээлтэй холбоотойгоор болон гэрээний биелэлтийг хангах зорилгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эдлэх бүхий л эрхийг эдэлж, эрх бүхий байгууллага, гуравдагч этгээд, зээлдэгч болон түүний хамтран зээлдэгч бусад Холбоотой этгээдэд холбогдуулан шаардлага гаргах, шүүх, арбитрт нэхэмжлэл гаргах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох;

2.1.1.4. Зээлтэй холбоотой бүхий л баримт бичгүүд, үүнд зээлийн гэрээ, зээлийн хувийн хэрэг, даатгалын гэрээний баталгаа, Фидуцийн гэрээ болон фидуцтэй холбоотой баримт бичгүүд;

2.1.1.5. Автомашины зээлийн авлагын эрхийг баталгаажуулж буй Фидуцийн зүйлийн өмчлөх эрхийн барьцааны гэрээнд заасны дагуу фидуцийн зүйлүүдийг барьцаалах, энэ Гэрээнд заасан Төлбөр барагдуулах нөхцөл байдал үүссэн тохиолдолд Фидуцийн зүйлийг өмчлөлдөө шилжүүлж, захиран зарцуулахтай холбоотой бүхий л эрхийг эдлэх;

**2.2. Худалдах хөрөнгийн хэмжээ**

Энэ Гэрээний дагуу худалдах Хөрөнгийн хэмжээг Хэлцэл биелэх өдрийн байдлаарх Хөрөнгийн багц дахь Зээлийн үндсэн төлбөрийн үлдэгдлийн нийлбэр дүнгээр тооцох ба уг дүн нь Гэрээний 3.1.1 дэх хэсэгт заасан Хэлцэл биелэх Үнэтэй тэнцүү байна.

**2.3. Хөрөнгөд тавигдах шалгуур**

2.3.1. Хэлцэл биелэх өдрийн байдлаар Хөрөнгө нь энэхүү Гэрээний хавсралтад заасан Шалгуур үзүүлэлтийг хангасан байна.

2.3.2. Хэлцэл биелэх өдрийн байдлаар Хөрөнгийн багц дах Зээлийн гэрээний үлдэгдэл үндсэн төлбөрийн нийт дүн нь 3,000,000,000 (гурван тэрбум) төгрөг хүртэл байна.

2.3.3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгийн багц дахь Зээлүүд нь Шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг Хэлцэл биелэх өдрөөс өмнө баталгаажуулах зорилгоор Үнэт цаас гаргагч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон бусад шаардлагатай этгээдтэй хамтран ажиллах ажилтныг томилж ажиллуулна.

**2.4. Хөрөнгө шилжүүлэх**

2.4.1. Үнэт цаас гаргагч нь энэ Гэрээнд заасан Үнийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид бүрэн төлснөөр Хөрөнгийн багцыг Үнэт цаас гаргагчид шилжсэнд тооцно.

2.4.2. Талууд Хэлцэл биелэх өдрөөс хойш ажлын 3 хоногт багтаан гэрээний 2.5 дэх хэсэгт заасан бүртгэлийг Хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн цахим санд бүртгүүлнэ.

2.4.3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгийн багцын бүх эрх, ашиг сонирхол, үр ашгийн цорын ганц, эрхийн доголдолгүй, бенефицар өмчлөгч тул Хэлцэл биелэх өдрийн байдлаар болон уг өдрөөс хойших хугацаанд эрхийн доголдолгүй байх Хөрөнгийн багцыг шилжүүлнэ.

**2.5. Фидуцийн зүйлийн өмчлөх эрхийн барьцаа**

2.5.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгийн багцын авлагын эрхийг баталгаажуулах зорилгоор Хоёрдугаар Хавсралтад хавсаргасан Фидуцийн зүйлийн өмчлөх эрхийн барьцааны гэрээг байгуулж уг гэрээнд Хөрөнгийн багц дах Зээлийн гэрээний дагуу

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

000316

ИНВЕСКОР АКТИВ ТЭК ХХК
9020080754 6461463

MDS & KHANLEX
ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД АШИГЛАСАН БОЛНО.
29 SEP 2020

СЗХ
он сар өдөр
2021.01.06
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН
MONGOLIAN STOCK EXC
2020-11-12
БҮРТГЭВ-0

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжсэн Фидуцийн зүйлийг өмчлөх эрхийг Иргэний хуулийн 153-160 дугаар зүйлд заасны дагуу Үнэт цаас гаргагчид барьцаалуулна.

2.5.2. Фидуцийн барьцааны гэрээнд заасан Барьцааны эрх хэрэгжүүлэх нөхцөл үүссэн тохиолдолд Үнэт цаас гаргагч нь Фидуцийн зүйлийг үл маргах журмаар өмчлөх эрхтэй болох бөгөөд уг өмчлөх эрхийн дагуу Фидуцийн гэрээнд заасан Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүхий л эрхийг хэрэгжүүлж, фидуцийн зүйлийг захиран зарцуулах эрх үүснэ.

2.5.3. Үнэт цаас гаргагч нь Барьцааны эрх хэрэгжүүлэх нөхцөл үүссэн тухай мэдсэн даруй Фидуцийн зүйлийг өмчлөлдөө шилжүүлэх тухай мэдэгдлийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид хүргүүлэх бөгөөд уг мэдэгдлийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч хүлээж авсан буюу хүлээж авсанд тооцогдсоноор тухайн мэдэгдэлд заасан хугацааны дотор Фидуцийн зүйлийн өмчлөх эрхийг Үнэт цаас гаргагчид шилжсэнд тооцож, бүртгэлд өөрчлөлт оруулах ажиллагааг хийж гүйцэтгэнэ. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь татан буугдах, гүйцэтгэх удирдлагын эрх хэмжээг хэрэгжүүлэгч байхгүй болсон зэрэг шалтгааны улмаас мэдэгдлийг хүлээн авах боломжгүй болсон нь энэхүү үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

2.5.4. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Фидуцийн барьцааны гэрээнд заасан Фидуцийн зүйлийг гуравдагч этгээдийн өмчлөлд шилжүүлэх, барьцаалах болон бусад аливаа хэлбэрээр захиран зарцуулах, түүний эрхийн байдлыг доройтуулахгүй бөгөөд Үнэт цаас гаргагч нь Фидуцийн зүйлээс барьцааны шаардлагыг тэргүүн ээлжид хангуулах эрхтэй байна.

2.5.5. Фидуцийн барьцааны гэрээний хавсралтаар Фидуцийн зүйл болох автомашинуудын жагсаалтыг батлах бөгөөд уг жагсаалтад тусгагдсан Фидуцийн зүйлийн мэдээллийг Хөрөнгө солих, буцаан худалдах, Зээл хаагдах бүрт шинэчилнэ. Уг гэрээний хавсралт дах Фидуцийн зүйлийн барьцааны мэдэгдлийг Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд заасны дагуу тээврийн хэрэгсэл тус бүрийн сериал дугаараар хөдлөх эд хөрөнгийн цахим мэдээллийн санд бүртгүүлнэ. Цахим мэдээллийн санд бүртгүүлэхтэй холбогдон гарах зардлыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч хариуцна.

**2.6. Хөрөнгийн бүртгэл**

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон Үнэт цаас гаргагч тус бүр нь энэ Гэрээнд заасан Хөрөнгийн багц дах Зээл тус бүрийн бүртгэлийг энэхүү Гэрээнд заасны дагуу хөтлөх бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь өөрийн бусад автомашины зээлийн бүртгэлээс тусад нь хөтөлнө.

## ГУРАВ. ҮНЭ ТӨЛӨХ

**3.1. Хөрөнгө худалдан авах үнэ**

3.1.1. Гэрээний 2.1 дэх хэсэгт заасан Хөрөнгийг худалдах Үнэ нь Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан Баталгаат үнэт цаасыг гаргаж, Монголын Хөрөнгийн Биржийн Анхдагч зах зээлийн арилжаагаар арилжаалах замаар Хөрөнгө оруулалтаас босгосон дүн байх ба 3,000,000,000 (гурван тэрбум) төгрөг хүртэл хэмжээтэй байна. Үнэ нь Гэрээний 2.2-т заасны дагуу Хэлцэл биелэх өдрийн

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК

СЗХ 2021.01.06 өдөр БҮРТГЭВ №
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2020-11-12 БҮРТГЭВ-02

байдлаарх Хөрөнгийн багц дахь Зээлийн үндсэн төлбөрийн үлдэгдлийн нийлбэр дүнтэй тэнцүү байна.

3.1.2. Үнэт цаас гаргагч нь Баталгаат үнэт цаасыг дараах байдлаар гарган арилжаална. Үүнд:

- Нийт гаргаж буй Баталгаат үнэт цаасны 85 хувьтай тэнцэх, X үнийн дүн бүхий А транчийн үнэт цаасыг олон нийтэд;
- Нийт гаргаж буй Баталгаат үнэт цаасны 15 хувьтай тэнцэх, X үнийн дүн бүхий Б транчийн үнэт цаснаас 10 хувьтай тэнцэх үнэт цаасыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид, 5 хувьтай тэнцэх үнэт цаасыг Андеррайтерт;

### 3.2. Үнэ төлөх хугацаа

3.2.1. Үнэт цаас гаргагч нь Анхдагч зах зээлийн арилжааны хугацаа дуусахад Хөрөнгө оруулалтаас босгох дүнг босгосон тохиолдолд Анхдагч зах зээлийн арилжаа дууссанаас хойш ажлын 7 хоногийн хугацаанд багтаан Үнийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид шилжүүлнэ.

3.2.2. Төрийн эрх бүхий байгууллагын үйл ажиллагаанаас шалтгаалан Хөрөнгө оруулалтаас босгосон дүн Үнэт цаас гаргагчид орж ирээгүй тохиолдолд Үнэт цаас гаргагч нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид Үнийг хугацаанд нь шилжүүлээгүйтэй холбоотой аливаа хариуцлага хүлээхгүй.

### 3.3. Нэмэгдсэн өртгийн албан татвар

Энэ Гэрээний дагуу Хөрөнгийн багцыг худалдан авахад төлсөн Үнэ нь нь НӨАТ-гүй дүн байх ба Монгол Улсын Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.14 тэх хэсэгт заасны дагуу НӨАТ-аас чөлөөлөгдөнө.

### 3.4. Хөрөнгө оруулалтаас босгох дүнд хүрэхгүй байх

3.4.1. Үнэт цаас гаргагч нь Анхдагч зах зээлийн арилжааны хугацаанд Хөрөнгө оруулалтаас босгосон дүн нь 3,000,000,000 (гурван тэрбум) төгрөгт хүрэхгүй байх тохиолдолд Хэлцэл амжилтгүй болсон гэж үзэх ба Хөрөнгийг үнэт цаас гаргагчид шилжүүлэхгүй.

3.4.2. Гэрээний 3.5.1 дэх хэсэгт заасан нөхцөл байдал бий болсон тохиолдолд Үнэт цаас гаргагч нь Хөрөнгө оруулагчдаас цугларсан хөрөнгийг буцаан олгох ажиллагааг хийнэ.

3.4.3. Үнэт цаас гаргагч нь энэ болон бусад гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөнөөс бусад тохиолдолд Хөрөнгө оруулалтаас босгох дүнд  хүрээгүйн улмаас Анхны үүрэг гүйцэтгэгчид учирсан аливаа хохирлыг хариуцахгүй бөгөөд Анхны үүрэг гүйцэтгэгч нь мөн адил гэрээний үүргийн зөрчил гаргаснаас бусад тохиолдолд Үнэт цаас гаргагчид учирсан аливаа хохирлыг хариуцахгүй.

### 3.5. Гэрээ хэрэгжүүлэх зардал

3.5.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь энэ гэрээг хэрэгжүүлж, Үнэт цаас гаргах үйл ажиллагаатай холбоотой зардлыг хариуцна. Уг зардалд Андеррайтерийн үйлчилгээний хөлс, Санхүүгийн Зохицуулах Хорооны үнэт цаасны бүртгэлийн хураамж, Монголын Хөрөнгийн Биржийн бүртгэл хүлээн авч хянах хөлс, үнэт цаасны бүртгэлийн хураамж, Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төвийн үнэт

"ИНВЕСКОР КАПИТАЛ" ҮЦК ХХК InvesCore CAPITAL 6317839 1119277128 УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ББСБ ХХК 9020080754 6501403
MDS & KHANLEX ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД АШИГЛАСАН БОЛНО. 29 SEP 2020



000319

СЗХ
он сар өдөр
2021 01 06
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН
MONGOLIAN STOCK EXC
2020 -11- 12
БҮРТГЭВ-0

цаасны бүртгэлийн хураамж, Монголын Үнэт Цаасны Клирингийн Төвийн арилжааны шимтгэлийн хураамж, бусад зардлууд багтана.

3.5.2. Үнэт цаас гаргагч нь энэ зүйлд заасан зардлыг 3.3 дахь хэсэгт заасны дагуу Анхны үүрэг гүйцэтгэгчид шилжүүлэх Үнээс суутган шилжүүлж болно.

## ДӨРӨВ. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧ БАТАЛГААТ ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ

**4.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн Баталгаат үнэт цаас худалдан авах үүрэг**

4.1.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаасны танилцуулгад заасан хугацаанд уг танилцуулгад тусгагдсан Б транчийн Баталгаат үнэт цааснаас Үнийн 10 хувьтай тэнцэх хэмжээтэйгээр худалдан авах үүрэг хүлээнэ.

4.1.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь худалдан авсан Б транчийн үнэт цаасыг өөр этгээдэд бусдад худалдахгүй байх үүрэгтэй.

4.1.3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь уг Б транчийн үнэт цаасны төлбөр нь Үнэт цаасны танилцуулга болон Үнэт цаас гаргагчийн Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлөх тухай журамд заасан төлбөрийн дарааллын дагуу төлөгдөх болохыг хүлээн зөвшөөрсөн болно.

## ТАВ. ХӨРӨНГӨ СОЛИХ, ХӨРӨНГИЙН БАГЦАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

**5.1. Хөрөнгө солих тохиолдол**

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгийн багц дах Хөрөнгө дараах байдлаар Шалгуур үзүүлэлтийг хангахгүй болсон тохиолдолд (цаашид “Шаардлага хангахгүй хөрөнгө” гэх) солих үүрэг хүлээнэ.

5.1.1. Зээлийн эргэн төлөлтийн хугацаа нь 15 болон түүнээс дээш хоногоор хэтэрсэн;

5.1.2. Зээл хугацаанаасаа өмнө эргэн төлөгдсөн;

5.1.3. Зээлийн авлагын эрхийг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн (Зээлдэгч нас барсан, сураггүй алга болсон, төлбөрийн чадваргүй болсон, зээл болон түүнтэй холбоотой асуудлаар шүүхэд маргаан үүсгэсэн зэрэг);

5.1.4. Зээлдэгчийн хүсэлтээр Зээлийн гэрээнд өөрчлөлт оруулсан нь Үнэт цаас гаргагчийн Үнэт цаас эзэмшигчдэд төлөх Үнэт цаасны төлбөрт нөлөөлөхүйц байна гэж Үнэт цаас гаргагч үзсэн;

5.1.5. Шалгуур үзүүлэлттэй холбоотойгоор Анхны Үүрэг гүйцэтгүүлэгчийн Гэрээний 8 дугаар зүйлд заасан баталгаа, мэдэгдэл зөрчигдсөн.

**5.2. Хөрөнгө солих мэдэгдэх хүргүүлэх**

5.2.1. Үнэт цаас гаргагч нь 5.1 дэх хэсэгт заасан хөрөнгө солих нөхцөл байдал үүссэн тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид бичгээр эсхүл и-мэйлээр хөрөнгө солих тухай мэдэгдлийг хүргүүлнэ.

5.2.2. Хөрөнгө солих мэдэгдэлд Шаардлага хангахгүй хөрөнгүүдийн жагсаалтыг, тухайн хөрөнгөд харгалзах зээлийн үндсэн төлбөрийн үлдэгдлийн мэдээлэл, шаардлага хангахгүй болсон шалтгааныг Гуравдугаар Хавсралт заасан хүснэгийн дагуу бөглөн хүргүүлнэ.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

000319

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЭЭ ХХК

СЗХ 2021.01.06
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020-11-12
БҮРТГЭВ-02

**5.3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч Хөрөнгө солих**

5.3.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгө солих мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногт багтаан тухайн Шаардлага хангахгүй хөрөнгийн оронд сольж шилжүүлж өгөх хөрөнгө (цаашид "Орлуулах хөрөнгө")-ийн жагсаалтыг гаргаж өгөх ба уг жагсаалтад тусгасан Орлуулах хөрөнгө нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

5.3.1.1. Шалгуур үзүүлэлт хангаж байгаа;

5.3.1.2. Зээлийн үлдэгдэл хугацаа нь Үнэт цаасны эргэн төлөлт хийгдэж дуусах хугацаанаас багагүй;

5.3.1.3. Шаардлага хангахгүй хөрөнгүүдийн зээлийн үндсэн төлбөрийн үлдэгдлийн нийлбэртэй тэнцүү буюу илүү хэмжээ бүхий үндсэн төлбөрийн үлдэгдэл дүнтэй;

5.3.1.4. Шаардлага хангахгүй хөрөнгийн сарын хуваарьт төлбөрийн нийлбэртэй тэнцүү буюу илүү хэмжээ бүхий сарын хуваарь төлбөртэй.

5.3.2. Үнэт цаас гаргагч нь Орлуулах хөрөнгийн жагсаалтыг шалгаж, өөрийн шалгуурт нийцэж байна гэж үзсэн тохиолдолд 2 хоногт хариу мэдэгдэх ба шалгуур хангахгүй гэж үзсэн тохиолдолд тайлбар болон жагсаалтаас хасуулж солиулах хөрөнгийн мэдээллээ хүргүүлнэ. Үнэт цаас гаргагч нь үндэслэлгүйгээр Орлуулах хөрөнгийн жагсаалтад байгаа хөрөнгийг хүлээн авахаас татгалзах эрхгүй байна.

5.3.3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчийн хариу мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногт багтаан хөрөнгүүдийг сольж, тэдгээрт холбогдох бүртгэлийг энэ Гэрээнд заасны дагуу хийлгэнэ.

5.3.4. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Орлуулах хөрөнгийг Үнэт цаас гаргагчид Гэрээний 2.4.1 дэх хэсэгт заасны дагуу шилжүүлэн өгч, 2.4.2 дахь хэсэгт заасны дагуу холбогдох бүртгэлийг хийлгэснээр Үнэт цаас гаргагч нь уг Орлуулах хөрөнгийг худалдан авсанд тооцогдох бөгөөд Шаардлага хангахгүй хөрөнгийг Анхны үүрэг гүйцэтгэгчид буцаан худалдсанд тооцож, буцаан шилжүүлэн өгөх ба бүртгэлээс хасуулна.

5.3.5. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Орлуулах хөрөнгийг шилжүүлэн өгсөн өдөр нь Сарын хуваарьт төлбөр төлөгдөх өдрөөс хойш байх буюу тухайн хөрөнгөд хамаарах зээлийн эргэн төлөлтийн хугацаанаас хамааран Сарын хуваарьт төлбөр бүрэн төлөгдөхгүй нөхцөлд Анхны үүрэг гүйцэтгэгч нь уг зөрүү төлбөрийг төлөх үүрэг хүлээнэ.

5.3.6. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Үнэт цаас гаргагчид шилжүүлэн өгсөн Орлуулах хөрөнгийн зээлийн үндсэн төлбөрийн үлдэгдлийн нийлбэр хэмжээ, эсхүл сарын хуваарьт төлбөрийн нийлбэрийн хэмжээ нь Шаардлага хангахгүй хөрөнгийнхөөс их байх тохиолдолд Үнэт цаас гаргагч нь тухайн хөрөнгө сольсноос хүлээн авсан эсхүл ирээдүйд хүлээн авсан зөрүү төлбөрийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид шилжүүлэх, эсхүл Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийг үйлчилгээ үзүүлэх явцдаа өөрийн дансанд суутган үлдээх зөвшөөрөл өгнө.

**5.4. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч хөрөнгө солих боломжгүй байх**

5.4.1. Анхны үүрэг гүйцэтгэгч нь Шаардлага хангахгүй хөрөнгийг бүхэлд нь солихуйц Орлуулах хөрөнгийн жагсаалтыг Үнэт цаас гаргагчид гаргаж өгөх боломжгүй эсхүл

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ
000320
УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК
9020000754 6081463
MDS & KHANLEX
ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД АШИГЛАСАН БОЛНО.
29 SEP 2020

СЗХ
2021.01.06
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИР
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020-11-12
БҮРТГЭВ-02

уг жагсаалтад буй хөрөнгө нь 5.3.1 дэх хэсэгт заасан шаардлагыг хэсэгчлэн хангахгүй байх тохиолдолд Үнэт цаас гаргагч нь Шаардлага хангахгүй хөрөнгийн солих боломжгүй хэсгийг буцаан худалдаж авах тухай шаардлагыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид хүргүүлнэ.

5.4.2. Буцаан худалдаж авах ажиллагааг энэ Гэрээний 9 дүгээр зүйлд заасантай адил журмаар гүйцэтгүүлнэ.

**5.5. Багцын хөрөнгийг нэмэгдүүлэх**

5.5.1. Дараах үндэслэл бий болсон тохиолдолд Үнэт цаас гаргагч нь багц дах хөрөнгийг нэмэгдүүлэх тухай шаардлагыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид гаргаж болно. Үүнд:

5.5.1.1. Баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцаас орох орлого нь уг баталгаат үнэт цаасны дагуу хүлээсэн үүргийг гүйцэтгэхэд хүрэлцэхээргүй болсон;

5.5.1.2. Баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн үнийн дүнгийн нийлбэр нь үнэт цаасны төлбөрийн төлөгдөөгүй үнийн дүнгийн нийлбэрийн 110 хувиас бага болсон;

5.5.1.3. Баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн дундаж хүү үнэт цаасны хүүнээс бага болсон;

5.5.1.4. Баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн дундаж хугацаа үнэт цаасны дундаж хугацаанаас бага болсон.

5.5.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчийн багцын хөрөнгийг нэмэгдүүлэх шаардлагыг хүлээн авсан тохиолдолд энэ Гэрээний 5.3 дахь хэсэгт заасан хугацаа журмын дагуу Хөрөнгийг нэмэгдүүлэх үүрэг хүлээнэ.

## ЗУРГАА. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ

**6.1. Үйлчилгээ үзүүлэх гэрээ**

6.1.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчтай Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээг энэхүү Гэрээ хүчин төгөлдөр болох өдөр байгуулах бөгөөд тус гэрээний дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгийн багц дах зээлийн эргэн төлөлтийн авлагыг Зээлдэгчдээс цуглуулан Үнэт цаас гаргагчид сар тутам Сарын хуваарьт төлбөр төлөх өдөр шилжүүлэх, Үнэт цаас гаргагч Үйлчилгээний төлбөр болон шимтгэлийг төлөх үүрэг хүлээнэ.

**6.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн үүрэг**

6.2.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгийн багц дах зээлийн данс бүртгэлийг өөрийн бусад зээлийн данс бүртгэл болон санхүүгийн тайлан тэнцлээс тусад нь хөтлөх үүрэгтэй.

6.2.2. Үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу Үнэт цаас гаргагч нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид Зээл олгогчийн эдлэх эрх, үйл ажиллагааг Үнэт цаас гаргагчийг төлөөлөн хэрэгжүүлэх эрхийг олгох бөгөөд Үйлчилгээ үзүүлэгч-Анхны үүрэг гүйцэтгэгч нь уг эрх хэмжээний дагуу үйл ажиллагаа явуулна.

6.2.3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үйлчилгээ үзүүлэх гэрээгээр эрх олгогдсоноос бусад тохиолдолд Хөрөнгийн багц дахь зээл болон Фидуцийн хөрөнгөтэй холбоотой гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, засварлах эрхгүй байна.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЭК ХХК



000321

6.2.4. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгө шилжсэнтэй холбоотойгоор тухайн Зээлдэгчийн эрх зүйн байдлыг дордуулах, зээлийн эргэн төлөлтөд сөргөөр нөлөөлж болзошгүй аливаа үйлдэл, эс үйлдэхүй хийхгүй байх үүрэгтэй ба Үйлчилгээ үзүүлэх гэрээгээр олгогдсон эрх хэмжээний хүрээнд Зээлдэгчийн зээлтэй холбоотой Зээл олгогчийн хувьд хэрэгжүүлэх бүхий л арга хэмжээ, үйлчилгээг Зээлдэгчид үзүүлэх үүрэгтэй.

6.2.5. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Зээлийн данс бүртгэлийг хадгалж хөтлөх, Үнэт цаас гаргагчтай тулган баталгаажуулах болон Хөрөнгө солих, Зээлийн баримт бичгийг Үнэт цаас гаргагчид хүргүүлэх хүлээн авах зэргээр Хөрөнгөтэй холбоотой ажиллагааг хариуцан гүйцэтгэх, Үнэт цаас гаргагчтай харилцах эрх бүхий ажилтныг томилж, уг ажилтны мэдээллийг Үнэт цаас гаргагчид өгөх үүрэгтэй.

6.2.6. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь гэрээний 6.2.5 дах хэсэгт заасан Ажилтны мэдээлэл өөрчлөгдсөн тохиолдолд нэн даруй Үнэт цаас гаргагч болон түүний эрх бүхий ажилтанд мэдээлэх бөгөөд ийнхүү мэдээлээгүйн улмаас Үнэт цаас гаргагч болон бусад этгээдэд хохирол учирсан тохиолдолд уг хохирлыг төлж барагдуулах үүрэг хүлээнэ.

**6.3. Зээлийн баримт бичгийг хадгалах**

6.3.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үйлчилгээ үзүүлэгчийн хувьд Хөрөнгийн багцын дараах баримт бичгүүдийг өөрийн оффис дээр хадгалж хамгаална. Үүнд:

6.3.1.1. Хөрөнгийн багцыг бүрдүүлж буй бүх зээлийн баримт бичгүүд;

6.3.1.2.Зээлдэгчээс гаргасан хүсэлт, захидал харилцаа,

6.3.2. Үнэт цаас гаргагч болон түүнд хөрөнгө итгэмжлэн удирдах болон аудитын үйлчилгээ үзүүлэгч болон бусад эрх олгогдсон этгээд хэдийд ч Зээлийн болон Хөрөнгийн багцын баримт бичгүүдэд бүхэлд нь болон хэсэгчлэн шалгалт хийх эрхтэй байна.

6.3.3. Үнэт цаас гаргагч нь 6.3.2 дахь хэсэгт заасан шалгалтыг хийх зорилгоор Зээлийн баримт бичгүүдийг авах тухай Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид мэдэгдсэн тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь ажлын 3 хоногийн хугацаанд багтаан Үнэт цаас гаргагчид хүргүүлэх бөгөөд Үнэт цаас гаргагч нь эрх бүхий этгээд томилж Зээлийн баримт бичгүүдэд газар дээр нь шалгалт хийх тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь тухайн эрх бүхий этгээдэд ажлын цагаар шалгалт хийх боломжоор хангана.

6.3.4. Үнэт цаас гаргагч нь хүсэлт гаргасан тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь өөрийн эзэмшилд байгаа Хөрөнгөтэй холбоотой аливаа мэдэгдэл, захидал харилцаа, бусад баримт бичгүүдийг Үнэт цаас гаргагчид ажлын 2 өдөрт багтаан гаргаж өгөх үүрэг хүлээнэ.

## ДОЛОО. ЗЭЭЛИЙН ДАНС БҮРТГЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ, ТУЛГАН ШАЛГАХ

**7.1. Зээлийн данс бүртгэл хөтлөх**

7.1.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгийн багц дах Зээлийн данс бүртгэлийг энэ Гэрээний 6.2.1 дэх заалтад заасны дагуу Үйлчилгээ үзүүлэх гэрээний хүчин төгөлдөр үргэлжлэх хугацаанд хөтлөх ба Сарын хуваарьт төлбөр төлөхөөс ажлын 3 хоногийн



000322

СЗХ
2021 . 01. 06
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020 -11- 12
БҮРТГЭВ-02

өмнө Үнэт цаас гаргагчид энэ Гэрээний Хавсралт 4-т заасан маягтын дагуу Зээлийн данс бүртгэлийн тайлан хүргүүлж байна.

7.1.2. Үнэт цаас гаргагч эсхүл түүнд хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлэгч нь мөн Зээлийн данс бүртгэлийг хөтлөх ба сар бүрийн тайланг хүлээн авч тулган баталгаажуулна.

7.1.3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон Үнэт цаас гаргагчийн Зээлийн данс бүртгэлийн хөтлөлт зөрсөн тохиолдолд талуудын эрх бүхий ажилтнууд нь ажлын 2 хоногт багтаан алдааг залруулах ажиллагааг хийж гүйцэтгэнэ.

**7.2. Шаардлага хангахгүй болсон хөрөнгийн мэдээлэл хүргүүлэх**

7.2.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгө энэ хуулийн 5.1 дэх хэсэгт заасан шаардлага хангахгүй болсон тохиолдолд нэн даруй буюу ажлын 1 өдөрт багтаан Үнэт цаас гаргагчид Хавсралт 3-т заасан Хөрөнгө солих мэдэгдлийг хүргүүлэх үүрэг хүлээнэ.

## НАЙМ. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧИЙН БАТАЛГАА, МЭДЭГДЭЛ

**8.1. Хөрөнгөтэй холбоотой баталгаа**

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгөтэй холбоотой дараах баталгааг Үнэт цаас гаргагчид гаргаж байна. Үүнд:

8.1.1. Хөрөнгийн багц дахь Хөрөнгө нэг бүр нь Хэлцэл биелэх өдрийн байдлаар хөрөнгөд тавигдах Шалгуур үзүүлэлтийг хангасан байна.

8.1.2. Энэ Гэрээ болон түүнд хавсаргасан мэдээллүүд нь (гэрээ болон хавсралтад заасан хөрөнгө, фидуцийн зүйл, тэдгээрийн шалгуур үзүүлэлтүүд, тэдгээртэй холбоотой баримт бичиг, мэдээлэл) үнэн зөв, бүрэн гүйцэт болно.

8.1.3. Хөрөнгө, түүний дотор фидуцийн зүйл нь дан ганц Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хууль зүйн болон бенефициар өмчлөлд байх бөгөөд тэдгээрийг Үнэт цаас гаргагчийг өмчлөлд бүрэн шилжүүлэхэд аливаа хязгаарлалт байхгүй болно.

8.1.4. Хөрөнгийн багц дах хөрөнгө, фидуцийн зүйлтэй холбоотой Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Зээлдэгчид төлөх аливаа өр төлбөр, Зээлийн гэрээ болон Фидуцийн гэрээнд зааснаас өөр нэмэлт үүрэг байхгүй болно.

8.1.5. Анхны үүрэг гүйцэтгэгч нь Зээлдэгч болон Зээлдэгчийн хамааралтай этгээд, Фидуцийн зүйлтэй холбоотой дараах сөрөг нөлөөтэй байж болохуйц аливаа маргаан, гомдол, нэхэмжлэл дампуурлын хэрэг зэргийг талаар мэдэгдэл, мэдээлэл аваагүй болно.

8.1.5.1. Зээлдэгч болон түүний хамааралтай этгээдийн Хөрөнгөтэй холбоотой хүлээсэн үүргээ биелүүлэх чадвар доройтоогүй байна.

8.1.5.2. Хөрөнгөтэй холбоотой Анхны үүрэг гүйцэтгэгчийн эрх хэрэгжих нөхцөл, эрхийн хүчин төгөлдөр байдал Гэрээний үргэлжлэх хугацаанд бүрэн хангагдсан байна.

8.1.6. Зээлдэгч нь Хөрөнгөтэй холбоотой аливаа үүргээ Хэлцэл биелэх өдөр хүртэл хэрэгжүүлж биелүүлсэн байх, үүргийн зөрчил бий болсон тохиолдолд уг зөрчлийг арилгасан, ийнхүү арилгасан зөрчлийн Үнэт цаас гаргагчид хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлэгч болон Аудитор шалган баталгаажуулах боломжтой байна.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ЗЭС ХХК
9020000754 6581853

8.1.7. Хөрөнгийн багц дах Зээлийн баримт бичгүүд болон Зээлийн данс бүртгэл нь зохих ёсоор бүртгэгдэн, хадгалагдсан бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшилд байгаа бөгөөд Хэлцэл биелэх өдрийн байдлаар Зээл бүрийн данс бүртгэл бүрэн гүйцэт ба шинэчлэгдсэн байна.

8.1.8. Хөрөнгийн багц дах зээл болон Фидуцийн зүйлтэй холбоотой аливаа шүүхийн маргаан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа үүсээгүй байна.

**8.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн мэдэгдэл**

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь дараах баталгааг Үнэт цаас гаргагчид гаргаж байна. Үүнд:

8.2.1. Энэхүү Гэрээ болон Баталгаат үнэт цаас гаргахтай холбоотой бусад холбогдох гэрээ хэлцэл түүний дотор Фидуцийн барьцааны гэрээ, Үйлчилгээ үзүүлэх гэрээ зэргийг байгуулах эрх зүйн бүрэн чадамжтай бөгөөд эдгээр гэрээ хэлцлийг байгуулснаар бусад гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээ болон эрх бүхий байгууллагын шийдвэр, журам, хууль тогтоомжтой зөрчилдөхгүй болно.

8.2.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь энэхүү Гэрээ болон бусад холбоотой гэрээг байгуулах, гэрээний дагуу хөрөнгө шилжүүлэх, барьцаалах болон бусад үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүхий л бэлтгэл ажлыг хангасан болно.

8.2.3. Үнэт цаас гаргагчид худалдаж буй Хөрөнгө болон Фидуцийн зүйл нь дан ганц Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хууль зүйн болон бенефициар бүрэн өмчлөлд байх бөгөөд тэдгээрийг Үнэт цаас гаргагчид зөрчилгүй эд хөрөнгийн эрх үүсэх бөгөөд тухайн шилжүүлэлт, эрх шилжүүлэлтийг бүртгүүлэх, дуусгавар болгоход аливаа хязгаарлалт байхгүй болно.

8.2.4. Хөрөнгийн багц дахь Зээл тус бүртэй холбоотойгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс

8.2.5. Зээлдэгч болон бусад этгээдэд төлөх өр төлбөр байхгүй бөгөөд Сарын хуваарьт төлбөртэй холбоотойгоор Зээлдэгчээс суутгал хийх эрх үүсээгүй байна.

8.2.6. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчийн "Эрсдэлийн удирдлага, дотоод хяналт хэрэгжүүлэх, эрсдэлийн сан байгуулах, сангийн хөрөнгийг зарцуулах тухай журам"-д заасны дагуу Эсрдэлийн сангийн хөрөнгийг байршуулж, хөрөнгийг захиран зарцуулсан тохиолдолд нөхөн байршуулах болохоо баталж байна.

**8.3. Мэдэгдэл, баталгаа хангагдах**

8.3.1. Үнэт цаас гаргагч нь бичгээр зөвшөөрөл олгосноос бусад тохиолдолд Хөрөнгийн багцыг худалдах, худалдан авах ажиллагааг дуусгавар болгох, Үнэт цаас гаргагч нь аливаа судалгаа шинжилгээ хийлгэх, Үнэт цаас гаргагч нь энэ Гэрээнд заасан эрх, үүргээ хэрэгжүүлээгүй эсхүл тийнхүү хэрэгжилтийг хойшлуулсан зэрэг нь энэ зүйлийн мэдэгдэл баталгаа хангагдахгүй байх үндэслэл болохгүй ба мэдэгдэл, баталгааг зөрчсөн аливаа зөрчилтэй холбоотой Үнэт цаас гаргагч эрхээ бүхэлд нь болон хэсэгчлэн хэрэгжүүлэхгүй байх үндэслэл болохгүй.

**8.4. Баталгаа, мэдэгдэл зөрчигдөх**

8.4.1. Үнэт цаас гаргагч нь энэ Гэрээнд заасан баталгаа мэдэгдэл Гэрээ байгуулагдах үед болон байгуулснаас хойш зөрчигдсөн талаар мэдсэн даруйдаа уг зөрчлийг арилгахыг

000324

СЗХ
2021 01 06
БҮРТГЭВ
№ 01
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020-11-12

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс шаардах эрхтэй бөгөөд зөрчигдсөн баталгаа мэдэгдэл нь цаашид гэрээний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөхүйц, гэрээ хэрэгжихгүй байх эрсдэлтэй гэж үзсэн тохиолдолд гэрээг цуцлах эрхтэй байна.

8.4.2. Үнэт цаас гаргагч нь энэ зүйлд заасан баталгаа, мэдэгдэл худал эсэхийг гэрээ байгуулах үед эсхүл түүнээс өмнө мэдэх боломжтой байсан эсэхээс үл хамааран баталгаа, мэдэгдэл зөрчигдсөнтэй холбоотой шаардлагыг Хөрөнгө худалдан авах үед болон түүнээс хойш гаргаж болох ба Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчаас тогтоосон хугацаанд уг зөрчлийг арилгах үүрэг хүлээнэ.

## ЕС. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧ ХӨРӨНГӨ БУЦААН ХУДАЛДАН АВАХ

**9.1 Анхны үүрэг гүйцэтгүүлэгч хөрөнгө буцаан худалдаж авах нөхцөл**

9.1.1. Хөрөнгийн багцын үлдэгдлийн дүн нь түүний анхны дүн буюу Хөрөнгө оруулалтаас босгосон дүнгийн 20 хувьд хүрсэн тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгэгч нь өөрийн санаачилгаар, эсхүл Үнэт цаас гаргагчийн бичгээр ирүүлсэн шаардлагад үндэслэн уг хөрөнгийг Үнэт цаас гаргагчаас буцаан худалдаж авна.

9.1.2. Хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн 20 ба түүнээс дээш хувь нь 1-ээс дээш сар хугацаа хэтэрсэн бөгөөд Анхны үүрэг гүйцэтгэгч нь уг хугацаа хэтэрсэн хөрөнгийг энэ Гэрээнд заасны дагуу сольж өгөөгүй тохиолдолд Үнэт цаас гаргагчийн бичгээр хүргүүлсэн шаардлагад үндэслэн Анхны үүрэг гүйцэтгэгч нь Үнэт цаас гаргагчид худалдсан нийт Хөрөнгийн багцыг буцаан худалдаж авна.

9.1.3. Үнэт цаас гаргагч нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид мэдэгдэл хүргүүлсэн огноогоор тухайн буцаан худалдах хөрөнгийн хэмжээ тодорхойлогдох ба тийнхүү мэдэгдэл хүргүүлснээс хойш 45 хоногийн хугацаанд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчид буцаан худалдан авах үнийг үе шаттайгаар төлж барагдуулна. Үнэт цаас гаргагч нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгч буцаан худалдан авах үнийг бүрэн төлж барагдуулснаар хөрөнгийн багцыг түүний өмчлөлд шилжүүлнэ.

**9.2 Хөрөнгө буцаан худалдан авах үнэ тогтоох**

9.2.1. Энэ Гэрээний 9.1.1, 9.1.2 дахь хэсэгт заасан худалдан авах үнийг Үнэт цаас гаргагчийн мэдэгдэл өгөх үеийн зах зээлийн үнээр тогтооно.

9.2.2. Аль нэг тал нь зах зээлийн бодит үнийг хөндлөнгийн шинжээчээр тодорхойлуулахаар шаардлага гаргасан тохиолдолд талууд санал нэгтэйгээр хөндлөнгийн шинжээч томилж дүгнэлт гаргуулах бөгөөд ажлын 5 хоногт хөндлөнгийн шинжээчийг томилох асуудлаар санал нэгдэж чадаагүй тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хөндлөнгийн шинжээчийг томилно.

9.2.3. Хөндлөнгийн шинжээчтэй холбоотой зардлыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь 70 хувь, Үнэт цаас гаргагч нь 30 хувиар хариуцна.

9.2.4. Хөндлөнгийн шинжээч нь нэгээс олон тооны Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн худалдан авах үнийг тогтоох тохиолдолд тэдгээр нь уг 70 хувийн төлбөрийг өөрсдийн буцаан худалдаж авах хөрөнгөтэй хувь тэнцүүлэн хувааж хариуцна.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ



УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК

2021.01.06
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020-11-12
БҮРТГЭВ-02

**9.3 Хөрөнгийг гуравдагч этгээдэд худалдах**

9.3.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь энэ зүйл болон 5.4 дэх хэсэгт заасан хөрөнгийг буцаан худалдаж авах чадваргүй байх тохиолдолд Үнэт цаас гаргагч нь уг Хөрөнгийг бусад гуравдагч этгээдэд худалдах эрхтэй байна. Үнэт цаас гаргагч нь ийнхүү гуравдагч этгээдэд хөрөнгө худалдсантай холбоотойгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид учирсан аливаа хохирлыг хариуцахгүй бөгөөд энэ Гэрээний дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс шаардах үүргийн гүйцэтгэлийг аливаа хэлбэрээр хязгаарлахгүй болно.

9.3.2. Анхны үүрэг Гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчид энэ зүйлийн 9.3.1 дэх хэсэгт заасан ажиллагааг хэрэгжүүлсэнтэй холбоотой учирсан аливаа хохирлыг нөхөн төлөх үүрэг хүлээнэ.

## АРАВ. ЗӨРЧИЛ

**10.1 Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ноцтой зөрчил**

Дараах тохиолдол бий болсон нөхцөлд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь ноцтой зөрчил гаргасан гэж үзнэ. Үүнд:

10.1.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн гаргасан аливаа баталгаа, мэдэгдэл, гэрээнд хавсаргасан аливаа баримт бичгүүд, түүнчлэн энэхүү Гэрээ хэрэгжих явцад Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс үүрэг гүйцэтгэгчид гарган өгсөн аливаа баталгаа, мэдэгдэл, тайлан мэдээ зэрэг нь худал, алдаатай байх;

10.1.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс энэ Гэрээний Хөрөнгө солих зохицуулалтын хүрээнд Үнэт цаас гаргагчид сольж өгсөн Орлуулах хөрөнгө нь шаардлага хангахгүй, хууль болон эрх бүхий байгууллага, Үнэт цаас гаргагчаас баталсан журамд нийцээгүй байх;

10.1.3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь энэ Гэрээнд заасан хөрөнгө сольж өгөх болон буцаан худалдаж авах үүргээ биелүүлэхгүй байх;

10.1.4. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн Үнэт цаас гаргагчид худалдсанаас бусад өөрийн автомашины зээлийн хөрөнгийн багц байхгүй болсон;

10.1.5. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч төлбөрийн чадваргүй болсон, татан буулгах ажиллагаа хийгдэж эхэлсэн болон дампуурлын хэрэг үүсгэсэн;

10.1.6. Дээр дурдсанаас бусад байдлаар энэхүү Гэрээнд заасан аливаа зүйл заалт зөрчигдсөн бөгөөд Үнэт цаас гаргагч нь уг зөрчлийг арилгуулахаар Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид мэдэгдэл өгсөн боловч уг зөрчлийг арилгаагүй.

10.1.7. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч ноцтой зөрчил гаргасан тохиолдолд энэ Гэрээний 2.5.3 дахь хэсэгт заасан Барьцааны эрх хэрэгжүүлэх нөхцөл үүссэн гэж үзэх бөгөөд Үнэт цаас гаргагч нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид мэдэгдэл хүргүүлэх замаар Фидуцийн зүйлийг өмчлөлдөө шилжүүлэн авах ба захиран зарцуулах эрхтэй болно. Мөн Үнэт цаас гаргагч нь гэрээний 9.3 дахь хэсэгт заасан журмыг баримтлан Хөрөнгийг гуравдагч этгээдэд худалдах эрхтэй байх ба Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс өөрт учирсан бүхий л хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй байна.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ
000326
УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ХХК
9020000754 6581463
MDS & KHANLEX
ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД АШИГЛАСАН БОЛНО.
2 9 SEP 2020

СЗХ
2021 .01. 06 өдөр
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020 -11- 12
БҮРТГЭВ-02

**10.2 Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зөрчил**

10.2.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь энэхүү Гэрээний зүйл заалтыг зөрчсөн бөгөөд уг зөрчил нь энэ зүйлийн 10.1.1-10.1.6 дахь хэсэгт зааснаас бусад зөрчил байх тохиолдолд Үнэт цаас гаргагч нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид бичгээр мэдэгдэл өгч ажлын 5 хоногт багтаан зөрчлийг арилгахыг шаардах бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь уг зөрчлийг арилгуулах тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш уг зөрчлийг ажлын 5 хоногт багтаан арилгах үүрэг хүлээнэ.

10.2.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь зөрчлийг арилгах хүртэлх хугацаанд болон түүнээс хойших хугацаанд зөрчилтэй холбоотойгоор Үнэт цаас гаргагчид бүхий л хохирлыг нөхөн төлж барагдуулах үүрэг хүлээнэ.

## АРВАН НЭГ. НУУЦЛАЛ

**11.1 Нууц мэдээлэл**

11.1.1. “Нууц мэдээлэл” гэдэгт Үнэт цаас гаргах ажиллагаа болон Хөрөнгө шилжүүлэх ажиллагаатай холбоотой аливаа мэдээлэл, Хөрөнгийн багц болон түүний Зээл, фидуцтай холбоотой Зээлдэгч болон гуравдагч этгээд, Үнэт цаас гаргагч ба Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй холбоотой аливаа мэдээлэл, Үнэт цаас гаргагчийн гуравдагч этгээд (үүнд андеррайтер, хууль зүйн үйлчилгээ үзүүлэгч, зээлийн шижнилгээ гаргагч, хөндлөнгийн аудитор, банк зэрэг байгууллагууд багтана)-тэй байгуулсан гэрээ хэлцэл, тохиролцоо болон тэдгээрээс авч буй үйлчилгээтэй холбоотой аливаа мэдээлэл, мөн талуудын бизнесийн, үйл ажиллагааны, маркетингийн болон санхүүгийн төлөвлөгөө, харилцагчид, хөрөнгө оруулагч, хувь эзэмшлийн тухай мэдээлэл, санхүүгийн нөхцөл байдлын тухай аливаа мэдээлэл, санхүүгийн тайлан, зах зээлийн судалгаа, хуулийн этгээдийн бүртгэл болон үүсгэн байгуулах үндсэн баримт бичиг, дүрэм журам, заавар, бодлого, гэрээ хэлцэл эдгээрт заасан нөхцөл, мэдээлэл, тоон үзүүлэлт, зураг, график мэдээллийг ойлгоно.

11.1.2. Энд дурдагдсан нууц мэдээлэл гэдэгт нийтэд ил болсон, эсхүл үнэт цаас гаргах ажиллагааны хүрээнд Үнэт цаасны танилцуулгад тусгах замаар олон нийтэд танилцуулагдах болон холбогдох хууль журмын дагуу тодорхой этгээдүүд (тухайлбал хөрөнгө оруулагчид)-д танилцуулах мэдээлэл хамаарахгүй болно.

**11.2 Нууцлал хадгалах**

11.2.1. Талууд хууль тогтоомж, төрийн эрх бүхий байгууллага шаардсанаас бусад Нууц мэдээллийг бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр аливаа этгээдэд задруулах, хэрэглэх эсвэл аливаа бусад зорилгоор өөртөө ашиглахыг хориглоно. Эрх бүхий байгууллагаас нөгөө талд мэдэгдэхийг хориглосноос бусад тохиолдолд нууц мэдээллийг задруулагч тал нь тухайн шаардлагын талаар нөгөө талдаа яаралтай мэдэгдэнэ.

11.2.2. Гэрээний 11.2.1 дэх хэсэгт заасан хязгаарлалт нь энэхүү Гэрээ дуусгавар болсон эсхүл цуцлагдсанаас хойш 5 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

**11.3 Нууц мэдээлэл задруулах**

11.3.1. Аль нэг тал нь нууц мэдээллийг амаар, бичгээр задруулсан тохиолдолд уг нууц мэдээллийг задруулсны улмаас нөгөө талдаа учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэг

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 ... 1119277128
УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК
УЛААНБААТАР ХОТ



000327

хүлээнэ. Учирсан хохирлыг тооцохдоо тухайн Нууц мэдээллийг задруулаагүй бол олох байсан бодит орлого, бизнесийн нэр хүнд, үнэт цаас гаргах төслийн амжилттай хэрэгжихэд сөргөөр нөлөөлж, амжилтгүй болох үндсэн хүчин зүйл болсон тохиолдолд үнэт цаас гаргах төсөл амжилттай хэрэгжсэн тохиолдолд олох байсан орлогыг тооцно.

## АРВАН ХОЁР. ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ, ДУУСГАВАР БОЛОХ

**12.1 Гэрээ хүчин төгөлдөр болох**

12.1.1. Энэхүү Гэрээ нь Талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болох бөгөөд гэрээг хоёр хувь үйлдэн, талууд тус бүр нэг нэг хувийг хадгална.

**12.2 Гэрээний хугацаа**

12.2.1. Энэхүү Гэрээ нь байгуулагдсан үеэс эхлэн талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж дуусгавар болох хүртэл буюу Үнэт цаасны төлбөрийг хөрөнгө оруулагчдад төлж дуусган Үнэт цаас гаргагчийг татан буулгах хүртэл, эсхүл Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь энэхүү Гэрээний дагуу шилжүүлсэн Хөрөнгийг бүгдийг нь энэх гэрээнд заасны дагуу буцаан худалдаж авах хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр үргэлжилнэ.

**12.3 Гэрээ цуцлагдах**

12.3.1. Энэхүү Гэрээний дагуу Хөрөнгийг Үнэт цаас гаргагч худалдан авч Хөрөнгөд суурилсан үнэт цаас гаргаж, олон нийтэд арилжаалсан тохиолдолд аль нэг тал санаачилгаараа энэ Гэрээг цуцлах эрхгүй байна.

## АРВАН ГУРАВ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

**13.1 Давагдашгүй хүчин зүйл**

Талууд гэрээний үүрэг гүйцэтгэхтэй холбоотойгоор гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлс /тухайлбал: үер, гал түймэр, газар хөдлөлт, халдварт өвчний тархалт, зэвсэгт мөргөлдөөн, иргэдийн үймээн, ажил хаялт, захиалагч, нийлүүлэгчийн буруутай үйл ажиллагаанаас үл хамаарах төрийн байгууллагын шийдвэр оролцоо гэх мэт/-ийн нөхцөл байдлын улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд нөгөө талдаа мэдэгдэж, харилцан тохиролцсоны үндсэн гэрээний үүргийн гүйцэтгэлийг тухайн нөхцөл байдлыг арилгах хүртэл хойшлуулж болно.

Ханшийн өөрчлөлттэй холбогдох эрсдэл нь давагдашгүй хүчин зүйлийн үндэслэл болохгүй.

## АРВАН ДӨРӨВ. ХЭРЭГЛЭГДЭХ ХУУЛЬ, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

**14.1 Хэрэглэгдэх хууль**

Энэ Гэрээг ойлгох, тайлбарлах, хэрэглэхдээ Монгол Улсын хууль тогтоомжийг баримтална.

**14.2 Маргаан шийдвэрлэх**

14.2.1. Энэхүү Гэрээ болон түүнтэй холбогдон гарч болох бүх маргааныг талууд хамтран шийдвэрлэхийг эрмэлзэнэ.



000329

СЭХ
он сар өдөр
2021 01 06
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020 -11- 12
БҮРТГЭВ-02

14.2.2. Хэрэв маргаантай асуудлаар талууд тохиролцоонд хүрч чадахгүй тохиолдолд энэхүү Гэрээнээс үүссэн болон холбогдон гарсан түүнчлэн уг гэрээг зөрчих, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой аливаа маргаантай асуудлыг МХАҮТ-ын дэргэдэх Монголын Олон улсын арбитрт, түүний Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу шийдвэрлүүлэх ба энэ нь талуудад эцсийн бөгөөд заавал биелүүлэх шийдвэр байна.

14.2.3. Арбитрын шийдвэртэй холбогдон гарах зардлыг аль буруутай тал нь хариуцна.

**14.3 Маргаан үүсгэхийг хязгаарлах**

Энэхүү Гэрээ байгуулагдах үндсэн зорилго болох үнэт цаас гаргах ажиллагаатай холбоотойгоор Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчийн гэрээний үүргийн зөрчилтэй холбоотойгоос бусад тохиолдолд аливаа байдлаар Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөхүйц ажиллагаа авч хэрэгжүүлэх (үүнд шүүх, арбитр, төрийн байгууллагад нэхэмжлэл гомдол гаргах болон бусад Үнэт цаас гаргагчийн эсрэг авч хэрэгжүүлэх ажиллагаануудыг ойлгоно)-гүй байх, төлбөр нэхэмжлэхгүй байх үүрэг хүлээх ба Үнэт цаас гаргагчийн эсрэг татан буулгах, дампуурлын хэрэг эхлүүлэх буюу үүнтэй ижил төсөөтэй үйл ажиллагаа хэрэгжүүлэхгүй байх үүрэгтэй.

## АРВАН ТАВ. ТАЛУУД ХАРИЛЦАХ

**15.1 Бичгээр харилцах**

15.1.1. Гэрээнд өөрөөр заагаагүй бол талууд хоорондоо бичгээр харилцах ба энэхүү Гэрээнд заасан цахим хаяг эсвэл шуудангийн хаягаар илгээнэ.

15.1.2. Бичгэн мэдэгдэл, захидал харилцааг нөгөө талд шуудангаар илгээсэн тохиолдолд тийнхүү илгээснээс хойш 7 /долоо/ хоногийн дараа, цахим хаягаар илгээсэн тохиолдолд дараагийн ажлын өдөр нөгөө тал хүлээн авсанд тооцно.

**15.2 Талуудын харилцах хаяг**

15.1.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч:

| | |
|---|---|
| Хаяглах нь: | "Инвескор ББСБ" ХК |
| Хаяг: | Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, Сөүлийн гудамж 10/1, Твин тауэр 1, 13 давхар |
| Цахим хаяг: | XXX |
| Утас: | XXX |
| Хариуцсан ажилтан: | XXX |

15.1.2. Үнэт цаас гаргагч:

| | |
|---|---|
| Хаяглах нь: | "Инвескор Актив ТЗК" ХХК |
| Хаяг: | Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, Сөүлийн гудамж 10/1, Твин тауэр 1, 13 давхар |
| Цахим хаяг: | XXX |
| Утас: | XXX |
| Хариуцсан ажилтан: | XXX |

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128



УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК

СЗХ
2021 .01.06 өдөр
БҮРТГЭВ
№

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020 -11- 12
БҮРТГЭВ-02

## АРВАН ЗУРГАА. БУСАД

**16.1 Өмнөх тохиролцоо**

Энэхүү Гэрээ хүчин төгөлдөр болсноор талуудын хоорондын өмнөх амаар болон бичгээр хийсэн хэлцэл, таамаглал, тохироо, ойлголцол зэрэг бүхий л тохиролцоог орлоно.

**16.2 Нэмэлт өөрчлөлт**

Талуудын аль нэг нь гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа нөгөө талдаа 10 /арав/-аас доошгүй хоногийн өмнө бичгээр мэдэгдэж, харилцан тохиролцох замаар нэмэлт өөрчлөлт оруулж болно. Нэмэлт өөрчлөлт нь талуудын эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулснаар энэхүү Гэрээний салшгүй хэсэг болно.

**16.3 Эрх, үүрэг шилжих**

Аль нэг тал нь нөгөө талынхаа бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр энэхүү Гэрээгээр хүлээх эрх, үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй байх үүрэгтэй. Аль нэг тал нь эрх залгамжлагч томилсон тохиолдолд тухайн эрх залгамжлагчийн хувьд энэ Гэрээ болон энэ Гэрээг хэрэгжүүлэхээр байгуулсан бусад гэрээнүүд хүчин төгөлдөр үйлчилнэ.

**16.4 Гэрээний хүчин төгөлдөр байдал**

Энэхүү Гэрээний аль нэг зүйл, заалтын хүчин төгөлдөр бус, хууль бус эсвэл мөрдөгдөхгүй болсон нь Гэрээний бусад зүйл, заалтад нөлөөлөхгүй.

**ТАЛУУД:**

| “ИНВЕСКОР ББСБ” ХК-ийг төлөөлөн | “ИНВЕСКОР АКТИВ ТЗК” ХХК-ийг төлөөлөн |
|---|---|
| _______________________ | _______________________ |
| Гүйцэтгэх захирал Д.Баясгалан | ТУЗ-ийн дарга Б.Хишигтөр |

“ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК” ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

000030

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК
9020080754 6901463

MDS & KHANLEX
ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД АШИГЛАСАН 20ЛНО.
29 SEP 2020

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore
CAPITAL
6317839 ♨.1119277128
УЛААНБААТАР ХОТ



УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР
АКТИВ
ХХК

*Инвескор Актив ТЗК" XXK-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 20/12 дугаар тогтоолын Нэгдүгээр Хавсралт*

ХӨРӨНГӨ ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

ГЭРЭЭНИЙ ДУГААР

№ ....

....

"МИКРО КРЕДИТ ББСБ" XXK

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч

болон

"ИНВЕСКОР АКТИВ ТЗК" XXK

Үнэт цаас гаргагч

Огноо: 2020 оны ... дугаар сарын ... -ний өдөр

Улаанбаатар хот

СЗХ
2021 .01. 06
БҮРТГЭВ
№ 01

...ЛЫН ХӨРӨНГ...
...OLIAN STOCK E...
2020 -11- 12
...РТГЭВ...

ГАРЧИГ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ ....4
1.1. Гэрээгээр зохицуулах харилцаа ....4
1.2. Нэр томьёо ....4
1.3. Хавсралтууд ....6
ХОЁР. ХӨРӨНГӨ ХУДАЛДАХ ҮНДСЭН НӨХЦӨЛ ....6
2.1. Худалдах хөрөнгө ....6
2.2. Худалдах хөрөнгийн хэмжээ ....7
2.3. Хөрөнгөд тавигдах шалгуур ....7
2.4. Хөрөнгө шилжүүлэх ....7
2.5. Фидуцийн зүйлийн өмчлөх эрхийн барьцаа ....7
2.6. Хөрөнгийн бүртгэл ....8
ГУРАВ. ҮНЭ ТӨЛӨХ ....8
3.1. Хөрөнгө худалдан авах үнэ ....8
3.2. Үнэ төлөх хугацаа ....9
3.3. Нэмэгдсэн өртгийн албан татвар ....9
3.4. Хөрөнгө оруулалтаас босгох дүнд хүрэхгүй байх ....9
3.5. Гэрээ хэрэгжүүлэх зардал ....9
ДӨРӨВ. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧ БАТАЛГААТ ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ ....10
4.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн Баталгаат үнэт цаас худалдан авах үүрэг ....10
ТАВ. ХӨРӨНГӨ СОЛИХ, ХӨРӨНГИЙН БАГЦАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ....10
5.1. Хөрөнгө солих тохиолдол ....10
5.2. Хөрөнгө солих мэдэгдэх хүргүүлэх ....10
5.3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч Хөрөнгө солих ....11
5.4. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч хөрөнгө солих боломжгүй байх ....11
5.5. Багцын хөрөнгийг нэмэгдүүлэх ....12
ЗУРГАА. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ....12
6.1. Үйлчилгээ үзүүлэх гэрээ ....12
6.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн үүрэг ....12
6.3. Зээлийн баримт бичгийг хадгалах ....13
ДОЛОО. ЗЭЭЛИЙН ДАНС БҮРТГЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ, ТУЛГАН ШАЛГАХ ....13
7.1. Зээлийн данс бүртгэл хөтлөх ....13
НАЙМ. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧИЙН БАТАЛГАА, МЭДЭГДЭЛ ....14
8.1. Хөрөнгөтэй холбоотой баталгаа ....14

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ



УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ... ХХК

СЗХ
он 2021 .01. 06 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020 -11- 12
БҮРТГЭВ-02

8.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн мэдэгдэл ..... 15
8.3. Мэдэгдэл, баталгаа хангагдах ..... 15
8.4. Баталгаа, мэдэгдэл зөрчигдөх ..... 15
ЕС. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧ ХӨРӨНГӨ БУЦААН ..... 16
ХУДАЛДАН АВАХ ..... 16
9.1 Анхны үүрэг гүйцэтгүүлэгч хөрөнгө буцаан худалдаж авах нөхцөл ..... 16
9.2 Хөрөнгө буцаан худалдан авах үнэ тогтоох ..... 16
9.3 Хөрөнгийг гуравдагч этгээдэд худалдах ..... 17
АРАВ. ЗӨРЧИЛ ..... 17
10.1 Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ноцтой зөрчил ..... 17
10.2 Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зөрчил ..... 18
АРВАН НЭГ. НУУЦЛАЛ ..... 18
11.1 Нууц мэдээлэл ..... 18
11.2 Нууцлал хадгалах ..... 18
11.3 Нууц мэдээлэл задруулах ..... 18
АРВАН ХОЁР. ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ, ДУУСГАВАР БОЛОХ ..... 19
12.1 Гэрээ хүчин төгөлдөр болох ..... 19
12.2 Гэрээний хугацаа ..... 19
12.3 Гэрээ цуцлагдах ..... 19
АРВАН ГУРАВ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ ..... 19
13.1 Давагдашгүй хүчин зүйл ..... 19
АРВАН ДӨРӨВ. ХЭРЭГЛЭГДЭХ ХУУЛЬ, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ ..... 19
14.1 Хэрэглэгдэх хууль ..... 19
14.2 Маргаан шийдвэрлэх ..... 20
14.3 Маргаан үүсгэхийг хязгаарлах ..... 20
АРВАН ТАВ. ТАЛУУД ХАРИЛЦАХ ..... 20
15.1 Бичгээр харилцах ..... 20
15.2 Талуудын харилцах хаяг ..... 20
АРВАН ЗУРГАА. БУСАД ..... 21
16.1 Өмнөх тохиролцоо ..... 21
16.2 Нэмэлт өөрчлөлт ..... 21
16.3 Эрх, үүрэг шилжих ..... 21
16.4 Гэрээний хүчин төгөлдөр байдал ..... 21

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

000334

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТӨК ХХК
9020080754 6581463

MDS & KHANLEX
ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД АШИГЛАСАН БОЛНО.
29 SEP 2020

СЗХ
2021 он 01 сар 06 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН
MONGOLIAN STOCK EXCH
2020 -11- 12
БҮРТГЭВ-02

Энэхүү ХӨРӨНГӨ ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ (цаашид “Гэрээ” гэх)-г,

1) Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан 5877997 тоот регистрийн, 9015003025 тоот улсын бүртгэлийн дугаартай, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө, 7/2 байр, 101 тоот хаягт байрлах “МИКРО КРЕДИТ ББСБ” ХХК (цаашид “Анхны үүрэг гүйцэтгүүлэгч” гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Г.Булганчимэг;

2) Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан 6581463 тоот регистрийн, 9011818840 тоот улсын бүртгэлийн дугаартай, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2 дугаар хороо, Сөүлийн гудамж, Твин Тауэр-1 хаягт байрлах “ИНВЕСКОР АКТИВ ТЗК” ХХК (цаашид “ТЗК” эсхүл “Үнэт цаас гаргагч” гэх), түүнийг төлөөлж Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Хишигтөр;

(Гэрээнд оролцогч талуудыг дангаар нь “Тал”, хамтад нь “Талууд” гэх) нар Иргэний хуулийн 243 дугаар зүйл, дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав. Үүнд:

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

**1.1. Гэрээгээр зохицуулах харилцаа**

Энэхүү Гэрээгээр Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчид Шалгуур үзүүлэлтийг хангасан Автомашины зээлийн авлагын эрх болон түүнд дагалдах эрхүүдийг Үнэт цаас гаргагчид худалдах, Үнэт цаас гаргагч нь хэлэлцэн тохирсон үнийг төлөх болон бусад холбогдох харилцаанд талуудын эдлэх эрх, үүргийг зохицуулна.

**1.2. Нэр томьёо**

1.2.1. Гэрээнд хэрэглэсэн нэр томьёог дараах агуулгаар ойлгоно. Үүнд:

**“Зээл”,** эсхүл **“Автомашины зээл”** гэж Зээлдүүлэгч буюу Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Зээлдэгчид автомашин худалдан авахад нь зориулан Зээлийн гэрээний дагуу зээл олгож, тухайн автомашиныг уг зээлийн үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар Фидуцийн гэрээ байгуулсныг.

**“Авлага”** гэж Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Зээлдэгчид олгосон зээлийн дагуу хүлээн авах эрх бүхий сар тутмын хүү, үндсэн төлбөр, нэмэгдүүлсэн хүү болон бусад төлбөрийг;

**“Анхдагч зах зээлийн арилжаа”** гэж Монголын Хөрөнгийн Биржийн анхдагч зах зээлийн арилжааг;

**“Баталгаат үнэт цаас”** эсхүл **“Үнэт цаас”** гэж Үнэт цаас гаргагчийн гарган арилжаалах Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан үнэт цаасыг;

**“Зээл олгогч”** гэж Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийг;

**“Зээлдэгч”** гэж Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн холбогдох журамд заасан шалгуурыг хангаж автомашины зээл авсан, уг зээлийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид төлөх үүрэгтэй этгээдийг;

“ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК” ХХК
InvesCore CAPITAL
6317839 д.1119277128
УЛААНБААТАР ХОТ



УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК

2021 .01. 06 өлөр
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020 -11- 12
БҮРТГЭВ-02

**"Зээлдэгчийн хамааралтай этгээд"** гэж хамтран зээлдэгч, барьцаа эсхүл баталгаа гаргагч, фидуцийн зүйлийг эзэмшигч зэргийг;

**"Зээлийн баримт бичгүүд"** гэж Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Зээлдэгчид зээл олгосон зээлийн гэрээ, зээлийн хувийн хэрэг, даатгалын гэрээний баталгаа, Фидуцийн гэрээ болон Фидуцийн хөрөнгөтэй холбоотой баримт бичгүүдийг;

**"Зээлийн данс бүртгэл"** гэж Зээлдэгч тус бүрийн Зээлийн эргэн төлөлт, үлдэгдэл, хүү, нэмэгдүүлсэн хүүг тооцоолж, эргэн төлөлтийг хугацаатай нь бүртгэсэн мэдээллийг;

**"Зээлийн хувийн хэрэг"** гэж Анхны үүрэг гүйцэтгүүлэгч өөрийн Зээлийн үйл ажиллагааны журмын дагуу цуглуулан хадгалдаг Зээлдэгчийн зээл, Фидуцийн зүйл, болон Хөрөнгийн багцын хэсэг болж буй хөрөнгөд хамаарах бүх гүйлгээ, мэдээллийг бүртгэж буй дансны бүртгэл, Зээлдэгчийн зээл олголтын баримт бичгүүд, бүртгэлийн бичиг баримт (электрон, программ хангамж болон бичмэл хэлбэртэй) болон эдгээр дансны бүртгэл, бүртгэлийн бичиг баримтын хамтаар хэрэглэх мэдэгдэл, мэдээ мэдээллийг;

**"Зээлийн эргэн төлөлт"** гэж Зээлдэгчийн Үйлчилгээ үзүүлэгчид сар тутам Зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөх Зээлийн үндсэн төлбөр, хүү болон Зээлийн гэрээний дагуу тооцогдох нэмэгдүүлсэн хүүг;

**"Орлуулах хөрөнгө"** гэж энэ Гэрээний 5.3.1 дэх хэсэгт заасан хөрөнгийг;

**"Сарын хуваарьт төлбөр"** гэж Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Үнэт цаас гаргагчид Үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу сар бүр шилжүүлэх төлбөрийг ойлгоно.

**"Үйлчилгээ"** гэж Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчтай байгуулсан Үйлчилгээ үзүүлэх гэрээний хүрээнд хөрөнгөтэй холбоотой төлбөр цуглуулан шилжүүлэхтэй холбоотойгоор үзүүлж буй үйлчилгээг;

**"Үнэ"** гэж Гэрээний 3.1.1 дэх хэсэгт заасан шалгуурыг хангасан, Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан Баталгаат үнэт цаасыг гаргаж, Монголын Хөрөнгийн Биржийн Анхдагч зах зээлийн арилжаагаар арилжаалах замаар Хөрөнгө оруулалтаас босгосон дүнг;

**"Үнэт цаасны танилцуулга"** Үнэт цаас гаргагчаас Баталгаат үнэт цаасыг олон нийтэд танилцуулж, арилжаалах зорилгоор холбогдох хууль, журамд нийцүүлэн боловсруулсан проспектусыг;

**"Фидуцийн зүйл"** гэж Зээлдэгчийн Анхны Үүрэг гүйцэтгүүлэгчтэй байгуулсан Фидуцийн гэрээний дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжүүлсэн автомашиныг;

**"Фидуцийн барьцааны гэрээ"** гэж энэ Гэрээний 2.5.1 дэх хэсэгт заасан Фидуцийн зүйлийн өмчлөх эрхийн барьцааны гэрээг;

**"Хөрөнгө"** гэж Гэрээний 2.1.1 дэх хэсэгт тодорхойлсон Зээлийн хөрөнгө болон түүнд холбогдох эрхийг;

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ
000336
УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АККТИВ ТЗК ХХК
9020080754 5581463
MDS & KHANLEX
ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД АШИГЛАСАН БОЛНО.
29 SEP 2020

СЗХ
2021 .01. 06
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020 -11- 12
БҮРТГЭВ-02

**"Хөрөнгийн багц"** гэж Гэрээний 2.1.1 дэх хэсэгт заасан, Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Үнэт цаас гаргагчид худалдсан хөрөнгүүдийн багцыг;

**"Хөрөнгө итгэмжлэн удирдагч"** гэдэгт Үнэт цаас гаргагчтай Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ байгуулсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасан этгээдийг;

**"Хөрөнгийн жагсаалт"** гэж энэ Гэрээний Нэгдүгээр Хавсралтад тусгагдсан, худалдаж буй Хөрөнгийн жагсаалтыг;

**"Хөрөнгө оруулалтаас босгосон дүн"** гэж Баталгаат үнэт цаасыг гаргаж, Монголын Хөрөнгийн Биржийн Анхдагч зах зээлийн арилжаагаар арилжаалах замаар олон нийт болон Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид арилжаалсан дүнгийн нийлбэрийг;

**"Хөрөнгө оруулалтаас босгох дүн"** гэж 1,000,000,000 (нэг тэрбум) төгрөгийг;

**"Хэлцэл биелэх өдөр"** гэж Үнэт цаас гаргагч нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид Гэрээний 3.3.1 дэх хэсэгт заасны дагуу Үнийг төлж, 2.4.1 дэх хэсэгт заасны дагуу Хөрөнгийн багцыг Үнэт цаас гаргагчид шилжсэнд тооцох өдрийг;

**"Шаардлага хангахгүй хөрөнгө"** гэж энэ Гэрээний 5.1 дэх хэсэгт заасан хөрөнгийг;

**"Шалгуур үзүүлэлт"** гэж Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор баталсан, энэ Гэрээнд хавсаргасан Хөрөнгийг багцад тавигдах хуулийн болон санхүүгийн шалгуур үзүүлэлтийг тус тус ойлгоно.

**1.3. Хавсралтууд**

1.3.1. Нэгдүгээр Хавсралт – Хөрөнгийн жагсаалт
1.3.2. Хоёрдугаар Хавсралт – Фидуцийн зүйлийн өмчлөх эрхийн барьцааны гэрээний төсөл
1.3.3. Гуравдугаар Хавсралт – Хөрөнгө солих мэдэгдэл
1.3.4. Дөрөвдүгээр Хавсралт – Зээлийн данс бүртгэлийн тайлан

## ХОЁР. ХӨРӨНГӨ ХУДАЛДАХ ҮНДСЭН НӨХЦӨЛ

**2.1. Худалдах хөрөнгө**

2.1.1. Үнэт цаас гаргагч нь Хэлцэл биелэх өдөр дор дурдсан Зээлийн хөрөнгө болон түүнд холбогдох эрх (хамтад нь "Хөрөнгө" гэх)-үүдийг багц болгон (цаашид "Хөрөнгийн багц" гэх) худалдан авч, гэрээнд заасан Үнийг төлөх, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь уг Хөрөнгийн багцыг худалдахаар харилцан тохиролцов.

2.1.1.1. Хөрөнгийн жагсаалтад тусгагдсан Зээлийн хувьд Зээл олгогчийн авлагын болон бусад бүхий л эрхүүд, үүнд тухайн зээлийн дагуу Зээлдэгчийн төлбөл зохих үндсэн төлбөр, хүү, нэмэгдүүлсэн хүү зэрэг төлбөрийг шаардах, төлбөр цуглуулах, нэхэмжлэл гаргах, Зээлийн төлөлтийг хүлээж авах, эдгээртэй холбоотой Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эдлэх бүхий л эрх;

2.1.1.2. Автомашины болон жолоочийн хариуцлагын даатгалтай холбоотой хохирол нөхөн төлөхийг шаардах эрх;

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ



УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЭЗ ХХК
9020000754 6981463

2.1.1.3. Хөрөнгийн жагсаалтад тусгагдсан Автомашины зээлтэй холбоотойгоор болон гэрээний биелэлтийг хангах зорилгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эдлэх бүхий л эрхийг эдэлж, эрх бүхий байгууллага, гуравдагч этгээд, зээлдэгч болон түүний хамтран зээлдэгч бусад Холбоотой этгээдэд холбогдуулан шаардлага гаргах, шүүх, арбитрт нэхэмжлэл гаргах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох;

2.1.1.4. Зээлтэй холбоотой бүхий л баримт бичгүүд, үүнд зээлийн гэрээ, зээлийн хувийн хэрэг, даатгалын гэрээний баталгаа, Фидуцийн гэрээ болон фидуцтэй холбоотой баримт бичгүүд;

2.1.1.5. Автомашины зээлийн авлагын эрхийг баталгаажуулж буй Фидуцийн зүйлийн өмчлөх эрхийн барьцааны гэрээнд заасны дагуу фидуцийн зүйлүүдийг барьцаалах, энэ Гэрээнд заасан Төлбөр барагдуулах нөхцөл байдал үүссэн тохиолдолд Фидуцийн зүйлийг өмчлөлдөө шилжүүлж, захиран зарцуулахтай холбоотой бүхий л эрхийг эдлэх.

**2.2. Худалдах хөрөнгийн хэмжээ**

Энэ Гэрээний дагуу худалдах Хөрөнгийн хэмжээг Хэлцэл биелэх өдрийн байдлаарх Хөрөнгийн багц дахь Зээлийн үндсэн төлбөрийн үлдэгдлийн нийлбэр дүнгээр тооцох ба уг дүн нь Гэрээний 3.1.1 дэх хэсэгт заасан Хэлцэл биелэх Үнэтэй тэнцүү байна.

**2.3. Хөрөнгөд тавигдах шалгуур**

2.3.1. Хэлцэл биелэх өдрийн байдлаар Хөрөнгө нь энэхүү Гэрээний хавсралтад заасан Шалгуур үзүүлэлтийг хангасан байна.

2.3.2. Хэлцэл биелэх өдрийн байдлаар Хөрөнгийн багц дах Зээлийн гэрээний үлдэгдэл үндсэн төлбөрийн нийт дүн нь 1,000,000,000 (нэг тэрбум) төгрөг хүртэл байна.

2.3.3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгийн багц дахь Зээлүүд нь Шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг Хэлцэл биелэх өдрөөс өмнө баталгаажуулах зорилгоор Үнэт цаас гаргагч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон бусад шаардлагатай этгээдтэй хамтран ажиллах ажилтныг томилж ажиллуулна.

**2.4. Хөрөнгө шилжүүлэх**

2.4.1. Үнэт цаас гаргагч нь энэ Гэрээнд заасан Үнийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид бүрэн төлснөөр Хөрөнгийн багцыг Үнэт цаас гаргагчид шилжсэнд тооцно.

2.4.2. Талууд Хэлцэл биелэх өдрөөс хойш ажлын 3 хоногт багтаан гэрээний 2.5 дэх хэсэгт заасан бүртгэлийг Хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн цахим санд бүртгүүлнэ.

2.4.3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгийн багцын бүх эрх, ашиг сонирхол, үр ашгийн цорын ганц, эрхийн доголдолгүй, бенефицар өмчлөгч тул Хэлцэл биелэх өдрийн байдлаар болон уг өдрөөс хойших хугацаанд эрхийн доголдолгүй байх Хөрөнгийн багцыг шилжүүлнэ.

**2.5. Фидуцийн зүйлийн өмчлөх эрхийн барьцаа**

2.5.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгийн багцын авлагын эрхийг баталгаажуулах зорилгоор Хоёрдугаар Хавсралтад хавсаргасан Фидуцийн зүйлийн өмчлөх эрхийн барьцааны гэрээг байгуулж уг гэрээнд Хөрөнгийн багц дах Зээлийн гэрээний дагуу



000339

СЗХ
2021 .01. 06
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020 -11- 12
БҮРТГЭВ-02

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжсэн Фидуцийн зүйлийг өмчлөх эрхийг Иргэний хуулийн 153-160 дугаар зүйлд заасны дагуу Үнэт цаас гаргагчид барьцаалуулна.

2.5.2. Фидуцийн барьцааны гэрээнд заасан Барьцааны эрх хэрэгжүүлэх нөхцөл үүссэн тохиолдолд Үнэт цаас гаргагч нь Фидуцийн зүйлийг үл маргах журмаар өмчлөх эрхтэй болох бөгөөд уг өмчлөх эрхийн дагуу Фидуцийн гэрээнд заасан Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүхий л эрхийг хэрэгжүүлж, фидуцийн зүйлийг захиран зарцуулах эрх үүснэ.

2.5.3. Үнэт цаас гаргагч нь Барьцааны эрх хэрэгжүүлэх нөхцөл үүссэн тухай мэдсэн даруй Фидуцийн зүйлийг өмчлөлдөө шилжүүлэх тухай мэдэгдлийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид хүргүүлэх бөгөөд уг мэдэгдлийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч хүлээж авсан буюу хүлээж авсанд тооцогдсоноор тухайн мэдэгдэлд заасан хугацааны дотор Фидуцийн зүйлийн өмчлөх эрхийг Үнэт цаас гаргагчид шилжсэнд тооцож, бүртгэлд өөрчлөлт оруулах ажиллагааг хийж гүйцэтгэнэ. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь татан буугдах, гүйцэтгэх удирдлагын эрх хэмжээг хэрэгжүүлэгч байхгүй болсон зэрэг шалтгааны улмаас мэдэгдлийг хүлээн авах боломжгүй болсон нь энэхүү үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

2.5.4. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Фидуцийн барьцааны гэрээнд заасан Фидуцийн зүйлийг гуравдагч этгээдийн өмчлөлд шилжүүлэх, барьцаалах болон бусад аливаа хэлбэрээр захиран зарцуулах, түүний эрхийн байдлыг доройтуулахгүй бөгөөд Үнэт цаас гаргагч нь Фидуцийн зүйлээс барьцааны шаардлагыг тэргүүн ээлжид хангуулах эрхтэй байна.

2.5.5. Фидуцийн барьцааны гэрээний хавсралтаар Фидуцийн зүйл болох автомашинуудын жагсаалтыг батлах бөгөөд уг жагсаалтад тусгагдсан Фидуцийн зүйлийн мэдээллийг Хөрөнгө солих, буцаан худалдах, Зээл хаагдах бүрт шинэчилнэ. Уг гэрээний хавсралт дах Фидуцийн зүйлийн барьцааны мэдэгдлийг Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд заасны дагуу тээврийн хэрэгсэл тус бүрийн сериал дугаараар хөдлөх эд хөрөнгийн цахим мэдээллийн санд бүртгүүлнэ. Цахим мэдээллийн санд бүртгүүлэхтэй холбогдон гарах зардлыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч хариуцна.

**2.6. Хөрөнгийн бүртгэл**

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон Үнэт цаас гаргагч тус бүр нь энэ Гэрээнд заасан Хөрөнгийн багц дах Зээл тус бүрийн бүртгэлийг энэхүү Гэрээнд заасны дагуу хөтлөх бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь өөрийн бусад автомашины зээлийн бүртгэлээс тусад нь хөтөлнө.

## ГУРАВ. ҮНЭ ТӨЛӨХ

**3.1. Хөрөнгө худалдан авах үнэ**

3.1.1. Гэрээний 2.1 дэх хэсэгт заасан Хөрөнгийг худалдах Үнэ нь Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан Баталгаат үнэт цаасыг гаргаж, Монголын Хөрөнгийн Биржийн Анхдагч зах зээлийн арилжаагаар арилжаалах замаар Хөрөнгө оруулалтаас босгосон дүн байх ба 1,000,000,000 (нэг тэрбум) төгрөг хүртэл хэмжээтэй байна. Үнэ нь Гэрээний 2.2-т заасны дагуу Хэлцэл биелэх өдрийн

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

ИНВЕСКОР АКТИВ ЗЭЭЛ ХХК



000339

байдлаарх Хөрөнгийн багц дахь Зээлийн үндсэн төлбөрийн үлдэгдлийн нийлбэр дүнтэй тэнцүү байна.

3.1.2. Үнэт цаас гаргагч нь Баталгаат үнэт цаасыг дараах байдлаар гарган арилжаална. Үүнд:

- Нийт гаргаж буй Баталгаат үнэт цаасны 85 хувьтай тэнцэх, X үнийн дүн бүхий А транчийн үнэт цаасыг олон нийтэд;
- Нийт гаргаж буй Баталгаат үнэт цаасны 15 хувьтай тэнцэх, X үнийн дүн бүхий Б транчийн үнэт цааснаас 10 хувьтай тэнцэх үнэт цаасыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид, 5 хувьтай тэнцэх үнэт цаасыг Андеррайтерт;

**3.2. Үнэ төлөх хугацаа**

3.2.1. Үнэт цаас гаргагч нь Анхдагч зах зээлийн арилжааны хугацаа дуусахад Хөрөнгө оруулалтаас босгох дүнг босгосон тохиолдолд Анхдагч зах зээлийн арилжаа дууссанаас хойш ажлын 7 хоногийн хугацаанд багтаан Үнийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид шилжүүлнэ.

3.2.2. Төрийн эрх бүхий байгууллагын үйл ажиллагаанаас шалтгаалан Хөрөнгө оруулалтаас босгосон дүн Үнэт цаас гаргагчид орж ирээгүй тохиолдолд Үнэт цаас гаргагч нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид Үнийг хугацаанд нь шилжүүлээгүйтэй холбоотой аливаа хариуцлага хүлээхгүй.

**3.3. Нэмэгдсэн өртгийн албан татвар**

Энэ Гэрээний дагуу Хөрөнгийн багцыг худалдан авахад төлсөн Үнэ нь нь НӨАТ-гүй дүн байх ба Монгол Улсын Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.14 тэх хэсэгт заасны дагуу НӨАТ-аас чөлөөлөгдөнө.

**3.4. Хөрөнгө оруулалтаас босгох дүнд хүрэхгүй байх**

3.4.1. Үнэт цаас гаргагч нь Анхдагч зах зээлийн арилжааны хугацаанд Хөрөнгө оруулалтаас босгосон дүн нь 1,000,000,000 (нэг тэрбум) төгрөгт хүрэхгүй байх тохиолдолд Хэлцэл амжилтгүй болсон гэж үзэх ба Хөрөнгийг үнэт цаас гаргагчид шилжүүлэхгүй.

3.4.2. Гэрээний 3.5.1 дэх хэсэгт заасан нөхцөл байдал бий болсон тохиолдолд Үнэт цаас гаргагч нь Хөрөнгө оруулагчдаас цугларсан хөрөнгийг буцаан олгох ажиллагааг хийнэ.

3.4.3. Үнэт цаас гаргагч нь энэ болон бусад гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөнөөс бусад тохиолдолд Хөрөнгө оруулалтаас босгох дүнд хүрээгүйн улмаас Анхны үүрэг гүйцэтгэгчид учирсан аливаа хохирлыг хариуцахгүй бөгөөд Анхны үүрэг гүйцэтгэгч нь мөн адил гэрээний үүргийн зөрчил гаргаснаас бусад тохиолдолд Үнэт цаас гаргагчид учирсан аливаа хохирлыг хариуцахгүй.

**3.5. Гэрээ хэрэгжүүлэх зардал**

3.5.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь энэ гэрээг хэрэгжүүлж, Үнэт цаас гаргах үйл ажиллагаатай холбоотой зардлыг хариуцна. Уг зардалд Андеррайтерийн үйлчилгээний хөлс, Санхүүгийн Зохицуулах Хорооны үнэт цаасны бүртгэлийн хураамж, Монголын Хөрөнгийн Биржийн бүртгэл хүлээн авч хянах хөлс, үнэт цаасны бүртгэлийн хураамж, Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төвийн үнэт

СЭХ
он сар өдөр
2021.01.06
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН
MONGOLIAN STOCK EXCH
2020-11-12
...ТГЭВ-02

цаасны бүртгэлийн хураамж, Монголын Үнэт Цаасны Клирингийн Төвийн арилжааны шимтгэлийн хураамж, бусад зардлууд багтана.

3.5.2. Үнэт цаас гаргагч нь энэ зүйлд заасан зардлыг 3.3 дахь хэсэгт заасны дагуу Анхны үүрэг гүйцэтгэгчид шилжүүлэх Үнээс суутган шилжүүлж болно.

## ДӨРӨВ. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧ БАТАЛГААТ ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ

**4.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн Баталгаат үнэт цаас худалдан авах үүрэг**

4.1.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаасны танилцуулгад заасан хугацаанд уг танилцуулгад тусгагдсан Б транчийн Баталгаат үнэт цааснаас Үнийн 10 хувьтай тэнцэх хэмжээтэйгээр худалдан авах үүрэг хүлээнэ.

4.1.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь худалдан авсан Б транчийн үнэт цаасыг өөр этгээдэд бусдад худалдахгүй байх үүрэгтэй.

4.1.3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь уг Б транчийн үнэт цаасны төлбөр нь Үнэт цаасны танилцуулга болон Үнэт цаас гаргагчийн Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлөх тухай журамд заасан төлбөрийн дараалын дагуу төлөгдөх болохыг хүлээн зөвшөөрсөн болно.

## ТАВ. ХӨРӨНГӨ СОЛИХ, ХӨРӨНГИЙН БАГЦАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

**5.1. Хөрөнгө солих тохиолдол**

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгийн багц дах Хөрөнгө дараах байдлаар Шалгуур үзүүлэлтийг хангахгүй болсон тохиолдолд (цаашид "Шаардлага хангахгүй хөрөнгө" гэх) солих үүрэг хүлээнэ.

5.1.1. Зээлийн эргэн төлөлтийн хугацаа нь 15 болон түүнээс дээш хоногоор хэтэрсэн;

5.1.2. Зээл хугацаанаасаа өмнө эргэн төлөгдсөн;

5.1.3. Зээлийн авлагын эрхийг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн (Зээлдэгч нас барсан, сураггүй алга болсон, төлбөрийн чадваргүй болсон, зээл болон түүнтэй холбоотой асуудлаар шүүхэд маргаан үүсгэсэн зэрэг);

5.1.4. Зээлдэгчийн хүсэлтээр Зээлийн гэрээнд өөрчлөлт оруулсан нь Үнэт цаас гаргагчийн Үнэт цаас эзэмшигчдэд төлөх Үнэт цаасны төлбөрт нөлөөлөхүйц байна гэж Үнэт цаас гаргагч үзсэн;

5.1.5. Шалгуур үзүүлэлттэй холбоотойгоор Анхны Үүрэг гүйцэтгүүлэгчийн Гэрээний 8 дугаар зүйлд заасан баталгаа, мэдэгдэл зөрчигдсөн.

**5.2. Хөрөнгө солих мэдэгдэх хүргүүлэх**

5.2.1. Үнэт цаас гаргагч нь 5.1 дэх хэсэгт заасан хөрөнгө солих нөхцөл байдал үүссэн тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид бичгээр эсхүл и-мэйлээр хөрөнгө солих тухай мэдэгдлийг хүргүүлнэ.

5.2.2. Хөрөнгө солих мэдэгдэлд Шаардлага хангахгүй хөрөнгүүдийн жагсаалтыг, тухайн хөрөнгөд харгалзах зээлийн үндсэн төлбөрийн үлдэгдлийн мэдээлэл, шаардлага хангахгүй болсон шалтгааныг Гуравдугаар Хавсралт заасан хүснэгтийн дагуу бөглөн хүргүүлнэ.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ



УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ... ХХК
9020080754 5581463

СХХ
2021 .01. 06 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020-11-12
БҮРТГЭВ-02

**5.3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч Хөрөнгө солих**

5.3.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгө солих мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногт багтаан тухайн Шаардлага хангахгүй хөрөнгийн оронд сольж шилжүүлж өгөх хөрөнгө (цаашид "Орлуулах хөрөнгө")-ийн жагсаалтыг гаргаж өгөх ба уг жагсаалтад тусгасан Орлуулах хөрөнгө нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

5.3.1.1. Шалгуур үзүүлэлт хангаж байгаа;

5.3.1.2. Зээлийн үлдэгдэл хугацаа нь Үнэт цаасны эргэн төлөлт хийгдэж дуусах хугацаанаас багагүй;

5.3.1.3. Шаардлага хангахгүй хөрөнгүүдийн зээлийн үндсэн төлбөрийн үлдэгдлийн нийлбэртэй тэнцүү буюу илүү хэмжээ бүхий үндсэн төлбөрийн үлдэгдэл дүнтэй;

5.3.1.4. Шаардлага хангахгүй хөрөнгийн сарын хуваарьт төлбөрийн нийлбэртэй тэнцүү буюу илүү хэмжээ бүхий сарын хуваарь төлбөртэй.

5.3.2. Үнэт цаас гаргагч нь Орлуулах хөрөнгийн жагсаалтыг шалгаж, өөрийн шалгуурт нийцэж байна гэж үзсэн тохиолдолд 2 хоногт хариу мэдэгдэх ба шалгуур хангахгүй гэж үзсэн тохиолдолд тайлбар болон жагсаалтаас хасуулж солиулах хөрөнгийн мэдээллээ хүргүүлнэ. Үнэт цаас гаргагч нь үндэслэлгүйгээр Орлуулах хөрөнгийн жагсаалтад байгаа хөрөнгийг хүлээн авахаас татгалзах эрхгүй байна.

5.3.3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчийн хариу мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногт багтаан хөрөнгүүдийг сольж, тэдгээрт холбогдох бүртгэлийг энэ Гэрээнд заасны дагуу хийлгэнэ.

5.3.4. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Орлуулах хөрөнгийг Үнэт цаас гаргагчид Гэрээний 2.4.1 дэх хэсэгт заасны дагуу шилжүүлэн өгч, 2.4.2 дахь хэсэгт заасны дагуу холбогдох бүртгэлийг хийлгэснээр Үнэт цаас гаргагч нь уг Орлуулах хөрөнгийг худалдан авсанд тооцогдох бөгөөд Шаардлага хангахгүй хөрөнгийг Анхны үүрэг гүйцэтгэгчид буцаан худалдсанд тооцож, буцаан шилжүүлэн өгөх ба бүртгэлээс хасуулна.

5.3.5. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Орлуулах хөрөнгийг шилжүүлэн өгсөн өдөр нь Сарын хуваарьт төлбөр төлөгдөх өдрөөс хойш байх буюу тухайн хөрөнгөд хамаарах зээлийн эргэн төлөлтийн хугацаанаас хамааран Сарын хуваарьт төлбөр бүрэн төлөгдөхгүй нөхцөлд Анхны үүрэг гүйцэтгэгч нь уг зөрүү төлбөрийг төлөх үүрэг хүлээнэ.

5.3.6. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Үнэт цаас гаргагчид шилжүүлэн өгсөн Орлуулах хөрөнгийн зээлийн үндсэн төлбөрийн үлдэгдлийн нийлбэр хэмжээ, эсхүл сарын хуваарьт төлбөрийн нийлбэрийн хэмжээ нь Шаардлага хангахгүй хөрөнгийнхөөс их байх тохиолдолд Үнэт цаас гаргагч нь тухайн хөрөнгө сольсноос хүлээн авсан эсхүл ирээдүйд хүлээн авсан зөрүү төлбөрийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид шилжүүлэх, эсхүл Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийг үйлчилгээ үзүүлэх явцдаа өөрийн дансанд суутган үлдээх зөвшөөрөл өгнө.

**5.4. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч хөрөнгө солих боломжгүй байх**

5.4.1. Анхны үүрэг гүйцэтгэгч нь Шаардлага хангахгүй хөрөнгийг бүхэлд нь солихуйц Орлуулах хөрөнгийн жагсаалтыг Үнэт цаас гаргагчид гаргаж өгөх боломжгүй эсхүл

"ИНВЕСКОР КАПИТАЛ" ҮЦК ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

000342

ИНВЕСКОР АКТИВ ТЭК ХХК
9020080754 6561463

MDS & KHANLEX

ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД АШИГЛАСАН БОЛНО.
2 0 SEP 2020

СЗХ
2021 .01. 06 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020 -11- 12
БҮРТГЭВ-02

уг жагсаалтад буй хөрөнгө нь 5.3.1 дэх хэсэгт заасан шаардлагыг хэсэгчлэн хангахгүй байх тохиолдолд Үнэт цаас гаргагч нь Шаардлага хангахгүй хөрөнгийн солих боломжгүй хэсгийг буцаан худалдаж авах тухай шаардлагыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид хүргүүлнэ.

5.4.2. Буцаан худалдаж авах ажиллагааг энэ Гэрээний 9 дүгээр зүйлд заасантай адил журмаар гүйцэтгүүлнэ.

**5.5. Багцын хөрөнгийг нэмэгдүүлэх**

5.5.1. Дараах үндэслэл бий болсон тохиолдолд Үнэт цаас гаргагч нь багц дах хөрөнгийг нэмэгдүүлэх тухай шаардлагыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид гаргаж болно. Үүнд:

- 5.5.1.1. Баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцаас орох орлого нь уг баталгаат үнэт цаасны дагуу хүлээсэн үүргийг гүйцэтгэхэд хүрэлцэхээргүй болсон;
- 5.5.1.2. Баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн үнийн дүнгийн нийлбэр нь үнэт цаасны төлбөрийн төлөгдөөгүй үнийн дүнгийн нийлбэрийн 110 хувиас бага болсон;
- 5.5.1.3. Баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн дундаж хүү үнэт цаасны хүүнээс бага болсон;
- 5.5.1.4. Баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн дундаж хугацаа үнэт цаасны дундаж хугацаанаас бага болсон.

5.5.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчийн багцын хөрөнгийг нэмэгдүүлэх шаардлагыг хүлээн авсан тохиолдолд энэ Гэрээний 5.3 дахь хэсэгт заасан хугацаа журмын дагуу Хөрөнгийг нэмэгдүүлэх үүрэг хүлээнэ.

## ЗУРГАА. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ

**6.1. Үйлчилгээ үзүүлэх гэрээ**

6.1.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчтай Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээг энэхүү Гэрээ хүчин төгөлдөр болох өдөр байгуулах бөгөөд тус гэрээний дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгийн багц дах зээлийн эргэн төлөлтийн авлагыг Зээлдэгчдээс цуглуулан Үнэт цаас гаргагчид сар тутам Сарын хуваарьт төлбөр төлөх өдөр шилжүүлэх, Үнэт цаас гаргагч Үйлчилгээний төлбөр болон шимтгэлийг төлөх үүрэг хүлээнэ.

**6.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн үүрэг**

6.2.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгийн багц дах зээлийн данс бүртгэлийг өөрийн бусад зээлийн данс бүртгэл болон санхүүгийн тайлан тэнцлээс тусад нь хөтлөх үүрэгтэй.

6.2.2. Үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу Үнэт цаас гаргагч нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид Зээл олгогчийн эдлэх эрх, үйл ажиллагааг Үнэт цаас гаргагчийг төлөөлөн хэрэгжүүлэх эрхийг олгох бөгөөд Үйлчилгээ үзүүлэгч-Анхны үүрэг гүйцэтгэгч нь уг эрх хэмжээний дагуу үйл ажиллагаа явуулна.

6.2.3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үйлчилгээ үзүүлэх гэрээгээр эрх олгогдсоноос бусад тохиолдолд Хөрөнгийн багц дахь зээл болон Фидуцийн хөрөнгөтэй холбоотой гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, засварлах эрхгүй байна.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

000343

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ХХК

СЗХ
2021 .04 сар 06 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020 -11- 12
БҮРТГЭВ

6.2.4. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгө шилжсэнтэй холбоотойгоор тухайн Зээлдэгчийн эрх зүйн байдлыг дордуулах, зээлийн эргэн төлөлтөд сөргөөр нөлөөлж болзошгүй аливаа үйлдэл, эс үйлдэхүй хийхгүй байх үүрэгтэй ба Үйлчилгээ үзүүлэх гэрээгээр олгогдсон эрх хэмжээний хүрээнд Зээлдэгчийн зээлтэй холбоотой Зээл олгогчийн хувьд хэрэгжүүлэх бүхий л арга хэмжээ, үйлчилгээг Зээлдэгчид үзүүлэх үүрэгтэй.

6.2.5. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Зээлийн данс бүртгэлийг хадгалж хөтлөх, Үнэт цаас гаргагчтай тулган баталгаажуулах болон Хөрөнгө солих, Зээлийн баримт бичгийг Үнэт цаас гаргагчид хүргүүлэх хүлээн авах зэргээр Хөрөнгөтэй холбоотой ажиллагааг хариуцан гүйцэтгэх, Үнэт цаас гаргагчтай харилцах эрх бүхий ажилтныг томилж, уг ажилтны мэдээллийг Үнэт цаас гаргагчид өгөх үүрэгтэй.

6.2.6. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь гэрээний 6.2.5 дах хэсэгт заасан Ажилтны мэдээлэл өөрчлөгдсөн тохиолдолд нэн даруй Үнэт цаас гаргагч болон түүний эрх бүхий ажилтанд мэдээлэх бөгөөд ийнхүү мэдээлээгүйн улмаас Үнэт цаас гаргагч болон бусад этгээдэд хохирол учирсан тохиолдолд уг хохирлыг төлж барагдуулах үүрэг хүлээнэ.

**6.3. Зээлийн баримт бичгийг хадгалах**

6.3.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үйлчилгээ үзүүлэгчийн хувьд Хөрөнгийн багцын дараах баримт бичгүүдийг өөрийн оффис дээр хадгалж хамгаална. Үүнд:

6.3.1.1. Хөрөнгийн багцыг бүрдүүлж буй бүх зээлийн баримт бичгүүд;

6.3.1.2.Зээлдэгчээс гаргасан хүсэлт, захидал харилцаа,

6.3.2. Үнэт цаас гаргагч болон түүнд хөрөнгө итгэмжлэн удирдах болон аудитын үйлчилгээ үзүүлэгч болон бусад эрх олгогдсон этгээд хэдийд ч Зээлийн болон Хөрөнгийн багцын баримт бичгүүдэд бүхэлд нь болон хэсэгчлэн шалгалт хийх эрхтэй байна.

6.3.3. Үнэт цаас гаргагч нь 6.3.2 дахь хэсэгт заасан шалгалтыг хийх зорилгоор Зээлийн баримт бичгүүдийг авах тухай Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид мэдэгдсэн тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь ажлын 3 хоногийн хугацаанд багтаан Үнэт цаас гаргагчид хүргүүлэх бөгөөд Үнэт цаас гаргагч нь эрх бүхий этгээд томилж Зээлийн баримт бичгүүдэд газар дээр нь шалгалт хийх тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь тухайн эрх бүхий этгээдэд ажлын цагаар шалгалт хийх боломжоор хангана.

6.3.4. Үнэт цаас гаргагч нь хүсэлт гаргасан тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь өөрийн эзэмшилд байгаа Хөрөнгөтэй холбоотой аливаа мэдэгдэл, захидал харилцаа, бусад баримт бичгүүдийг Үнэт цаас гаргагчид ажлын 2 өдөрт багтаан гаргаж өгөх үүрэг хүлээнэ.

## ДОЛОО. ЗЭЭЛИЙН ДАНС БҮРТГЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ, ТУЛГАН ШАЛГАХ

**7.1. Зээлийн данс бүртгэл хөтлөх**

7.1.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгийн багц дах Зээлийн данс бүртгэлийг энэ Гэрээний 6.2.1 дэх заалтад заасны дагуу Үйлчилгээ үзүүлэх гэрээний хүчин төгөлдөр үргэлжлэх хугацаанд хөтлөх ба Сарын хуваарьт төлбөр төлөхөөс ажлын 3 хоногийн

"ИНВЕСКОР КАПИТАЛ" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

000344

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК
9020000754 6881463

MDS & KHANLEX
ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД АШИГЛАСАН БОЛНО.
2 3 SEP 2020

СЗХ
2021.01.06 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020-11-12
БҮРТГЭВ-02

өмнө Үнэт цаас гаргагчид энэ Гэрээний Хавсралт 4-т заасан маягтын дагуу Зээлийн данс бүртгэлийн тайлан хүргүүлж байна.

7.1.2. Үнэт цаас гаргагч эсхүл түүнд хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлэгч нь мөн Зээлийн данс бүртгэлийг хөтлөх ба сар бүрийн тайланг хүлээн авч тулган баталгаажуулна.

7.1.3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон Үнэт цаас гаргагчийн Зээлийн данс бүртгэлийн хөтлөлт зөрсөн тохиолдолд талуудын эрх бүхий ажилтнууд нь ажлын 2 хоногт багтаан алдааг залруулах ажиллагааг хийж гүйцэтгэнэ.

**7.2. Шаардлага хангахгүй болсон хөрөнгийн мэдээлэл хүргүүлэх**

7.2.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгө энэ хуулийн 5.1 дэх хэсэгт заасан шаардлага хангахгүй болсон тохиолдолд нэн даруй буюу ажлын 1 өдөрт багтаан Үнэт цаас гаргагчид Хавсралт 3-т заасан Хөрөнгө солих мэдэгдлийг хүргүүлэх үүрэг хүлээнэ.

## НАЙМ. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧИЙН БАТАЛГАА, МЭДЭГДЭЛ

**8.1. Хөрөнгөтэй холбоотой баталгаа**

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгөтэй холбоотой дараах баталгааг Үнэт цаас гаргагчид гаргаж байна. Үүнд:

8.1.1. Хөрөнгийн багц дахь Хөрөнгө нэг бүр нь Хэлцэл биелэх өдрийн байдлаар хөрөнгөд тавигдах Шалгуур үзүүлэлтийг хангасан байна.

8.1.2. Энэ Гэрээ болон түүнд хавсаргасан мэдээллүүд нь (гэрээ болон хавсралтад заасан хөрөнгө, фидуцийн зүйл, тэдгээрийн шалгуур үзүүлэлтүүд, тэдгээртэй холбоотой баримт бичиг, мэдээлэл) үнэн зөв, бүрэн гүйцэт болно.

8.1.3. Хөрөнгө, түүний дотор фидуцийн зүйл нь дан ганц Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хууль зүйн болон бенефициар өмчлөлд байх бөгөөд тэдгээрийг Үнэт цаас гаргагчийг өмчлөлд бүрэн шилжүүлэхэд аливаа хязгаарлалт байхгүй болно.

8.1.4. Хөрөнгийн багц дах хөрөнгө, фидуцийн зүйлтэй холбоотой Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Зээлдэгчид төлөх аливаа өр төлбөр, Зээлийн гэрээ болон Фидуцийн гэрээнд зааснаас өөр нэмэлт үүрэг байхгүй болно.

8.1.5. Анхны үүрэг гүйцэтгэгч нь Зээлдэгч болон Зээлдэгчийн хамааралтай этгээд, Фидуцийн зүйлтэй холбоотой дараах сөрөг нөлөөтэй байж болохуйц аливаа маргаан, гомдол, нэхэмжлэл дампуурлын хэрэг зэргийг талаар мэдэгдэл, мэдээлэл аваагүй болно.

8.1.5.1. Зээлдэгч болон түүний хамааралтай этгээдийн Хөрөнгөтэй холбоотой хүлээсэн үүргээ биелүүлэх чадвар доройтоогүй байна.

8.1.5.2. Хөрөнгөтэй холбоотой Анхны үүрэг гүйцэтгэгчийн эрх хэрэгжих нөхцөл, эрхийн хүчин төгөлдөр байдал Гэрээний үргэлжлэх хугацаанд бүрэн хангагдсан байна.

8.1.6. Зээлдэгч нь Хөрөнгөтэй холбоотой аливаа үүргээ Хэлцэл биелэх өдөр хүртэл хэрэгжүүлж биелүүлсэн байх, үүргийн зөрчил бий болсон тохиолдолд уг зөрчлийг арилгасан, ийнхүү арилгасан зөрчлийн Үнэт цаас гаргагчид хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлэгч болон Аудитор шалган баталгаажуулах боломжтой байна.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ



УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК

ӨӨХ
өдөр
2021.01.08
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020-11-12
БҮРТГЭВ-02

8.1.7. Хөрөнгийн багц дах Зээлийн баримт бичгүүд болон Зээлийн данс бүртгэл нь зохих ёсоор бүртгэгдэн, хадгалагдсан бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшилд байгаа бөгөөд Хэлцэл биелэх өдрийн байдлаар Зээл бүрийн данс бүртгэл бүрэн гүйцэт ба шинэчлэгдсэн байна.

8.1.8. Хөрөнгийн багц дах зээл болон Фидуцийн зүйлтэй холбоотой аливаа шүүхийн маргаан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа үүсээгүй байна.

**8.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн мэдэгдэл**

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь дараах баталгааг Үнэт цаас гаргагчид гаргаж байна. Үүнд:

8.2.1. Энэхүү Гэрээ болон Баталгаат үнэт цаас гаргахтай холбоотой бусад холбогдох гэрээ хэлцэл түүний дотор Фидуцийн барьцааны гэрээ, Үйлчилгээ үзүүлэх гэрээ зэргийг байгуулах эрх зүйн бүрэн чадамжтай бөгөөд эдгээр гэрээ хэлцлийг байгуулснаар бусад гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээ болон эрх бүхий байгууллагын шийдвэр, журам, хууль тогтоомжтой зөрчилдөхгүй болно.

8.2.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь энэхүү Гэрээ болон бусад холбоотой гэрээг байгуулах, гэрээний дагуу хөрөнгө шилжүүлэх, барьцаалах болон бусад үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүхий л бэлтгэл ажлыг хангасан болно.

8.2.3. Үнэт цаас гаргагчид худалдаж буй Хөрөнгө болон Фидуцийн зүйл нь дан ганц Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хууль зүйн болон бенефициар бүрэн өмчлөлд байх бөгөөд тэдгээрийг Үнэт цаас гаргагчид  зөрчилгүй эд хөрөнгийн эрх үүсэх бөгөөд тухайн шилжүүлэлт, эрх шилжүүлэлтийг бүртгүүлэх, дуусгавар болгоход аливаа хязгаарлалт байхгүй болно.

8.2.4. Хөрөнгийн багц дахь Зээл тус бүртэй холбоотойгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс

8.2.5. Зээлдэгч болон бусад этгээдэд төлөх өр төлбөр байхгүй бөгөөд Сарын хуваарьт төлбөртэй холбоотойгоор Зээлдэгчээс суутгал хийх эрх үүсээгүй байна.

8.2.6. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчийн "Эрсдэлийн удирдлага, дотоод хяналт хэрэгжүүлэх, эрсдэлийн сан байгуулах, сангийн хөрөнгийг зарцуулах тухай журам"-д заасны дагуу Эсрдэлийн сангийн хөрөнгийг байршуулж, хөрөнгийг захиран зарцуулсан тохиолдолд нөхөн байршуулах болохоо баталж байна.

**8.3. Мэдэгдэл, баталгаа хангагдах**

8.3.1. Үнэт цаас гаргагч нь бичгээр зөвшөөрөл олгосноос бусад тохиолдолд Хөрөнгийн багцыг худалдах, худалдан авах ажиллагааг дуусгавар болгох, Үнэт цаас гаргагч нь аливаа судалгаа шинжилгээ хийлгэх, Үнэт цаас гаргагч нь энэ Гэрээнд заасан эрх, үүргээ хэрэгжүүлээгүй эсхүл тийнхүү хэрэгжилтийг хойшлуулсан зэрэг нь энэ зүйлийн мэдэгдэл баталгаа хангагдахгүй байх үндэслэл болохгүй ба мэдэгдэл, баталгааг зөрчсөн аливаа зөрчилтэй холбоотой Үнэт цаас гаргагч эрхээ бүхэлд нь болон хэсэгчлэн хэрэгжүүлэхгүй байх үндэслэл болохгүй.

**8.4. Баталгаа, мэдэгдэл зөрчигдөх**

8.4.1. Үнэт цаас гаргагч нь энэ Гэрээнд заасан баталгаа мэдэгдэл Гэрээ байгуулагдах үед болон байгуулснаас хойш зөрчигдсөн талаар мэдсэн даруйдаа уг зөрчлийг арилгахыг

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 ☎1119277128
УЛААНБААТАР ХОТ
000346
УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЭК ХХК
9030080754 ☎6581463
MDS & KHANLEX
ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД АШИГЛАСАН БОЛНО.
29 SEP 2020

СЭХ
2021 он 01 сар 06 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИ...
MONGOLIAN STOCK EXCHA...
2020 -11- 12
БҮРТГЭВ-02

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс шаардах эрхтэй бөгөөд зөрчигдсөн баталгаа мэдэгдэл нь цаашид гэрээний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөхүйц, гэрээ хэрэгжихгүй байх эрсдэлтэй гэж үзсэн тохиолдолд гэрээг цуцлах эрхтэй байна.

8.4.2. Үнэт цаас гаргагч нь энэ зүйлд заасан баталгаа, мэдэгдэл худал эсэхийг гэрээ байгуулах үед эсхүл түүнээс өмнө мэдэх боломжтой байсан эсэхээс үл хамааран баталгаа, мэдэгдэл зөрчигдсөнтэй холбоотой шаардлагыг Хөрөнгө худалдан авах үед болон түүнээс хойш гаргаж болох ба Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчаас тогтоосон хугацаанд уг зөрчлийг арилгах үүрэг хүлээнэ.

## ЕС. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧ ХӨРӨНГӨ БУЦААН ХУДАЛДАН АВАХ

**9.1 Анхны үүрэг гүйцэтгүүлэгч хөрөнгө буцаан худалдаж авах нөхцөл**

9.1.1. Хөрөнгийн багцын үлдэгдлийн дүн нь түүний анхны дүн буюу Хөрөнгө оруулалтаас босгосон дүнгийн 20 хувьд хүрсэн тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгэгч нь өөрийн санаачилгаар, эсхүл Үнэт цаас гаргагчийн бичгээр ирүүлсэн шаардлагад үндэслэн уг хөрөнгийг Үнэт цаас гаргагчаас буцаан худалдаж авна.

9.1.2. Хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн 20 ба түүнээс дээш хувь нь 1-ээс дээш сар хугацаа хэтэрсэн бөгөөд Анхны үүрэг гүйцэтгэгч нь уг хугацаа хэтэрсэн хөрөнгийг энэ Гэрээнд заасны дагуу сольж өгөөгүй тохиолдолд Үнэт цаас гаргагчийн бичгээр хүргүүлсэн шаардлагад үндэслэн Анхны үүрэг гүйцэтгэгч нь Үнэт цаас гаргагчид худалдсан нийт Хөрөнгийн багцыг буцаан худалдаж авна.

9.1.3. Үнэт цаас гаргагч нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид мэдэгдэл хүргүүлсэн огноогоор тухайн буцаан худалдах хөрөнгийн хэмжээ тодорхойлогдох ба тийнхүү мэдэгдэл хүргүүлснээс хойш 45 хоногийн хугацаанд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчид буцаан худалдан авах үнийг үе шаттайгаар төлж барагдуулна. Үнэт цаас гаргагч нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгч буцаан худалдан авах үнийг бүрэн төлж барагдуулснаар хөрөнгийн багцыг түүний өмчлөлд шилжүүлнэ.

**9.2 Хөрөнгө буцаан худалдан авах үнэ тогтоох**

9.2.1. Энэ Гэрээний 9.1.1, 9.1.2 дахь хэсэгт заасан худалдан авах үнийг Үнэт цаас гаргагчийн мэдэгдэл өгөх үеийн зах зээлийн үнээр тогтооно.

9.2.2. Аль нэг тал нь зах зээлийн бодит үнийг хөндлөнгийн шинжээчээр тодорхойлуулахаар шаардлага гаргасан тохиолдолд талууд санал нэгтэйгээр хөндлөнгийн шинжээч томилж дүгнэлт гаргуулах бөгөөд ажлын 5 хоногт хөндлөнгийн шинжээчийг томилох асуудлаар санал нэгдэж чадаагүй тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хөндлөнгийн шинжээчийг томилно.

9.2.3. Хөндлөнгийн шинжээчтэй холбоотой зардлыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь 70 хувь, Үнэт цаас гаргагч нь 30 хувиар хариуцна.

9.2.4. Хөндлөнгийн шинжээч нь нэгээс олон тооны Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн худалдан авах үнийг тогтоох тохиолдолд тэдгээр нь уг 70 хувийн төлбөрийг өөрсдийн буцаан худалдаж авах хөрөнгөтэй хувь тэнцүүлэн хувааж хариуцна.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

000347

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК
9020980 6581463

СЗХ
он сар өдөр 2021-01-06
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020-11-12
БҮРТГЭВ-02

**9.3 Хөрөнгийг гуравдагч этгээдэд худалдах**

9.3.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь энэ зүйл болон 5.4 дэх хэсэгт заасан хөрөнгийг буцаан худалдаж авах чадваргүй байх тохиолдолд Үнэт цаас гаргагч нь уг Хөрөнгийг бусад гуравдагч этгээдэд худалдах эрхтэй байна. Үнэт цаас гаргагч нь ийнхүү гуравдагч этгээдэд хөрөнгө худалдсантай холбоотойгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид учирсан аливаа хохирлыг хариуцахгүй бөгөөд энэ Гэрээний дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс шаардах үүргийн гүйцэтгэлийг аливаа хэлбэрээр хязгаарлахгүй болно.

9.3.2. Анхны үүрэг Гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчид энэ зүйлийн 9.3.1 дэх хэсэгт заасан ажиллагааг хэрэгжүүлсэнтэй холбоотой учирсан аливаа хохирлыг нөхөн төлөх үүрэг хүлээнэ.

## АРАВ. ЗӨРЧИЛ

**10.1 Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ноцтой зөрчил**

Дараах тохиолдол бий болсон нөхцөлд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь ноцтой зөрчил гаргасан гэж үзнэ. Үүнд:

10.1.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн гаргасан аливаа баталгаа, мэдэгдэл, гэрээнд хавсаргасан аливаа баримт бичгүүд, түүнчлэн энэхүү Гэрээ хэрэгжих явцад Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс үүрэг гүйцэтгэгчид гарган өгсөн аливаа баталгаа, мэдэгдэл, тайлан мэдээ зэрэг нь худал, алдаатай байх;

10.1.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс энэ Гэрээний Хөрөнгө солих зохицуулалтын хүрээнд Үнэт цаас гаргагчид сольж өгсөн Орлуулах хөрөнгө нь шаардлага хангахгүй, хууль болон эрх бүхий байгууллага, Үнэт цаас гаргагчаас баталсан журамд нийцээгүй байх;

10.1.3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь энэ Гэрээнд заасан хөрөнгө сольж өгөх болон буцаан худалдаж авах үүргээ биелүүлэхгүй байх;

10.1.4. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн Үнэт цаас гаргагчид худалдсанаас бусад өөрийн автомашины зээлийн хөрөнгийн багц байхгүй болсон;

10.1.5. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч төлбөрийн чадваргүй болсон, татан буулгах ажиллагаа хийгдэж эхэлсэн болон дампуурлын хэрэг үүсгэсэн;

10.1.6. Дээр дурдсанаас бусад байдлаар энэхүү Гэрээнд заасан аливаа зүйл заалт зөрчигдсөн бөгөөд Үнэт цаас гаргагч нь уг зөрчлийг арилгуулахаар Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид мэдэгдэл өгсөн боловч уг зөрчлийг арилгаагүй.

10.1.7. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч ноцтой зөрчил гаргасан тохиолдолд энэ Гэрээний 2.5.3 дахь хэсэгт заасан Барьцааны эрх хэрэгжүүлэх нөхцөл үүссэн гэж үзэх бөгөөд Үнэт цаас гаргагч нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид мэдэгдэл хүргүүлэх замаар Фидуцийн зүйлийг өмчлөлдөө шилжүүлэн авах ба захиран зарцуулах эрхтэй болно. Мөн Үнэт цаас гаргагч нь гэрээний 9.3 дахь хэсэгт заасан журмыг баримтлан Хөрөнгийг гуравдагч этгээдэд худалдах эрхтэй байх ба Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс өөрт учирсан бүхий л хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй байна.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ



УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ББСБ ХХК

MDS & KHANLEX
ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД АШИГЛАСАН БОЛНО.
29 SEP 2020

СЗХ
он сар өдөр
2021.01.06
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИ...
MONGOLIAN STOCK EXCHAN...
2020-11-12
БҮРТГЭВ-02

**10.2 Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зөрчил**

10.2.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь энэхүү Гэрээний зүйл заалтыг зөрчсөн бөгөөд уг зөрчил нь энэ зүйлийн 10.1.1-10.1.6 дахь хэсэгт зааснаас бусад зөрчил байх тохиолдолд Үнэт цаас гаргагч нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид бичгээр мэдэгдэл өгч ажлын 5 хоногт багтаан зөрчлийг арилгахыг шаардах бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь уг зөрчлийг арилгуулах тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш уг зөрчлийг ажлын 5 хоногт багтаан арилгах үүрэг хүлээнэ.

10.2.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь зөрчлийг арилгах хүртэлх хугацаанд болон түүнээс хойших хугацаанд зөрчилтэй холбоотойгоор Үнэт цаас гаргагчид бүхий л хохирлыг нөхөн төлж барагдуулах үүрэг хүлээнэ.

## АРВАН НЭГ. НУУЦЛАЛ

**11.1 Нууц мэдээлэл**

11.1.1. "Нууц мэдээлэл" гэдэгт Үнэт цаас гаргах ажиллагаа болон Хөрөнгө шилжүүлэх ажиллагаатай холбоотой аливаа мэдээлэл, Хөрөнгийн багц болон түүний Зээл, фидуцтай холбоотой Зээлдэгч болон гуравдагч этгээд, Үнэт цаас гаргагч ба Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй холбоотой аливаа мэдээлэл, Үнэт цаас гаргагчийн гуравдагч этгээд (үүнд андеррайтер, хууль зүйн үйлчилгээ үзүүлэгч, зээлийн шижнилгээ гаргагч, хөндлөнгийн аудитор, банк зэрэг байгууллагууд багтана)-тэй байгуулсан гэрээ хэлцэл, тохиролцоо болон тэдгээрээс авч буй үйлчилгээтэй холбоотой аливаа мэдээлэл, мөн талуудын бизнесийн, үйл ажиллагааны, маркетингийн болон санхүүгийн төлөвлөгөө, харилцагчид, хөрөнгө оруулагч, хувь эзэмшлийн тухай мэдээлэл, санхүүгийн нөхцөл байдлын тухай аливаа мэдээлэл, санхүүгийн тайлан, зах зээлийн судалгаа, хуулийн этгээдийн бүртгэл болон үүсгэн байгуулах үндсэн баримт бичиг, дүрэм журам, заавар, бодлого, гэрээ хэлцэл эдгээрт заасан нөхцөл, мэдээлэл, тоон үзүүлэлт, зураг, график мэдээллийг ойлгоно.

11.1.2. Энд дурдагдсан нууц мэдээлэл гэдэгт нийтэд ил болсон, эсхүл үнэт цаас гаргах ажиллагааны хүрээнд Үнэт цаасны танилцуулгад тусгах замаар олон нийтэд танилцуулагдах болон холбогдох хууль журмын дагуу тодорхой этгээдүүд (тухайлбал хөрөнгө оруулагчид)-д танилцуулах мэдээлэл хамаарахгүй болно.

**11.2 Нууцлал хадгалах**

11.2.1. Талууд хууль тогтоомж, төрийн эрх бүхий байгууллага шаардсанаас бусад Нууц мэдээллийг бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр аливаа этгээдэд задруулах, хэрэглэх эсвэл аливаа бусад зорилгоор өөртөө ашиглахыг хориглоно. Эрх бүхий байгууллагаас нөгөө талд мэдэгдэхийг хориглосноос бусад тохиолдолд нууц мэдээллийг задруулагч тал нь тухайн шаардлагын талаар нөгөө талдаа яаралтай мэдэгдэнэ.

11.2.2. Гэрээний 11.2.1 дэх хэсэгт заасан хязгаарлалт нь энэхүү Гэрээ дуусгавар болсон эсхүл цуцлагдсанаас хойш 5 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

**11.3 Нууц мэдээлэл задруулах**

11.3.1. Аль нэг тал нь нууц мэдээллийг амаар, бичгээр задруулсан тохиолдолд уг нууц мэдээллийг задруулсны улмаас нөгөө талдаа учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэг

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

ИНВЕСКОР АКТИВ ББК ХХК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ он... сар... өдөр БҮРТГЭВ 2021.01.08 № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2020-11-12 БҮРТГЭВ-02

хүлээнэ. Учирсан хохирлыг тооцохдоо тухайн Нууц мэдээллийг задруулаагүй бол олох байсан бодит орлого, бизнесийн нэр хүнд, үнэт цаас гаргах төслийн амжилттай хэрэгжихэд сөргөөр нөлөөлж, амжилтгүй болох үндсэн хүчин зүйл болсон тохиолдолд үнэт цаас гаргах төсөл амжилттай хэрэгжсэн тохиолдолд олох байсан орлогыг тооцно.

## АРВАН ХОЁР. ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ, ДУУСГАВАР БОЛОХ

**12.1 Гэрээ хүчин төгөлдөр болох**

12.1.1. Энэхүү Гэрээ нь Талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болох бөгөөд гэрээг хоёр хувь үйлдэн, талууд тус бүр нэг нэг хувийг хадгална.

**12.2 Гэрээний хугацаа**

12.2.1. Энэхүү Гэрээ нь байгуулагдсан үеэс эхлэн талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж дуусгавар болох хүртэл буюу Үнэт цаасны төлбөрийг хөрөнгө оруулагчдад төлж дуусган Үнэт цаас гаргагчийг татан буулгах хүртэл, эсхүл Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь энэхүү Гэрээний дагуу шилжүүлсэн Хөрөнгийг бүгдийг нь энэх гэрээнд заасны дагуу буцаан худалдаж авах хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр үргэлжилнэ.

**12.3 Гэрээ цуцлагдах**

12.3.1. Энэхүү Гэрээний дагуу Хөрөнгийг Үнэт цаас гаргагч худалдан авч Хөрөнгөд суурилсан үнэт цаас гаргаж, олон нийтэд арилжаалсан тохиолдолд аль нэг тал санаачилгаараа энэ Гэрээг цуцлах эрхгүй байна.

## АРВАН ГУРАВ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

**13.1 Давагдашгүй хүчин зүйл**

Талууд гэрээний үүрэг гүйцэтгэхтэй холбоотойгоор гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлс /тухайлбал: үер, гал түймэр, газар хөдлөлт, халдварт өвчний тархалт, зэвсэгт мөргөлдөөн, иргэдийн үймээн, ажил хаялт, захиалагч, нийлүүлэгчийн буруутай үйл ажиллагаанаас үл хамаарах төрийн байгууллагын шийдвэр оролцоо гэх мэт/-ийн нөхцөл байдлын улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд нөгөө талдаа мэдэгдэж, харилцан тохиролцсоны үндсэн гэрээний үүргийн гүйцэтгэлийг тухайн нөхцөл байдлыг арилгах хүртэл хойшлуулж болно.

Ханшийн өөрчлөлттэй холбогдох эрсдэл нь давагдашгүй хүчин зүйлийн үндэслэл болохгүй.

## АРВАН ДӨРӨВ. ХЭРЭГЛЭГДЭХ ХУУЛЬ, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

**14.1 Хэрэглэгдэх хууль**

Энэ Гэрээг ойлгох, тайлбарлах, хэрэглэхдээ Монгол Улсын хууль тогтоомжийг баримтална.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL 6317839 ☎ 1119277128 УЛААНБААТАР ХОТ

000350

УЛААНБААТАР ХОТ ИНВЕСКОР АКТИВ ХХК 9020080754 ☎ 6581463

MDS & KHANLEX ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД АШИГЛАСАН БОЛНО. 2 0 SEP 2020

СЗХ
он сар өдөр 2021 01 06
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГ... MONGOLIAN STOCK E...
2020 -11- 12
БҮРТГЭВ

**14.2 Маргаан шийдвэрлэх**

14.2.1. Энэхүү Гэрээ болон түүнтэй холбогдон гарч болох бүх маргааныг талууд хамтран шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

14.2.2. Хэрэв маргаантай асуудлаар талууд тохиролцоонд хүрч чадахгүй тохиолдолд энэхүү Гэрээнээс үүссэн болон холбогдон гарсан түүнчлэн уг гэрээг зөрчих, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой аливаа маргаантай асуудлыг МХАҮТ-ын дэргэдэх Монголын Олон улсын арбитрт, түүний Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу шийдвэрлүүлэх ба энэ нь талуудад эцсийн бөгөөд заавал биелүүлэх шийдвэр байна.

14.2.3. Арбитрын шийдвэртэй холбогдон гарах зардлыг аль буруутай тал нь хариуцна.

**14.3 Маргаан үүсгэхийг хязгаарлах**

Энэхүү Гэрээ байгуулагдах үндсэн зорилго болох үнэт цаас гаргах ажиллагаатай холбоотойгоор Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчийн гэрээний үүргийн зөрчилтэй холбоотойгоос бусад тохиолдолд аливаа байдлаар Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөхүйц ажиллагаа авч хэрэгжүүлэх (үүнд шүүх, арбитр, төрийн байгууллагад нэхэмжлэл гомдол гаргах болон бусад Үнэт цаас гаргагчийн эсрэг авч хэрэгжүүлэх ажиллагаануудыг ойлгоно)-гүй байх, төлбөр нэхэмжлэхгүй байх үүрэг хүлээх ба Үнэт цаас гаргагчийн эсрэг татан буулгах, дампуурлын хэрэг эхлүүлэх буюу үүнтэй ижил төсөөтэй үйл ажиллагаа хэрэгжүүлэхгүй байх үүрэгтэй.

## АРВАН ТАВ. ТАЛУУД ХАРИЛЦАХ

**15.1 Бичгээр харилцах**

15.1.1. Гэрээнд өөрөөр заагаагүй бол талууд хоорондоо бичгээр харилцах ба энэхүү Гэрээнд заасан цахим хаяг эсвэл шуудангийн хаягаар илгээнэ.

15.1.2. Бичгэн мэдэгдэл, захидал харилцааг нөгөө талд шуудангаар илгээсэн тохиолдолд тийнхүү илгээснээс хойш 7 /долоо/ хоногийн дараа, цахим хаягаар илгээсэн тохиолдолд дараагийн ажлын өдөр нөгөө тал хүлээн авсанд тооцно.

**15.2 Талуудын харилцах хаяг**

15.1.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч:

Хаяглах нь: “Микро Кредит ББСБ” ХХК
Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө, 7/2 байр, 101 тоот хаяг

Цахим хаяг: XXX
Утас: XXX
Хариуцсан ажилтан: XXX

15.1.2. Үнэт цаас гаргагч:

Хаяглах нь: “Инвескор Актив ТЗК” ХХК
Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, Сөүлийн гудамж 10/1, Твин тауэр 1, 13 давхар
Цахим хаяг: XXX

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК
9020089734 6581463

000351

СЗХ
он... сар... өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2020-11-12
БҮРТГЭВ-02

Утас: XXX
Хариуцсан ажилтан: XXX

## АРВАН ЗУРГАА. БУСАД

**16.1 Өмнөх тохиролцоо**

Энэхүү Гэрээ хүчин төгөлдөр болсноор талуудын хоорондын өмнөх амаар болон бичгээр хийсэн хэлцэл, таамаглал, тохироо, ойлголцол зэрэг бүхий л тохиролцоог орлоно.

**16.2 Нэмэлт өөрчлөлт**

Талуудын аль нэг нь гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа нөгөө талдаа 10 /арав/-аас доошгүй хоногийн өмнө бичгээр мэдэгдэж, харилцан тохиролцох замаар нэмэлт өөрчлөлт оруулж болно. Нэмэлт өөрчлөлт нь талуудын эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулснаар энэхүү Гэрээний салшгүй хэсэг болно.

**16.3 Эрх, үүрэг шилжих**

Аль нэг тал нь нөгөө талынхаа бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр энэхүү Гэрээгээр хүлээх эрх, үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй байх үүрэгтэй. Аль нэг тал нь эрх залгамжлагч томилсон тохиолдолд тухайн эрх залгамжлагчийн хувьд энэ Гэрээ болон энэ Гэрээг хэрэгжүүлэхээр байгуулсан бусад гэрээнүүд хүчин төгөлдөр үйлчилнэ.

**16.4 Гэрээний хүчин төгөлдөр байдал**

Энэхүү Гэрээний аль нэг зүйл, заалтын хүчин төгөлдөр бус, хууль бус эсвэл мөрдөгдөхгүй болсон нь Гэрээний бусад зүйл, заалтад нөлөөлөхгүй.

**ТАЛУУД:**

| "МИКРО КРЕДИТ ББСБ" ХК-ийг төлөөлөн | "ИНВЕСКОР АКТИВ ТЗК" ХХК-ийг төлөөлөн. |
|---|---|
| _______________________ | _______________________ |
| Гүйцэтгэх захирал Г.Булганчимэг | ТУЗ-ийн дарга Б.Хишигтөр |

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

000352

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК
9020080754 6581463

MDS & KHANLEX
ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД АШИГЛАСАН БОЛНО.
29 SEP 2020

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore
CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ



УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР

*"Инвескор Актив" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн*
*2020 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 20/04 дүгээр тогтоолын Долоодугаар Хавсралт*

# ФИДУЦИЙН БАРЬЦААНЫ ГЭРЭЭ

ГЭРЭЭНИЙ ДУГААР

№ ....

....

"ИНВЕСКОР ББСБ" ХК

Барьцаалуулагч

Болон

"ИНВЕСКОР АКТИВ ТЗК" ХХК

Барьцаалагч

Огноо: 2020 оны ... дугаар сарын ... өдөр

Улаанбаатар хот

СЗХ
он сар өдөр
2021-01-06
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ...
MONGOLIAN STOCK EXC...
2020 -11- 12
БҮРТГЭВ-02

Энэхүү ФИДУЦИЙН БАРЬЦААНЫ ГЭРЭЭ (цаашид “Гэрээ” гэх)-г,

1) Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан 6060854 тоот регистрийн, 9015003118 тоот улсын бүртгэлийн дугаартай, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2 дугаар хороо, Сөүлийн гудамж, Твин Тауэр-1 хаягт байрлах “ИНВЕСКОР ББСБ” ХК (цаашид “Барьцаалуулагч” гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Д.Баясгалан;

2) Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан 6581463 тоот регистрийн, 9011818840 тоот улсын бүртгэлийн дугаартай, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2 дугаар хороо, Сөүлийн гудамж, Твин Тауэр-1 хаягт байрлах “ИНВЕСКОР АКТИВ” ХХК (цаашид “ТЗК” эсхүл “Барьцаалагч” гэх), түүнийг төлөөлж Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Хишигтөр;

(Гэрээнд оролцогч талуудыг дангаар нь “Тал”, хамтад нь “Талууд” гэх) нар Иргэний хуулийн 153-160 дугаар зүйл, дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав. Үүнд:

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

### 1.1. Гэрээгээр зохицуулах харилцаа

Энэхүү гэрээгээр Барьцаалагч болон Барьцаалуулагчийн хооронд байгуулагдсан Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний дагуу шилжүүлж буй Хөрөнгийн багц, уг багцад буй автомашины зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны эргэн төлөлтийн үүргийн гүйцэтгэлийн хангуулах зорилгоор Барьцаалуулагч нь Фидуцийн зүйлийн өмчлөх эрхийг Барьцаалагчид барьцаалуулахтай холбогдох харилцаанд талуудын эдлэх эрх, үүргийг зохицуулна.

### 1.2. Нэр томьёо

1.2.1. Гэрээнд хэрэглэсэн нэр томьёог дараах агуулгаар ойлгоно. Үүнд:

**“Барьцааны зүйл”** гэж энэ Гэрээний 2.1.1 дэх хэсэгт тодорхойлсныг;

**“Барьцаа хөрөнгийн жагсаалт”** гэж Гэрээний 2.1.1 дэх хэсэгт тодорхойлж, энэ Гэрээнд хавсаргасан Барьцааны зүйлүүдийн жагсаалтыг;

**“Орлуулах хөрөнгө”** гэж энэ Хөрөнгө худалдах худалдан авах гэрээний 5.3.1 дэх хэсэгт заасан хөрөнгийг;

**“Үнэт цаас”** эсхүл **“ХБҮЦ”** гэж Үнэт цаас гаргагчийн гарган арилжаалах Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 10 дугаар зүйлд үнэт цаасыг;

**“Фидуцийн зүйл”** гэж Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээнд тодорхойлсон Зээлдэгчийн Анхны Үүрэг гүйцэтгүүлэгчтэй байгуулсан Зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар тэдгээрийн хооронд байгуулсан Фидуцийн гэрээний дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжүүлсэн автомашиныг;

**“Хөрөнгө”** гэж Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээнд тодорхойлсныг;

**“Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ”** гэж талуудын хооронд энэ Гэрээ байгуулагдах өдөр байгуулагдсан ....... тоот гэрээ, түүний хавсралт болон нэмэлт өөрчлөлтийг хамтад нь;

**“Шаардлага хангахгүй хөрөнгө”** гэж энэ Хөрөнгө худалдах худалдан авах гэрээний 5.1 дэх хэсэгт заасан хөрөнгийг тус тус ойлгоно.

### 1.3. Хавсралтууд

1.3.1. Нэгдүгээр Хавсралт – Барьцаа хөрөнгийн жагсаалт

1.3.2. Хоёрдугаар Хавсралт – Барьцааны мэдэгдэл

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК
9020080754 6581463



000355

СЗХ
он сар өдөр
2021 01 06
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020-11-12
БҮРТГЭВ-02

## ХОЁР. БАРЬЦААНЫ ЗҮЙЛ

**2.1. Барьцааны зүйл**

2.1.1. Барьцаалуулагч нь Барьцаагаар хангагдах үүрэг (ХБҮЦ)-ийн гүйцэтгэлийг хангах зорилгоор Фидуцийн гэрээний дагуу өмчлөх эрхийг нь олж авсан Нэгдүгээр Хавсралт дахь Барьцаа хөрөнгийн жагсаалтад жагсаасан Фидуцийн зүйлүүдийг түүнтэй холбоотой эрхийн хамтаар (цаашид хамтад нь “Барьцааны зүйл” гэх) барьцаалж байна.

2.1.2. Барьцааны зүйл нь Талуудын хооронд байгуулагдсан Хөрөнгө худалдах худалдан авах гэрээний Хөрөнгийг баталгаажуулж буй эрхийн нэг хэсэг бөгөөд уг Хөрөнгөтэй салшгүй холбоотой байна.

**2.2. Барьцааны зүйлийн өмчлөл, эзэмшил**

Барьцааны зүйл Барьцаалуулагчийн өмчлөлд байх ба гуравдагч этгээдийн эзэмшилд байж болно.

**2.3. Барьцаа хөрөнгийн жагсаалтад өөрчлөлт оруулах**

Талуудын хооронд байгуулагдсан Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ, Үнэт цаас гаргагчийн баталсан журамд заасны дагуу Хөрөнгөд өөрчлөлт орж, солигдсон тохиолдолд тухайн Хөрөнгөд холбогдох Барьцааны зүйлд мөн өөрчлөлт орох ба Барьцаа хөрөнгийн жагсаалтад дараах байдлаар өөрчлөгдөнө.

2.3.1. Барьцааны зүйл хасагдах. Зээлдэгч нь Барьцаалуулагчид төлөх зээлийг төлж барагдуулсан бөгөөд Барьцаалуулагч нь Үйлчилгээ үзүүлэгчийн хувьд уг зээлийн эргэн төлөлтийг Барьцаалагчид шилжүүлсэн тохиолдолд Фидуцийн зүйлийн өмчлөх эрх Барьцаалуулагчид бус Зээлдэгчид шилжих бөгөөд Барьцаа хөрөнгийн жагсаалтад тусгагдсан Барьцааны зүйл хасагдаж, Барьцаалуулагчийн барьцаанаас чөлөөлөгдөнө.

2.3.2. Барьцааны зүйл солигдох. Хөрөнгө нь Хөрөнгө худалдах худалдан авах гэрээний дагуу шаардлага хангахгүй болсон бөгөөд хөрөнгө солих ажиллагаа хийсэн тохиолдолд уг Хөрөнгөд холбогдох Барьцааны зүйл солигдоно.

2.3.3. Барьцааны зүйлийг солиход Багцын хөрөнгөд өөрчлөлт оруулах, хөрөнгийг багцаас хасах тухай журмыг баримтлах ба Барьцаалуулагч нь Орлуулах хөрөнгийг баталгаажуулж буй Барьцааны зүйлийн жагсаалтыг Барьцаалагчид ирүүлж, Барьцаалагч нь энэхүү гэрээнд заасны дагуу Бүртгэлийн байгууллагад барьцааны бүртгэл хийлгэснээр Барьцаа баталгаажсанд тооцно. Барьцааны бүртгэлийг хийх үед мөн Шаардлага хангахгүй хөрөнгөд холбогдох Барьцааны зүйлийг Барьцаалагчийн барьцаанаас чөлөөлөх бүртгэлийг зэрэг хийнэ.

## ГУРАВ. БАРЬЦААНЫ НӨХЦӨЛ

**3.1. Барьцаагаар хангагдах шаардлага**

Барьцаагаар хангагдах шаардлага нь Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээнд заасан хөрөнгөөр тодорхойлогдох ба Хөрөнгийг бүрдүүлж буй зээлийн авлага, түүнд холбогдох эрхүүд, Барьцааны зүйлийг худалдан борлуулахад гарсан зардал, улсын тэмдэгтийн хураамж, нөхөн төлүүлэх шүүхийн зардал, Барьцааны зүйлийг арчлан хамгаалахад гарсан зардал уг эд хөрөнгөтэй холбоотойгоор төлсөн татвар хураамж, төлбөр болон зээлдүүлэгчид учирсан бусад хохирлын нийлбэрээр тодорхойлогдоно.

**3.2. Барьцааны баталгаажилт**

3.2.1. Барьцаалагч нь барьцааны эрхийг баталгаажуулах зорилгоор Гэрээний Нэгдүгээр Хавсралт дахь Барьцаа хөрөнгийн жагсаалт дахь Барьцааны зүйл тус бүрээр хөдлөх эд хөрөнгийн болон эдийн бус хөрөнгийн Барьцааны мэдэгдлийг үйлдэж, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн

"ИНВЕСКОР КАПИТАЛ" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

000356

УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР АККИБ ТЗК ХХК

MDS & KHANLEX
ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД АШИГЛАСАН БОЛНО.
29 SEP 2020

СЗХ
2021 .01. 06 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН Б
MONGOLIAN STOCK EXCH
2020 -11- 12
БҮРТГЭВ-02

бус хөрөнгийн барьцааны тухай хуульд заасны дагуу тээврийн хэрэгсэл тус бүрийн сериал дугаараар Улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд бүртгүүлнэ.

3.2.2. Барьцааны мэдэгдлийг цахим мэдээллийн санд бүртгүүлэх, бүртгэлд өөрчлөлт оруулах, Барьцааны мэдэгдлийн анхны бүртгэлийн хугацааг сунгах, Барьцааны мэдэгдлийг цуцлахтай холбоотой Улсын бүртгэлийн байгууллагад төлөх хураамж, шимтгэлийг Барьцаалуулагч хариуцна.

3.2.3. Барьцаалуулагч нь барьцааны зүйлтэй холбоотой Барьцааны мэдэгдлийг Улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд бүртгүүлэх зөвшөөрлийг Барьцаалагчид үүгээр олгож байна.

3.2.4. Энэ гэрээний 3.2.3-т заасан Барьцаалуулагчаас Барьцаалагчид олгосон зөвшөөрлийн хүрээнд Барьцаалагч нь Барьцааны мэдэгдлийн бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулах, хугацаа сунгах, Барьцааны мэдэгдлийн талаар лавлагаа авах эрхтэй болохыг тодорхойлж байна.

**3.3. Барьцаа хөрөнгөтэй холбоотой мэдэгдэл**

3.3.1. Барьцаалуулагч нь барьцааны зүйлтэй холбоотой аливаа мэдэгдэл, хүсэлт, шаардлагыг эрх бүхий байгууллага, Зээлдэгч болон бусад аливаа этгээдээс хүлээн авсан тохиолдолд энэ талаар Барьцаалагчид ажлын 1 хоногт бичгээр мэдэгдэх үүрэг хүлээнэ.

**3.4. Тэргүүн ээлжид шаардлага хангуулах**

Барьцаалагч нь энэхүү гэрээний дагуу барьцаалж буй Барьцааны зүйлээр бусад аливаа шаардлагаас тэргүүн ээлжид үүргийн гүйцэтгэл хангуулна.

**3.5. Барьцааны зүйлийг бусдад шилжүүлэх болон барьцаалахгүй байх**

Барьцаалуулагч нь энэхүү Гэрээ хүчин төгөлдөр үргэлжлэх хугацаанд Барьцааны зүйлийн өмчлөх эрхийг аливаа хэлбэрээр бусад этгээдэд шилжүүлэхгүй, барьцаалахгүй, тийнхүү шилжүүлэхээр амлахгүй байх үүрэгтэй.

## ДӨРӨВ. БАРЬЦААГААР ҮҮРГИЙН ГҮЙЦЭТГЭЛ ХАНГУУЛАХ

**4.1. Барьцаагаар үүргийн гүйцэтгэл хангуулах нөхцөл**

4.1.1. Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний 10.1 дэх хэсэгт заасан ноцтой зөрчлийн тохиолдол бий болсон тохиолдолд Барьцаалагч нь Барьцааны зүйлийг өөрийн өмчлөлд шилжүүлж, Барьцаалуулагчийн үүргийн гүйцэтгэлийг хангуулна.

**4.2. Барьцаагаар үүргийн гүйцэтгэл хангуулах ажиллагаа**

4.2.1. Барьцаалагч нь Барьцааны эрх хэрэгжүүлэх нөхцөл үүссэн тухай мэдсэн даруй Фидуцийн зүйлийг өмчлөлдөө шилжүүлэх тухай мэдэгдлийг Барьцаалуулагчид хүргүүлнэ.

4.2.2. Барьцаалуулагч нь Барьцаалагчийн мэдэгдлийг хүлээж авсан буюу хүлээж авсанд тооцогдох өдрөөс хойш ажлын 5 дахь хоногт Барьцааны зүйлийн өмчлөх эрх Барьцаалагчид үл маргах журмаар шилжинэ. Барьцаалуулагч нь татан буугдах, гүйцэтгэх удирдлагын эрх хэмжээг хэрэгжүүлэгч байхгүй болсон зэрэг шалтгааны улмаас мэдэгдлийг хүлээн авах боломжгүй болсон нь энэ зүйлийг хэрэгжүүлэхгүй байх үндэслэл болохгүй.

